ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

ᠡᠷᠦᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠬᠥᠭᠵᠢᠯ ᠤᠨ ᠲᠥᠪ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

30 жил

1996-2026



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ



1996-2026

Улаанбаатар хот
2026

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЖИЛИЙН ОЙ
1996 - 2026

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ - 30 ЖИЛ”

Боловсруулсан: Ш.Солонго
Г.Дамба
О.Мөнхбадрал
Д.Дондогмаа
Б.Болортуяа
Б.Алтантулга
Ш.Алтанцэцэг
С.Лхагвасүрэн
П.Батчулуун
С.Даваажаргал
Л.Бор
Б.Мөнхцэцэг
Н.Гантулга
Ч.Баярмаа
С.Өлзийсайхан
Д.Бямбасүрэн
Ш.Энхзаяа
Р.Энхсүрэн
Ц.Хандармаа
Ч.Батнасан
Г.Тэмүүжин
Д.Энхээ

Эмхэтгэсэн: Л.Оюунчимэг
Н.Нарангэрэл
Л.Туяа, Яруу найрагч, судлаач

Хянан тохиолдуулсан: М.Одгэрэл, АУ-ны магистр

Ерөнхий хянан тохиолдуулсан: Ц.Содномпил, АУ-ны доктор (Ph.D), профессор, Академич
Б.Нарантуяа, АУ-ны доктор (Ph.D)

Эх бэлтгэсэн: Г.Самдан
Цаасны хэмжээ: 200х160
Хэвлэлийн хуудас: 37х.х

АГУУЛГА

ОРШИЛ ҮГ 5

МЭНДЧИЛГЭЭ 6

ТОВЧИЛСОН ҮГ 12

БИДНИЙ БАХАРХАЛ 14

БҮЛЭГ НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ТҮҮХЭН ТОВЧООН 17

1.1. Байгууллагын хөгжлийн он цагийн хэлхээс, түүхэн товчоон (1996–2026) 18

БҮЛЭГ ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖИЛД БИДНИЙ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР (АНХДАГЧ, ШИНЭЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА) 29

БҮЛЭГ ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН НЭГЖҮҮД 65

3.1. Байгууллагын хүний нөөцийн чадавх, танилцуулга 66

3.2. Захиргааны алба 69

3.3. Их өгөгдөл, судалгааны алба 72

3.4. Цахим хөгжлийн алба 78

3.5. Хүний нөөцийн хөгжлийн алба 82

3.6. Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн алба 86

3.7. Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба 92

3.8. Гадаад эмчилгээг зохицуулах алба 99

3.9. Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба 102

3.10. Санхүүгийн алба 105

БҮЛЭГ ДӨРӨВ. ТУУРГА ТУСГААРЛАСАН Ч ТҮҮХЭЭ БҮТЭЭЛЦСЭН АЛБАД 107

4.1. Эрүүл мэндийг дэмжих алба 108

4.2. “ЭСС ТВ радио студи (1995–2011 он) 113

4.3. Эдийн засаг, технологийн алба 116

4.4. Эмийн зохицуулалтын алба 117

4.5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын алба 123

4.6. Алсын түргэн тусламжийн алба 125

4.7. Дуудлага зохицуулах алба 127

4.8. Зайн оношилгооны төв 129

АГУУЛГА

БҮЛЭГ ТАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР 131

5.1. Цар тахлын үед хэрэгжүүлсэн үйл ажиллагаа 132

БҮЛЭГ ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА 147

6.1. Гадаад хамтын ажиллагаа 148

6.2. Хамтрагч байгууллагууд 158

6.3. Хамтын ажиллагаа - Зургийн цомог 160

БҮЛЭГ ДОЛОО. БАХАРХАЛТ ТҮҮХЭЭ БҮТЭЭЛЦСЭН ҮЕ ҮЕИЙН ХАМТ ОЛОН 163

7.1. Төвийн удирдлагууд 164

7.2. Нэгжийн удирдлагууд 169

7.3. Төвийн ахмадууд 174

7.4. Түүх өгүүлэх ярилцлагууд 181

7.5. Дурсамж, түүх болон үлдээсэн мөр 201

7.6. Хамтрагч байгууллага, хамт олны сэтгэгдэл...Дурсамж...Талархал... Мэндчилгээ 232

БҮЛЭГ НАЙМ. ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ 243

БҮЛЭГ ЕС. ИХ ҮЙЛСИЙН ЗАМД 257

БҮЛЭГ АРАВ. ХАВСРАЛТ 261

10.1. Бүтэц, зохион байгуулалтын талаар гарсан тушаал шийдвэр 262

10.2. Бүтээлийн жагсаалт 270

ОРШИЛ ҮГ

Түүх бол өнгөрснийг өгүүлэх төдийгүй ирээдүйг чиглүүлэх үнэт өв юм. Байгууллага бүрийн хөгжил дэвшил нь үе үеийн хамт олны мэдлэг, ур чадвар, сэтгэл зүтгэл, үнэт зүйл, хамтын бүтээлээр бичигдэн үлддэг.

Энэхүү номыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн хөгжлийн замнал, бүтээн байгуулалт, ололт амжилт, шинэчлэл өөрчлөлтийн дүгнэлт, сургамжийг баримтжуулан хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгууллагын хөгжил, дэвшилд тус дэм болох зорилготойгоор бүтээв.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол улсын эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжих, урагшлуулах, шинэ шатанд гаргах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, хүний нөөцийн хөгжил, эрүүл мэндийн мэдээлэл, бодлогын судалгаа, цахим шилжилт, магадлан итгэмжлэл, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зохицуулалт, гадаад эмчилгээний зохицуулалт зэрэг олон чиглэлээр үндэсний хэмжээний бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, салбарын хөгжилд бодит хувь нэмэр оруулсаар ирсэн.

Эдгээр он жилүүдэд тус төв нь улсын болон салбарын хэмжээнд хөгжлийн олон шинэ үйл ажиллагаа, шинэ санаачилга, шинэлэг арга барилыг нэвтрүүлж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээнд чухал үүрэг гүйцэтгэн ажилласан нь байгууллагын түүхэнд онцгой байр суурь эзэлнэ.

30 жилийн түүхийн номонд байгууллагын үүсэл хөгжил, он цагийн хэлхээс, үе үеийн бүтэц зохион байгуулалт, нэгжүүдийн үйл ажиллагаа, анхдагч санаачилга, улсын болон салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр, хамтын ажиллагаа, хамт олны бахархал, ахмад ажилтнуудын дурсамж, гэрэл зургийн архив зэрэг олон үнэ цэнэтэй мэдээллийг нэгтгэн оруулаа. Түүнчлэн хамтрагч байгууллага болон хамт олны дурсамж, ярилцлага, санал, сэтгэгдлийг оруулснаараа онцлог боллоо.

Энэ нь зөвхөн өнгөрсөн хугацааны тайлан бус, байгууллагын үнэт өв, уламжлал, хамтын хөдөлмөрийн бодит гэрч, ирээдүйн хөгжлийн үндэс суурийг илэрхийлсэн баримтад тулгуурласан түүх юм.

Энэхүү бүтээл нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хамт олны бахархалт түүхийг мөнхлөн үлдээж, өнөөдрийн бүтээсэн үнэ цэнийг маргаашийн хөгжилтэй холбох гүүр болж, ирээдүй үеийн ажилтан, судлаач, уншигчдын гарын авлага, лавлах бүтээл болон үлдэнэ гэдэгт итгэлтэй байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн удирдлагууд, ажилтан, албан хаагчид, ахмад буурлууд, хамтран ажиллагч байгууллага, түншүүд, дэмжигч бүх хүмүүст энэхүү номыг бүтээхэд үнэт баримт, дурсамж, санал бодлоо харамгүй хуваалцсан явдалд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

НОМЫГ ЭМХЭТГЭН, БАРИНТАГЛАСАН ГИШҮҮД БОЛОН РЕДАКТОРУУД

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн,
Эрүүл мэндийн сайд
Э.Батшугар

Монгол улсын эрүүл мэндийн салбарын шинэчлэл, хөгжлийн түүхэнд мэдээлэл, сургалт, судалгаа, хүний нөөцийн хөгжил, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд Эрүүл мэндийн хөгжлийн төв болон түүний өмнөх үе үеийн байгууллагууд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн билээ.

Энэхүү түүхэн замналын эхлэл 1996 онд тавигдаж, Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвийг байгуулан, салбарын удирдлагын чадавхыг бэхжүүлэх, бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах, эрүүл мэндийн удирдах ажилтныг бэлтгэх, давтан сургах, салбарын тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь өнөөгийн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үндэс суурийг тавьсан түүхэн үйл явдал байлаа.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд тус байгууллагын нэр, бүтэц, зохион байгуулалт нь цаг үеийн шаардлага, төрийн байгуулалтын өөрчлөлт, салбарын шинэчлэлтэй уялдан олонтаа хувьсан өөрчлөгдсөн хэдий ч нотолгоо, мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжих, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үндсэн зорилго нь үеийн үед уламжлагдан иржээ.

Энэ хугацаанд эрүүл мэндийн статистик, мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх, эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, төгсөлтийн дараах сургалтыг зохицуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх, эмийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ, хүн амын эрүүл мэндийг дэмжих, телемедицин болон цахим эрүүл мэндийг хөгжүүлэх зэрэг олон чухал чиглэлээр салбарын шинэчлэлд үнэтэй хувь нэмэр оруулсан байна.

Энэхүү 30 жилийн түүхийн хамгийн үнэ цэнтэй өв нь байгууллагын бүтэц, тогтолцооноос гадна түүнийг бүрдүүлж, хөгжүүлж ирсэн хүний нөөц, мэргэжлийн чадавх юм. Үе үеийн удирдлага, эрдэмтэн судлаачид, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургагч багш, албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хөдөлмөр зүтгэл, манлайлал, хамтын ажиллагааны үр дүнд тус байгууллага салбарын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулжээ.

Түүнчлэн тус байгууллагын хамт олны дундаас төрийн бодлого, удирдлагын түвшинд ажилласан мэргэжилтнүүд, үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн судлаач, сургагч багш, эмч, мэргэжилтнүүд олноор төрөн гарсан нь байгууллагын оюуны өв, түүхэн гавьяаны нэгэн илэрхийлэл юм.

Өнөөдөр эрүүл мэндийн салбар хөгжлийн шинэ үе шатанд шилжиж, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ нотолгоо, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, хүний нөөцийн тасралтгүй хөгжил, цахим шилжилт, инновац, шинэ технологийн хэрэглээг эрчимжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Энэ цаг үед Эрүүл мэндийн хөгжлийн төв нь хуримтлуулсан мэдлэг, туршлага, мэргэжлийн чадавхдаа тулгуурлан мэдээлэл, судалгаа, сургалт, хүний нөөц, тусламж, үйлчилгээний чанар, инновац, цахим эрүүл мэндийн чиглэлээр салбарынхаа хөгжлийг дэмжин, шинэ үеийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжлийн тэргүүлэх байгууллага болон улам бүр бэхжин хөгжих учиртай.

Монгол улсын эрүүл мэндийн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, иргэн бүрд чанартай, аюулгүй, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ хүргэхэд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжлийн үүрэг, оролцоо цаашид ч чухал хэвээр байх болно.

Иймд түүхт 30 жилийнхээ ололт, амжилтыг бататган, үе үеийн ахмадуудынхаа үнэт өв, туршлагыг залуу үеийн эрч хүч, шинэ мэдлэг, дэвшилтэт технологитой хослуулж, эрүүл мэндийн салбарынхаа ирээдүйн төлөө улам ихийг бүтээхийг нийт хамт олонд нь хүсэн ерөөе.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үе үеийн удирдлага, ахмад ажилтан, албан хаагчид, өнөөдөр ажиллаж буй нийт хамт олонд түүхт 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйлс бүтээл арвин, эрүүл мэндийн салбарын хөгжил дэвшил өөдрөг, хамт олны ажил үйлс үргэлж өөдөө байх болтугай!

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **Э.БАТШУГАР**

МЭНДЧИЛГЭЭ



ДЭМБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч Др. Сокорро Эскаланте

Эрүүл мэндийн хөгжлийн төв үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

ЭМХТ нь Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн билээ. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд тус төв нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эрүүл мэндийн мэдээлэл, статистикийн тогтолцоог үндэсний хэмжээнд бэхжүүлэх чиглэлээр тэргүүлэгч үүргээ гүйцэтгэсээр ирсэн. Эдгээр үйл ажиллагаагаараа ЭМХТ нь нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжиж, Монгол Улсын эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, гүйцэтгэлийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

ДЭМБ олон жилийн турш ЭМХТ-тэй нягт хамтран ажиллаж ирсэн. Бидний хамтын ажиллагаа эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх, бодлогын судалгаа, эрүүл мэндийн мэдээлэл, статистик, үндэсний эрүүл мэндийн зардлын тооцоо, төгсөлтийн дараах сургалт, магадлан итгэмжлэл, тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах зэрэг олон чиглэлийг хамарсан. Эдгээр хамтын үйл ажиллагаа нь Монгол Улсын “Эрүүл мэндийг хүн бүрд” гэсэн алсын хараах хэрэгжүүлэхэд чухал тулгуур болж байна.

Хувь хүнийхээ хувьд, 2019 оноос хойш ЭМХТ-тэй хамтран ажиллах завшаан надад тохиосон юм. Эмийн зохицуулалтын чиг үүрэг ЭМХТ-ийн харьяанд байхад би ДЭМБ-ын Бүсийн төвөөс хамтран ажиллаж, эмийн зохицуулалтын үндэсний чадавхыг бэхжүүлэхэд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж байлаа. Энэхүү хамтын ажиллагаа нь Монгол Улсад эмийн зохицуулалтын байгууллагыг байгуулах үндэс суурийг тавихад хувь нэмэр оруулсан гэж бодож байна. Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр ЭМХТ-ийн гүйцэтгэж байгаа үүрэг, хүчин чармайлт, амжилтуудыг тэмдэглэж буй энэ түүхэн үед хамтын ажиллагаагаа эргэн дурсах нь миний хувьд онцгой утга учиртай санагдаж байна.

Энэхүү завшааныг ашиглан өнгөрсөн 30 жилийн хугацаанд ЭМХТ-ийн амжилт бүтээлд хувь нэмрээ оруулсан үе үеийн удирдлага, хамт олон болон бүх хүмүүст дахин халуун баяр хүргэе. Ирээдүйн зорилгод нийцүүлэн эрүүл мэндийн тогтолцоог өөрчлөн бэхжүүлэх их эрхэм үйлсдээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

Др. СОКОРРО ЭСКАЛАНТЕ

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн нэрийн өмнөөс Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түүхт 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж, Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд өнгөрсөн гучин жилийн хугацаанд оруулсан үнэтэй хувь нэмрийг тань өндрөөр үнэлж буйгаа илэрхийлье.

НҮБ-ын Хүүхдийн Сан Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй олон жилийн турш тогтоон хөгжүүлж ирсэн хамтын ажиллагаагаа эрхэмлэн үздэг. Бид хамтран орчны эрүүл мэнд, олон нийтэд түшиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тэр дундаа олон нийтэд түшиглэсэн хүүхдийн өвчний цогц менежмент (cIMCI), эрүүл мэндийн цахим үйлчилгээ, бага насны хүүхдийн хөгжил, дархлаажуулалт, вакцинаторуудын сургалт зэрэг чиглэлээр богино болон урт хугацааны багц цагийн сургалтуудыг зохион байгуулж, эрүүл мэндийн ажилтнуудын мэргэшлийн тасралтгүй хөгжлийг дэмжин ажиллаж ирлээ. Түүнчлэн анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглах практик гарын авлага, арга зүйн удирдамжийг боловсруулж, анхан шатны тусламж, үйлчилгээг бэхжүүлэхийн зэрэгцээ "Хүүхдэд ээлтэй эмнэлэг" санаачилга болон эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаагаар дамжуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулсан.

Бидний хамтын ажиллагааны нэг чухал чиглэл нь эрүүл мэндийн өгөгдөл, мэдээллийн тогтолцоог бэхжүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх явдал байлаа. Энэ хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сан эрүүл мэндийн өгөгдөл, мэдээллийг цуглуулах, удирдах, ашиглах үйл ажиллагааг сайжруулж, нотолгоонд суурилсан төлөвлөлт, шийдвэр гаргалтыг дэмжин ажилласан. Тухайлбал, улсын хэмжээнд эрүүл мэндийн мэдээллийг тогтмол цуглуулах, хадгалах, ашиглах H-info 3.0 системийн үйл ажиллагааг дэмжих хүчин чадал өндөртэй серверээр хангахад дэмжлэг үзүүлсэн юм.

Эдгээр ололт амжилт нь Монгол улсын хүүхэд бүр, гэр бүл бүрийн төлөө илүү хүчирхэг, аливаа сорилтыг даван туулах чадвартай, тэгш хүртээмжтэй эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх бидний хамтын зорилго, тууштай хүчин чармайлтын илэрхийлэл билээ.

НҮБ-ын Хүүхдийн Сан цаашид ч энэхүү эрхэм хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагаа, инновац, манлайллын хөгжлийн дараагийн үе шатанд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэхдээ таатай байх болно.

Biate Dastel **БИАТЕ ДАСТЕЛ**



Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч Биате Дастел

МЭНДЧИЛГЭЭ



Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн ойн баярын мэндийг үе үеийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагчдад Үндэсний Статистикийн Хорооны нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье.

Эрүүл мэндийн салбарын хөгжил дэвшил, ололт амжилт, сорилт боломжийг бодит тоон мэдээллээр илэрхийлж, салбарын түүхийг бичин үлдээж буй танай хамт олны хөдөлмөр, зүтгэл үнэлж баршгүй билээ.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид эрүүл мэндийн салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх, статистик мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг дэмжих чиглэлд нягт хамтран ажиллаж ирлээ.

Үндэсний Статистикийн Хороо нь Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс төрөлт, нас баралт, өвчлөл, хүний нөөц, хүчин чадлын үзүүлэлтүүдийн тоон мэдээллийг сар, жилийн давтамжтай хүлээн авч боловсруулдаг бөгөөд салбарын танилцуулга, сарын танилцуулга, статистикийн эмхэтгэл мөн “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-гаар дамжуулан хэрэглэгчдэд түгээж байна. Түүнчлэн эрүүл мэндийн хувийн хэвшлийн орлого, зарлагын мэдээлэлд тулгуурлан салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг тооцон гаргадаг билээ.

Цаашид бид мэдээллийн чанарыг сайжруулахад хамтран ажиллаж, эрүүл мэндийн салбарын хөгжлийг бодит, чанартай тоон мэдээллээр дэмжиж, хөгжлийн эрин үетэй хөл нийлүүлэн алхахдаа итгэл дүүрэн байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн түүхийг бүтээхэд мэдлэг чадвар, сэтгэл зүрх, ур чадвар бүхнээ зориулсан танай нийт хамт олонд дахин ойн баярын мэнд хүргэж, хамгийн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА Б.БАТДАВАА

МЭНДЧИЛГЭЭ

Өнөөдөр бид эрүүл мэндийн салбарын хөгжил, дэвшилд оруулсан 30 жилийн хөдөлмөр, бүтээлийн түүхийг нэгэн бүтээлд эмхэтгэн, өнгөрсөн хугацаанд хийж бүтээсэн ололт амжилт, сургамж, туршлагыг эргэн дүгнэж байна.

Энэ хугацаанд бид эрүүл мэндийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, дүн шинжилгээ, хэтийн тооцооллыг гүйцэтгэн, бодлого боловсруулагч, иргэдийг нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллээр ханган ажиллаж ирлээ.

Мөн салбарын мэдээллийн технологийн хөгжлийг дэмжих, цахим мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, салбарын цахим шилжилтийн үндэс суурийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Хүний нөөцийн хөгжлийн хүрээнд бид эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, сургалт эрхлэх байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн тогтолцоог сайжруулах чиглэлээр тасралтгүй ажиллаж байна.

Түүнчлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, магадлан итгэмжлэлийн бие даасан, хараат бус үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирлээ.

Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны үндэсний зохицуулалт, иргэдийн гадаад эмчилгээний бүртгэл, зөвлөгөө, мэдээлэл, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр ч тууштай ажиллаж байна.

Энэ ойн баярын өдөр үе үеийн удирдлага, хамт олон, ахмадууд, түнш байгууллагууд, эрдэмтэн судлаачид, эрүүл мэндийн салбарын нийт ажилтнуудад гүн талархал илэрхийлж байна. Та бүхний хичээл зүтгэл, хамтын ажиллагаа нь бидний үнэт зүйл юм.

Манай байгууллагын түүх бол хөгжлийн түүх, шинэчлэлийн түүх, хамтын итгэлийн түүх билээ.

Та бүхэнд 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ М.ОДГЭРЭЛ



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал М.Одгэрэл

ТОВЧИЛСОН ҮГ

АБЗХН	- Ажлын байрны зэрэглэл хөгжүүлэх нэгж
АНУ	- Америкийн нэгдсэн улс
АУ	- Анагаах ухаан
АУХ	- Анагаах ухааны хүрээлэн
АХБ	- Азийн хөгжлийн банк
АШУҮИС	- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БЗД	- Баянзүрх дүүрэг
БЗДХ	- Бэлгийн замаар дамжих халдвар
БНМАУ	- Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСУ	- Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	- Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БОЭТ	- Бүсийн Оношилгоо эмчилгээний төв
БСШУЯ	- Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ГССҮТ	- Гэмтэл, согог судлалын үндэсний төв
ДОХ	- Дархлалын олдмол хомсдол
ДЭМБ	- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЕБС	- Ерөнхий боловсролын сургууль
ЗГХА	- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
КОВИД – 19	- Коронавируст халдварын цар тахал
МАХН	- Монгол ардын хувьсгалт нам
МИЛА	- Магадлан итгэмжлэлийн алба
МННХ	- Монголын нээлттэй нийгэм хүрээлэн
МУБИС	- Монгол улсын боловсролын их сургууль
МУИС	- Монгол улсын их сургууль
МҮЭ	- Монголын үйлдвэрчний эвлэл
НБГ	- Нийслэлийн боловсролын газар
НДББ	- Номхон далайн баруун бүс
НҮБ	- Нэгдсэн Үндэстний байгууллага
ХАС	- Хүн амын сан
ХС	- Хүүхдийн сан
НҮЭМ	- Нөхөн үржихүйн эрүүл мэнд
НЭМҮТ	- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НЭМХ	- Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс
ОБЕГ	- Онцгой байдлын ерөнхий газар
ОХУ	- Оросын Холбооны Улс
ӨҮНҮЭМ	-Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд
ӨОУА	- Өвчний олон улсын ангилал

СнЗ	- Сайд нарын зөвлөл
ССБА	- Сургалт, судалгаа, боловсролын алба
ТББ	- Төрийн бус байгууллага
ТДСА	- Төгсөлтийн дараах сургалтын алба
ТССМА	- Тогтолцооны судалгаа, статистик мэдээллийн алба
УАЦГО	- Улсын ариун цэвэр, гэгээрлийн ордон
УГТЭ	- Улсын гуравдугаар төв эмнэлэг
УИХ	- Улсын их хурал
УНТЭ	- Улсын нэгдүгээр төв эмнэлэг
ХБНГУ	- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХДХВ/ДОХ/БЗДХ	- Хүний Дархлал Хомсдлын Вирус/Дархлалын Олдмол Хомсдол /Бэлгийн замаар дамжих халдвар
ХНХА	- Хүний нөөцийн хөгжлийн алба
ХӨСҮТ	- Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	- Хавдар судлалын үндэсний төв
ЧБА	- Чанарын баталгаажилтын алба
ШУТ	- Шинжлэх ухаан технологи
ЭАМДИ	- Эмнэлгийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институт
ЭАХНСҮТ	- Эрүүл ахуй халдвар нян судлалын үндэсний төв
ЭЗУ	- Эдийн засгийн ухаан
ЭМАССЗА	- Эрүүл мэндийн ажилтны сургалт судалгаа зөвшөөрлийн алба
ЭМБШХ	- Эрүүл мэндийн бодлогын шинжилгээний хэлтэс
ЭМГ	- Эрүүл мэндийн газар
ЭМДА	- Эрүүл мэндийг дэмжих алба
ЭМДХ	- Эрүүл мэндийг дэмжих хэлтэс
ЭМНХЯ	- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам
ЭМСБШХ	- Эрүүл мэндийн салбарын бодлогын шинжилгээний хэлтэс
ЭМСМА	- Эрүүл мэндийн статистик мэдээллийн алба
ЭМСХХ	- Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр
ЭМСЯ	- Эрүүл мэнд, спортын яам
ЭМС	- Эрүүл мэндийн сайд
ЭМУ	- Эрүүл мэндийн удирдлага
ЭМУМБТ	- Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв
ЭМУМТ	- Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв
ЭМХТ	- Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМХҮТ	- Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв
ЭМШУИС	- Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

САЛБАРЫН БАХАРХАЛ БИДНИЙ НЭГ



Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Анагаах ухааны доктор, профессор, академич

ЦЭРЭНДОРЖ **СОДНОМПИЛ**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийг үүсгэн байгуулах шинжлэх ухааны үндэслэл, хөгжлийн үзэл баримтлал, бүтэц, стратеги, санхүү, үйл ажиллагааны тогтолцоог боловсруулан, эрүүл мэндийн салбарын хөгжлийн шинэ институцийн үндэс суурийг тавьсан ба одоог хүртэл хөгжил дэвшлийн бүх шатанд нь хувь нэмрээ оруулж, байгууллагынхаа ирээдүйн хөгжлийн бодлогыг хамгаалан ажиллаж буй эрхэм зүтгэлтэн.

Ц.Содномпил нь Монгол улс, эрүүл мэндийн салбарт анх удаа хөгжлийн хөшүүрэг болох эмч, сувилагч, эм зүйч нарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох болон эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үзэл баримтлал, эрх зүйн өөрчлөлт бүрдүүлэн, үйл ажиллагааг эхлүүлсэн нь одоог хүртэл амжилттай үргэлжилж байна.




Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Анагаах ухааны доктор

САМДАН **ДУЛАМСҮРЭН**

Эрүүл мэндийн удирдлага, хүний нөөцийн хөгжил, магадлан итгэмжлэл, төгсөлтийн дараах сургалт, эрүүл мэндийн мэдээллийн шинэчлэлийн суурийг бүтээлцэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд өөрийн мэдлэг чадвараа харамгүй дайчлан төвийн хүний нөөцийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн, эрхэм удирдагч юм.

Улс эх орныхоо хөгжил дэвшил, эрүүл мэндийн салбарын түүхэн бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм хүмүүсийн хөдөлмөр, зүтгэл, манлайллыг онцлон хүргэж байна. Тэдний мэдлэг, ёс зүй, эх оронч сэтгэл, бүтээлч үйлс нь үе, үеийн залуу мэргэжилтнүүдэд үлгэр дуурайлал болж, эрүүл мэндийн салбарын хөгжилд тод мөрөө үлдээх болно.



Анагаах ухааны доктор

БАЯРМАГНАЙ **НАРАНТУЯА**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн байгууллагын чадавх, хөгжлийн суурийг бэхжүүлж, стратегийн хөгжил, үйл ажиллагааны үр нөлөөг өргөжүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн салбарын цахим хөгжлийг түүчээлэн, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ, чанар, аюулгүй байдал, хүний нөөцийн хөгжлийн шинэ хандлагыг төлөвшүүлэн, хамт олныг байгууллагын үнэт зүйл хэмээн эрхэмлэж, тэднийг манлайлан удирдаж, хамтын зорилгод нэгтгэн, итгэлийг нь хүлээсэн удирдагч юм.



Монгол Улсын Төрийн соёрхолт, Хүний гавьяат эмч

ПАНДААН **БАТЧУЛУУН**

Монгол улсад эрхтэн шилжүүлэн суулгах анагаах ухааны шинэ эрин үеийг эхлүүлж, үндэсний тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг боловсруулан, олон зуун хүний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах үйл хэрэгт амьдралаа зориулан Монголын анагаах ухааны түүхэнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны ололт амжилтыг дэлхийн түвшинд хүргэх их үйлсэд түүхэн хувь нэмэр оруулж буй нэрт мэс засалч, салбарын манлайлагч юм.





Hr.hdc.gov.mn

acc.hdc.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

1

БҮЛЭГ НЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ТҮҮХЭН ТОВЧООН



1313.mn

hinfo.mn

1.1. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС (1996-2026)

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн түүх нь нэг байгууллагын түүх төдийгүй эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл, мэдлэгт суурилсан ирээдүйг бүтээлцсэн хамтын хөдөлмөрийн түүх юм.

1996 - 1997 он
ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1996.10.04-ний өдрийн А/233 дугаар тушаалд тэмдэглэснээр "Анагаах ухааны үндэсний хүрээлэнгийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийн гүйцэтгэгчид, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийн "Эрүүл мэндийн статистик мэдээллийн төв"-ийг нэгтгэн Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны харьяа "Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв" болгон 1996.10.01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай" гэжээ.

1997 - 2000 он
ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, МЭДЭЭЛЭЛ, БОЛОВСРОЛЫН ТӨВ

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997.09.11-ний А/311 дүгээр тушаалаар Эмнэлэг гэгээрлийн ордонд үйл ажиллагаа явуулж байсан "Эрүүл мэндийн сургалтын арга зүйн төв"-ийг Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвтэй нэгтгэн Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв болгон ЭМНХЯ-ны харьяанд байгуулжээ.

2000 оны 6-12 сар
ҮНДЭСНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

ЭМНХ-ын сайдын 2000.06.29-ний өдрийн 193 дугаар тушаалаар Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийг 2000 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Үндэсний эрүүл мэндийн газар болгон шийдвэрлэжээ.

2000 - 2002 он
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Эрүүл мэндийн сайдын 2000.12.22-ны 106 дугаар тушаалаар "Үндэсний эрүүл мэндийн газар"-ыг "Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв" болгон өөрчлөн зохион байгуулж дүрмийг батлав.



Эрүүлийг хамгааллын удирдлагын эрдэм шинжилгээний төвийн захирал Б.Дэмбэрэл, эрдэмтдийн хамт



Эмнэлгийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийн Удирдах ажилтны анхны сургалт, 1993 он

2003 - 2004 он
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙГ УДИРДАХ ГАЗАР

Улсын Их Хурлын 2002 оны "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" 58 дугаар тогтоол, Засгийн газрын 2002 оны "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" 162 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2002.12.09-ний өдрийн 285 дугаар тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эмнэлгийн тусламжийг удирдах газар болгон зохион байгуулсан.

2005 - 2008 он
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоол, Засгийн газрын 2004 оны 236 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2005.01.24-ний өдрийн 11 дүгээр тушаалаар "Эмнэлгийн тусламжийг удирдах газар"-ыг "Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв" болгон зохион байгуулжээ.

2009 - 2012
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" 64 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2009.03.02-ны өдрийн 67 дугаар тушаалаар ЭМХҮТ-ийг ЗГХА-Эрүүл мэндийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан.

2012 оноос
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

Монгол Улсын Засгийн газрын 2012.09.22-ны өдрийн "Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай" 50, 2015 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 376 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2012.09.28-ны өдрийн 320 дугаар тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн төв болон өөрчлөн зохион байгуулагдан ажиллаж байна.



ЭМСАЗТ-ийн захирал Ч.Уртнасан мэргэжилтэн, зохиолчдын хамт 1996 он



Ариун цэвэр гэгээрлийн ордон болон, Эмнэлгийн ажилчдын соёлын ордны хамт олон

1.2. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХЭН ТОВЧООН (1996-2026)

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ 1996-1997 он

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1996.10.04-ний өдрийн А/233 дугаар тушаалаар "Анагаах ухааны үндэсний хүрээлэнгийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийн гүйцэтгэгчид, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийн "Эрүүл мэндийн статистик мэдээллийн төв"-ийг нэгтгэн Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвийг байгуулснаар өнөөдрийн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түүх эхэлсэн билээ.

Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвийн захирлаар Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Анагаах ухааны доктор (Ph.D), профессор Ц.Содномпил, дэд захирлаар П.Алтанхуяг нар томилогдож, Эрдэм шинжилгээний төслийн баг, Статистик мэдээллийн төв, Сургалтын алба, Санхүү хангамжийн алба, Эмч нарын байр гэсэн бүтэцтэйгээр 45 ажиллагсадтай ажиллаж эхэлжээ.

Тус төв нь эрүүл мэндийн удирдах ажилтанг бэлтгэх, давтан сургах, эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг судалж, салбарыг хөгжүүлэх загвар, чиглэл боловсруулах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг үнэн зөв мэдээ, мэдээллээр хангах, эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр сургалт, судалгаа, практик үйл ажиллагааг хэрэгжүүлж байв.





2. ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, МЭДЭЭЛЭЛ, БОЛОВСРОЛЫН ТӨВ 1997-2000 он

Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн захирлаар Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Анагаах ухааны доктор (Ph.D), профессор Ц.Содномпил, дэд захирлаар Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Анагаах ухааны доктор (Ph.D) С.Дуламсүрэн нар ажиллаж, Эрдмийн зөвлөл, Магадлан итгэмжлэх зөвлөл, Захиргааны зөвлөл, Сургалт, судалгаа, боловсролын алба, Статистик мэдээллийн алба, Магадлан итгэмжлэх алба, Нийтлэг үйлчилгээний алба, "ЭСС ТВ студи" гэсэн бүтэц, 85 орон тоотой ажиллажээ.

Эмнэлгийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор магадлан итгэмжлэх, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох цоо шинэ чиг үүргийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн нь Монгол улсад магадлан итгэмжлэл, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн анхдагч үндсийг тавьсан юм.

Зах зээлийн нөхцөлд ажиллах Эрүүл мэндийн удирдах ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, бүтцийг шинэ нөхцөлд боловсронгуй болгох судалгаа хийж зөвлөмж гаргах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, статистик мэдээллийг боловсронгуй болгох, эрүүл мэндийн байгууллагуудад удирдлагын арга барилыг сайжруулах асуудлаар зөвлөгөө өгөх ажлыг эрчимтэй хөгжүүлсэн үе байлаа.

Тус төвийн үйл ажиллагаа өргөжиж шинээр төгсөлтийн дараах сургалтыг нэгдсэн зохицуулалт, арга зүй, удирдлагаар хангах, нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө, стандартын дагуу зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндсэн чиг үүрэг бүхий *"Төгсөлтийн дараах сургалтын алба"* байгуулагдсан.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997.10.01-ний өдрийн А/311 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвийн бүтцэд ЭМНХЯ-ны харьяанд ажиллаж байсан Эрүүл мэндийн сургалт арга зүйн төвийг нэгтгэн "Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв" болгон өөрчлөн байгуулжээ.



ЭМХҮТ-ийн захирал Ц.Содномпил, төвийн хамт олон 2000 он

3. ҮНДЭСНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР 2000 он

ЭМНХ-ын сайдын 2000.06.29-ний өдрийн 193 дугаар тушаалаар Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийг Үндэсний эрүүл мэндийн газар болгон өөрчлөхөөр шийдвэрлэжээ.

Тушаалд зааснаар эрүүл мэндийн үндэсний бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах "Үндэсний эрүүл мэндийн газар"-ыг 2000.07.01-ний өдрөөс байгуулан, даргаар Ц.Содномпил, орлогч даргаар С.Дуламсүрэнг томилжээ.

2000 оны УИХ-ын сонгуулиар Засгийн газар шинээр байгуулагдаж энэхүү шийдвэр хэрэгжээгүй.

4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ 2000-2002 он

ЭМХҮТ-ийн Захирлаар С.Дуламсүрэн, Дэд захирлаар С.Гансүх нар томилогдож, Анагаах ухааны боловсролын болон Магадлан итгэмжлэлийн зөвлөл, Төгсөлтийн дараах сургалт, Магадлан итгэмжлэл, Статистик мэдээлэл, Эрүүл мэндийн удирдлага, Эрүүл мэндийг дэмжих, Захиргаа, үйлчилгээний алба гэсэн бүтэц, 95 орон тоотой байсан.

Төгсөлтийн дараах сургалтын албанд Эмч нарын байр, Эрүүл мэндийг дэмжих албанд "ЭСС" ТВ студи харьяалагдан, Магадлан итгэмжлэлийн алба нь Акредитацийн тасаг, Лицензийн тасагтайгаар үйл ажиллагаагаа явуулж байв.

5. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙГ УДИРДАХ ГАЗАР 2003-2004 он

Эрүүл мэндийн тусламжийн бодлогыг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар хүн амыг эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тусламж, үйлчилгээгээр тасралтгүй хангах үйл ажиллагааг зохион байгуулах эрхэм зорилгыг дэвшүүлж, Эмнэлгийн тусламжийг удирдах газар нь:

- Эрүүл мэндийн эдийн засаг, санхүү, технологи;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар;
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил;
- Эм зүй, эм ханган нийлүүлэлт, бүртгэл мэдээлэл;
- Эрүүл мэндийн статистик мэдээлэл;
- Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тэргүүлэх чиглэлээ болгожээ.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой эрүүл мэндийн байгууллага, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалт,

> *Эрүүл мэндийн сайдын 2000.12.22-ны өдрийн 106 дугаар тушаалаар "Үндэсний эрүүл мэндийн газар"-ыг "Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв" болгон өөрчлөн зохион байгуулж, эрүүл мэндийн удирдлагыг боловсронгуй болгох, хүн амын эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, эмнэлгийн байгууллагыг магадлан итгэмжлэх, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагад эрх олгох, удирдлагаар хангаж зохицуулах, дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байсан байна.*

техник хангамжийг зохион байгуулах чиг үүрэг бүхий Эдийн засаг, технологийн;

Эмгэг судлалын шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах чиг үүрэг бүхий Эмгэг судлалын;

Эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд зайлшгүй шаардлагатай эмийн тасралтгүй хангамжийг зохицуулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх асуудлыг зохион байгуулах Эм зүйн;

Эмнэлгийн барилгын захиалга хийх чиг үүрэг бүхий Барилга захиалагчийн товчоо зэрэг өмнө байгаагүй шинэ алба, нэгж нэмэгдсэн байна.

ЭТУГ-ын бүтцэд:

- Эрүүл мэндийн сайдын 2002.12.20-ны өдрийн 303 дугаар тушаалаар Эрүүл мэндийн улсын хяналтын албанаас Эмийн мэдээллийн төв /2/, эмчилгээний болон эмийн чанарын хяналтын лаборатори /13/, эмчилгээний чанарын хяналт /2/;
- Засгийн газрын 2002 оны 162 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2003.01.03-ны өдрийн 1 дүгээр тушаалаар Эмгэг судлал, шүүх эмнэлгийн төвөөс 47 орон тоотой бүтцийн нэгж;
- Эрүүл мэндийн сайдын 2004.04.08-ны өдрийн 81 дүгээр тушаалаар Нийслэлийн яаралтай тусламжийн төвөөс Алсын түргэн тусламжийн үйлчилгээ тус тус шилжиж ирсэн байна.

ЗГХА-ЭТУГ нь ЭМЯ-ны Анагаах ухааны боловсролын зөвлөл, Тусгай зөвшөөрлийн зөвлөлийн ажлын алба, Захиргаа үйлчилгээ, Эдийн засаг, технологийн алба түүний дор Барилга захилагчийн товчоо, Чанарын баталгаажилт, Эмгэг судлал, Хүний нөөцийн хөгжил, Төгсөлтийн дараах сургалтын алба түүний дор Эмч нарын дотуур байр, Эм зүй, Статистик мэдээлэл, Эрүүл мэндийг дэмжих алба түүний дор "ЭСС"ТВ студи гэсэн бүтэц, 172 орон тоотой ажиллаж байжээ.



Ч.Батсайхан даргатай Эмгэг судлалын албаны хамт олон

ЗГХА-ЭТУГ-ын Даргаар С.Дуламсүрэн, Дэд даргаар Ц.Нацагдорж, С.Гансүх, менежер Ц.Бовийшарав, Ж.Алтантуяа, Л.Жигжидсүрэн, Ч.Батсайхан, Я.Буянжаргал, Ш.Оюунбилэг, Л.Оюунчимэг, С.Өлзийсайхан, В.Лхагвадорж, Д.Нямхорол, Д.Жаргалсайхан нар албадын даргаар, н.Чулуунбат, Г.Алтанцэцэг, Ю.Дамбадорж нар нэгжийн даргаар ажиллаж байжээ.

ЭТУГ нь бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны цар хүрээ, Засгийн газрын бүтцэд эзлэх байр суурираа төвийн 30 жилийн түүхэн хөгжлийн оргил үе байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Эрүүл мэндийн яамны харьяа Клиникийн нэгдсэн эмнэлэг, нарийн мэргэжлийн төв зэрэг 16 байгууллага нь ЭТУГ-тай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээтэй ажиллаж удирдамж чиглэл авч ажилладаг байсан.

Мөн эрүүл мэндийн салбарыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх, эмийн бүртгэл, мэдээллийг сайжруулж зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж үндэсний түвшинд үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлсэн онцлог үе байжээ.

> *“Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоол, Засгийн газрын 2004 оны 236 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2005.01.24-ний өдрийн 11 дүгээр тушаалаар “Эмнэлгийн тусламжийг удирдах газар” нь “Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв” болсон.”*

6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ 2005-2008 он

Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд эрүүл мэндийн салбарын хөгжлийн асуудлаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий мэргэжлийн төв байгууллага болсон юм.

Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв нь 2005-2007, 2007-2009 онуудад 2 өөр бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байдаг.



ЭМХҮТ-ийн хамт олон, 2007 он

2005-2007 онуудад Захиргааны зөвлөл, Эрүүл мэндийн удирдлага, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл сургалтын албанд Эмч нарын байр, Магадлан итгэмжлэл, Статистик мэдээлэл, Эрүүл мэндийг дэмжих албанд–ЭССТВ студи, Захиргааны алба гэсэн бүтэц, 76

орон тоотой, Захирлаар С.Дуламсүрэн, Дэд захирлаар С.Гансүх нар ажиллаж байлаа.

Эрүүл мэндийн сайдын 2005.01.18-ны өдрийн 09 дүгээр тушаалаар Ажлын байрны зэрэглэл хөгжүүлэх нэгжийг ЭМСХ-2 төслийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтний байршлыг зохицуулах, орон тооны илүүдэлтэй мэргэжилтнийг ажлын байраар хангахад зуучлах зорилготой 3 орон тоотой байгуулж, нэгжийн ахлагчаар С.Лхагвасүрэн ажиллаж байв.

Эрүүл мэндийн сайдын 2007.03.20-ны өдрийн 67 дугаар тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж, Захирлаар Ц.Содномпил, Дэд захирлаар С.Дуламсүрэн нарыг томилсон байна.

Энэхүү бүтцээр Захиргааны зөвлөл, Эрүүл мэнд, санхүүгийн удирдлагын, Статистик мэдээллийн, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл, сургалтын, Магадлан итгэмжлэлийн, Эрүүл мэндийг дэмжих, Эмийн бүртгэл, мэдээллийн, Санхүү, үйлчилгээний алба болон Захиргааны нэгжтэй, 92 орон тоотой ажилласан байна.

Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв нь эрүүл мэнд, санхүүгийн удирдлага, мэдээллийг боловсронгуй болгох, эрүүл мэндийн хүний нөөцийг хөгжүүлэх, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааг баталгаажуулах, эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого, түүний хэрэгжилт, техник үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байсан.

Эмийн тухай хуулийг хэрэгжүүлж эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бүртгэл мэдээллийг сайжруулахад чиглэгдэж Эмийн бүртгэлийн хэлтэс анх удаа тус төвийн бүтцийн нэгжид байгуулагдсан юм.

7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР 2009-2012 он

ЗГХА-ЭМГ нь эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хүний нөөцийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй хөгжлийг хангах, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааны баталгаажилтыг сайжруулах, эрүүл мэндийн статистик мэдээлэл, мэдээллийн технологийг сайжруулах, телемедицин-алсын зайн оношлогоо, эмчилгээг хөгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанарын бодлогыг хэрэгжүүлэх, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тусгай зөвшөөрөл, бүртгэлийн асуудлыг боловсронгуй болгох зэрэг зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна.

> *Эрүүл мэндийн сайдын 2010 оны 151 дүгээр тушаалаар "Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар"-ыг баталж, Эрүүл мэндийн салбарын бодлогын шинжилгээ, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэл, Эрүүл мэндийг дэмжих, Эрүүл мэндийн ажилтны сургалт, судалгаа, зөвшөөрөл, Эмийн бүртгэл баталгаажуулалт, Зайн анагаах ухааны хөгжил, Захиргаа, санхүүгийн хэлтэстэй ажилласан.*



Ш.Энхбат даргатай ЗГХА-ЭМГ-ын хамт олон

Агентлагийн даргаар Эрүүлийн хамгаалахын гавьяат ажилтан, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор (Sc.D), Эрүүл мэндийн дэд сайд асан Ш.Энхбат, Эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч даргаар Ц.Хун, Эмийн асуудал хариуцсан орлогч даргаар Эм зүйн ухааны доктор М.Уранчимэг нар ажиллажээ.

Эмнэлгийн технологи, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Сэвжид, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга Ш.Баттөр, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга Л.Оюун, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтсийн дарга Д.Баярмаа, Эрүүл мэндийн статистикийн хэлтсийн дарга Д.Нямхорол, Эмийн зохицуулалтын хэлтсийн дарга Д.Оюунтуяа, Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Д.Жаргалмөнх нар ажиллаж байсан бөгөөд Эмнэлгийн тусламжийн хэлтэс нь Телемедициний үндэсний сүлжээний төвийн дарга Ч.Бат-Эрдэнэ, Түргэн тусламжийн үндэсний сүлжээний төвийн даргаар Ө.Баяр нар ажиллаж байсан.



ЗГХА-ЭМГ-ын хамт олон 2009-2010 он



Ш.Энхбат даргатай ЗГХА-ЭМГ-ын Удирдлагын зөвлөл, 2011 он

8. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ 2012 оноос

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай” 50, 2015 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 376 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн хөгжлийн төв” болон өөрчлөн зохион байгуулагдсан.

2012 оноос Ерөнхий захирлаар Ч.Бат-Эрдэнэ, Б.Нарантуяа, Э.Содномжамц, Д.Ганцэцэг, Захирлаар Б.Нарантуяа нар ажиллаж байлаа.

Эрүүл мэнд, спортын сайдын 2014 оны 357 дугаар тушаалаар “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн алба”;

Эрүүл мэндийн сайдын 2018.03.01-ний өдрийн “ЭМХТ-ийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай” А/70 дугаар тушаалаар тус төвийн бүтцэд “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба”;

Эрүүл мэндийн сайдын 2021.01.20-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Дуудлага зохицуулах алба”;


Эрүүл мэндийн сайдын 2024.03.05-ны өдрийн “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/113 дугаар тушаалаар “Мэдээлэл технологийн алба”

Эрүүл мэндийн сайдын 2025.02.06-ны өдрийн А/38 дугаар тушаалаар “Гадаад эмчилгээг зохицуулах алба” тус тус байгуулагдсан.

2025 оны 5 дугаар сараас Их өгөгдөл судалгааны алба, Цахим хөгжлийн алба, Хүний нөөцийн хөгжлийн алба, Тусламж үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн, Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах, Гадаад эмчилгээг зохицуулах, Хяналт-шинжилгээ, үнэлгээний, Захиргааны болон Санхүүгийн алба гэсэн бүтцийн нэгжтэй, 88 орон тоотой үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа ба төвийн Захирлаар АУ-ны магистр М.Одгэрэл ажиллаж байна.



ЭМХТ-ийн хамт олон, 2013 он





Eburtgel.hdc.gov.mn

STATA

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

2

БҮЛЭГ ХОЁР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖИЛД БИДНИЙ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

(Анхдагч шинэлэг үйл ажиллагаа)



sudalgaa.1313.mn

ds.hdcgov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

ТУС ТӨВ НЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУДЫГ НЭВТРҮҮЛЖЭЭ.

1996-2006 он:

- MNSYS програм хангамжийг нэвтрүүлж, статистикийн цахим бүртгэлийг эхлүүлэв.
- Монгол улсад Өвчний олон улсын 10 дахь ангиллыг (ICD-10) нэвтрүүлж, хүн амын өвчлөл, нас баралтыг олон улсын жишигт нийцүүлэн бүртгэж, тайлагнадаг болов.
- Сар тутмын "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл" эмхэтгэлийг эрхлэн гаргаж мэдээлэл хэрэглэгчдэд хүргэдэг болов.
- "Эрүүл мэндийн үзүүлэлт" ном анх хэвлэгдэж эхэлсэн. .

Сар тутмын "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл" эмхэтгэл болон жил бүрийн "Эрүүл мэндийн үзүүлэлт" статистикийн эмхэтгэлийг тогтмол эрхлэн хэвлүүлж эхэлсэн нь эрүүл мэндийн салбарын мэдээллийг нэгтгэн түгээх, бодлого, төлөвлөлт, судалгаа, шинжилгээний мэдээллийн үндсэн эх сурвалж болох суурийг тавьсан.

1997- 2000 он:

- MED-INFO программ нэвтэрч, Улаанбаатар хотын гуравдагч шатлалын эмнэлгүүдэд компьютерийн анхан шатны сургалтыг зохион байгуулав.
- ЭМЯ, ЭМХТ-ийн Статистик мэдээллийн алба, аймаг, нийслэлийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийг компьютержүүлэв.
- ЭМЯ болон ЭМХТ хооронд дотоод сүлжээ байгуулж, интернет, цахим шуудан, веб хуудсыг тасралтгүй ашиглах болов.

2001- 2006 он

- "Эрүүл мэндийн үзүүлэлт" номыг англи хэл дээр эрхлэн гаргадаг болов. Ийнхүү "Эрүүл мэндийн үзүүлэлт" номыг жил бүр монгол, англи хэлээр гаргадаг болсон нь Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлтийг бусад улс орон, олон улсын байгууллагууд ашиглах, хэрэглэх боломжийг бүрдүүлсэн.
- Бүх аймгийн Эрүүл мэндийн газрын Статистикийн алба тайлан мэдээгээ цахим шуудангаар дамжуулж эхлэв.
- H-INFO стандарт программыг нэвтрүүлж, Эрүүл мэндийн статистикийн мэдээ тайланг өнөөг хүртэл гаргаж байна. Өнөөдөр H-Info 3.0 програм хангамжид нийт 6000 гаруй хэрэглэгч хандалт хийж мэдээллийн сан үүсгэж байна. Үндэсний дата төвд серверийг байршуулан мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байгаа нь мэдээллийн тасралтгүй байдлыг хангах гол тулгуур болж байна.

2001 он

- Эмнэлгийн мэргэжилтний бүртгэлийн цахим сантай болов. Лицензийн албаны үйл ажиллагааг цахимжуулж мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтний бүртгэлийн цахим санг бий болгох эхлэлийг тавьсан.

2009 он

- Magic test 2009 програм хангамжийн бүртгэлийн хэсэг нь бүрэн ашиглагдаж байгаа ба 9000 гаруй сорилын сантай. 2009 оноос хойш цахимаар шалгалт авч эхэлсэн.

2010 он

- “Телемедициний үйлчилгээг зохицуулах алба” байгуулагдав.
- Дуу, дүрсний дамжуулалт нь тусдаа тоног төхөөрөмжүүдийг ДЭМБ-ын санхүүжилтээр ЭМЯ, ЗГХА-ЭМГ (ЭМХТ), УНТЭ, УГТЭ, ГССЭҮТ, УХТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, АӨСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ, ЗӨСҮТ, 4 БОЭТ-д суурилуулж, алсын зайнаас зөвлөгөө өгөх үйлчилгээг эхлүүлсэн.

2012 он

- АХБ-ны ЭМСХХ-3 төслийн хүрээнд Архангай, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг болон нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэгт Телемедициний үйлчилгээ буюу алсын зайн оношилгоо, эмчилгээ, сургалт сурталчилгааг зохион байгуулахаар тоног төхөөрөмж суурилуулсан нь өндөр чанарын видео холболтоор алсын зайнаас зөвлөгөө өгөх, сургалт хийх боломж бүрдэж RealTime-Telemedicine үйлчилгээний эхлэл болсон.

2013 он

- АХБ-ны “Санхүүгийн хямралын үед ядуу иргэдийн эрүүл мэндийг хамгаалах” JFPR 9136-MON төслийн хүрээнд Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж (RealTime-Telemedicine) -ийг суурилуулж сүлжээний холболтыг сайжруулсан.
- Телемедициний сүлжээ өргөжиж, тусгай мэргэжлийн 8 төв, 3 төв эмнэлэг, 4 бүсийн оношилгоо эмчилгээний төв, 17 аймгийн Нэгдсэн эмнэлэг, нийслэлийн 2 дүүргийн Нэгдсэн эмнэлгийг тус тус холбосон.
- Төгсөлтийн дараах сургалтын албаны үйл ажиллагааг цахимжуулах нэгдсэн програм хангамж нь эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн сантай, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийн мэдээллүүд хөтлөгдөж цахим шалгалт авах, үнэт

Эрүүл мэндийн статистикийн бүртгэл, мэдээлэл, Цахим эрүүл мэндийн чиглэлээр

цаасан дээр мэдээний сангаас гэрчилгээ хэвлэх, тайлан мэдээ боловсруулах боломжтой болов.

Эрүүл мэндийн статистикийн бүртгэл, мэдээлэл, Цахим эрүүл мэндийн чиглэлээр

2014 он

- АХБ-ны санхүүжилтээр ЭМЯ-ны харьяа 16 байгууллагыг холбож нийт 41 эрүүл мэндийн байгууллага телемедициний үйлчилгээг ашиглаж эхэлсэн. Үүний 12 байгууллага нь Panasonic загварын 4-10 хэрэглэгч нэгэн зэрэг холбох хүчин чадалтай тоног төхөөрөмж, 19 байгууллага нь Lifesize загварын 4 хэрэглэгч холбох хүчин чадал бүхий тоног төхөөрөмж, ЭМХТ-д нэгдсэн холболт хийх LIFESIZE MULTIPOINT сүлжээний төхөөрөмжтэй бөгөөд нийт 20 газрыг зэрэг холбох хүчин чадалтай, телемедициний үйлчилгээний бичлэг хийж архивлах Lifesize server 2200 төхөөрөмжийг тус тус ашигласан.
- Телемедицин ашиглан алсын зайнаас анх удаа хагалгааг удирдан амжилттай зохион байгуулж 3-р шатлалын эрүүл мэндийн байгууллагаас өдөр бүр тогтмол зөвлөгөө авах, өвчтөн хянуулах, сургалт хийх, хурал зохион байгуулах үйл ажиллагааг хэвшүүлэн орон нутгаас Улаанбаатар хотод ирж эмчлүүлэх шаардлагагүй тохиолдлуудыг багасгаж иргэнээс гарах зардал, цаг хугацааг хэмнэж, эрүүл мэндийн байгууллагын хүлээгдлийг бууруулж тусламж үйлчилгээний чанарыг сайжруулсан.
- H-Info 3.0 хувилбарыг ДЭМБ-ын санхүүжилтээр хөгжүүлэн эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө мэдээллээ цахимаар оруулах боломж бүрдсэн. Ингэснээр мэдээлэл дамжуулах хугацаа богиносож, тайлагналтын шуурхай, үнэн зөв байдал эрс сайжирсан. Цаашлаад уг системийг эрүүл мэндийн бусад цахим платформуудтай холбон хөгжүүлснээр мэдээлэл солилцох, эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэл үүсгэх, сарын статистик мэдээг автомат байдлаар нэгтгэн боловсруулах зэрэг олон шинэ боломжийг бий болгожээ.
- ICD-10-ын дөрөв дэх тэмдэглэгээний түвшний ангиллыг нэвтрүүлснээр өвчлөл, нас баралтын шалтгааныг илүү нарийвчлалтай бүртгэх боломж бүрдэж, эрүүл мэндийн статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв байдал мэдэгдэхүйц сайжирсан.
- “Улирал тутмын статистик мэдээлэл”-д аймаг, бүсийн түвшинд статистикийн тайлан боловсруулж эхэлснээр эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг газарзүйн байршил болон улирлын онцлогтой уялдуулан харьцуулах, дүн шинжилгээ хийх боломж нэмэгдсэн.

2016 он

- Шилэн кабелын өндөр хурдны интернет сүлжээг үүсгэн 14 аймгийн Нэгдсэн эмнэлэг, ЭМХТ, ХСҮТ-ийг холбосноор тус сүлжээгээр дамжуулан мэдээлэл илгээх боломж бүрдэж мэдээллийн аюулгүй байдал хангагдан хэрэглээ нэмэгдсэн. Тус сүлжээг ашиглан видео зөвлөгөө, документ дамжуулалт, алсын зайн хяналт, алсын зайн хагалгааг удирдан явуулах, сургалт, хурал зөвлөгөөн гэх зэрэг олон үйлчилгээг үзүүлсэн.

2017 он

- H-Info 3.0 программ хангамжийн зохиогчийн эрхийг авлаа. H-Info 3.0 програм хангамжийн зохиогчийн эрхийн 8743 дугаартай гэрчилгээг "Оюуны өмч улсын бүртгэлийн газар"-ын Зохиогчийн эрхийн бүртгэлийн газраас авсан нь Эрүүл мэндийн салбарын түүхэнд анхдагч тохиолдол боллоо.
- ICD кодлолтын сургалт: Люксембургийн "Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил МОН/005" төслийн дэмжлэгтэйгээр нийт 513 эмч, мэргэжилтэн, сувилагчийг ICD-10 ангиллын сургалтад хамруулсан. Жил бүр 21 аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад энэхүү сургалтыг тогтмол зохион байгуулж, 2020 оноос COVID-19-ийн тохиолдол, оношлогоо, нас баралтыг зөв кодлох чиглэлийн гарын авлагыг мэргэжилтнүүдэд хүргэсэн.
- "Бүртгэл мэдээллийн ажилтан" мэргэшлийн сургалтыг жилд 2 удаа зохион байгуулж, өнөөг хүртэл нийт 156 мэргэшсэн ажилтныг бэлтгэсэн. Сургалтад 5 модулийн хүрээнд эрүүл мэндийн статистик тайлан мэдээ цуглуулах, боловсруулах, дамжуулах, мэдээллийн чанарыг хангах чадварыг эзэмшүүлж байна.

2019 он

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын Номхон далайн баруун бүсийн Дүүргийн эрүүл мэндийн мэдээллийн систем (DHIS2)-д Монгол улс нийт 109 үзүүлэлтийг олон улсын аргачлалын дагуу тооцоолж, мэдээллийн санд оруулсан. Үүнд Тогтвортой хөгжлийн зорилтын (SDG) 30, SDG-ийн үндсэн 24, Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын (UHC) 47, хүн ам зүйн 8 үзүүлэлт багтсан.
- 2019 оны 5 дугаар сард ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн төвөөс гишүүн орнуудын ирүүлсэн мэдээлэлд хяналт, баталгаажуулалт хийж, Монгол улсын үзүүлэлтүүдийг үнэлэн бүсийн албан ёсны эмхэтгэлд хэвлэн нийтэлсэн нь үндэсний эрүүл мэндийн статистикийн мэдээллийн чанар, найдвартай байдал олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэх чухал үйл явдал болсон юм.

Эрүүл мэндийн статистикийн бүртгэл, мэдээлэл, Цахим эрүүл мэндийн чиглэлээр

Эрүүл мэндийн статистикийн бүртгэл, мэдээлэл, Цахим эрүүл мэндийн чиглэлээр

- ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн албан тайланд (Y.C.Chong, 2003) Монгол улсын эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог ижил түвшний улс орнуудтай харьцуулахад мэдээний хамрах хүрээ, стандартчилал, мэдээллийн агуулга, шуурхай байдлын үзүүлэлтээр давуу хөгжсөн хэмээн үнэлсэн байдаг.
- H-INFO3.0 системд UNICEF-ын санхүүжилтээр бүрэн шинэчлэл хийж нэвтрүүлсэн. Эрүүл мэндийн цахим системүүдтэй мэдээлэл солилцоог шинэчлэн Эрүүл мэндийн статистик мэдээллийг задгай хэлбэрээр авч боловсруулалт хийснээр мэдээллийн чанарыг нэмэгдүүлсэн.

2020 он

- Монгол улсад эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулан "Эрүүл мэндийн үзүүлэлт" жилийн эмхэтгэлд анхны бүртгэлийн үеэс өнөөг хүртэлх статистик мэдээллийг харьцуулан нэгтгэсэн.

2021 он

- Сар тутмын "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл" эмхэтгэл бүтэц, агуулгын хувьд шинэчлэгдэн сүүлийн 10 жилийн мэдээллийг график, дүрслэлтэйгээр харуулдаг болсон. Жирэмсний хяналт, үр хөндөлт, халдварт өвчний талаарх мэдээллийг нэмсэнээр хүн амын өвчлөл, төрөлт, нас баралтын тархвар зүйн шилжилтийн чиг хандлагыг цогцоор нь ажиглах боломжийг бүрдүүлсэн.

2022 он

- "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл" 4 боть эмхэтгэлийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд нээлттэй байршуулж эхэлсэн.
- 1313.mn — Нээлттэй мэдээллийн платформ цахим хуудас нээсэн ба энэхүү хуудсыг Tableau дашборд программаар ажиллуулж, 28 төрлийн мэдээллийг нийтэд нээлттэй болгосон. 2000–2021 оны 8 бүлэг, 66 мэдээллийг интерактив хэлбэрт оруулсан энэхүү платформ ikon.mn, gogo.mn, medee.mn зэрэг мэдээллийн хэрэгслүүдийн эх сурвалж болж, иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл хүрэх хүртээмжийг өргөжүүлжээ.
- H-IINFO 3.0-ийн веб хувилбарыг хөгжүүлэн ашиглаж эхэлсэн. Улсын бүртгэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар, Үндэсний дата төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, И-Монгол зэрэг төрийн мэдээллийн системүүдтэй мэдээлэл солилцох боломж өргөжсөн.

2019 - 2026 он

- Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд доорхи программ хангамжуудыг хөгжүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлэв. Үүнд:

- Сул ажлын байрны бүртгэл;
- Телемедициний бүртгэл;
- Эрүүл мэндийн ололт амжилт, алдаа зөрчлийн мэдээний сан;
- Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны програм;
- Эмнэлзүйн удирдамж, зааврын мэдээний сан.
- Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан, Цахим шалгалт
- Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн систем
- H-INFO программын вэб хувилбар
- Ковидын нэгдсэн удирдлага, хяналтын дэд систем
- 1313.mn программ
- Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээний цагаан дэвтрийн цахимжилт

2020 - 2026 он

- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтолцоог сайжруулах зорилгоор “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан”-г үүсгэсэн. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн байдалд дүн шинжилгээ, судалгаа хийх, тайлан, боловсруулалт цахимжиж удирдлагыг мэдээллээр хангах, эрүүл мэндийн бусад системүүдтэй мэдээлэл солилцох боломжтой болсон.
- Сантай болсноор цахим шалгалт зохион байгуулах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, зэрэг олгох, хянах, тайлан мэдээлэл гаргах, сул ажлын байрны мэдээлэл бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаанууд цахимаар хийгдэж байна.

2024 он

- Засгийн газрын 2024.03.06-ны өдрийн 100 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам” батлагдан хэрэгжиж эхэлсэн.
- Эрүүл мэндийн сайдын 2024.03.05-ны өдрийн А/113 дугаар тушаалаар Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон иргэдийг нотолгоонд суурилсан үнэн, зөв мэдээллээр хангах зорилгоор төвийн бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулан “Мэдээлэл, технологийн алба” -ыг байгуулсан.

2021-2026 он

- Эрүүл мэндийн ажилчдыг зайнаас сургах интерактив сургалтыг зохион байгуулах зорилгоор Зайн сургалтын платформ хөгжүүлэгдэж 4465 хэрэглэгчдэд 19 бүлэг хичээлийг цахимаар хүргэн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, багц цаг олгох үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн статистикийн бүртгэл, мэдээлэл, Цахим эрүүл мэндийн чиглэлээр

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОГТОЛЦОО, БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1994-2000 он:

- Энэ үед эрүүл мэндийн салбарын бодлого, эрх зүйн орчныг өөрчлөхөд нотолгоо болсон судалгаанууд хийгдсэн байдаг.
- Хамгийн олон эрдэм шинжилгээний бүтээлийг Шинжлэх ухааны бүтээлийн фондод хүлээлгэн өгсөн.
- Нийт 50 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэснээс 62 хувь нь бодлого, тогтолцооны судалгаа, 38 хувь нь байгууллага, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, хүн амын зан үйлтэй холбоотой судалгаанууд хийгдсэн байна.
- Тухайлбал, МУ-ын ЗГ-ын 1998 оны 130-р тогтоолоор батлагдсан “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал” Үндэсний хөтөлбөрийн үндэслэл судалгаа; халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр болон Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн шинэчилсэн найруулгын үндэслэл судалгаа; Монгол улсад гериатрын анхны кабинет байгуулагдахад лавлагаа материал болсон судалгаанууд дурдаж болох юм.

1997 он:

- Эрүүл мэндийн эрдэм шинжилгээний төсөл боловсруулах Үндэсний сургагч багш анх удаа бэлтгэсэн.

2001-2006 он:

- Эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн боловсрол олгох МСС-ны чиглэлээр түлхүү судалсан.
- Нийт 60 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэснээс 69.2 хувь нь бодлого, тогтолцооны судалгаа, 30.8 хувь нь байгууллага, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, хүн амын зан үйлтэй холбоотой судалгаанууд хийгдсэн байна.
- Энэ хугацаанд 2004 онд батлагдсан Эмч, эмнэлгийн мэргэжилтний АБТ-ын үлгэрчилсэн загварын үндэслэл судалгаа; эмч, эмнэлгийн мэргэжилтний цалин, нэмэгдэл хөлс тооцох журмын үндэслэл судалгаа; 2003 онд эрүүл мэндийн салбарын Хүний нөөцийн хөгжлийн бодлогын үндэслэл судалгаа; төгсөлтийн дараах сургалтын үнэлгээ, хэрэгцээний нотолгоо болсон судалгаа; Монгол улсын өсвөр үеийн эрүүл мэндийн үйлчилгээний стандартын үндэслэл болсон томоохон судалгаанууд хийгдсэн.

2000 он:

- “Судалгааны арга зүй”, “Төслийн удирдлага” сэдвээр богино хугацааны сургалтууд зохион байгуулж эхэлсэн.

2007-2011 он:

- Бодлогын судалгаа, шинжилгээ хийх бие даасан нэгжтэй болсон.

- Төрийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагуудын захиалгаар түлхүү судалгаа хийгдсэн.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эдийн засаг санхүү, шинжлэх ухаан, технологийн чиглэлээрх судалгаанууд хийгдсэн байна.
- Энэ хугацаанд нийт 40 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэснээс 80.6 хувь нь бодлого, тогтолцооны судалгаа, 19.4 хувь нь байгууллага, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, хүн амын зан үйлтэй холбоотой судалгаанууд хийгдсэн байна.
- Томоохон судалгаануудыг дурдвал, Эрүүл мэндийн технологийн талаар төрөөс баримтлах бодлогын үндэслэл болсон судалгаа; Эрүүл мэндийн боловсролын талаар 2010-2015 онд баримтлах стратегийн үндэслэл судалгаа; Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх МСС-ны үндэсний стратегийн үндэслэл судалгаа зэргийг дурдаж болох юм.

2007-2008 он:

- "Эрүүл монгол хүн" Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх судалгаа, аргачлал алгоритм, гарын авлага гарсан.

2007-2009 он:

- Эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийх ажил эхэлж, клиникийн 9 технологид хийгдсэн үнэлгээний тайлан үр дүнг Шинжлэх ухаан, технологийн санд хүлээлгэн өгсөн.

2012-2016 он:

- Энэ хугацаанд нийт 50 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэснээс 93.7 хувь нь бодлого, тогтолцооны судалгаа, 6.3 хувь нь байгууллага, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, хүн амын зан үйлтэй холбоотой судалгаанууд хийгдсэн байна.
- Энэ үед илүү эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, тоног төхөөрөмж, төр хувийн хэвшлийн түншлэл, эрүүл мэндийн эдийн засаг чиглэл зэрэг өргөн хүрээгээр судалгаа, шинжилгээ түлхүү хийгдсэн байдаг.
- "Гадаадад эмчлүүлэгчийн судалгаа", "Орны ашиглалт, хэрэгцээ", "Эрүүл мэндийн ажилтныг хариуцлагын даатгалд хамруулах эрсдэлийн үнэлгээ" зэрэг судалгаа нь эмнэлгийн тусламжийг сайжруулах бодлого, шийдвэрийн үнэслэл болсон байдаг.

2013 он:

- ЭМХТ-ийн "Бүтээлийн товчоон" анх удаа эмхэтгэн гарсан.
- Эрүүл мэндийн байгууллагын оношлогоо хий "Байгууллагын оношлогоо"-ны аргачлал анх удаа боловсруулж, нэвтэрсэн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОГТОЛЦОО, БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2017-2026 он:

- Энэ үе ЭМХТ-ийн мэргэжилтнүүдийн өөрсдийн санаачлагаар судалгаанууд хийгдсэнээрээ онцлогтой.
- Нийт 80 гаруй судалгааны ажил хийж гүйцэтгэсэн ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүлээгдэл, хэрэглэгчийн үнэлгээ, эм, тоног төхөөрөмж, багц цагийн бүрдэлт, донор зэрэг чиглэлээр түлхүү анхаарч ажилласан.
- "Эмнэлгүүдийн сүүлийн 10 жилийн ор ашиглалтад хийгдсэн дүн шинжилгээ", "Магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдал" судалгаа, нас баралтын статистикийн мэдээллийн чанарыг сайжруулахад нотолгоо болсон "Хүн амын нас баралтын бүртгэл, мэдээллийн чанарын (ANACONDA) үнэлгээ", халдварт бус өвчний наса баралтын хэтийн төлөвийг тооцоолж, үр дүнг НҮБ-д тайлагнасан судалгаа зэрэг бодлогын шийдвэр гаргахад үндэслэл болсон томоохон судалгаанууд хийгдсэн байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ ЧИГЛЭЛЭЭР

2003 он

- Эрүүл мэндийн үндэсний тооцооны хамрах хүрээ, ангиллыг батлуулсан.

2005 он

- Монгол улсын Эрүүл мэндийн үндэсний тооцооны анхны тайлан ном хэвлэн нийтэлсэн. 1999–2002 оны эрүүл мэндийн зардлын үзүүлэлтийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас боловсруулсан "Эрүүл мэндийн тооцооны систем–2000" (System of Health Accounts 2000) аргачлалын дагуу анх удаа тооцон гаргасан.

2014 он

- 2003–2014 оныг хамарсан 12 жилийн тооцооллыг шинэчилсэн ангиллын дагуу ДЭМБ-ын техникийн дэмжлэгтэйгээр тооцон гаргаж, 2017 онд нэгдсэн үр дүнг танилцуулсан.

2019 он

- ДЭМБ-ын техникийн дэмжлэгтэйгээр 2015 оны ЭМҮТ-ны үр дүнг боловсруулан танилцуулсан.

2023-2024 он

- ЭМҮТ-ны 2016–2022 оны тооцооллыг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр "Эрүүл мэндийн тооцооны систем-2011" шинэчилсэн аргачлалын дагуу тооцож, 2024 онд "Монгол улсын эрүүл мэндийн үндэсний тооцоо, 2016–2022" нэгдсэн тайланг боловсруулсан.

- Энэхүү тайлан нь эрүүл мэндийн санхүүжилтийн үндсэн гурван ангиллаас гадна орлогын эх үүсвэр, санхүүжүүлэх орлого, хөрөнгийн ангилал, газар зүйн байршил гэсэн нэмэлт дөрвөн ангилал, мөн эрүүл мэндийн санхүүжилтийн 26 үндсэн үзүүлэлтийг тооцож, олон улсын харьцуулсан шинжилгээг тусгаснаараа өмнөх тайлангуудаас илүү өргөн хүрээтэй, арга зүйн хувьд боловсронгуй болсон.

2025-2026 он

- 2025 онд 2023 оны, 2026 онд 2024 оны үр дүнг олон улсын жишгийн дагуу Т-2 горимын дагуу боловсруулж, ДЭМБ-ын бүсийн зөвлөхөөр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр ДЭМБ-ын мэдээллийн санд байршуулсан бөгөөд энэхүү ажил тогтмол үргэлжилж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

1999 он

- “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын алба” байгуулагдав.

2000 он

- Төгсөлтийн дараах сургалтад суралцагч эмнэлгийн мэргэжилтний сургалтын төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлдэг болов.
- Энэ үеэс эхлэн Эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцуулах цоо шинэ ажлын эхлэл тавигдсан ба мэргэжил олгох сургалтын чиглэл, индексийг боловсруулсан.
  - Төгсөлтийн дараах сургалт явуулах эрхийг анх удаа:
  - Анагаах ухааны их сургууль
  - Хавдар судлалын төв
  - Улсын клиникийн төв эмнэлэг
  - Клиникийн I амаржих газар
  - Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд олгосон байна.

2001 он

- ЭМС-ын А/296 дугаар тушаалаар резидентийн сургалтыг 30–45 кредит, 1–1.5 жилээр анх баталсан. 2005 онд 1 жилийн сургалтыг 44 багц цагтай болгов. 2026 оны байдлаар үндсэн мэргэшлийн сургалт 2–3 жил, жилд нэг удаагийн элсэлттэй, төрөлжсөн мэргэшил 3 сараас 1 жил хүртэл, жилд хоёр удаагийн элсэлтийг зохион байгуулж байна.
- Санхүү, эдийн засгийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2001 оны 26/38 дугаар хамтарсан тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг санхүүжүүлэх журам” батлагдаж, сургалтын зардлын жишгийг анх удаа тогтоосон.

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

2002 он

- Зайн сургалтыг орон даяар анх зохион байгуулж эхэлсэн. 2021 онд НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр “Цахим сургалт” платформ болон хөгжиж, 13 чиглэлээр 61 модуль, нийгмийн эрүүл мэндийн 5 модуль интерактив хичээл байршуулав.

2003 он

- Сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг төрийн санхүүжилтээр зохион байгуулж эхэлсэн.

2005 он

- Мэргэжилтэн бүр жил бүр 3 ба 6 багц цагийн тасралтгүй сургалтад заавал хамрагддаг тогтолцоо нэвтэрч, өнөөг хүртэл хэвээр байна. Үүнээс гадна 40 байгууллага, 74 мэргэжлийн нийгэмлэг, холбоо нийт 114 байгууллага жилд давхардсан тоогоор 80,000 гаруй мэргэжилтнийг богино хугацааны сургалтад хамруулдаг болсон.

2006-2007 он

- Резидент, дадлагажигч эмчийн тогтолцоо ЭМС-ын 227, 90 дугаар тушаалаар бэхжив. Их эмчээр төгссөн эмч нар 2007 оноос цалинтайгаар “Дадлагажигч их эмч”-ээр ажиллах эрхтэй болов.
- ЭМС-ын 2007 оны 57 дугаар тушаалаар сум, сум дундын эмнэлэгт шилжин ажиллах эмчид урамшуулал олгох журам батлагдаж, Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарын хөгжил-2 төслийн дэмжлэгтэйгээр орон нутгийн эмнэлгүүдийг эмчээр тогтвортой хангах ажилд түлхэц өгсөн юм.

2015-2020 он

- Японы ЖАЙКА ОУБ-ын дэмжлэгтэй “Анхан болон хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төсөл хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд Ерөнхий мэргэшил судлалын шинэ сургалт (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184, 2017 оны А/337 дугаар тушаал), сүлжээ эмнэлгийн тогтолцоо, эмнэл зүйн сургагч багш бэлтгэх тогтолцоо, чадамжид суурилсан хөтөлбөр бий болов. 2022 онд энэ загварыг жишиг болгон үндсэн мэргэшлийн 38 чиглэлийг чадамжид суурилсан болгон бүрэн шинэчилж, сургалтын явцад 6 бүлэг, 16 дэд бүлэг, 64 үзүүлэлт бүхий үнэлгээний шинэ тогтолцоо нэвтэрлээ.

2016 он

- Эмнэл зүйн сургагч багш бэлтгэх тогтолцоо нэвтэрч, 89 удаагийн сургалтаар 1,500 гаруй эмч, 528 орчим сувилагч, 100 эх баригчийг сургагч багшаар бэлтгэсний дотор 83 эмч, 46 сувилагч, 10 эх баригч чиглүүлэгч багшийн түвшинд хүрч, дараагийн үеийн сургагч багш бэлтгэх ажлыг өөрсдөө удирдан явуулж байна.

2016-2018 он

- АХБ-ны Эрүүл мэндийн салбарын хөгжил 4, 5 төслийн хүрээнд 2016–2018 онд Сонгинохайрхан дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн 17 чиглэлийн 21 суралцагчийг бэлтгэв.

2017 он

- Эрүүл мэндийн салбарын "Хүний нөөцийн хөгжлийн систем" мэдээний сантай болж эмнэлгийн мэргэжилтнийг хөгжүүлэх, тэдний лиценз, шалгалт, сургалт болон хөгжлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн.
- "Хөдөлмөрийн яармаг" арга хэмжээ зохион байгуулж эхлэв. Энэхүү арга хэмжээгээр төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-ын сул ажлын байрны мэдээллийг олон нийтэд түгээж, байгууллагуудын хүний нөөцийн дутагдлыг арилгахад дэмжлэг үзүүлдэг болсон.

2018 он

- Орхон аймгийн БОЭТ, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвөөс эхлэн орон нутагт "Ерөнхий мэргэшил судлал" резидентийн сургалт өргөжиж, өнөөдөр 8 аймгийн Нэгдсэн эмнэлэг (Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Булган, Хөвсгөл, Баянхонгор), 4 дүүргийн Эрүүл мэндийн төв (Чингэлтэй, Баянгол, Налайх, Сонгинохайрхан), төрөлжсөн мэргэжлийн 2 (УГТЭ), бусад яамны харьяа 3 — нийт 18 эмнэлэгт хүрч, 288 мэргэшсэн эмч бэлтгэгджээ. Орхон аймагт БОЭТ, Медипас эмнэлэг, Мэндцэцэн ӨЭМТ хамтран гэрээт сургалтын сүлжээ байгуулсан.

2019 он

- Эрүүл мэндийн салбарт анх удаа ЭМХТ, Японы ЖАЙКА байгууллага, сургалт эрхлэх байгууллагын төлөөлөл хамтран Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагыг боловсруулан 2019.06.03-ны өдрийн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл (ЭМХЗ)-ийн хурлаар батлууллаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

2020 он

- Эрүүл мэндийн мэргэжилтнүүд төгсөлтийн дараах сургалтад цахимаар хамрагдах, багц цаг цуглуулах боломжтой "Зайн сургалтын программ хангамж"-ийг хөгжүүлэн ашиглаж эхэлсэн.
- Сургалт эрхлэх 13 байгууллагатай хамтран чадамжид суурилсан, олон улсын жишиг сургалтын хөтөлбөрийг үндсэн мэргэшлийн 9, төрөлжсөн мэргэшлийн 5 чиглэлээр батлуулж, төгсөлтийн дараах сургалтад хэрэглэж эхлэв.

2021 он

- Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2021 оноос резидент эмч нар цалинтай болов. 2021 онд сард 700,000₮-өөр эхэлсэн энэ цалин 2026 онд 1,114,000₮ болоод байна.

2021-2024 он

- Японы ЖАЙКА ОУБ-ын дэмжлэгтэй "Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог сайжруулах" төсөл хэрэгжүүлэв. Сувилагч, эх баригчийн тогтолцоо энэ жилүүдэд шинэчлэгдэв. ЭМС-ын 2021 оны А/445 дугаар тушаалаар батлагдсан 5 чиглэлийн мэргэшлийн индексийн дагуу Эх барихуйн мэргэшүүлэх 5 хөтөлбөр (бэлгийн болон нөхөн үржихүйн, жирэмсэн ба төрсний дараах үеийн, жирэмслэлтэд бэлтгэх, хөхөөр хоололтын, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгч) ЭМХЗ-ийн 2022 оны тогтоолоор батлагдаж, 2023 оноос ЭХЭМҮТ, Өргөө, Амгалан амаржих газарт хэрэгжиж эхэлсэн. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 451 дүгээр тушаалаар Сувилагч, Эх баригчийн чадамж, Шинэ сувилагч, Шинэ эх баригчийн хөтөлбөр батлагдаж, 2024 оны А/289 дүгээр тушаалаар эх баригчийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдэв.

2022 он

- "Үндсэн мэргэшлийн сургалтын жишиг 35 чиглэлийн хөтөлбөрийг батлуулж, үндсэн мэргэшлийн сургалт эрхэлж байгаа анагаах ухааны боловсрол олгох сургууль болон эмнэлгүүд ижил агуулга бүхий жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг болсон.
- Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022.06.30-ны өдрийн тогтоолоор Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн БОЭТ-үүдэд "Ерөнхий мэргэшил судлал"-аар сургалт эрхлэх зөвшөөрөл олгосон.
- Төгсөлтийн дараах сургалтад элсэгчийн бичиг баримтын бүрдлийг "Төрийн мэдээлэл солилцооны систем", "Иргэний нийгмийн даатгалын мэдээний сан", "Дээд боловсролын мэдээллийн систем"-ээр хянаж, сургалт эрхлэх байгууллагын сонголт, баталгаажуулалтыг цахимаар хийдэг болов.

2025 он

- Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийг “Улсын жишиг” болгох ажлын хүрээнд 60 ажилтныг улсын төсөв, БНСУ-ын Хьюндай эмнэлгийн хамтарсан санхүүжилтээр гадаад, дотоод сургалтад үе шаттай хамруулсны үр дүнд тус амбулатори 2025 оны 9 дүгээр сарын 1-ээс “Улсын жишиг амбулатори”-иор ажиллаж эхлэв.

1998 он

- УИХ-ын 1998.05.07-ны өдрийн “Эрүүл мэндийн, Эмийн, Ариун цэврийн тухай хуулиудыг баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 53 дугаар тогтоолоор эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, мэргэжилтнүүд төгсөлтийн дараах сургалтаар багц цаг биелүүлж зөвшөөрлөө сунгуулах, улмаар эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтыг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбож явуулдаг болсон нь эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй хөгжүүлэх, иргэдэд чанартай тусламж үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

1999 он

- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх анхны лицензийг АУИС-ийн багш нарт, гадаадын эмч нарын лицензийг БНСУ-ын KYUNG HEE их Сургуулийн профессор Ли, Кан нарын 5 багш, эмчид олгосон.
- Ийнхүү эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг мэргэжил бүрээр 3–5 жилээр олгож Монгол улсын болон Эрүүл мэндийн салбарт анх нэвтрүүлсэн ба улмаар бидний туршлагыг боловсролын болон бусад салбарт нэвтрүүлсэн.

2002 он

- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу Эмчлэх, Сувилах, Эм барих, Эх барих мэргэжлийн төрлөөр 5 жилээр олгож эхэлсэн.

2007 он

- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2007 оноос эзэмшсэн мэргэжлээр олгодог болов.

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2013 он

- Гадаад, дотоодын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг цахимаар авч эхэлсэн.
- Резидент эмчийн ур чадварын тэмцээн зохион байгуулж эхлэв.

2016-2020 он

- Эрүүл мэндийн тухай Монгол Улсын хуулийн шинэчилсэн найруулгаар сэргээн заслын мэргэжилтэнд зөвшөөрөл олгох эрх зүйн орчин бүрдэж, 2020 онд анх удаа хөдөлмөр засалч 29, хөдөлгөөн засалч 194 хүн зөвшөөрөл авав.

2018 он

- Төгсөгчдийн лицензийн шалгалтыг Realtime технологи ашиглан дүнг автоматаар төвийн цахим хуудаст шууд мэдээлж зохион байгуулж эхлэв.
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн болон үндсэн мэргэшлийн шалгалтын 12 мэргэжлийн чиглэлийн 14564 жишиг сорилыг хариуны хамт цахим хуудсанд байршуулж, эмнэлгийн мэргэжилтнүүд шалгалтанд бэлдэх боломж бүрдүүлсэн.
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг UBT буюу смарт төхөөрөмжид суурилсан программ хангамж ашиглан орон зайнаас үл хамааран авах ажлыг эхлүүллээ.

2020 он

- Анагаах ухааны их дээд сургууль, коллеж төгсөгчдийн болон эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг анх удаа online хэлбэрээр зохион байгуулав.

2021 он

- Цахим тогтолцоог бэхжүүлсэн. Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан буюу hr.hdc.gov.mn цахим системээр 2021 оноос зөвшөөрөл хүсэх, сунгах, шалгалт зохион байгуулах, цахим гэрчилгээ олгох, сургалтын бүртгэл хөтлөх, сорилын нэгдсэн сан хадгалах зэрэг бараг бүх үйл явцыг нэг дороос удирддаг болов. 67,360 ажилтны нэрийн ард одоо 59,572 мэргэжилтний зөвшөөрлийн бүрэн түүх цахимаар хадгалагдаж байна. 2026 оноос программыг “Дан”, “И-Монгол”, “Хур”, Боловсролын нэгдсэн мэдээллийн сан, Нийгмийн даатгал зэрэг бусад төрийн сантай бодит цагийн горимоор холбох ажил үргэлжилж байна.

2024-2025 он

- 32 улсаас 35 чиглэлээр 245, 2025 онд 18 улсаас 41 чиглэлээр 264 хүн зөвшөөрөл авав. (БНСУ, БНХАУ, Япон, АНУ, БНТУ,

Энэтхэг, Австрали, Их Британи, Канад зэргээс) Одоо 20 гаруй байгууллагад 14 чиглэлээр ажиллаж буй гадаадын 40 орчим эмч, мэргэжилтний дунд ОХУ, Япон, БНХАУ, ӨАБНУ, Экватор, БНСУ, Португали, Польш, Куба, Замби зэрэг орны иргэд байна.

2019-2025 он

- Шалгалтын сорилын санд 45,000 гаруй сорил бүрджээ. 2019 онд ДЭМБ-ын дэмжлэгээр, 2021 онд 12 чиглэлээр 4,330 сорил, 18 чиглэлээр 3,600 мультимедиа, тохиолдолд суурилсан сорил тус тус нэмэгдэв. 2025 онд БНСУ-ын Анагаах ухааны боловсролын нийгэмлэгтэй хамтран гадаадын их эмчийн шалгалтад зориулж 5,000 гаруй сорилоор нэмж баяжуулсан.

2015–2025 он

- Давхардсан тоогоор 108,550 мэргэжилтэн зөвшөөрөл авсан ба 54,437 нь тасралтгүй сургалтын багц цагаар, 54,113 нь шалгалтад тэнцэж авчээ.

2026 он

- 56,572 эмнэлгийн мэргэжилтнээс 29,217 эмчлэх, 17,069 сувилах, 10,168 эм барих, 2,728 эх барих, 390 сэргээн засах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй зөвшөөрөлтэй байна.

ГАДААД СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

2014 он

Гадаад сургалтын эрх зүйн орчин анх бүрдэж, 2017–2021 онд 738 мэргэжилтэн 28 үндсэн, 94 төрөлжсөн чиглэлээр АНУ, Япон, ОХУ, БНСУ, Сингапур, БНФУ, БНЭУ, Шинэ Зеланд зэрэг оронд суралцав. 2026 оны эхний хагаст зүрх, мэдрэлийн мэс заслын 3 эмч БНСУ-д, уламжлалт анагаах ухааны 30 сувилагч БНХАУ-ын Хөх хотод сурав.

2021 он

- Эрүүл мэндийн ажилтны гадаад сургалтыг анх удаа цахим хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн.
- Тайпэйн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газартай хамтран Тайваний Олон Улсын эмнэлгийн мэргэжилтний сургалтын төвөөс “Үндэсний эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн удирдлага”, “Яаралтай тусламж үйлчилгээ, түлэгдэлтийн үеийн асаргаа”, “Цахим эрүүл мэнд” сэдвээр цахим сургалтыг анх удаа зохион байгуулж 20 эмч, мэргэжилтэн хамрагдсан.
- Зочин профессорын хөтөлбөр хэрэгжүүлэхээр БНСУ-ын Сунчухьяан эмнэлэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Энэ хүрээнд Коронавируст (Ковид-19) халдварын

ГАДААД СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

үеийн батлагдсан тохиолдолд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эх барих эмэгтэйчүүд судлал, хүүхэд судлал, мэдрэлийн мэс засал судлал, өрхийн анагаах ухаан судлалаар нарийн мэргэшсэн профессоруудыг урьж ЭМЯ-ны харьяа төрөлжсөн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг эмнэл зүйн чиглэлээр чадавхижуулах ажлын байрны сургалтыг зохион байгуулсан.

- UpToDate цахим платформын хэрэглээг нэвтрүүлсэн.

  Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үүднээс UpToDate цахим платформын эзэмшигч Wolters Kluwer компанитай хамтран 2021 оноос эхлэн платформын хэрэглээг нэвтрүүлэхээр улсын хэмжээнд нийт 45 сургагч багшийг бэлтгэсэн. Сургагч багш нарын тусламжтайгаар нийслэл болон орон нутгийн эмч, мэргэжилтний UpToDate цахим платформын хэрэглээг нэмэгдүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж, 2026 оны 10 сарын байдлаар нийт 50,000 гаруй эмнэлгийн мэргэжилтэн UpToDate эмнэлзүйн платформыг идэвхтэй хэрэглэж, шинжлэх ухааны нотолгоонд суурилсан эмнэлзүйн шийдвэр гаргаж байна. Түүнчлэн 2026 оны 4 сараас эхлэн UpToDate эмнэлзүйн цахим платформыг хиймэл оюун ухаантай холбон хэрэглэх туршилтын ажил хийгдэж байна.

2022 он

- 2022 оны А/185 дугаар тушаалаар тэргүүлэх чиглэл батлагдаж, 2024 онд 270, 2025 онд 265, нийт 600 орчим мэргэжилтэн гадаадад туршлага судлав.
- БНТУ-ын ЛИВ эмнэлэгтэй хамтран Монгол улсад нэн хэрэгцээтэй байсан ризотоми мэс заслын сургалтыг зохион байгуулан, гадаад дотоод (УГТЭ, ЭНЭМҮТ, УНТЭ)-ын эмч нарын хамтарсан мэс заслыг 5 хүүхдэд хийлгэж, Монгол улсад нутагшуулах эхлэлийг тавьсан. Зочин профессорын баг нь 32 хүүхдэд үзлэг оношлогоо, 2 хүүхдэд мэс заслын хагалгааг үнэ төлбөргүй хийсэн.

2023 он

- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон улсын монгол эмнэлгийн хороотой хамтран “Уламжлалт анагаах ухааны эмч нарын мэргэжил дээшлүүлэх эмнэл зүйн олон улсын сургалт” зохион байгуулж, уламжлалт анагаах ухааны 150 эмч хамрагдан эмнэл зүйн ур чадвараа дээшлүүлсэн ба дээрх эмч нарт БНХАУ-ын Шинжлэх ухаан техник мэргэжлийн яамнаас гэрчилгээ олгосон.

2024 он

- Монгол улсад оношлогдож, эмчлэх боломжгүй өвчин эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээний шинэ арга, дэвшилтэт технологийг эх орондоо нутагшуулах, эдгээр өвчнийг эх орондоо эмчлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор 2024-2025 онд Эрүүл мэндийн сайдын А/273 тушаалын дагуу 8 өвчний чиглэлээр нийт 10 багийн 45 эмнэлгийн мэргэжилтэнг АНУ, БНЭУ, БНТУ, БНСУ, БНХАУ-д сургалтад хамруулсан.
- Багийн эмч, эх баригч, сувилагч нарыг онол, дадлага хосолсон гадаад сургалтад хамруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор ЭМС-ын 2024 оны А/199 дүгээр тушаалаар 200 гаруй сувилагч, багийн бага эмч, эх баригч болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтанг БНСУ болон БНХАУ-д онол, дадлага хосолсон богино хугацааны мээргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.

2024 он

- Анх удаа резидент эмч олон улсын эмнэлзүйн дадлага сургалтад гадаадын өндөр хөгжилтэй оронд хамрагдах боломжтой болсон. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, БНСУ-ын “Олон улсын боловсролын солилцооны холбоо”-той хамтран АНУ-д эмч мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтад хамруулах тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлан, шалгаруулж Цэргийн төв эмнэлгийн Мэс заслын хоёрдугаар дамжааны резидент эмч М.Номин-Эрдэнэ, ЭХЭМҮТ-ийн Эх барих, эмэгтэйчүүдийн 2-р дамжааны резидент эмч О.Номунзул нар нь АНУ-ын “Beverly Hills Plastic Surgery Hospital”-д эмнэлзүйн сургалтад хамрагдсан.

2026 он

- БНСУ-ын Кёнги аймгийн Sejong Hospital-д УНТЭ-ийн зүрх судасны мэс заслын эмч Ч.Нармандах – 2026.04.01-26-ны өдрүүдэд;
- Catholic university of Korea Bucheon hospital-д ГССҮТ-ийн гэмтлийн тархины мэс заслын эмч Л.Дагвадорж, УХТЭ-ийн мэдрэлийн мэс заслын эмч Э.Анхбаяр нарыг 2026.04.06-05.01-ний өдрүүдэдд тус тус богино хугацааны сургалтад тус тус хамруулсан байна.
- Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчин эмгэгийн тоог бууруулах, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт тэргүүлэх технологийг нэвтрүүлэх зорилгоор БНСУ-ын Korea Health Industry Development Institute (KHIDI) (эрүүл мэндийн хөгжлийн институт) тэй хамтран 2026 онд үндэсний 3 багийн 8 эмчийг БНСУ-ын Severance Hospital болон Bucheon Sejong Hospital-д суралцуулахаар гэрээ байгуулан сургалт 2026 оны 10-р сараас эхэлсэн.

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

2001 он

- Мэргэшлийн зэрэг олгох ажил 1995 онд АУИС-ийн харьяанд эхэлж, 2001 онд ЭМХТ-д шилжин ирсэн. Эрх зүйн орчин 1995- 2019 онуудад шинэчлэгдэж, Эх баригч мэргэжилтний зөвлөх зэрэг нэмэгдэж, анхан шатны зэргийн ажилласан жилийн шаардлага 6 болж буурав.

2002 он

- Эрүүл мэндийн сайдын 2002 оны 156 дугаар тушаалаар анх удаа эмнэлгийн сувилагч, тусгай дунд мэргэжилтнүүд мэргэжлийн зэргийн шалгалт өгдөг болсон. Мэргэжлийн зэргийн шалгалтыг анх удаа орон нутагт зохион байгуулан 430 хүн тэнцэж мэргэжлийн зэрэг хамгаалжээ.

2009 он

- Мэргэжлийн нийгэмлэг, холбоод сонгон шалгаруулалтаар шалгалт зохион байгуулж, ЭМХТ нэгдсэн арга зүй, хяналтаар хангадаг болсон. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2026 оны 01 дүгээр тогтоолоор 2026–2028 онд 32 нийгэмлэг, холбоонд 52 чиглэлээр шалгалт зохион байгуулах зөвшөөрөл олгосон. Сүүлийн 10 жилд 11,558 мэргэжилтэн мэргэшлийн зэрэг хамгаалсан байна.

2011 он

- Мэргэжлийн зэргийн шалгалтыг анх удаа гадаадад буюу Польш улсад зохион байгуулж 23 эмч амжилттай оролцов.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ЧИГЛЭЛЭЭР

1998 он

- Засгийн газрын 1998 оны 181 дүгээр тогтоолоор "Магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм"-ийг баталж, Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн бүтцэд "Магадлан итгэмжлэл, лицензийн алба" анх байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн.

1999 он

- Анхны эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийг Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгосон. Энэ үйл ажиллагаа Монгол улсын болон эрүүл мэндийн салбарт анхны бөгөөд хөгжлийн шинэ түвшний үйл ажиллагаа болсон юм. Бидний энэхүү шинэ ажлыг бусад салбарууд судалж хэрэгжүүлж эхэлсэн юм.

2000 он

- Эрүүл мэндийн байгууллагын чанарын хяналтын тогтолцоо бүрдэж, эрүүл мэндийн байгууллагуудад орон тооны бус "Чанарын алба" ажиллаж эхэлсэн.

2002 он

- Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 246 дугаар тогтоолоор анхны "Магадлан шинжлэх ажлын шалгуур"-ыг баталж, магадлан итгэмжлэлийн анхны орон тооны бус 30 шинжээчийг сонгон шалгаруулсан.

2003 он

- Нийслэлийн түргэн тусламжийн төвөөс алсын түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээний чиг үүрэг шилжиж ирсэн.

2003-2005 он

- 2003 онд анх "Хүмүүн", "Хатагтай", "Мишээл" зэрэг хувийн хэвшлийн эмнэлгүүд магадлан итгэмжлэгдэж, улмаар 118 хувийн хэвшлийн эмнэлэг, 2005 онд 14 эмийн сан магадлан итгэмжлэгдсэн юм. Мөн Магадлан итгэмжлэлийн баталгаажилт болох гэрчилгээний загвар бий болгосон нь өнөөг хүртэл хэрэглэгдэж байна.
- Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт эрх зүйн баримт бичгийг боловсруулан батлуулсан. Сумын эрүүл мэндийн , Сум дундын эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг болон Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг тус тус боловсруулж, батлуулснаар улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны нэгдсэн жишиг бий болсон бөгөөл эрүүл мэндийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үндсэн тулгуур баримт бичиг бүрдсэн.
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр эмнэлзүйн удирдамж, заавар, журмыг боловсруулан батлуулах ажлыг эрчимжүүлж, ДЭМБ-ын санхүүжилтээр Хөдөөгийн эмнэлгийн мэс заслын тусламж, Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамж боловсруулан хэвлүүлж, энэхүү гарын авлага, зааврыг цахим хэлбэрээр үндэсний хэмжээнд түгээж мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан.
- Аймаг, сумын эмнэлгийн яаралтай болон мэс заслын тусламж, үйлчилгээг чадавхижуулах төслийг Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дундговь, Хэнтий, Төв аймгуудыг сонгон шалгаруулж, хэрэгжүүлсэн бөгөөд ингэснээр алслагдсан бүс нутагт эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажил хийгдсэн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ЧИГЛЭЛЭЭР

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ЧИГЛЭЛЭЭР

- “Нэг цэг”-ийн зарчмаар ажиллах тогтолцоог эхлүүлж мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэн, байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, үнэлэлт, дүгнэлт өгөх болон тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг нэг газраас зохицуулж эхэлсэн.
- Монгол улсад 2004 онд гар хөл амны өвчин шинээр бүртгэгдэж, дэгдэлт үүссэн үед уг халдварыг таслан зогсоох ажлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулсан. Хилийн боомтоор ирж байгаа суудлын галт тэрэгний зорчигчдод үзлэг хийх, тэдэнд халдвараас сэргийлэх мэдээлэл сурталчилгааг хийх ажлыг эрүүл мэндийн байгууллагууд болон Монголын Улаан загламайн нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлэв.

2007-2008 он

- “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан баталж, улсын хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн.
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын хяналт, удирдлага, зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэх үүрэг бүхий "Чанарын алба" нь бие даасан, орон тооны, байнгын ажиллагаатай бүтцэд шилжсэн нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад гарсан нэгэн чухал дэвшил болсон.

2010-2012 он

- ЭМЯ, Мянганы сорилтын сан, ЗГХА-ЭМГ хамтран 21 аймагт “Эрүүл мэндийн тусламжийн чанар”-ын анхны 48 үндэсний сургагч багш бэлтгэсэн.
- Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Чанарын албаны дүрэм батлах тухай” 06/25 дугаар тушаал батлагдаж эрүүл мэндийн байгууллагуудын чанарын алба тогтвортой ажиллах, ажил үүргийн хуваарь нь тодорхой болж, тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах хууль эрхзүйн үндсийг бүрдүүлсэн.

2019-2020 он

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санаачилгаар “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр”-ийг эрүүл мэндийн салбарт анх удаа албан ёсоор тэмдэглэж эхэлсэн.
- Нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний мэдээллийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор Wolters Kluwer компанитай хамтран UpToDate олон улсын эмнэлзүйн цахим платформыг Монгол улсад амжилттай нэвтрүүлсэн.
- Магадлан итгэмжлэх шалгуурыг АНУ, Канад, Малайз, Joint Commission International" (JCI) байгууллага зэрэг олон улсын

туршлагаас суралцан, шинэчлэн боловсруулсан нь олон улсын магадлан итгэмжлэлтэй зэрэгцэн хөгжих боломжийг олгосон.

2022 он

- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний эрх зүйн орчин шинэчлэгдэж, үнэлгээний асуумж, аргачлалыг боловсронгуй болгохын зэрэгцээ үнэлгээний үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэн QR кодод суурилсан үнэлгээний тогтолцоог нэвтрүүлсэн.
- Эрүүл мэндийн байгууллагад гарч буй тусламж үйлчилгээний алдаа, зөрчил, тохиолдлыг ил тод бүртгэх, мэдээлэх, түүнд дүн шинжилгээ хийх зорилгоор Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн санг http://eburtgel.hdc.gov.mn амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Улсын хэмжээнд нийт 2,864 эрүүл мэндийн байгууллагын 10,100 гаруй эмнэлгийн мэргэжилтэн, 1,305 гаруй чанарын мэргэжилтэн системд холбогдож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн нийт 8,575 тохиолдол, 4,515 эрсдэлийг системд бүртгэж, хариу арга хэмжээ авч ажилласан байна.
- “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн цахим систем” программ хангамжийг хөгжүүлэн нэвтрүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлүүлэх хүсэлт болон холбогдох бүх материалыг цаг хугацаа, орон зай үл харгалзан цахим хэлбэрээр (health.acc.hdc.gov.mn) хүлээн авч шийдвэрлэдэг болсон. Магадлан итгэмжлэлийн цахим системд 1,040 эрүүл мэндийн байгууллага бүртгэлтэй байгаагаас 867 байгууллага магадлан итгэмжлэгдэж, үйл ажиллагаа явуулж байна.
- Эрүүл мэндийн салбарт анх удаа “Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын менежер” бэлтгэж эхэлснээр Эрүүл мэндийн байгууллагын чанарын албанд мэргэшсэн мэргэжилтэн ажиллаж эхэлсэн.

2023 он:

- Шинжээч сонгон шалгаруулах журмыг шинэчилж, шинжээчийг баримт бичигт үндэслэн сонгон шалгаруулах бус мэдлэг, ур чадварыг нь үнэлж нээлттэй, ил тод сонгон шалгаруулдаг болсон. Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилогдсон 188 орон тооны бус шинжээч улсын хэмжээнд хараат бус үнэлгээ хийж, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд оролцон ажиллаж байна.
- Үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл”, Энэтхэг улсын “Чанар, магадлан

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ЧИГЛЭЛЭЭР

итгэмжлэлийн институт", Казакстаны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн төв (ACQH), БНСУ-ын Чүнг-Анг их сургууль, Хюндай эмнэлэг зэрэг олон улсын нэр хүндтэй байгууллагуудтай хамтран уулзалт, сургалт зохион байгуулж, тэргүүн туршлагаас судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

2026 он:

- Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын олон улсын нийгэмлэгт (ISQua) "Байгууллагын гишүүн"-ээр элсэж гишүүнчлэлийн албан ёсны гэрчилгээгээ хүлээн авсан.
- Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж үндэсний магадлан итгэмжлэлийн тогтолцоог олон улсын жишигт нийцэн хөгжих боломж бүрдсэн. Өнөөдөр магадлан итгэмжлэл нь зөвхөн хяналт шалгалтын хэрэгсэл бус, эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг үнэлэх, багийн хамтын ажиллагаа, манлайллыг хөгжүүлэх, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх соёлыг түгээгч гол хөшүүрэг болж чадсан.
- Үнэлгээний шинжээчийн ёс зүйн дүрэмтэй болсон.

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1990 он

- Эрүүл мэндийн сургалт арга зүйн төвд Аэробекийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж эхэлсэн.

1992-2007 он

- Бие чийрэгжүүлэх хийн дасгалын сургалт, Чийрэгжүүлэлтийн арга зүйч багшийн сургалтыг улсын хэмжээнд тасралтгүй бэлтгэж, Чийрэгжүүлэлтийн арга зүйч нараар дамжуулан эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдад хийсэн Хийн дасгал нь үр дүнгээ өгсөн ажил болсон.

1995 – 2011 он

- Эрүүл мэндийн сайдын 1995 оны А/84 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны "ЭСС ТВ, радио студи" байгуулагдсан.
- "Эмчгүй газарт" цуврал нэвтрүүлэг, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлье сэдвээр телевизийн нэвтрүүлэг, телевизийн реклам, сурталчилгаа, радиогийн 10 минутын нэвтрүүлэг, радиогийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, НҮЭМ-

ийн цуврал нэвтрүүлэг болон эрүүл мэндийн бусад чиглэлээр баримтат кино, нэвтрүүлэг, сурвалжлага, сэрэмжлүүлгийг бэлтгэн мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулан үр дүнтэй ажиллаж байв.

- 1999 онд "Эмчгүй газарт" цуврал нэвтрүүлгийг 36 удаа явуулж захиалгаар сургалтын 9 кино, орчуулгын 3 кино хийж мэдээллийн цар хүрээгээ тэлж салбарын хэмжээний сургалт сурталчилгааны баримтат кино, сэрэмжлүүлэг, зөвлөгөө, эрүүл мэндийн нэвтрүүлгүүдийг бүтээж нийтэд сурталчлах ажлыг гүйцэтгэж байсан.

1996 он

- Монгол улсад анх "Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн" эхэлсэн.

1996 - 1998 он

- "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" сонин гарав. НҮБ-ын ХАС-ийн НҮЭМ-ийн төсөлтэй хамтран "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" сонинг улирал тутамд 50000 ширхэг хэвлүүлэн нийслэл, 21 аймаг, 360 гаруй сумын сургуулиудад хүргэж өсвөр насны хүүхэд, залуучуудыг Эрүүл мэндийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, эрүүл аж төрөх дадал, хандлага эзэмшихэд нь тодорхой хувь нэмэр оруулсан.
- Ерөнхий боловсролын сургуульд "Эрүүл мэндийн хичээл" заах багш нарыг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд бүсчлэн бэлтгэж эхэлсэн.
- Улсын хэмжээнд Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эхлүүлсэн ба Нийслэлийн ерөнхий боловсролын 2, 58, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын сургуулийг "Эрүүл мэндийг дэмжигч загвар сургууль"-иар сонгон ажиллуулсан.
- Эрүүл мэндийн хичээл заах багш нарын гарын авлагыг боловсруулсан.
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн программд "Эрүүл мэндийн хичээл"-ийг анх оруулсан.

2000 он

- "Эрүүл мэндийг дэмжих алба" байгуулагдав.
- Монгол-Германы хамтарсан GTZ төсөл, Глобаль сангийн "Сургуулийн боловсрол" дэд хөтөлбөрийн дэмжлэгээр Боловсролын хүрээлэн, Нийслэлийн Боловсролын газрын багш нартай хамтран Сэлэнгэ, Завхан, Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Булган, Орхон, Увс, Төв аймаг Нийслэлийн 8 дүүргийн ЕБС-ийн 8-10-р ангийн 3000 орчим сурагчдыг Нөхөн үржихүйн болон, Бэлгийн эрүүл мэндийн чиглэлээр сургагч багшаар бэлтгэж "Ye тэнгийн сургагч" нарыг ажилуулж эхэлсэн.

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2001 он

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2001.10.03-ны өдрийн “Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” стратегийг 224 дүгээр тогтоолоор батлуулсан.

2003 - 2012 он

- “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шалгаруулах ажлыг зохион байгуулсан.
- Сумын Засаг дарга нарын дунд ”Эрүүл мэндийг дэмжигч” сум хөгжүүлэх ухуулга сурталчилгааны ажил хийснээр Дундговь аймгийн Дэлгэрцогт сум “Эрүүл мэндийг дэмжигч загвар сум”-аар шалгарсан.
- Улсын хэмжээнд Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сурталчлан таниулж Боловсролын салбар, Эрчим хүчний салбар, Засаг захиргааны салбар, Онцгой байдлын газар зэрэг олон салбаруудыг хамарч, Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олны тоо нэмэгдэж 2012 оны байдлаар улсын хэмжээнд 405 байгууллага болж өргөжсөн.
- Анхан болон хоёрдогч шатлалын ЭМБ-ыг хөгжүүлэх, орон нутагт НЭМ-ийг хөгжүүлэх механизмыг бүрдүүлэх, хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг сайжруулах зорилгоор Францын Санте сюд төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр Сэлэнгэ, Архангай аймгийн эрүүл мэндийн байгууллагууд дээр “Байгууллага хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэв.

2004-2010 он

- ЭМХҮТ-ийн нэрийн хуудас болсон зохиогчийн эрхтэй “Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа бүхий цаг тооны бичиг” боловсруулан жил бүр хэвлүүлэн түгээсэн нь эрүүл аж төрөх зан үйлд чиглэсэн мэдээллийг хүн амд хүргэхэд ач холбогдолтой шинэлэг бүтээл болсон.
- 13-15 насны өсвөр үеийнхний дунд ”Тамхины хэрэглээний түвшин тогтоох” болон “Эрүүл аж төрөх зан үйлийн мэдлэг, хандлага, дадлын түвшин тогтоох” сэдэвт судалгааг үндэсний хэмжээнд 20-60 насны хүмүүсийг хамруулан явуулж суурь түвшин тогтоосон.
- ЭМДА-аас олон арван теле хичээл, хүүхэлдэйн кино, боловсруулан түгээж, ”НЭМ-ийн сургалтын модуль” ном гарын авлага боловсруулж, ”Шинэ нийгмийн эрүүл мэнд” номыг анх

удаа орчуулан төв орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдийн хүртээл болгосон.

2006 он

- Эрүүл мэндийг дэмжих сан байгуулав. Эрүүл мэндийг дэмжих албаны дарга Д. Жаргалсайхан нь шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлснээр 2006 онд Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай" хуулийн 5.4.21-р заалтад Эрүүл мэндийг дэмжих санг багтаасан. Тус сан нь анхны санхүүжилтээ тамхины албан татварын нэмэлт 2 хувиас бүрдүүлж эхэлсэн ба улмаар архи, согтууруулах бүтээгдэхүүний тусгай татварын 1 хувь, мөн эмийн импортын нэмэгдсэн өртгийн татварын 2 хувиас санхүүжилтийн эх үүсвэр нь өргөжсөн.

2006-2009 он

- НҮБ-ын ХАС, Японы Олон улсын гэр бүл төлөвлөлтийн нийгэмлэгтэй хамтран "Ухаалаг, халамжтай эр нөхөр" төсөл хэрэгжүүлж, "Эрдэнэт" үйлдвэрийн ажиллагсдын дунд эрүүл мэндийн мэдлэг, дадал, хандлага МСС-ны ажлын хэрэгцээг тодорхойлон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлон эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх МСС-ны арга зүйгээр орон нутгийн мэргэжилтнүүдийг хангаж хамтын ажиллагааны загварыг бий болгов.

2007 он

- Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудийн сургалтын хөтөлбөрт "Эрүүл мэнд" хичээлийг оруулсан. "Эрүүл мэнд" хичээлийг оруулах зорилгоор ДЭМБ-ын зөвлөх профессор Лоуренс Ст.Лежерийн боловсруулсан "Эрүүл мэндийг дэмжих", "Аюулгүй амьдрал", "Орчны эрүүл мэнд", "Амны хөндийн эрүүл мэнд", "Эм мансуурах бодис", "Зөв хооллолт", "Хөдөлгөөн эрүүл мэнд", "Сэтгэцийн эрүүл мэнд" зэрэг 8 сэдвийг орчуулан, 117 цагийн хичээлийн 9 модулийг боловсруулан сургалтын албадад хүлээлгэж өгснөөр багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж "Эрүүл мэнд" хичээлийн сургалтын хөтөлбөртэй болж 2007 оноос өнөөг хүртэл Эрүүл мэндийн багш бэлтгэж байна.
- "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийг орон даяар хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулав.
- Дэлхий нийтэд тархсан халдварт өвчний дэгдэлтийн үед (Холер,АЦХАХ, Шувууны томуу, H1N1 г.м) халдвараас сэргийлэх сурталчилгааг орон даяар явуулах ажлыг арга зүй зохион байгуулалтаар ханган ажилласан.

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2010 он

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын бүрэлдэхүүнд Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (НЭМХ) байгуулагдав.

2011 он

- “Эрүүл мэндийн багш” сүлжээ нээв. ЕБС-ийн эрүүл мэндийн багш нарын сайн туршлагыг нэвтрүүлэх, багш нар бие биенээсээ эрүүл мэндийн хичээлийг заах үр дүнтэй, шинэлэг арга, аргачлалыг сурталчлах зорилготой бөгөөд, энэ сүлжээнд олон багш хамрагдсан амжилттай ажил болсон.

2012-2013 он

- “Хүн амыг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эрт илрүүлэх” ажлыг анх Булган аймгаас эхлүүлсэн.

2012 он

- ЗГХА-ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс нь Архангай аймгийн ЭМГ, Цэцэрлэг сумын ЗДТГ-тай хамтран “Тамхигүй загвар сум бий болгох” төслийг 2012 онд амжилттай хэрэгжүүлсэн. Тус сум нь тамхигүй орчныг бүрдүүлж, иргэдийнхээ эрүүл мэндийг дэмжих зорилгоор 100% тамхигүй сум болцгооё хэмээн санаачлан хэрэгжүүлж, орон нутагтаа бүрэн тамхигүй орчныг амжилттай бүрдүүлсэн анхдагч сум болсон.
- 2012 оны 9 дүгээр сард ЗГХА-ЭМГ татан буугдаж тус газарт хэрэгжиж байсан нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг ЭМЯ болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд шилжсэн.

2014 он

- Иргэний эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх, эрүүл зөв дадал хэвшилтэй болгох, эрүүл, урт наслах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээг улсын хэмжээнд анх удаа зохион байгуулсан.

2003 он

- ”Үнэ төлбөргүй эм олгох журам”-ыг шинэчлэн Сүрьеэ, хорт хавдрын 3,4-р шат, сэтгэцийн өвчин эмгэг, чихрийн шижин, чихрийн бус шижин, бамбай булчирхайн дутмагшил, эд эрхтэн шилжүүлэн суулгасны дараах байдал зэрэг 15 өвчний үед хэрэглэх тодорхой нэрийн эмийг төрөөс үнэ төлбөргүй олгож эхэлсэн.
- Эмийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж 15 аймгийн Эрүүл мэндийн газарт эмийн мэргэжилтэн ажиллах ажлыг эхлүүлсэн.

2003–2007 он

- Монгол улсад зонхилон тохиолдсон эмийн хордлогын төлөв байдлыг бичиглэлийн судалгааны аргаар анх удаа судалсан.

2004 он

- “Эмийн мэдээлэл” сэтгүүлийг эрхлэн гаргаж, аймаг, хотын эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, эмнэлгүүдэд хүргэх ажлыг эхлүүлсэн. Эмийн мэдээлэл” сэтгүүлээр дамжуулан эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмийн зохистой хэрэглээний талаар зайн сургалтыг шинэчилсэн программаар явуулах ажлыг эхлүүлсэн байна.

2005 он

- Лайсмед мэдээний сангийн программыг анх нэвтрүүлсэн. Уг программаар эмийн бүртгэл, хэрэглэх зааврын мэдээллийг оруулж, эрүүл мэндийн байгууллага, иргэдийг мэдээллээр хангасан.

2005-2007 он

- Эмийн сангийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эхэлж, нийслэлийн 14 эмийн сан магадлан итгэмжлэгдэв. Эм, эмнэлгийн хэрэгсэлд чанарын баталгаажуулалт хийж эхэлсэн.

2006 он

- Эмнэлгийн эмийн санд тарилгын шингэн үйлдвэрлэж байсан үйл ажиллагааг зогсоож, үйлдвэрлэлийн нөхцөлд тарилгын шингэнийг үйлдвэрлэдэг болсноор эмийн чанар, аюулгүй байдал сайжрах, үндэсний үйлдвэр хөгжих нөхцөл бүрдсэн.

2011 он

- Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм хэрэглэх зааврыг баталгаажуулах ажлыг эхлүүлсэн. Мэргэжлийн түвшинд хянагдсан эмийн зааврыг эх хэл дээрээ танилцах боломж бүрдснээр 2011 оны эцсээр 1200 гаруй эмийн зааврыг эмийн мэдээний лайсмэд санд оруулснаар иргэд эмийн хэрэглэх зааврын мэдээллийг улсын бүртгэлд бүртгэгдсэн

ЭМ, ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

ЭМ, ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

эмийн зурагтай нь авах боломжтой болсон.

- Гадаадын улс орнуудын туршлага болон өөрийн орны эм зүйн салбарын тэргүүлэх мэргэжилтнүүдийн саналыг үндэслэн эм, эмийн түүхий эдийн нэрийг латин цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулж фармакопейн өгүүллийг боловсруулж хэвлэж түгээснээр анхны МУ-ын Үндэсний фармакопейтой болсон.
- Хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх импорт, экспорт, үндэсний үйлдвэрийн эм, эмийн түүхий эд, уламжлалт эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, вакцин, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдалд тохирлын үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулах ажлыг 2011 оны 07 сараас эхэлсэн.

2014 он

- Эмийн гаж нөлөө, хордлогыг бүртгэн мэдээлэх, хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эмч нарт сургалт сурталчилгаа хийж эхэлсэн.

2015 он

- Эрүүл мэндийн сайдын тушаалаар Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам болон Монгол Улсын Шадар сайдын тушаалаар төлбөрийн хэмжээг батлуулж, анх зүрхний цахилгаан бичлэгийн аппаратад шалгалт тохируулга хийж эхэлсэн.
- “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан”-гийн цахим программыг хөгжүүлж, жил бүр баяжилт хийн, шийдвэр гаргагчдыг бодит тоо мэдээллээр хангах боломжийг бүрдүүлсэн.

2016 он

- Эрүүл мэндийн салбарын дэд бүтцийн судалгааг жил бүр гаргаж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлж ирсэн.
- Эмнэлгийн инженер, техникч нарыг чадавхжуулах сургалтыг байгууллагын дотоод нөөц болон Азийн хөгжлийн банкны (АХБ) "ЭМСХХ-5" төслийн хүрээнд 2016 оноос эхлэн тасралтгүй зохион байгуулж эхэлсэн.

2017-2018 он

- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн нөөц, төсөл хөтөлбөрийн явцын иж бүрэн үнэлгээг хийсэн.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн болон эрүүл мэндийн салбарын дэд бүтцийн чиглэлээр бүхий л төрлийн судалгаа, тоо мэдээллийг тогтмол гарган ажиллаж байсан.

2018 он

- Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга, аргачлал болон хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээний журмыг батлуулсан

2019 он

- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн II байранд шалгалт тохируулгын стандартад нийцсэн лабораторийг байгуулсан. Шалгалт тохируулгын нэр төрлийг жил бүр нэмэгдүүлж олон улсын жишигт нийцсэн 11 нэр төрлийн 23 эталон анализатор, симулятор ашиглан 17 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг ханган шалгалт тохируулга хийж хэвшсэн.
- UMDNS олон улсын нэршлийн системээс 442 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр томьёо, тодорхойлолтыг зургаар баяжуулан "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэр томьёоны толь бичиг"-ийг хэвлүүлсэн.
- Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC)-оос эрхлэн гаргадаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт, аюулгүй ажиллагааны стандартуудыг орчуулан боловсруулж, 2019 оноос Монгол Улсын үндэсний стандартаар бүртгүүлсэн.

2021 он

- Монгол Улсын Засгийн газрын 2020.12.16-ны өдрийн “Агентлаг байгуулах тухай” 222 дугаар тогтоолоор тус төвийн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалттай холбогдсон чиг үүрэг бүхий нэгж ЗГХА-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт шилжсэн.

2024 он

- Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дүрс оношилгооны хариуг зайнаас бичих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, нэгдсэн мэдээний сан үүсгэх чиг үүрэг бүхий “Зайн оношилгооны төв” 2024.12.17-нд байгуулагдав.

2025 он

- Зайн оношилгооны төв нь 1, 2 дугаар сард 17 эрүүл мэндийн байгууллагад дүрс оношилгооны чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 556 шинжилгээ (толгой, хүзүү, сээр, хэвлий, цээж, бүсэлхий нурууны тодосгогчтой, тодосгогчгүй КТ, цээжний рентгэн зураг, шөрмөсний хэт авиан шинжилгээ)-ний хариуг телемедицинээр өгсөн.
- Энэ үйл ажиллагааг 2025.02.25-ны өдрөөс УХТЭ-т шилжүүлсэн.

ЗАЙН ОНОШИЛГООНЫ ЧИГЛЭЛЭЭР

ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2018 он

- Монгол Улсын Донорын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэд "Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба" байгуулагдав.
- Монгол улс Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах холбооны 27 дугаар их хурлаар шинэчлэгдсэн хүний наймаа, хүний эрхтний наймааны эсрэг Истанбулын тунхаглалд нэгдэн оров.
- Монгол улсад анхны тархины үхэлтэй донор илрүүлэх багийг Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэгт байгуулав.
- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах чиглэлийн анхны 6 журмыг боловсруулан батлуулав.
- Тархины үхэлтэй донорын гэр бүлтэй уулзалт зохион байгуулан, донор болгох хүсэлт тавьж, зөвшөөрөл аван тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг зохион байгуулж эхлэв.
- Тархины үхэлтэй 1 донороос зөвшөөрөл авч, 2 хүнд бөөр шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.

2019 он

- Тархины үхэлтэй 8 донороос зөвшөөрөл авч, 11 хүнд бөөр, 8 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.
- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага, Тархины үхэлтэй донор илрүүлж буй эрүүл мэндийн байгууллага болон Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба нь хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулав.
- Донорын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор "Амьдрал бэлэглэе" арга хэмжээг Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав.
- Донорын зөвшөөрлөө илэрхийлэх "Донорын карт"-ыг иргэдэд гардуулав.
- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улс оронд олон улсын сургалтад хамруулж эхлэв.
- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ёс зүйн удирдамжийг боловсруулан Эрүүл мэндийн яамны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороогоор батлуулав.
- Монгол улсад эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт, хяналт хийж эхлэв.
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон олон улсын

байгууллагад эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны статистик тоон мэдээллийг солилцдог болов.

- Монголын эрхтэн шилжүүлэн суулгах холбоо, Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтран нийгмийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг "Эрүүл амьдралын төлөө-2019" төсөл хэрэгжүүлэв.

2020 он

- Тархины үхэлтэй 5 донороос зөвшөөрөл авч, 6 хүнд бөөр, 4 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.
- Шинэ инноваци нэвтрүүлэх зорилгоор Нойр булчирхай шилжүүлэн суулгах үндэсний багийг байгуулан, нойр булчирхай шилжүүлэн суулгах эмнэлзүйн зааврыг боловсруулан батлуулав.
- "Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа"-тай холбоотой баримт бичгийн эмхэтгэл номыг анхлан боловсруулж хэвлүүлэв.
- БНСУ болон БНЭУ-д эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд явах тохиолдолд донор, реципиентийн хамаарал, өөрийн хүсэлт зэргийг шалгасан албан тодорхойлолтыг тухайн улсын виза бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалтад оруулав.
- 2020 оны 10 дугаар сарын 30-нд "Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг өргөжүүлэх нь" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж 11 эрүүл мэндийн байгууллагын 100 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцов.

2021 он

- Тархины үхэлтэй 7 донороос зөвшөөрөл авч, 8 хүнд бөөр, 7 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.
- Амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг өргөжүүлэх зорилгоор Улсын гуравдугаар төв эмнэлэг болон Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хамтарсан "Зүрх шилжүүлэн суулгах үндэснийг баг" байгуулав.
- Олон нийтийн донор болон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний тухай ойлголтыг сайжруулах зорилгоор кино, продакшнтай хамтран ажиллаж эхлэв.

2022 он

- Тархины үхэлтэй 3 донороос зөвшөөрөл авч, 4 хүнд бөөр, 2 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.
- Монгол Улсын Донорын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулан батлуулав.

ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- Амьгүй донороос элэг, бөөр шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийн хүлээх жагсаалтыг холбогдох эрүүл мэндийн байгууллагаас нэгтгэн авч, хөтөлдөг болов.
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл боловсруулж эхлэв.
- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээлийн сан байгуулав.
- Их, дээд сургуулийн оюутнуудад зориулан “Донорын тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр дараах сургалтуудыг зохион байгуулж эхлэв.
- Амьгүй донорын гэр бүлд оршуулгын тэтгэмж өгдөг болов.

2023 он

- Тархины үхэлтэй 3 донороос зөвшөөрөл авч, 4 хүнд бөөр, 2 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.
- Элэг шилжүүлэн суулгах эмнэл зүйн заавар болон Бөөр шилжүүлэн суулгах эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулав.
- “Бөөр шилжүүлэн суулгасны дараах хяналтын эмч” бэлтгэх төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулан, бэлтгэж эхлэв.

2024 он

- Тархины үхэлтэй 5 донороос зөвшөөрөл авч, 10 хүнд бөөр, 4 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.
- “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн салбар зөвлөл” байгуулагдав.
- Донорын карт буюу донорын зөвшөөрлийн хуудсыг цахимжуулах ажлын хүрээнд "И Монгол академи" УТҮГ, Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д “Донорын зөвшөөрлийн хүсэлт” шинэ үйлчилгээг нэвтрүүлэв.
- “International Congress of Organ Transplantation” олон улсын ICOT-4 дэх удаагийн хурлыг зохион байгуулав.
- БНТУ болон БНХАУ-д эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд явах тохиолдолд донор, реципиентийн хамаарал, өөрийн хүсэлт зэргийг шалгасан албан тодорхойлолтыг тухайн улсын виз бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалтад оруулав.

2025-2026 он

- Тархины үхэлтэй 3 донороос зөвшөөрөл авч, 6 хүнд бөөр, 3 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай зохион байгуулав.

- Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтран “Эрхтэн шилжүүлэн суулгуулагсдын спортын IV наадам”-ыг зохион байгуулав.
- “Монгол Улсын Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулав.
- Тээгч эх ашиглан төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг биологийн эцэг/эх-ийн нэр дээр бүртгэж эхлэв.
- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн систем шинэчлэгдэв.
- “International Congress of Organ Transplantation” олон улсын ICOT-5 дахь удаагийн хурлыг Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулав.

2020 он

- 2020.09.01-ний өдрөөс нийслэлийн 6 дүүргийн Эрүүл мэндийн төвийн амбулаторийн эмчийн үзлэгийн цагийг 1800-0119 дугаарын утсаар олгох үйл ажиллагаа эхэлсэн.

2021 он

- “Дуудлага зохицуулах алба” байгуулагдаж, төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн 30 ажилтан ажиллаж эхэлсэн.
- Үйл ажиллагаа нь өргөжиж 19 эрүүл мэндийн байгууллага холбогдов. (Аймгийн нэгдсэн эмнэлэг 3, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв 2, алслагдсан дүүргийн эрүүл мэндийн төв 1)

2022 он

- Аймгийн 2 Нэгдсэн эмнэлэг, 1 Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Сум дундын 1 эмнэлэг нэмэгдэж, нийт 31 эрүүл мэндийн байгууллага холбогдсон.


2024 он

- Нийт 40 эрүүл мэндийн байгууллага (дүүргийн эрүүл мэндийн төв 8, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 9, аймгийн БОЭТ, Нэгдсэн эмнэлэг 21, хөдөөгийн Нэгдсэн эмнэлэг 2) дуудлага зохицуулах сүлжээнд холбогдож 1800-0119 дугаарын утсаар амбулаторийн эмчийн үзлэгийн цагийг олгодог болсон.

2025 он

- 2025.03.01-ний өдрөөс дуудлага зохицуулах үйл ажиллагааг УХТЭ-т шилжүүлсэн.

ДУУДЛАГА ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР





Hr.hdc.gov.mn

acc.hdc.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

3

БҮЛЭГ ГУРАВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН НЭГЖҮҮД



1313.mn
hinfo.mn

3.1. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ, ТАНИЛЦУУЛГА

“Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, салбарын бодлого тодорхойлоход шаардлагатай судалгаа хийх, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын чанар, магадлан итгэмжлэл, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа, иргэдийн гадаад эмчилгээг үндэсний хэмжээнд зохицуулах үндсэн чиг үүргийг 9 албаны 86 албан хаагч хэрэгжүүлж байна.”

Байгууллага нь суралцагч байгууллага байх зарчмыг баримталж, ажлын байрны чиг үүрэгтэй уялдсан, хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулах, албан хаагчдын мэргэшлийн түвшин, мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд онцгойлон анхаарч олон талын дэмжлэг үзүүлж ирсэн уламжлалтай билээ.

2024-2026 онд ахлах мэргэжилтэн Г.Батцэцэг Боловсрол судлалын доктор, мэргэжилтэн Г.Раднаа, Л.Оюунбилэг нар Анагаах ухааны докторын зэрэг амжилттай хамгаалж, Био-анагаахын шинжлэх ухааны доктор Ч.Батчингис, Боловсролын удирдлагын доктор Л.Гэрэлт-Од нар нь судалгаа шинжилгээнд тулгуурласан шинэ үеийн хөгжлийн чиг хандлагыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулж буй манай байгууллагын залуучуудын төлөөлөл, эрхэм докторууд юм. Байгууллагын маань нийт албан хаагчийн 41% нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, 29% нь мэргэшлийн зэрэгтэй, үүнээс 5 зөвлөх, 9 тэргүүлэх, 11 ахлах зэрэгтэй албан хаагч ажиллаж байна.

2023-2026 онд давхардсан тоогоор 50 гаруй албан хаагч Тархвар зүй, Биостатистик судлал, Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, Нийгмийн эрүүл мэнд, Эрүүл мэндийн эдийн засаг, Нэгдсэн менежментийн тогтолцооны дотоод аудитор, Процессийн дахин инженерчлэл, Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар хамрагджээ.

Мөн сүүлийн 2 жилд давхардсан тоогоор 64 албан хаагч гадаадын 14 оронд, 39 удаагийн сургалтад мэргэжлийн чиг үүргийн дагуу хамрагдаж, мэдлэг, мэргэжлээ дээшлүүлжээ. Түүнчлэн БНСУ-ын ЗГ-ын магистр, докторын тэтгэлэгт хөтөлбөрт сүүлийн 5 жилд 5 албан хаагч амжилттай суралцан төгсөж, байгууллагадаа ажиллаж байна.

Бидний хамт олноос хүн амын эрүүл мэндийг хамгаалах, салбарыг хөгжүүлэх үйлсэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөр бүтээлээ үнэлүүлсэн Төрийн соёрхолт, Хүний гавьяат



эмч 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт 4, Алтангадас одонт 22, Хөдөлмөрийн хүндэт медальт 14, “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” 20 ажиллаж байна.



М.Одгэрэл даргатай Удирдлагын зөвлөл. 2026 он



Ж.Ундрал даргатай Эцэг эхийн зөвлөлийн хамт олон, 2026 он



Б.Алтангэрэл даргатай Хамт олны зөвлөл, 2026 он



Б.Нямсүрэн даргатай Ёс зүйн дэд хороо, 2025 он



Г.Нямдаваа ахлагчтай Спорт хамтлаг, 2026 он

ОДОО АЖИЛЛАЖ БАЙГАА АЛБАН ХААГЧИД

ЗАХИРГААНЫ АЛБА

Захирал Машбат Одгэрэл

1. Шагдарсүрэн Солонго
2. Баяраа Нямсүрэн
3. Батжаргал Байгалмаа
4. Эрдэнэчулуун Эгиймаа
5. Болдбаатар Мөнгөнзул
6. Дэлгэрбаян Уганбат
7. Баатар Атарцэцэг
8. Сүхбаатар Батбаатар
9. Наранбаатар Энхболор
10. Дэлгэрбаян Уганбат

ИХ ӨГӨГДӨЛ, СУДАЛГААНЫ АЛБА

1. Ганзориг Дамба
2. Сэрээнэндорж Даваажаргал
3. Чингэс Мичидмаа
4. Цогбадрал Болормаа
5. Хишигжаргал Дэлгэрмаа
6. Жаргалсайхан Ундрал
7. Дорж Уранчимэг
8. Баатар Солонго
9. Чинболд Батчингис
10. Даваа Сумъяа
11. Ганбаатар Ган-Эрдэнэ
12. Чадраабал Тунгалаг

ЦАХИМ ХӨГЖЛИЙН АЛБА

1. Онхоодой Мөнхбадрал
2. Нямдорж Гантулга
3. Жанлав Эрдэнэ-Очир
4. Лхагвасүрэн Гэрэлт-Од
5. Дансран Бямбасүрэн
6. Лхагважав Золжаргал
7. Эрдэнэбазар Мөнх-Оргил
8. Будмир Ган-Эрдэнэ
9. Ганбаатар Алтангэрэл
10. Алтанхуяг Нар
11. Ганбаатар Нямдаваа
12. Мягмарсүрэн Цолмон
13. Батсайхан Чулуунчимэг
14. Бат-Орших Долгормаа
15. Дэлгэрханд Гантулга
16. Бадралсайхан Мишээл
17. Дансран Намсрай

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН АЛБА

1. Дэмчиг Дондогмаа
2. Болдбаатар Дэлгэрмаа
3. Цэвэгдорж Даваахүү
4. Ганчулуун Золжаргал
5. Доржсүрэн Цацрал
6. Өлзийбаяр Сэлэнгэ
7. Баттулга Базаррагчаа
8. Энхбат Урин
9. Энхээ Батжаргал
10. Түшиг Бат-Эрдэнэ

ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН АЛБА

1. Батбилэг Болортуяа
2. Лхагва Бор
3. Батбаатар Мөнхцэцэг
4. Пүрвээ Баярцэцэг
5. Алтангэрэл Мягмарсүрэн
6. Батсайхан Болорчимэг
7. Баянтуул Мөнхбат
8. Гансүх Золжаргал
9. Цэрэндорж Цэрэндолгор
10. Гочоо Раднаа
11. Зориг Наранбаатар

ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ АЛБА

1. Баяраа Алтантулга
2. Гончигжав Батцэцэг
3. Ядам Бадамсүрэн
4. Пандаан Батчулуун
5. ПаламТунгалаг

ГАДААД ЭМЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ АЛБА

1. Ширчинням Алтанцэцэг
2. Батбаяр Одонгоо
3. Бямбаа Болдбаатар
4. Болортулга Алтангэрэл
5. Чинбаатар Баярмаа

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

1. Лувсанноров Оюунчимэг
2. Цэрэнжанцан Одончимэг
3. Намсрайжав Энхцэцэг
4. Лханаасүрэн Баянжаргал

САНХҮҮГИЙН АЛБА

1. Санжмятав Лхагвасүрэн
2. Энхтайван Арвинжаргал
3. Пүрэвжав Саранцэцэг



3.2. ЗАХИРГААНЫ АЛБА

Захиргааны алба нь нь байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, төвийн удирдлага, хүний нөөц, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, сургалт хөгжлийн бодлогыг хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг хүлээн 13 албан хаагчтайгаар ажиллаж байна.


Тус албыг Г.Мажигсүрэн, Г.Лхагвадорж, Ц.Мөнхдалай, Ц.Уранчимэг, Ц.Одончимэг, Д.Жаргалмөнх, Г.Цэцэнсанаа, Т.Содгэрэл, Л.Оюунчимэг, Н.Энхтайван, Б.Доржмягмар нар удирдаж байсан бөгөөд одоо Ш.Солонго албаны даргаар ажиллаж байна.





Хөгжлийн тухай

Бүтцийн нэгж бүрийн үйлсийг тэтгэж,
Бүтээлийн замыг бат бөх засна.
Байгууллагын хөгжлийн алтан хэмнэлийг
Багаараа хамтдаа урагшлуулна.
Удирдлагын бодлогыг түшин дэмжиж,
Урагшлах үйлсийг уялдуулна.
Хүний нөөцийн үнэ цэнийг эрхэмлэн,
Хүчирхэг хамт олныг бүтээлцэнэ.
Гадаад хамтын нөхөрлөлийн гүүрийг
Ган бат итгэлээр холбон өргөтгөнө.
Мэдлэг, туршлагын солилцоогоор
Маргаашийн хөгжлийг хамтдаа цогцлооно.
Олон нийтэд үйлсээ түгээн сурталчилж,
Ололт амжилтаа бахархал болгон хүргэнэ.
Итгэл, нэр хүндийг эрхэм болгон
Ирээдүйн өнгийг улам тодруулна.
Ажилтан бүрийн сайн сайхны төлөө
Амьдралын баталгааг эн тэргүүнд тавина.
Сургалт, хөгжлийн их өргөөнд
Сэтгэл, мэдлэгийг хамтад нь тэтгэнэ.
Хууль, бодлогыг чанд мөрдөж,
Хариуцлагын жишгийг хамтдаа бүтээнэ.
Эрүүл мэндийн хөгжлийн төлөө
Эв нэгдэлтэйгээр үргэлж манлайлна.




ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ






МЭДЭЭЛЭЛ



3.3. ИХ ӨГӨГДӨЛ, СУДАЛГААНЫ АЛБА

“Эрүүл мэндийн салбарын статистик мэдээллийн үйл ажиллагааг нэгтгэн хариуцаж, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр тасралтгүй хангаж ирсэн “Их өгөгдөл, судалгааны алба” нь ЭМХТ-ийн 30 жилийн ойн босгон дээр өнгөрсөн замнал, тэдгээрийн өгсөн бодит үр дүн, ирэх жилүүдэд тавигдах суурийг нэгтгэн харуулахыг зорьж байна.”

Энэхүү алба нь 1996 оны эрдэм шинжилгээний төслийн баг, статистик мэдээллийн төвөөс эх сурвалжтай ууган алба бөгөөд албаны анхны даргаар П.Алтанхуяг, улмаар Э.Анурад, Ц.Ганбаатар, Д.Нямхорол, С.Ариунтуяа, Н.Нарангэрэл, Ч.Зулцэцэг, Х.Ганцэцэг, Б.Доржмягмар, Б.Үзмээ нар тус тус удирдаж байсан билээ.

Нэгэн цагт тоо бүртгэгч гэдэг ганц орон тоо байсан газар өнөөдөр “Их өгөгдөл” гэдэг үгийг цогцлоон бүтээжээ. Энэ өөрчлөлт тохиолдлын хэрэг биш тоо бүртгэлээс эхэлсэн ажил өдгөө их өгөгдөл боловсруулах, дүн шинжилгээ хийх, ирээдүйг тооцоолох мэргэжлийн үйл ажиллагаа болж хувирсны илэрхийлэл юм.



Их өгөгдөл, судалгааны албаны хамт олон, 2026 он

Г.Дамба даргатай “Их өгөгдөл, судалгааны алба” нь эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон тогтолцооны судалгаа, эрүүл мэндийн эдийн засаг, үндэсний тооцоолол хийх, эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэглэгчийг нотолгоо, мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хүлээн, 13 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Монгол улсын эрүүл мэндийн статистик зуун дамнасан баялаг түүхийг бүтээн цогцлоосон нь чадварлаг эмч, мэргэжилтэн, судлаачдын нөр их хөдөлмөр, тууштай зүтгэлийн үр дүн билээ.

1996 онд Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвд Статистик мэдээллийн алба байгуулагдаж, ICD-10 ангиллыг нэвтрүүлснээр эрүүл мэндийн статистикийн тогтолцоо олон улсын стандартад нийцсэн хөгжлийн шатанд шилжсэн.

Үүний дараа H-INFO цуврал мэдээллийн системүүдийг үе шаттайгаар хөгжүүлж, 1996–2022 оны хугацаанд үндэсний хэмжээний эрүүл мэндийн мэдээллийн цахим тогтолцооны суурийг



Статистик мэдээллийн албаны хамт олон, 1998 он

бүрдүүлжээ. Энэхүү хөгжлийн үр дүнд 2019 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн төвөөс Монгол улсын эрүүл мэндийн 109 үндсэн үзүүлэлтийг баталгаажуулж, бүсийн албан ёсны мэдээллийн санд нийтэлсэн нь үндэсний эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоо олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэх чухал үйл явдал болсон.

Цаашид цахим эрүүл мэнд, их өгөгдөл, дата шинжлэл, хиймэл оюун ухааны технологийн хөгжлийг эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоотой уялдуулан ашиглах, мэдээллийн чанар, хүртээмж, шуурхай байдлыг тасралтгүй сайжруулах, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг цахим тайлагналын нэгдсэн тогтолцоонд бүрэн хамруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, залуу мэргэжилтнүүдийг тогтвортой бэлтгэх нь ирэх арван жилийн хөгжлийн тэргүүлэх чиглэл хэвээр байх болно.







ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОГТОЛЦОО, БОДЛОГЫН СУДАЛГАА

“Эрүүл мэндийн салбарын тогтолцоо, бодлогын судалгааны суурь нь 1996 онд Шинжлэх ухаан технологийн захиалгат судалгаа хийж эхэлсэн үеэс тавигдсан түүхтэй.”

Энэхүү 30 жилийн түүхэн хугацаанд хийж гүйцэтгэсэн 300 гаруй эрдэм судлалын ажил, түүний дотор 80 гаруй хувийг эзлэх бодлого, тогтолцооны судалгааны нөр их хөдөлмөр нь эрүүл мэндийн салбарт бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх, боловсронгуй болгох, өөрчлөлт шинэчлэл хийхэд үндэслэл, нотолгоот мэдээллээр хангахад ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын 50 гаруй хувь нь Монгол улсын болон олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцэгдэн олны хүртээл болсон байдаг.

Хүн амын зан үйл, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг судалсан судалгаа 20 гаруй хувийг эзэлдэг ба энэхүү судалгааны үр дүнд үндэслэн хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг дэмжих ном, гарын авлага, санамж, зөвлөмжөөр хангах, сургалт зохион байгуулах ажлууд үндэсний хэмжээнд зохион байгуулагджээ.

Мөн судалгааны бүтээлүүд нь эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт, удирдлагын арга барил, удирдах ажилтны сургалтын хэрэгцээг тодорхойлон сургалтад хамруулах, үнэлгээ хийх, ном гарын авлага бэлтгэхэд голлох эх сурвалж, нотолгоо, мэдээлэл болж байсан онцлогтой байсан.

2007-2011 онуудад байгууллагын бүтэц, стратегийн төргүүлэх чиглэлд эрүүл мэндийн салбарын бодлогын судалгаа, шинжилгээ хийх анхны бие даасан нэгж бий болж, Шинжлэх ухаан технологийн сан, ЭМЯ, ДЭМБ, НҮБ-ын ХАС зэрэг олон газрын захиалгаар судалгааны ажлууд хийж байсан.

30 жилийн хугацаанд гүйцэтгэсэн эрдэм судлалын ажил нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, төр хувийн хэвшлийн түншлэл, эрүүл мэндийн салбарын эдийн засаг, санхүү, зээл тусламж, шинжлэх ухаан технологи зэрэг өргөн хүрээгээр бодлогын судалгаа, шинжилгээг түлхүү хийсэн байдаг.





ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТООЦОО (ЭМҮТ)

Монгол улсад Эрүүл мэндийн үндэсний тооцоог (ЭМҮТ) олон улсын аргачлал, жишигт нийцүүлэн тооцож, хэрэгжүүлэх ажлын эхлэл 2002–2005 онд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлагын удирдлагыг бэхжүүлэх” төслийн хүрээнд тавигдсан.

ЭМҮТ-ыг тогтвортой хэрэгжүүлж, цаашид институтчилэн хөгжүүлэх санаачилгыг Дэлхийн банк 2009 онд дэвшүүлсэн ба энэхүү санаачилгын хүрээнд 2010 онд “Макро эдийн засаг ба эрүүл мэнд” төрийн бус байгууллага зөвлөхөөр ажиллаж, ЭМҮТ-д шаардлагатай мэдээллийн урсгал, мэдээллийн эх үүсвэр, түүнчлэн эрх зүйн орчны өнөөгийн байдалд үнэлгээ хийж, цаашид хөгжүүлэх үндэс суурийг бүрдүүлсэн.

Үүний үргэлжлэл болгон Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр 2011–2013 онд хэрэгжсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3” төслийн хүрээнд ЭМҮТ-ыг тооцох мэргэжилтнүүдийг бэлтгэж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлсэн нь тус ажлыг үндэсний хэмжээнд тогтвортой хэрэгжүүлэх чухал алхам болсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын техник туслалцааны хүрээнд ЭМҮТ-ны аргачлалыг Монгол улсын онцлогт тохируулан боловсруулах, мэдээллийн урсгалыг хөгжүүлэх болон тооцоо, судалгааг тогтмолжуулахад дэмжин ажиллаж байна. Ингэснээр эрүүл мэндийн салбарын санхүүжилт, зарцуулалт, эх үүсвэрийн талаарх бодит мэдээллийг нэгтгэн боловсруулж, салбарын бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтад ашиглах боломж бүрдсэн юм.



ЭМҮТ-ыг эрүүл мэндийн салбарын мэдээлэл, статистик, судалгааны тогтолцоонд нэвтрүүлэн, холбогдох суурь судалгаа, тооцооллыг тогтмол хийж, үр дүнг “Эрүүл мэндийн үзүүлэлт” эмхэтгэлийн “Эрүүл мэндийн эдийн засаг” бүлэгт тусган нийтэлж, олон нийтэд хүргэж ирсэн. Түүнчлэн Монгол Улсын эрүүл мэндийн зардал, санхүүжилтийн талаарх тооцоо, мэдээллийг ДЭМБ-ын Дэлхийн эрүүл мэндийн зардлын мэдээллийн санд тусгуулан, олон улсын түвшинд нийтлүүлж байна. Ийнхүү ЭМҮТ нь эрүүл мэндийн салбарын санхүүжилт, зарцуулалт, эдийн засгийн мэдээллийг цогцоор нь харуулахын зэрэгцээ үндэсний болон олон улсын түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргалтыг нотолгоонд тулгуурлан дэмжих чухал мэдээллийн тогтолцоо болон хөгжиж байна.













Мэдлэгийн их сан

Их мэдээллийн далайгаас
Их мэдлэгийн санг бүрдүүлж,
Ирээдүйн хөгжлийн чигийг тольдон,
Итгэл даах судалгааг бүтээнэ.
Өгөгдлийн өргөн цар хүрээг
Өнөөгийн шийдэл болгон боловсруулж,
Өргөн нотолгоонд түшиглэн
Өөдрөг ирээдүйн шийдлийг дэмжинэ.
Судалгаа, шинжилгээний үр дүнгээр
Салбарын хэрэгцээг тольдон харж,
Судалгаанд суурилсан шинэ мэдлэгээр
Сонголт, шийдвэрийг оновчилно.
Аливаа өгөгдлөөс үнэ цэнийг нээн,
Ач холбогдлыг судалгаагаар тодруулж,
Аливаа шийдвэрт нотолгоо болон шингэн,
Арвин их оюуны санг бүтээлцэнэ.



3.4 ЦАХИМ ХӨГЖЛИЙН АЛБА

“Монгол улсын хувьд өргөн уудам газар нутаг, хүн амын сийрэг суурьшил, алслагдсан бүс нутгийн онцлог нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт тэгш, хүртээмжтэй хүргэхэд томоохон сорилт болсоор ирсэн. Ийм нөхцөлд мэдээлэл, харилцаа холбооны технологийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх нь зөвхөн техникийн шинэчлэл бус, иргэн бүрт эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг газарзүйн байршлаас үл хамааран хүргэх үндэсний хэмжээний шийдэл байлаа.”

Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон иргэдийг нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллэр хангах үндсэн чиг үүрэг бүхий “Мэдээлэл технологийн алба” нь Эрүүл мэндийн сайдын 2024.03.05-ны өдрийн А/113 дугаар тушаалаар байгуулагдсан.

Албаны анхны даргаар Б.Доржмягмар, улмаар Б.Үзмээ ажиллаж байсан. Өнөөдөр “Цахим хөгжлийн алба”-ыг О.Мөнхбадрал удирдаж байна.



О.Мөнхбадрал даргатай Цахим хөгжлийн алба

Түс алба нь өнгөрсөн хугацаанд зайнаас оношилгоо, эмчилгээний тогтолцоог бий болгох, эрүүл мэндийн статистикийн мэдээллийг цахимжуулах, эмнэлгийн мэргэжилтний бүртгэл, лицензийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, хүний нөөцийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл солилцооны үндэсний тогтолцоог хөгжүүлэх зэрэг олон чиглэлээр эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн тулгуур бүтэц, дэд системүүдийг үе шаттайгаар бий болгожээ.

Монгол Улсын Засгийн газрын 2008–2012 болон 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт телемедицин буюу зайнаас зөвлөгөө, оношилгоо, эмчилгээний үйлчилгээг эрүүл мэндийн салбарт үе шаттайгаар нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх үндсэн байгууллагын нэг нь Эрүүл мэндийн хөгжлийн төв байлаа. Түс төв нь 2010 онд Телемедициний үйлчилгээг зохицуулах албыг байгуулснаар Монгол улсад зайн анагаах ухааныг системтэйгээр хөгжүүлэх үндэс суурийг тавьжээ.



ДЭМБ-ийн санхүүжилтаар дуу, дүрс нь тусдаа тоног төхөөрөмжийг 17 байгууллага

Audio, Video

2010



АХБ-ны санхүүжилттэй ЭМСХХ-3 төслийн хүрээнд 5 аймаг 2 дүүрэгт

Lifesize

2012



АХБ-ны санхүүжилттай JRR9136 MON төслийн шугамаар 21 аймаг

Lifesize

2013



АХБ-ны санхүүжилтээр ЭМЯ-ны харъяа 16 байгууллагыг

Lifesize

2014



Шилэн кабелын холболт 14 аймаг ЭМХТ, ХСҮТ

VPN

2016



Алсын зайн зөвлөгөө 3-р шатлалын ЭМБ-аас орон нутгийн НЭ-т

Эрүүл мэндийн статистикийн мэдээллийн цахимжилтын эхлэл нь 1994 оноос өмнөх үеэс улбаатай. Тухайн үед эрүүл мэндийн байгууллагууд статистикийн мэдээллийг DBASE III орчинд ажилладаг программ ашиглан боловсруулдаг байсан бөгөөд жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулахад 72–200 цаг тасралтгүй ажиллах шаардлагатай байсан нь мэдээллийн боловсруулалт ихээхэн хугацаа, хөдөлмөр шаарддаг байсныг илтгэнэ.

Энэ нөхцөл байдлыг шинэ шатанд гаргах зорилгоор 1994–2001 онд MNSYS программ эрүүл мэндийн салбарт нэвтэрсэн нь үндэсний хэмжээний цахим статистикийн хөгжлийн эхлэл болсон юм.

Үүний дараагийн шатанд 2001 онд хөгжүүлсэн MedInfo программ нь эрүүл мэндийн байгууллагуудын өдөр тутмын статистикийн үйл ажиллагааг илүү боловсронгуй болгож, мэдээллийг системтэйгээр боловсруулах боломжийг өргөжүүлсэн юм.

Эрүүл мэндийн статистикийн цахим шинэчлэлийн дараагийн алхам нь 2006 онд H-Info системийг улсын хэмжээнд нэвтрүүлснээр эхэлжээ.

2008 онд H-Info системийг Microsoft Windows орчинд ажиллах H-Info Version 2 хувилбар сум, өрхийн эрүүл мэндийн төв хүртэл өргөжин хүрч, анхан шатны байгууллагуудад бүрэн нэвтрэх нөхцөл бүрдсэн билээ.

1994 — Audio, Video
Dos-н орчинд төрөлт, нас баралт, эмнэлгээс гаргагч, Статионар, амбулаторийн өвчлөлийн тайлан шивдэг. ЭМБ-уудын үйл ажиллагааны тайлан, хүний нөөцийн тайлан мэдээлэл

1998 — Lifesize
Dos-н орчинд эрүүл мэндийн статистик мэдээллийг бүртгэн, тайлан мэдээллийг боловсруулан гаргадаг болсон.

2001 — Lifesize
Windows-н орчинд эрүүл мэндийн статистик мэдээллийг бүртгэн, тайлан мэдээллийг боловсруулан гаргадаг болсон.

2006 — Lifesize
MEDINFO програмын баазыг(db) хөрвүүлэн авч нөхцөлт шүүлт хайлт хийх боловсруулалтын хэсэг сайжирсан

2008 — VPN
Server-client хандалттай болж цаг бүртгэлийн модуль нэвтрүүлж эмнэлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж эхэлсэн

2014 — Lifesize
Интернэт орчинд мэдээлэл солилцдог десктоп хувилбарыг хөгжлүүлэн ЭМС-ийн 2013 оны 450 тоот тушаалын дагуу бүртгэж тайлагнаж эхэлсэн.

2022 — VPN
Програм хангамжийг веб суурьтай болгон хөгжүүлж ЭМС-ийн 2019 оны А/611 тоот тушаалын дагуу шинэчлэлтийг хийв.



Х.Ганцэцэг даргатай Эрүүл мэндийн мэдээллийн алба



Б.Үзмээ даргатай Мэдээлэл, технологийн алба

Цахим хөгжлийн жигүүр

Цаг үеийн хөгжлийн хурдад
Цахим шийдлээр хариу өгч,
Цогц технологийг түшиг болгон
Цагийн аястай хамт манлайлна.
Хөгжлийн шинэ санаа, боломжийг
Хиймэл оюун, технологиор тэтгэж,
Хурд, хүртээмж, чанарыг эрхэмлэн,
Хэрэглэгч төвтэй шийдлийг хөгжүүлнэ.
Ард иргэдийн эрүүл мэндийн төлөө
Ахиц дэвшлийг цахимаар түүчээлж,
Автоматжуулсан ухаалаг шийдлээр
Айсуй ирээдүйн боломжийг нээж,
Аялгуу нэгтэй хөгжлийг бүтээлцэнэ.



Ө.Баяр даргатай Мэдээлэл технологи, телемедициний хэлтэс



С.Солонго даргатай Мэдээлэл технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба

3.5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН АЛБА

1996 онд “Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв” байгуулагдаж, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтныг бэлтгэх, давтан сургах, эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг судалж, салбарыг хөгжүүлэх загвар, чиглэл боловсруулж, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдыг мэдээ, мэдээллээр хангах чиглэлээр сургалт, судалгаа, практик үйл ажиллагааг хэрэгжүүлж, эрүүл мэндийн удирдах ажилтны сургалтыг явуулж эхэлсэн нь одоогийн Хүний нөөцийн хөгжлийн албаны үйл ажиллагааны эхлэл тавигдсан.

1999 онд “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын алба” байгуулагдан, 2000.02.16-ны өдрөөс энэхүү шинэ албаны анхны бүрэлдэхүүнд албаны даргаар С.Өлзийсайхан, мэргэжилтнээр С.Батболд, С.Алтанбагана, Ц.Уранчимэг нар ажиллаж байв.

Албыг 2000-2012 онд С.Өлзийсайхан, үргэлжлүүлэн Ц.Амарзаяа, С.Тогтохбаяр, АУ-ны доктор, дэд профессор Д.Уранчимэг, Д.Дондогмаа, З.Наранбаатар, АУ-ны доктор, профессор Б.Амарсайхан, АУ-ны доктор Б.Дашлхүмбэ, Д.Ичинхорлоо, Б.Батцоож, Б.Отгончимэг нар удирдаж байв.

2026 оноос ХНХА-ны даргаар Д.Дондогмаа, ахлах мэргэжилтэн Ц.Даваахүү, Г.Золжаргал, мэргэжилтэн Д.Цацрал, Ө.Сэлэнгэ, Б.Болортуяа, Э.Батжаргал, Т.Бат-Эрдэнэ, Б.Базаррагчаа, Б.Дэлгэрмаа, Э.Урин нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.





Хүний нөөцийн хөгжлийн албаны хамт олон, 2026 он

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд, Гэгээрлийн сайдын 1999 оны А-133/148 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 156 дугаар тушаалаар Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, бүртгэх журам, сургалт эрхлэх байгууллагад тавигдах нийтлэг шаардлага, мэргэшлийн жагсаалт батлагдаж, эрүүл мэндийн байгууллагууд төгсөлтийн дараах сургалтыг бие даан эрхлэх эрх зүйн үндэс тавигдсан.

Төгсөлтийн дараах сургалтаар эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшил эзэмшүүлэх мэргэшлийн жагсаалтыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 156 дугаар тушаалаар батлан үндсэн мэргэшлийн 23, төрөлжсөн мэргэшлийн 117 чиглэлээр сургалт зохион байгуулж эхэлсэн.

Санхүү, эдийн засгийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2001 оны 26/38 дугаар хамтарсан тушаалаар "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг санхүүжүүлэх журам" батлагдаж, сургалтын зардлын жишгийг анх удаа тогтоож, орон нутгаас суралцаж байгаа эмч, мэргэжилтний сургалтын төлбөр, хоол, унаа, байрны зардал 140 сая ₮-ийг улсын төсвөөс анх шийдвэрлүүлж байсан. Энэ нь орон нутгийн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад үр дүнтэй ажил болсон.

Анагаах ухааны боловсрол эзэмшсэн хүний их эмч нь төгсөлтийн дараах 3 сарын сургалтаар анх үндсэн мэргэшил эзэмшиж байсан бол ЭМС-ын 2001 оны 296 дугаар тушаалаар үндсэн нарийн мэргэжлийн резидентийн сургалтыг 30-45 кредит, 1-1.5 жил байхаар сургалтын агуулгын хэмжээ, үргэлжлэх хугацааг баталж мөрдсөн.

Улмаар ЭМС, БСШУС-ын 2005 оны 140/193 дугаар хамтарсан тушаалаар төгсөлтийн дараах сургалтыг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуультай нийцүүлэн үндсэн нарийн мэргэжлийн ба төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтаар мэргэжил олгохоор тусгаж, 1 жилийн сургалтыг 44 багц цагийн агуулгатай байхаар зааж өгсөн.



ЭМС-ын 2006 оны 227 дугаар тушаал, 2007 оны 90 дүгээр тушаалаар "Дадлагажигч их эмч"-ийн ажиллах журам батлагдан хэрэгжүүлж, Анагаахын сургуулийг хүний их эмчээр төгссөн эмч нарыг 2007 оноос цалинтайгаар ажиллах эрх зүйн үндэс бүрдсэн.









Д.Уранчимэг даргатай Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны хамт олон, 2015-2016 он



С.Өлзийсайхан даргатай Эмнэлгийн мэргэжилтний сургалт, зөвшөөрлийн албаны хамт олон, 2005-2007 он



Хүний хөгжлийн тулгуур

Хүн бол хөгжлийн үнэт баялаг,
Хамт олон бол хүчний эх булаг.
Хүсэл, мэдлэг, ур чадварыг дэмжиж,
Хүн бүрийн үнэ цэнийг өргөнө.
Насан туршийн суралцах боломжийг нээж,
Нэмэгдэх мэдлэг, ур чадварыг дэмжиж,
Нягт хамтын ажиллагаанд түшиглэн,
Нэр хүндтэй, чадварлаг хамт олныг бүтээнэ.
Хөдөлмөрийн үнэ цэнийг дээдлэн,
Хүний эрх, сайн сайхныг хамгаалж,
Хамт олны итгэл, оролцоонд түшиглэн
Хөгжих орчныг бүрдүүлнэ.
Ажилтнаа хөгжүүлж, байгууллагаа хөгжүүлэн,
Авьяас чадварыг бодлогоор дэмжиж,
Арвин их мэдлэгтэй хамт олноороо
Айсуй ирээдүйн хөгжлийг бүтээнэ.
Сургалт, хөгжлийн боломжийг нээж,
Суралцах хүсэлд нь жигүүр ургуулж,
Мэргэшсэн, чадварлаг хамт олныг
Мөнхөд хөгжлийн түүчээ болгоно.





3.6 ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН АЛБА

“Эмнэлгийн үүдэнд орох хүн бүр нэг зүйлд итгэдэг. Энд над руу ирэх тусламж найдвартай байх болно гэдэгт.

Энэ итгэлийг өдөр бүр, нүдэнд харагдахгүйгээр баталгаажуулж байдаг механизм бий. Түүний нэр нь магадлан итгэмжлэл.”

1998 онд батлагдсан “Эрүүл мэндийн тухай хууль”-д магадлан итгэмжлэх үйл ажиллагааны эрх зүйн үндэс тусгагдаж, Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвд “Магадлан итгэмжлэл, лицензийн алба” анх байгуулагдсанаар эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй.

Энэхүү түүхэн замнал нь магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалт, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн сэтгэл ханамж, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ зэрэг олон чиглэлээр өргөжин тэлж, өнөөдөр олон улсын жишигт нийцсэн, бие даасан, хараат бус үндэсний магадлан итгэмжлэлийн тогтолцоог хөгжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Албаны анхны даргаар АУ-ны доктор, профессор Л.Жигжидсүрэн, мэргэжилтнээр С.Гансүх, Ө.Ганчимэг, Б.Цэцэгмаа, Б.Болдбаатар нар ажиллаж байв.



Л.Жигжидсүрэн даргатай Магадлан итгэмжлэл, лицензийн албаны хамт олон, 1999 он

Тус нэгжийн үе үеийн удирдлагаар Я.Буянжаргал, Ө.Ганчимэг, Г.Оюунцэцэг, Ш.Баттөр, Б.Цэцэгмаа, Н.Нарангэрэл, Д.Баттулга, Н.Сэвжид, М.Одгэрэл, Ш.Алтанцэцэг нар ажиллаж, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж ирсэн ба одоо Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн албаны даргаар Б.Болортуяа ажиллаж байна.



Анх магадлан итгэмжлэгдсэн байгууллагын төлөөлөл



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

БАТЛАМЖ

ДУГААР _____

_____ нь
эрүүл мэндийн тусламж,
үйлчилгээний чанарын шаардлага хангасныг
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭВ.

20__ оны __ сарын ___ хүртэл хүчинтэй.

ЗАХИРАЛ _____ Ц.СОДНОМПИЛ

Улаанбаатар хот 20___.___.___

Анхны гэрчилгээний загвар

УИХ-ын 2002 оны 58-р тогтоолыг үндэслэн Засгийн газар 2002 оны 162-р тогтоолоор Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах шийдвэр гарснаар ЭМХҮТ-ийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Эмнэлгийн тусламжийг удирдах газар" болгон өргөжүүлэн зохион байгуулснаар энэхүү агентлагийн чиг үүрэгт эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, чанарын хөтөлбөр хэрэгжүүлэх замаар эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийг хангуулах зорилгыг тусгаснаар Чанарын баталгаажилтын алба анх байгуулагдаж магадлан итгэмжлэл өргөжсөн түүхтэй.


Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 246 дугаар тогтоолоор анхны "Магадлан шинжлэх ажлын шалгуур"-ыг баталснаас хойш магадлан итгэмжлэх шалгуур нь 2006, 2008, 2011, 2014, 2019, 2020, 2026 онуудад тус тус шинэчлэгдэн батлагдсан ба АНУ, Канад, Малайз, Joint Commission International" (JCI) байгууллага зэрэг олон улсын туршлагаас суралцан, шалгуурт тусгаж ажилласан нь олон улсын магадлан итгэмжлэлтэй зэрэгцэн хөгжих боломжийг олгосон.



М.Одгэрэл даргатай магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, 2020-2022 он

Албаны бүтэц, нэршлийн өөрчлөлтийн товчоон

- *1999-2002 он: Магадлан итгэмжлэл, лицензийн алба*
- *2002-2006 он: Чанарын баталгаажилтын алба*
- *2007-2009 он: Магадлан итгэмжлэлийн алба*
- *2010 он: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн хэлтэс*
- *2011-2012 он: Эмнэлгийн тусламжийн хэлтэс*
- *2016-2017 он: Чанар, магадлан итгэмжлэлийн алба*
- *2018-2020 он: Магадлан итгэмжлэл, лицензийн алба*
- *2021-2024 он: Магадлан итгэмжлэлийн алба*
- *2025 оноос хойш: Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн алба*



SQua байгууллагын гишүүнчлэлийн гэрчилгээ

2026 онд тус төв нь Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын олон улсын нийгэмлэг (ISQua)-ийн гишүүн болсон ба дэлхийн шилдэг туршлагыг нэвтрүүлэх, хамтарсан сургалт, судалгаа, төсөл, хөтөлбөрүүдэд оролцох, судалгаа, мэдээллийн санг ашиглах боломжтой болсон.



Б.Болортуяа даргатай Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, 2026 он


HYUNDAE GENERAL HOSPITAL
9월 NEWS
몽골 보건개발센터 대표단
10人 연수 프로그램 지원!
중앙대의료원 현대병원

2023 оноос хамтын ажиллагааны хүрээг шинэ шатанд гаргаж, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Энэтхэг улсын Чанар, магадлан итгэмжлэлийн институт, Казахстан Улсын Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн төв (ACQH), Бүгд Найрамдах Солонгос Улсын Чүнг-Анг их сургууль, Хюндай эмнэлэг зэрэг байгууллагуудтай туршлага солилцох, сургалт, зөвлөлдөх уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна.













Ш.Алтанцэцэг даргатай Тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, 2025 он



С.Гансүх даргатай магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, 2005 он



Н.Нарангэрэл даргатай Чанар, магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, 2017 он

> *Чанарын удирдлагын тогтолцооны хөгжлийн нэгэн шинэ үе шат нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг үндэсний хэмжээний хөдөлгөөн болгон өргөжүүлсэн явдал байв.*

Анх 2000 оноос эрүүл мэндийн байгууллагуудад орон тооны бус "Чанарын алба" ажиллаж эхэлсэн бол, 2007 оноос бие даасан, орон тооны, байнгын ажиллагаатай "Чанарын алба"-ны бүтцэд шилжсэн нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад гарсан нэгэн чухал дэвшил байв.







Н.Сэвжид даргатай Магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, 2023 он



Н.Нарангэрэл даргатай Магадлан итгэмжлэл, лицензийн албаны хамт олон, 2019-2020 он



Д.Баттулга даргатай Магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, 2018 он

Чанарын баталгаа

Тусламж, үйлчилгээний чанарыг
Тогтмол үнэлж, сайжруулан,
Тодорхой шалгуур, үзүүлэлтээр
Түвшин, үр дүнг тольдоно.
Үйлчилгээний чанарыг эрхэмлэн,
Үнэн зөв үнэлгээ, дүгнэлтээр
Үйл ажиллагааны алдаа, зөрчлийг илрүүлж,
Үр дүнг тасралтгүй дээшлүүлнэ.
Чанартай тусламжийн төлөө
Чанд стандартыг эрхэмлэн,
Чадвар, мэргэжлийн түвшинг бататгаж,
Чанарын соёлыг байгууллага бүрд бэхжүүлж,
Чин сэтгэлээрээ зүтгэнэ.
Магадлан итгэмжлэлийн жишгийг эрхэмлэн,
Мэргэжлийн стандартыг тогтвортой мөрдөж,
Мэдлэг, арга зүйг түгээн дэлгэрүүлж,
Манлайлах чанарын соёлыг төлөвшүүлнэ.
Ирээдүйн эрсдэлээс урьдчилан сэргийлж,
Илүү чанартай үйлчилгээг төлөвшүүлэн,
Иргэн бүрийн итгэл, сэтгэлийг эрхэмлэн,
Итгэл даах чанарын тогтолцоог бэхжүүлнэ.
Аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж,
Алдаа бүрээс сургамж авч сайжруулан,
Амжилтын зөв жишгийг түгээн дэлгэрүүлж,
Арвин чанартай тусламжийг хамтдаа бүтээнэ.



3.7. ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ АЛБА

Монгол Улсын Донорын тухай хууль анх 2000 онд батлагдаж, 2018 онд шинэчлэгдэн батлагдахдаа амьд болон амьгүй донорын үйл ажиллагааны зохицуулалтыг тусгаж, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах, зохион байгуулах, хянах чиг үүрэг бүхий "Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба"-ыг тус төвийн бүтцэд байгуулсан.



Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны анхны бүрэлдэхүүн (2018 он)

Монгол Улсын Төрийн соёрхолт, Хүний гавьяат эмч, элэг шилжүүлэн суулгах мэс заслын анхдагч П.Батчулуун албаны даргаар ажиллаж, ахлах мэргэжилтэн Г.Батцэцэг, мэргэжилтэн Н. Дашдондов, П.Тунгалаг, Ц.Одончимэг, Н.Цэндмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлжээ.

Мэдээллийн системийг сайжруулах, үйл ажиллагааг цахимжуулах, хуваарилалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх, донорын нөөцийг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих, эмнэлгүүдийн хамтын ажиллагааг үр дүнтэй болгох, гадаадын ижил төстэй байгууллагууд, мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох, сургалт, семинар зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлж байна.

Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" анхдагч хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласнаар 2026.05.08-ны өдөр Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар энэхүү хууль батлагдан гарлаа.

Энэ бол амьдрал бэлэглэсэн доноруудын энэрэнгүй үйлс, итгэл найдвараа өвөрлөсөн өвчтөнүүдийн хүсэл мөрөөдөл, хүний амь насыг аврахын төлөө тангараг өргөсөн эмч, мэргэжилтнүүдийн

уйгагүй хөдөлмөр, Монголын эрүүл мэндийн салбарын хамтын бүтээл юм. Өнгөрсөн хугацаанд бий болгосон энэхүү тогтолцоо нь өнөөдөр олон арван хүний амь насыг аварч, олон гэр бүлд аз жаргал, шинэ итгэл найдвар бэлэглэж байна.



Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг 2022 он ЭМХТ



Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг 2022 он Төрийн ордон

> *Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ нь орчин үеийн анагаах ухааны өндөр хөгжлийг илтгэх, цуллаг эрхтний эмгэгийн төгсгөлийн шатанд хүрсэн эмчлүүлэгчийн амь насыг аврах чухал салбар болон хөгжиж байна.*



Хуулийн ажлын дэд хэсгийн хуралдааны үед 2026.04.20



УИХ-ын гишүүн Хууль санаачлагч Ж.Чинбүрэн болон Б.Баярбаатар гишүүн ахалсан ажлын хэсэг 2026.04.30



Тархины үхэл тодорхойлох багийг 2026 оны байдлаар 26 эрүүл мэндийн байгууллагад байгуулан ажиллаж байна.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ

2018
- Алба байгуулагдав

2019
- Донорын бүртгэл
- Үндэсний журам

2020
- Тархины үхлийн багууд

2021
- Ил тод тогтолцоо

2022
- Донорын хууль
- Зүрх шилжүүлэн суулгах баг

2023
- Чанарын шинэ шат

2024
- Цахим хөгжил

2025
- Үндэсний систем

2026
- Монгол Улсын Их Хурлаас “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль”-ийг соёрхон батлав



БНТУ-д зохион байгуулагдсан Олон улсын мэргэжилтнүүдийн уулзалт 2018 он



УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ЦССҮТ, ГССҮТ, ЭМҮТ, УХТЭ, ЭМХТ-өөс 22 хүний бүрэлдэхүүнтэй БНТУ-д олон улсын анхдугаар чуулганд оролцсон. 2018 он



Монгол Улсын Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг, 2021 он

> *Мадрид хотноо 2018 онд зохион байгуулагдсан Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах холбооны 27 дугаар хурлаар Монгол улс Истанбулын тунхаглалд нэгдэн орсон.*



Зүрх шилжүүлэн суулгах үндэсний багийн анхны хурал, 2021 он



2021он "Элэг шилжүүлэн суулгах эмчилгээг Монгол улсад нутагшуулсан нь" сэдэвт бүтээлээр Төрийн соёрхол хүртсэн хамт олон.



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын ивээл дор эрхтэн шилжүүлэн суулгуулсан иргэдийн дунд зохион байгуулсан Спортын III наадам. 2018 он



"Тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгах" сургалтыг ЭМЯ дээр зохион байгуулсан. 2018 он



Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба, 2018 он



Донор эмнэлэг, Реципиент эмнэлэг болон ЭМХТ-ийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба нар хамтран ажиллах гэрээ байгуулсан нь 2019 он



AST болон БНСУ-ын багтай хамтран зохион байгуулсан олон улсын семинар, 2018 он



“Амьдрал бэлэглэе” өдөрлөгийн хүрээнд зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэг, 2019 он

Амьдралын ариун жигүүр

Эрхтэн шилжүүлэн суулгах үйлсийг
Эрдэм, ёс зүй, хариуцлагаар түшиж,
Эмнэлгийн мэргэжилтэн, байгууллагуудыг
Эвийн хүчээр нэгэн зорилгод нэгтгэнэ.
Шинэ амьдралын найдвар тээсэн нэгэнд
Шинжлэх ухаан, технологийн ололтыг хүргэж,
Шилдэг туршлага, мэдлэгийг түгээн дэлгэрүүлж,
Шийдэл бүрийг хүнлэг сэтгэлээр уялдуулна.
Сайн үйлсээр амьдрал бэлэглэсэн донорын ариун үйлсийг
Сайтар хүндэтгэн, талархал дүүрэн дээдэлж,
Салбарын эмнэлэг, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг
Саруул ирээдүйн төлөө бэхжүүлнэ.
Үйл ажиллагааны чанар, аюулгүй байдлыг эрхэмлэн,
Үргэлж итгэл даах тогтолцоог нэвтрүүлж,
Үе үеийн их үйлсийг үргэлжлүүлэн,
Үр дүнтэй шийдэл, зөв зохицуулалтаар дэмжинэ.
Амьдрал бэлэглэх ариун үйлсийг
Ард иргэдийн итгэлтэй хамт хөгжүүлж,
Аврагдах найдвар тээсэн нэгэнд
Амьдралын шинэ боломжийг нээнэ.
Зүрх сэтгэл, эрдэм мэдлэгийг хослуулан,
Зөв ёс зүй, хариуцлагыг эрхэмлэж,
Зорилго нэгтэй хамт олны хүчээр
Зуу зуун найдварын төлөө урагшилна.
Ариун үйлсийн үнэ цэнийг дээдэлж,
Амьдралын үргэлжлэлийг итгэлээр тэтгэн,
Алхам бүрээ хүнлэг сэтгэл, эрдмээр хөтөлж,
Амьдрал бэлэглэх үйлсэд хамтдаа зүтгэнэ.
Нэг донор — олон амьдралын найдвар,
Нэгэн үйлс — амьдралын үргэлжлэл.
Эрхтэн шилжүүлэн суулгах хөгжлийн төлөө
Эрдэм, хүнлэг сэтгэлээр хамтдаа манлайлна.



Эх орондоо эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас зайлшгүй шаардлагаар болон өөрийн хүсэлтээр гадаад улсын эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлэх, иргэний эмнэлгээ сонгон үйлчлүүлэх эрхийг хангах, түүнд учрах санхүүгийн хүндрэлийг тодорхой хэмжээнд бууруулах чиглэлээр төрийн бодлогыг боловсронгуй болгох, нэгдсэн зохицуулалтаар хангах хэрэгцээ шаардлагаар тус төвийн бүтцэд 2025 онд Гадаад эмчилгээг зохицуулах алба байгуулагдсан.

Гадаад эмчилгээг зохицуулах алба нь төвийн түүхэнд отгон нэгж хэдий ч хэрэгжүүлж буй чиг үүрэг, цар хүрээ нь нийгмийн ач холбогдол өндөртэй, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн тогтолцоонд шинэ урсгал, боломжийг нээсэн юм.

Алба нь эрх зүйн орчныг бий болгох, нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ хийх, иргэдийг зөвхөн гадаадын эрүүл мэндийн байгууллагатай холбон зуучлах бус, үйлчилгээний чанарыг сайжруулан мэргэжлийн зөвлөгөө өгөх, эргэн хяналт, цахим шилжилтийг нэвтрүүлсэн, эрүүл мэндийн тогтолцооны шинэ чиглэлийг тодорхойлогч болон хөгжихийг зорин ажиллаж байна.



Ш.Алтанцэцэг даргатай Гадаад эмчилгээг зохицуулах албаны хамт олон, 2026 он

Ахлах мэргэжилтэн Ч.Баярмаа, Б.Болдбаатар, мэргэжилтэн Б.Мөнхбат, Б.Базаррагчаа, Х.Ариунзаяа нарын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж, албаны даргаар Б.Жаргалтуяа томилогдож мэргэжилтэн А.Мягмарсүрэн Х.Болорчимэг нар шинээр тус бүрэлдэхүүнд ажилласан түүхтэй.

Өдгөө Ш.Алтанцэцэг тус албыг удирдан Монгол улсад эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад улсад эмчлүүлэх иргэдэд шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөх, эмчилгээний үйл

3.8. ГАДААД ЭМЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ АЛБА

“Орчин үеийн анагаах ухаанд технологийн дэвшил, мэдээлэл солилцоо хамгийн гол нөлөө үзүүлэн хүн төрөлхтний өвчнийг эмчлэх арга технологи улам бүр боловсронгуй болж, анагаах ухааны хөгжил, улс орнуудын хамтын ажиллагаа нь дэлхий нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.”

ажиллагааны зохицуулалтыг хангах, төрийн болон мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, олон улсын эрүүл мэндийн байгууллагуудтай харилцах зэрэг хариуцлагатай чиг үүргийг 6 орон тоотой хэрэгжүүлж байна.



2025 онд Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 19 байгууллагатай, 2026 онд БНСУ-ын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн яамны Эрүүл мэндийн хөгжлийн хүрээлэнгийн харъяа 25 эмнэлэгтэй тус тус хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулжээ.

Эдгээр санамж бичиг нь Монгол улсын иргэдэд гадаад улсын эрүүл мэндийн байгууллагуудын чанартай тусламж, үйлчилгээнд хүрэх боломжийг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, мэргэжлийн хамтын ажиллагаа, эмчилгээний зохицуулалтыг сайжруулах чухал суурь болсон юм.





Эрүүл мэндийн гүүр

Гадаад эмчилгээний зохицуулалтыг
Гардан хариуцаж, зөв шийдлийг эрэлхийлэн,
Ганц ч иргэнийг орхигдуулалгүй
Гүүр болон дэлхийн шилдэг туршлагатай холбоно.

Эх орондоо эмчлүүлэх боломжийг
Эрхэм зорилго болгон нэмэгдүүлж,
Эмчилгээний шинэ арга, дэвшлийг ойртуулан,
Эрүүл мэндийн тусламжийг улам төгөлдөржүүлнэ.

Зорилтот тусламж, үйлчилгээг дэлхийтэй холбон,
Зөвлөмж, шийдлээр иргэн бүрийг дэмжиж,
Зүрх сэтгэлд ойр халамж, итгэлийг эрхэмлэн,
Зөв зохицуулалтаар эрүүл мэндийн үнэ цэнийг дээдэлнэ.

Алс холын эрүүл мэндийн байгууллагуудтай
Арвин туршлагад тулгуурласан хамтын ажиллагааг
хөгжүүлж,
Анагаах ухааны шинэ мэдлэг, технологийг эх орондоо
ойртуулан,
Ард иргэдийн эрүүл мэндийн төлөө дэлхийтэй
холбогдоно.



3.9. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг хянах, үнэлэх, төлөвлөлтийг үр дүнд чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2012 оноос Захиргаа, аж ахуйн албанд мэргэжилтэн Ч.Батнасан ажиллаж эхэлснээр Хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын эхлэл тавигдсан билээ.

2017 онд төвийн Захирлын дэргэд "Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг" анх байгуулагдан даргаар Ч.Баттулга**,** мэргэжилтэн Ц.Одончимэг, Б.Батнаран, Ш.Солонго, Б.Баттуяа нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж эхэлсэн.



Алба байгуулагдсан цагаас хойш бүтэц, бүрэлдэхүүнд доорхи өөрчлөлтүүд оржээ.

- 2017-2018 он "Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг"
- 2018-2020 он "Захиргаа, санхүү, дотоод хяналтын алба"
- 2021-2025 он "Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба"
- 2025 оноос "Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба" нэртэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Бүрэлдэхүүн:

- 2017 онд албаны даргаар Ч.Баттулга, мэргэжилтэн Ц.Одончимэг, Б.Батнаран, Ш.Солонго, Б.Баттуяа;
- 2021 онд албаны даргаар Э.Цацрал, Б.Ариунзаяа, ахлах мэргэжилтэн Ц.Одончимэг, Б.Батнаран, мэргэжилтэн Г.Жанцангүмпэн, Д.Аюуш;
- 2022 оны 2 дугаар сараас Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны даргаар Ш.Алтанцэцэг, ахлах мэргэжилтэн Ц.Одончимэг, Б.Батнаран, мэргэжилтнээр Г.Жанцангүмпэн, Л.Нар-Угтах;
- 2025 оны 3 дугаар сараас Хяналт-шинжилгээ, үнэлгээний албаны даргаар Л.Оюунчимэг, мэргэжилтэн Н.Энхцэцэг, П.Тунгалаг, Б.Баянжаргал, Э.Батжаргал;
- Одоо тус албаны даргаар Л.Оюунчимэг, Ахлах мэргэжилтэн Ц.Одончимэг, мэргэжилтэн Н.Энхцэцэг нар ажиллаж байна.



Э.Цацрал даргатай ХШҮДА-ын албаны хамт олон, 2021 он



Б.Ариунзаяа даргатай ХШҮДА-ын албаны хамт олон, 2021 он





Ш.Алтанцэцэг даргатай ХШҮДА-ын албаны хамт олон, 2022 он



Л.Оюунчимэг даргатай ХШҮ-ний албаны хамт олон, 2025 он.

Хариуцлагын жигүүр

Хариуцлагын жигүүр дэлгэн
Хөгжлийн замыг чиглүүлж,
Хяналт, шинжилгээ, үнэлгээгээр
Хамтын зорилгыг тодруулна.

Шударга ёсыг эрхэмлэн,
Шалгуур үзүүлэлтээр шинжлэн,
Шийдэл, зөвлөмжөө боловсруулж,
Шинэ хөгжлийн замыг нээнэ.

Үр дүн, ил тод байдлыг дээдэлж,
Үйл хэрэг бүхнийг урагшлуулан,
Үнэлгээ, дүгнэлтээр өнөөгийн байдлыг тодруулж,
Үйл ажиллагааны зөв чигийг гэрэлтүүлнэ.

Дотоод аудит, эрсдэлийн бодлогоор
Дэвшлийн суурийг бататгаж,
Дүгнэлт, зөвлөмжөөрөө чигийг тольдож,
Удирдлагын итгэлийг бэхжүүлнэ.

Арга зүй, зөв чиглэлээр
Ажилтан бүрээ дэмжин манлайлж,
Алсын хараа, эрхэм зорилгыг
Ажил хэрэг болгон биелүүлж,
Нэгэн зорилгын төлөө нэгдэн
Нэр төртэй хөдөлмөрлөнө.



3.10. САНХҮҮГИЙН АЛБА

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түүхийг бүтээлцсэн гучин жилийн хугацаанд санхүү нь байгууллагын тогтвортой хөгжлийн тулгуур байж, төсөв, төлөвлөлт, тайлагналт, хөрөнгө оруулалт, эдийн засгийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэн, эрүүл мэндийн салбарын бодлого, шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан санхүү, эдийн засгийн мэдээллээр хангах чухал үүргийг нэр төртэйгээр гүйцэтгэж иржээ.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/38 дугаар тушаалын дагуу Санхүүгийн алба бие даасан нэгж болон зохион байгуулагдсан.

Санхүүгийн албаны манлайлал

Готовын Мажигсүрэн нь 1971 оноос Улаанбаатар хотын банкны Гүйлгээний хэлтэст Ахлах нягтлан бодогчоор ажил хөдөлмөрийн гараагаа эхэлж улмаар Ардын боловсролын яам, АУДуС, Анагаах ухааны үндэсний хүрээлэнд Системийн болон аппаратын нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогч, 1996 оноос Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвд Санхүү, аж ахуйн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогчоор тасралтгүй ажилласан.



Ерөнхий ня-бо Г.Мажигсүрэн, туслах ня-бо Б.Очир, тооцооны ня-бо Н.Галаа, нярав Д.Дулмаа, Ч.Тунгалаг нар

Тэрээр улсад 30 гаруй жил, эрүүл мэндийн салбарт 20 гаруй жил ажиллах хугацаандаа өөрийн эзэмшсэн мэргэжил, мэдлэг, туршлагаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сурган бэлтгэх үйлсэд зориулж ирсэн. Тэрээр сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулах, эх орондоо мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай, манлайлан ажиллаж ирсэн билээ.

Болдбаатарын Очир нь 2002 оноос тус төвд нягтлан бодогчоор ажлын гараагаа эхэлж, эрүүл мэндийн салбарт 23 жилийн турш хөдөлмөрлөсөн бөгөөд Санхүүгийн албаны анхны даргаар ажиллаж байсан.

Тэрээр байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, резидент эмчийг цалинжуулах асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг өндөр хөгжилтэй оронд сургаж мэргэшүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан мэргэжилтэн юм.

Санхүүгийн баттүшиг

Санхүүгийн үйл ажиллагаа эхлэл цагаас
Салбарынхаа хөгжилд түшиг болж,
Сахилга, хариуцлагыг эрхэмлэн,
Сайн үйлсийн мөрийг бүтээлцэнэ.

Аливаа төсөв, төлөвлөгөөг
Алсын хэмжээнд зөв тооцож,
Ажлын үр дүн, тайлан бүрийг
Алдаагүй нягтлан хөтөлнө.

Нягт бүртгэл, бодит тооцоогоор
Нөөц хөрөнгийг зөв зохицуулж,
Нотолгоонд суурилсан мэдээлэл нь
Нямбай шийдвэрийн үндэс болно.

Хөгжлийн гучин жилийн замд
Хариуцлагатай үүргээ нэр төртэй биелүүлж,
Хамтын хөдөлмөр, хичээл зүтгэлээр
Хөгжлийн суурийг бат бэхжүүлнэ.

Үр дүн, ил тод байдлыг эрхэмлэн,
Үнэн зөв мэдээллийг бүрдүүлж,
Үндэслэлтэй шийдвэрт дэмжлэг болж,
Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.

Үе үеийн хамт олны хөдөлмөрөөр
Үнэт түүх, бүтээлийн мөрөө үлдээн,
Үндэсний эрүүл мэндийн хөгжлийн төлөө
Үргэлжлүүлэн хамтдаа манлайлъя.



Б.Очир даргатай Санхүүгийн албаны хамт олон, 2025 он



С.Лхагвасүрэн даргатай Санхүүгийн албаны хамт олон, 2026 он

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

4

БҮЛЭГ ДӨРӨВ

ТУУРГА ТУСГААРЛАСАН Ч ТҮҮХЭЭ БҮТЭЭЛЦСЭН АЛБАД



sudalgaa.1313.mn

ds.hdcgov.mn

4.1. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ АЛБА

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түүх нь зөвхөн нэг байгууллагын хөгжлийн түүх бус, эрүүл мэндийн салбарын бодлого, удирдлага, мэдээлэл, чанар, сургалт, инновацын хөгжлийг хамтад нь бүтээлцсэн олон байгууллага, нэгжийн хамтын замнал юм. Нийгмийн хөгжлийн хэрэгцээ, эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэл, төрийн удирдлагын бодлоготой уялдан зарим алба, нэгж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр бие даасан байгууллага болон өргөжин хөгжсөн хэдий ч тэдгээрийн эх үндэс нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хөгжилтэй салшгүй холбоотой хэвээр үлджээ.

Эдгээр нэгжүүд нь тухайн цаг үеийн хөгжлийн шаардлагыг манлайлан хэрэгжүүлж, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, эмийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо, алсын дуудлагын тусламж, амбулаторын эмчийн үзлэгийн цаг захиалгын үйлчилгээг үндэсний хэмжээнд төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Хэдийгээр өнөөдөр өөр өөрийн чиг үүрэг, бүтэц, удирдлагатайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа ч тэдгээр нь эрүүл мэндийн салбарын хөгжлийн нэгэн цогц түүхийг хамтдаа бүтээлцсэн, нэгэн үндэснээс урган гарсан байгууллагууд билээ.

Иймээс энэхүү бүлэгт Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эхлэлтэй, улмаар бие даан хөгжсөн дөрвөн чиглэлийн үйл ажиллагааны түүхэн хөгжил, салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр, өнөөгийн хөгжлийн чиг хандлагыг тоймлон өгүүлэв.



Д.Жаргалсайхан даргатай Эрүүл мэндийг дэмжих албаны хамт олон 2002 он

1941 онд Ариун цэвэр соёлын ордон нэртэйгээр эх үүсвэр нь тавигдсан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа явуулах үйл ажиллагаа нь 1999 онд Боловсролын алба, 2000 оноос Эрүүл мэндийг дэмжих алба, 2008 оноос Эрүүл мэндийн дэмжих хэлтэс, 2011 оноос Нигмийн эрүүл мэндийг дэмжих хэлтэс нэртэйгээр 2012 он хүртэл тус байгууллагын бүтцэд үйл ажиллагаа явуулж байлаа. Тус албаны даргаар В.Гармаа, Д.Жаргалсайхан, Л.Оюун, Ц.Хандармаа нар ажиллаж байсан юм. Түүнчлэн ЭМДА, НЭМХ- т Ч.Батнасан, В.Гармаа, Д.Ганганоров, Д.Болорчимэг, М.Хишгээ, Б.Баттөгс, Б.Байгалмаа, Ө. Энхмаа, Ч.Оюун, Б.Майцэцэг. С.Жаргалсайхан, Д.Уранчимэг, Д.Болдмаа, Долгорсүрэн, Г.Оюунцэцэг, Ц.Амаржаргал, Б.Болдбаатар, Ч.Сэлэнгэ, Баярмаа, Ц.Марта, Х.Оюунбилэг нар мэргэжилтнээр ажиллаж байв.



НҮЭМ-ийн ухуулан сурталчлагч багш нарыг бэлтгэх сургалт, 2000 он



Зан үйлд үйлд нөлөөлөх мэдээлэл, сургалт, сурталчилгааны арга зүйн сургалт, 2000 он

Улаанбаатар хотод эрүүл ахуйн жижиг музей байгуулагдаж "Ариун цэвэр соёлын ордон" нэртэйгээр ажиллаж улмаар энэ үеэс эхлэн улсын хэмжээнд ариун цэвэр гэгээрлийн ажлыг сайжруулах, ард иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа нь өргөжсөөр ирсэн юм. Энэхүү үйл ажиллагаа нь ЭМХТ-ийн 30 жилийн түүхэн хөгжлийн явцад улам боловсронгуй болон өргөжин хөгжиж байжээ.

Эмнэлэгт шүтсэн ард иргэдийн хандлагыг өөрчилж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн өөрсдийнх нь оролцоотойгоор эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн, хүн амд хүртээмжтэй, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэн, хөгжүүлэхэд чиглэгдэж байсан дэлхийн улс орнуудын хандлагад нийцүүлэн Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж ирсэн байна.



ЭМДХ-ийн хамт олон, 2010 он



Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн хамт олон



Ц.Март, Х.Оюунбилэг нар Хөх хотод сургалтад сууж байна.

2000 оноос Эрүүл мэндийг дэмжих алба бие даан ажиллах болсон нь үндэсний хэмжээнд эрүүл мэндийг дэмжигч байгуулага, хамт олныг идэвхижүүлэх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сурталчилгааг чанаржуулах асуудлыг шинэ түвшинд тавьсан юм.

Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааг арга зүйн хувьд боловсронгуй болгож үе тэнгийнхний сургалт явуулах, эрүүл мэндийг дэмжих байгууллагыг хөгжүүлэх, эрүүл орчныг бүрдүүлэхэд шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшинд ухуулга сурталчилгаа явуулах, хүн амд эрүүл мэндийн суурь боловсрол олгож, эрүүл зан үйлийг амьдралд төлөвшүүлэх зэрэг чиглээээр ахиц дэвшил гарсан байна.



Архангай аймгийн Цэцэрлэг сум "Тамхигүй сум", 2012



Сүхбаатарын талбай дээрх өдөрлөг

Монгол улсад Эрүүл мэндийг дэмжих сан байгуулахад ДЭМБ нь дэмжлэг үзүүлсэн билээ. НДББ-ээс санаачлан хэрэгжүүлсэн ProLead хөтөлбөрт Монгол улс орж, тэр үеийн Эрүүл мэндийг дэмжих албаны дарга Д.Жаргалсайхан нь Эрүүл мэндийг дэмжих сан бий болгох сургалтанд хамрагдаж, албаны дарга Л.Оюун зүүн өмнөд Азийн орнуудын туршлагын дагуу шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлснээр 2006 онд Монгол Улсын "Засгийн Газрын Тусгай Сангийн Тухай" хуулийн 5.4.21 -р заалтад Эрүүл мэндийг дэмжих санг багтаасан билээ. Тус сан нь анхны санхүүжилтээ тамхины албан татварын нэмэлт 2 хувиас бүрдүүлж 2007 онд 200 000 US$ -тэй тэнцэх хэмжээний санхүүжилттэй эхэлж 2012 он гэхэд нийтдээ 3 071 310 US$ хүрсэн байна. Эрүүл мэндийг дэмжих сан нь өөрийн логотой болж, сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болгонд энэхүү логог ашиглахыг зөвлөж байжээ.



Ухаалаг халамжтай эр нөхөр төслийн зохицуулагч Л.Оюун төслийнхөө үйл ажиллагааны талаар танилцуулж байгаа нь 2006 он



ЭМДХ-ийн хамт олон, 2008 он



ММСС-ийн төслөөс шаардлагатай тоног төхөөрөмж гардуулах үйл ажиллагаа, 2012 он





Л. Оюун даргатай Эрүүл мэндийг дэмжих албаны хамт олон, 2006 он





Солонгосын Эрүүл мэндийг дэмжих нийгэмлэгээс ЭМХҮТ-д "Эмнэлгийн багаж, төхөөрөмж, авто машин хүлээлгэн өгөх ёслолын үйл ажиллагаа, 2005 он

1991 он Эмнэлэг гэгээрлийн ордны суурин дээр Улсын эрүүл мэндийн сургалт арга зүйн төв (УЭМСАЗТ) дөнгөж байгуулагдаж байсан үе. Төвлөрсөн төлөвлөгөөт нийгэм (социализм)дөнгөж задраад ардчилал зах зээлийн нийгэмд орж байсан цаг. 1990-ээд оноос Дэлхий нийтээр шинэ нийгмийн эрүүл мэнд буюу хүн төвтэй нийгэм хамт олонд тулгуурласан шинэ концепци хүчтэй гарч ирж байсан.

Манай улс ч гэсэн шинэ нийгмийн эрүүл мэндийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих, мэдээлэл сургалт сурталчилгааг шинэ шатанд гаргах бодлогын чанартай шийдвэрүүдийг гаргаж байсан юм. Социализмийн үед эрүүл мэндийн сургалт сурталчилгаа ихэвчлэн халдварт өвчнийг устгах, сэргийлэх чиглэлд байсан бол шинэ нийгмийн эрүүл мэндийн зарчмаар халдварт, халдварт бус өвчнөөс сэргийлэх, сургалт сурталчилгааг эрчимжүүлж эхэлсэн юм.

Анх 1990 онд эрүүл мэндийн студийг сонирхогчийн 2 камер, 2 видео тоглуулагч зэрэг техниктэйгээр Ю.Дамбадорж ажиллуулж эхэлсэн.

Улмаар тэр үеийн Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, ЭМЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Баярсайхан нарын онцгой идэвх санаачлагын дүнд Улсын Эрүүл Мэндийн Сургалт, Арга зүйн төв (УЭМСАЗТ)-д ДЭМБ-ын хөрөнгө оруулалтаар SVHS форматын тоног төхөөрөмжөөр хангагдсан Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны мэргэжлийн “ЭСС ТВ” студийг 1994 оноос байгуулж, 1995 оноос Эрүүл мэндийн сайдын тушаалаар албан ёсоор нээсэн билээ. 2000 оны үед НҮБ ХАС, Норвегийн Лютерийн буяны байгууллагын хандив тусламжаар BETACAM форматын тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж улам бүр сайжирсан юм.

Тэр үед манай улс ганцхан Монгол телевиз мөн Оросын нэг нийт 2 суваг гардаг цаг үе байсан. Тийм ч учраас хүн ардад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг хүртээмжтэй болгох үүднээс Монгол Улсад анх удаа ЭМЯ бие даасан студитэй болсон юм.

Студийн анхны үүсгэн байгуулагч нь студийн дарга Ю. Дамбадорж, зураглаач Г.Тэмүүжин, техникч н.Батбаяр нар ажилласан бөгөөд улмаар уран сайхны удирдагч, найруулагчаар Г.Батнягт, сэтгүүлч А.Сарантуяа, найруулагч Д.Нарантуяа, эвлүүлэгч П.Анхтуяа, зураглаач, техникч Д.Амарсанаа нар нэмэгдэн ажиллаж эхэлсэн бөгөөд бүгд хуучнаар ЗХУ-д төгссөн мэргэжлийн уран бүтээлчид байсан.

Тус студи нь Монгол улсад бие даасан, мэргэжлийн, мэргэшсэн анхны студи гэдэгтэй хэн ч маргахгүй биз.

4.2. “ЭСС ТВ РАДИО СТУДИ” (1995-2011)

> *Анх ЭМСС /эрүүл мэндийн сургалт сурталчилгаа/ студи гэж нэрлэхээр төлөвлөж байсан боловч жоохон эвгүй сонсогдоод байна. ЭСС гэвэл зүгээр юм байна нэрт сэтгүүлч Ш.Гүрбазар агсан зөвлөснөөр “ЭСС ТВ студи” гэж нэрлэсэн түүхтэй.*

Хамгийн анхны бие даасан бүрэн хэмжээний нэвтрүүлгийг 1996.06.01-нд Эх үрсийн баярт зориулан хийж тэр үеийн Монгол телевизээр орон даяар нэвтрүүлж байсан.

Монгол Улсын анхны мэргэжлийн тус студи нь Монголын үндэсний телевиз, Улаанбаатар телевиз, MN-25 суваг телевиз болон бусад телевизүүдтэй улирал, жилийн гэрээ байгуулж үндэсний болон орон нутгийн хэмжээнд дамжуулан үзүүлж сургалт сурталчилгаа хийж ирсэн.



Эрүүл мэндийг дэмжих орчинг бий болгох, хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, хүн амын өвчлөлийг бууруулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, оношлогоо, эмчилгээний дэвшилтэт технологи, эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, хүүхдийг хөхөөр хооллох, иоджуулсан давс зэрэг чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах, мэргэжлийн арга зүйгээр хангах зорилгоор анхны нэвтрүүлгээ хийж эхэлснээс хойш эрүүл мэндийн нэвтрүүлэг болон сургалтын теле материалыг мэргэжлийн түвшинд бие даан бэлтгэж 7 хоногт 1-2 удаа 10-20 минутаар үзэгчиддээ МҮТВ, Улаанбаатар болон бусад телевизүүдээр үзэгч олондоо хүргэж эхэлсэн юм. 1999 оноос Давид Вагнерийн номоор бэлтгэсэн “Эмчгүй газарт” цуврал зөвлөгөө нь явуулдаг болсон нь үзэгч олны талархал хүлээсэн нэвтрүүлгүүдийн нэг билээ.

Хожим нь 2000 онд эрүүл мэндийн сургалт сурталчилгааны “ЭСС радио студи”-ийг байгуулсан бөгөөд найруулагчаар Ц.Баттөмөр сэтгүүлчээр Д.Наранчимэг нар ажилласан. Мөн дэлхий нийтийн техникийн дэвшилтэй хөл нийлүүлэн анхны график дизайнараар Д. Булганчимэг, Ш.Мөнхбат нар ажиллаж байсан.

Эрүүл мэндийн телевиз, радиогийн нэвтрүүлэг, цуврал зөвлөгөө, сэрэмжлүүлэг, сургалтын цуврал кино зэргийг хийж Монголын үндэсний телевиз болон бусад телевизүүдээр гаргахаас гадна бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбоотой ажиллаж байсан.

НҮБ болон бусад олон улсын байгууллагуудаас хэрэгжиж байгаа төслүүдийн шугамаар хийгдсэн эрүүл мэндийн холбогдолтой мэдээ мэдээлэл, сургалтын материалыг орчуулан бэлтгэж үзэгч олондоо хүргэх мөн салбарын байгууллага, хамт олны үйл ажиллагааны талаар баримтат кино, хөрөг нэвтрүүлэг, мэдээлэл сурталчилгааг бэлтгэн явуулж ирсэн.



2001 оноос Засгийн Газрын 224 дүгээр тогтоолын дагуу Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны сэдэвчилсэн төлөвлөгөө хийн радио, телевизийн нэвтрүүлэг бэлтгэж МҮТВ, МР-оор нийт хүн амд хүргэж байсан.

Мөн НҮБ-ын ХАС-ын НҮЭМ-мэдээлэл сургалт сурталчилгаа төсөлтэй хамтран "Эсэн мэнд амаржихуй", "Нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хүүхдийн эрүүл мэнд" радио, телевизийн цуврал зөвлөгөө бэлтгэн телевиз радиогоор хүн амдаа сурталчилж байсан.

Өнгөрсөн хугацаанд хийсэн бүтээсэн нь олон. "Эмчгүй газарт" 138 цуврал, "НҮЭМ" 70 цуврал, халдварт болон халдварт бус өвчин, шүд амны эрүүл ахуй, ДОХ бэлгийн замын халдварт өвчин гэх мэт эрүүл мэндийн салбарыг бүхэлд хамарсан мэдээлэл сурталчилгааг хийж байсан.

Жил бүрийн тэмдэглэлт болон эрүүл мэндийн өдрүүдэд зориулсан сэдэвчилсэн нэвтрүүлэг, зөвлөгөө, реклам сэрэмжлүүлэг бэлтгэн радио телевизийн сувгаар нэвтрүүлж, хувилж олшруулан аймаг орон нутагт түгээж ажилладаг байв.



Хүн амыг олноор хамарч, иргэдийн сэтгэлийг түгшээсэн SARS, Холёр зэрэг өвчний үед маш их идэвх зүтгэлтэй ажиллаж байсан. 2011 онд бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсан.

4.3. ЭДИЙН ЗАСАГ, ТЕХНОЛОГИЙН АЛБА

Эдийн засаг, технологийн алба нь 2003 онд байгуулагдан тухайн үеийн үр дүнд тулгуурласан санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлэхээр батлагдсан “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байгуулагдан үр дүнд тулгуурласан санхүүжилтийн гэрээ байгуулах үйл явцыг удирдан зохион байгуулж байсан.

Энэхүү үр дүнгийн гэрээнд тулгуурласан санхүүжилтийн шинэчлэлийн гол зааltууд 2011 оноос Төсвийн тухай хуульд нэгтгэгдэн орж, өнөөг хүртэл үзэл санаа нь уламжлагдан хэрэгжиж байна. Тус албаны даргаар Ж.Алтантуяа, Н.Оюунгэрэл нар ажиллаж байсан.

Албаны эдийн засгийн чиглэлийн асуудлыг Н.Оюунгэрэл, Б.Мөнхханд, Б.Ариунаа, Ц.Ганчимэг, Ш.Сабит нар хариуцан ажиллаж ЭМЯ-ны харьяа гуравдугаар шатлалын эмнэлгийн үр дүнгийн гэрээ байгуулах бүтээгдэхүүний шалгуурыг тодорхойлох, эмнэлгийн төсвийн төлөвлөлтийг эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй уялдуулан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайланд хяналт тавих, эрүүл мэндийн даатгал, төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой сайдын тушаал, холбогдох журмын төслийг үндэслэл тооцооны хамт бэлтгэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх MRI оношилгооны технологи, эрхтэн шилжүүлсэн иргэдэд үнэ төлбөргүй олгох дархлаа дарангуйлах эм, гемодиализын тусламж үйлчилгээний эдийн засгийн тооцооллыг хийж байлаа.

Тоног, төхөөрөмж, технологийн асуудлыг Б.Баяр, П.Отгонжаргал нар хариуцан тухайн үед шинээр нэвтрүүлэх шаардлагатай өндөр үнэтэй хэдий ч зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээний оношилгоо болон бусад технологийн талаар холбогдох судалгаа, нотолгоонд суурилсан мэдээллийг боловсруулж, ЭМЯ-ны тушаал шийдвэрийн үндэслэл тооцоог хийдэг байсан.

Эрүүл мэндийн технологийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлтэд зориулсан хөрөнгө оруулалтын зардлыг тооцох чиглэлээр ажиллаж ирсэн байдаг.





Ж.Алтантуяа, ЭТУГ-ын Эдийн засаг технологийн албаны хамт олон, 2004 он

4.4 ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА

ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Эм зүйн алба 2002 он

Эрүүл мэндийн сайдын 2002.12.09-ний өдрийн 285 дугаар тушаалаар Эм зүйн алба 10 хүний бүрэлдэхүүнтэй анх байгуулагдсан.



Эмийн бүртгэлийн нэгж 2006 он

Эм зүйн алба нь 2006 оноос эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн Статистик мэдээллийн албаны бүрэлдэхүүнд эмийн бүртгэлийн нэгж болон ажиллаж эхэлсэн.

Эмийн бүртгэл, мэдээллийн алба 2007 он

Эмийн тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой ЭМХҮТ-ийн бүтэц үйл ажиллагаа, стратегид өөрчлөлт ороход "Эмийн бүртгэл мэдээллийн алба" нэртэйгээр шинээр байгуулагдсан.

Эмийн бүртгэлийн хэлтэс 2009 он

2009 онд ЭМХҮТ нь ЗГХА-ЭМГ-болон өөрчлөгдсөн ба "Эмийн бүртгэлийн хэлтэс" болон зохион байгуулагдсан.



Эмийн бүртгэл баталгаажуулалтын хэлтэс 2010 он

2010 онд ЗГХА-ЭМГ-ын үйл ажиллагааны чиг үүрэгт эмийн баталгаажилтын асуудал нэмэгдэн үйл ажиллагаа нь өргөжиж Эмийн бүртгэл, баталгаажуулалтын хэлтэс (ЭББХ) болон өөрчдөгдсөн.

2010 онд эмийг сурталчилахад баримтлах ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, эмийг жороор олгоход дэмжлэг үзүүлэх замаар эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, эмийн бүртгэлийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай чирэгдэлгүй болгох үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж эхэлсэн.



Эмийн зохицуулалтын хэлтэс 2011 он

Тус хэлтэс эмийн чанар аюулгүй байдлын талаар төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдлага, ажиллагсдыг мэдээллээр ханган ажилласан төдийгүй цаашид хамтран ажиллах эхлэлээ тавьсан нь иргэд чанартай аюулгүй эмийн тусламж,үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал алхам болсон байна.



Эмийн зохицуулалтын алба 2015-2016 он

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Орчин үеийн эмийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, уламжлалт эм, тангийн үйлдвэрлэлийг өргөтгөх” стратегийн зорилтын хүрээнд Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 13 дугаар тушаалаар “Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх” журмыг шинэчлэн батлсан. Энэхүү журамд хяналтын хатуу зохицуулалттай эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн эмийг түргэвчилсэн журмаар МУ-ын эмийн бүртгэлд бүртгэх хугацааг богиносгон зааж өгсөн нь эм бүртгүүлэх хүсэлт гаргасан байгууллагад учрах чирэгдлийг багасгасан зарчмын өөрчлөлт оруулсан.



2016 онд Эмийн зохицуулалтын алба (ЭЗА)-ыг эмийн бүртгэл, мэдээний сан, эмийн аюулгүй байдал гаж нөлөөний үнэлгээ, мэдээлэл, бүртгэлийн дараах тандалт судалгаа, зохистой хэрэглээ, импорт, экспортын лиценз олгох бүхий 8 орон тоотойгоор өөрчлөн байгуулсан.

ЭЗА нь эмийн бүртгэл, импорт, экспортын лиценз олголт, зохистой хэрэглээ, гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл, зах зээлийн тандалт судалгаа, зар сурталчилгаа, эмийн хэрэглэх зааврын баталгаажилт, лайсмед мэдээний цахим систем нэвтрүүлэх чиглэлээр ажилласан байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн алба

ЭМС-ын 2016 оны А/203 дугаар тушаалын дагуу Эмийн зохицуулалтын алба нь 2017 оны 1-р сараас эхлэн Эм, эмнэлгийн хэрэгслийн алба болж бүтэц зохион байгуулалтын хувьд шинэчлэгдэн, зайлшгүй шаардлагатай эмийн үнэ, хангамж, хүртээмжийн мэдээний сан, эмийн худалдан авалтын мэдээний сангийн чиг үүргүүдийг нэмэлтээр хэрэгжүүлэн ажилласан.

> *“Эрүүл мэнд, спортын сайдын 2015.03.25-ны 79 дүгээр тушаалаар ЭМХТ-д эмийн бүртгэл, мэдээний сан, эмийн аюулгүй байдал гаж нөлөөний үнэлгээ, мэдээлэл, бүртгэлийн дараах тандалт судалгаа, зохистой хэрэглээ, импорт, экспортын лиценз олгох бүхий чиг үүрэг бүхий 7 орон тоотойгоор Эмийн зохицуулалтын албыг байгуулсан.”*



Эм, эмнэлгийн хэрэгслийн алба нь эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын лиценз олголт, эмийн зохистой хэрэглээ, гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл, зах зээлийн дараах тандалт судалгаа, эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа болон эмийн хэрэглэх зааврын баталгаажилт зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлэн, эмийн мэдээллийн Лайсмед цахим сангийн тогтвортой үйл ажиллагааг ханган ажилладаг.

Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлын хүрээнд “Антибиотикийн талаарх мэдлэгийг сайжруулах” сэдэвт 7 хоногийн аяныг жил бүр улсын хэмжээнд зохион байгуулдаг болсон.

Элэгний С вирусийн эсрэг АНУ-ын “Харвони”, Энэтхэгийн “Ледвир”, “Ледифос”, “Хедсинат-ЛП”, “Вирпас” эмийг улсын бүртгэлд бүртгэж зах зээлд хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн.





Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба 2018-2020

2018 онд Эм, эмнэлгийн хэрэгслийн албыг 14 орон тоотой эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба болгон өөрчлөн зохион байгуулсан.

- Эмийн чиглэлээр – 9
- Тоног төхөөрөмжийн чиглэлээр – 5 мэргэжилтэн ажиллах болсон



Эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, шалгалт тохируулгыг хийж баталгаажуулж, баталгаатай тоног төхөөрөмжөөр үйлчлэх үйл ажиллагааг тогтмолжуулсан.



ЗГХА-ЭМГ-ын Эмийн зохицуулалтын хэлтсийн хамт олон, 2011-2012



ЗГХА-ЭМГ-ын Эмийн бүртгэл, баталгаажуулалтын хэлтэс, 2010-2011




AAW 2015





4.5. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЛБА

Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2014 оны 357 дугаар тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтцэд "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн алба" анх байгуулагдсан. Тус алба нь эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах, инженер, техникч нарын мэргэшлийг дээшлүүлэх, нэгдсэн цахим мэдээллийн сан үүсгэх, шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгааг гаргаж шийдвэр гаргагчдыг бодит мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байв.





Анх байгуулагдахад Эрүүл мэндийн яамны харьяа 10 эрүүл мэндийн байгууллагын инженерүүдийг цалингийн сантай нь татан ажиллуулсан бөгөөд анхны бүрэлдэхүүнд:

- Улсын нэгдүгээр төв эмнэлгээс С.Зоригоо
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс Р.Энхсүрэн
- Улсын гуравдугаар төв эмнэлгээс Б.Батцоож
- Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс Б.Санж-Очир
- Халдвар өвчин судлалын үндэсний төвөөс Ж.Халиунаа нар шилжин ирж ажиллажээ.

Эрүүл мэндийн салбарын хэрэгцээ шаардлага, цаг үеийн өөрчлөлттэй холбогдон тус алба нь бүтэц, зохион байгуулалтын хувьд дараах үе шатуудыг туулж өнгөрүүлжээ.

2014 онд Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын хяналт, сургалт, бүртгэл мэдээллийн алба

2015 онд Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба (ЭМС-ын 79 дүгээр тушаал).



С. Солонго даргатай Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, 2015 он



Ж. Баатар даргатай Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, 2018 он



Д.Тамир даргатай Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, 2018 он



Ш.Энхзаяа даргатай Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба



Эдүгээ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны тавьсан суурь бааз, үүсгэсэн салбарын стандарт, цахим систем, мэргэшсэн хүний нөөц нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, чанарын хяналтын нэгдмэл тогтолцоо болон үргэлжлэн хөгжиж байна.

Энэхүү чиг үүрэг нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар” байгуулагдсанаар тус алба нь чиг үүргийнхээ дагуу тус агентлагт шилжсэн.

4.6. АЛСЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН АЛБА

“Алсын түргэн тусламжийн үйлчилгээ нь анх Ардын эрүүлийн хамгаалах яамнаас хөдөөгийн хөдөлмөрчдөд болон малчдад нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор 1935 онд Улсын клиникийн төв эмнэлгийг түшиглэн байгуулагдсан түүхтэй. Тухайн үед морин өртөөгөөр хөдөө орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байжээ.”

1965 он: Эрүүлийг хамгаалах яаманд Бага эмч Хас-эрдэнэ, Мишигдорж, жолооч Будсүрэн, Жагварал, Тогмид нар бүрэлдэхүүнтэйгээр ГАЗ-51 маркийн машинаар УГТЭ-ийн мэдрэлийн мэс заслын эмч Хайрула, мэс заслын эмч Рэнцэндорж, халдвартын эмч Гаамаа, дотрын эмч Рагчаа нарын бүрэлдэхүүнтэйгээр дуудлаганд явж байв.

1974–1988 он: Эрүүл мэндийн яамны Эмчлэн сэргийлэх хэлтэст харьяалагдан, мэргэжилтэн З.Лувсанбалдан хариуцаж, бага эмч Батсүх, Долгор, Лувсанпүрэв, жолооч Бунчинсүрэн, Тогмид, Сандагдорж, Цэрэннадмид нар ажиллаж ГАЗ-69 маркийн машин, мөн онгоц, галт тэргээр тусламж үзүүлж байжээ.



Алсын дуудлагын жолооч

Г.Дорждагва, 1978 он

- 1999 он: Нийслэлийн яаралтай тусламжийн төв (/103/-ийн дэд дарга Д.Пүрэвсүрэн, жолооч Б.Наранцогт, С.Бүрэнтөгс, Г.Дорждавга) болон ЭМЯ-ны харьяа эмнэлэг төвийн эмч нар алсын дуудлаганд явах үйл ажиллагааг хэрэгжүүлж байв.
- 2004 оны 07-р сарын 1: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эмнэлгийн тусламжийг удирдах газарт шилжиж, мэргэжилтэн Оюунцэцэг хариуцан, бага эмч Ж.Баянчимэг, Б.Ууганбаяр, Д.Энхээ, А.Цэрэннадмид, жолооч Б.Наранцогт, С.Бүрэнтөгс, Г.Дорждавга нар ажиллаж эхэлжээ.
- 2005–2009 он: ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газарт харьяалагдаж, тус газрын мэргэжилтэн Ч.Баярмаа хариуцан, нягтлан бодогч П.Энхболор, бага эмч Д.Энхээ, А.Цэрэннадмид, Ж.Баянчимэг, Б.Ууганбаяр, жолооч Б.Наранцогт, С.Бүрэнтөгс, Г.Дорждавга нар УАЗ-469, Тоёото маркийн автомашинаар алсын дуудлагад үйлчилж байв.

Алсын дуудлагын бага эмч Ж.Ууганбаяр, жолооч, Г.Бүрэнтөгс Алсын дуудлаганд явуулж байгаа нь , 2005 он

- 2009-2014 он хүртэл Эрүүл мэндийн хөгжлийн төвд бага эмч Д.Энхээ, А.Цэрэннадмид, Ж.Баянчимэг, Б.Ууганбаяр, жолооч Б.Наранцогт, С.Бүрэнтөгс, Г.Батдэлгэр,Г.Цогт-Адьяа нар ажиллаж УАЗ-469, Тоёото маркийн автомашинаар алсын дуудлагад үйлчилж байв.



Алсын түргэн тусламжийн дуудлагын албаны хамт олон, 2009 он

Албаны удирдлага, зохицуулалт: Өнгөрсөн хугацаанд тус үйл ажиллагааг Ардын эрүүлийг хамгаалах яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Нийслэлийн яаралтай тусламжийн төв, ЗГХА-Эмнэлгийн тусламжийг удирдах газар зэрэг байгууллагууд зохион байгуулж ирсэн. 2005 оноос ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийг удирдах газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд харьяалагдаж, алсын түргэн тусламж дуудах өвчний жагсаалт, журам шинэчлэгдэн яаралтай тусламжийн шуурхай бэлэн байдлыг хангаж ажилласан.

- 2004–2014 онуудын үйл ажиллагаа: Хөдөө орон нутгаас ирж байгаа дуудлагыг 24 цагаар хүлээн авч, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан өвчний нэршлийн дагуу төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, клиникийн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нараас хуваарь авч, нарийн мэргэжлийн болон зөвлөх эмч нарын багийг томилон ажиллуулж байв.
- Бүтэц, орон тоо (2005–2014 он): ЭМЯ-нд байрлаж байх үедээ нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байжээ. Үүнд:
  - Алсын түргэн тусламж хариуцсан мэргэжилтэн – 1
  - Санхүү хариуцсан ажилтан – 1
  - Алсын түргэн тусламж хариуцсан ажилтан – 4
  - Дуудлагын жолооч – 3

Алсын түргэн тусламжийн үйлчилгээний чиг үүргийг дээрх нэгж 2014.10.01-ний өдөр хүртэл хэрэгжүүлж байгаад Эрүүл мэндийн сайдын 2014.08.11-ний өдрийн "Алсын дуудлага, явуулын эмнэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 263 дугаар тушаалаар УГТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ, УНТЭ-т орон тоо, цалингийн сангийн хамт шилжсэн.


4.7. ДУУДЛАГА ЗОХИЦУУЛАХ АЛБА

Иргэдэд эрүүл мэндийн тусламжийг нэг алхам ойртуулсан нь

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800-0119 тусгай дугаарт суурилсан дуудлага зохицуулах үйлчилгээг эхлүүлсэн нь эрүүл мэндийн салбарын зохион байгуулалтад шинэчлэл авчирсан юм. Анх дуудлагын 11 ажилтан нийслэлийн 6 дүүргийн Эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгийн цагийг утсаар товлон олгох хэлбэрээр эхэлж байв.









2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Дуудлага зохицуулах алба” албан ёсоор байгуулагдаж, 2021 оны 2 дугаар сарын 9-нөөс Д.Бямбасүрэнгийн удирдлага дор 7 хүний бүрэлдэхүүнтэй эхлүүлсэн. Улмаар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг зэрэг нийт 13 байгууллагатай хамтран ажиллаж, тухайн эрүүл мэндийн байгууллагаас дадлага туршлагатай 30 цахим бүртгэлийн ажилтныг дуудлагын төвд ажиллуулсан. Ийнхүү үзлэгийн цаг товлолтыг нэгдсэн байдлаар зохицуулах, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэх боломж бүрдсэн бөгөөд үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн сайдын А/478 тушаалаар батлагдсан журмын дагуу хэрэгжиж иржээ.

“1800-0119 дуудлагын утас нь анх үйл ажиллагаа явуулж эхэлсэн жилд буюу 2020 онд 221,154 дуудлага хүлээн авч үйлчилж байсан бол 2025 оны байдлаар даруй дөрөв дахин их буюу 948,955 мянган дуудлага хүлээн авсан. Таван жилийн хугацаанд нийт 7,675,787 дуудлага хандснаас 5,203,858 (67.8%) дуудлагад бүрэн үйлчилсэн үзүүлэлттэй байна.”



Байгуулагдсанаас хойш эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттайгаар нэвтэрч, нийт 40 эрүүл мэндийн байгууллага (дүүргийн эрүүл мэндийн төв 8, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 9, аймгийн БОЭТ, Нэгдсэн эмнэлэг 21, хөдөөгийн Нэгдсэн эмнэлэг 2)-д нэвтрүүлэн хамтран ажиллаж байгаа бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2020.10.16-ны өдрийн А/478 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн цаг товлох үйлчилгээг утсаар зохицуулах журам”-ын дагуу үйл ажиллагаа зохицуулан ажилласан.

- Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг /9/ - УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ХСҮТ, ГССҮТ, СЭМҮТ, АӨСҮТ
- Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг /7/ - БЗДЭМТ, БГДЭМТ, СБДЭМТ, СХДЭМТ, ХУДЭМТ, ХУДНЭ, ЧДЭМТ, НДЭМТ
- Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ /21/ - Хэнтий НЭ, Баянхонгор НЭ, Баян-өлгий НЭ, Дундговь НЭ, Булган НЭ, Говь-алтай НЭ, Архангай НЭ, Говьсүмбэр НЭ, Дархан-Уул НЭ, Дорноговь НЭ, Дорнод БОЭТ, Завхан НЭ, Өвөрхангай БОЭТ, Орхон БОЭТ, Өмнөговь БОЭТ, Төв НЭ, Сүхбаатар НЭ, Увс НЭ, Ховд НЭ, Хөвсгөл НЭ
- Хөдөөгийн Нэгдсэн эмнэлэг /3/ - Мандал сумын НЭ, Замын-Үүд сумын НЭ, Хэнтий-Бор-өндөр сумын НЭ

2025 оны 2-р сард чиг үүргийн дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Цахим эмнэлэгт 1800-0119 дуудлагын утасны үйл ажиллагаа шилжсэн.





Мэргэжлийн тусламжийг орон зайнаас үл хамааран хүргэсэн нь

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн нэг чухал чиглэл нь төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг орон нутагт нутагшуулах, оношилгоо, эмчилгээний чадавхыг бэхжүүлэх, орчин үеийн технологийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэхэд чиглэж ирсэн.



Тус төв нь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүдийн дүрс оношилгооны шинжилгээний хариуг зайнаас унших, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, оношилгооны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь Монгол Улсад телемедицинийг оношилгооны практикт үр дүнтэй ашиглах шинэ боломжийг бүрдүүлсэн юм.

Зайн оношилгооны төвийн үйл ажиллагааг төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн өндөр ур чадвартай дүрс оношилгооны эмч нараас бүрдсэн мэргэжлийн баг хэрэгжүүлсэн.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ-өөс тархи, нуруу нугас, хүүхэд, гэмтэл согогийн чиглэлээр мэргэшсэн Б.Эрдэнэбулган, Ц.Отгонтуяа, Л.Амартүвшин, Х.Хонгорзул, Б.Ариун-Эрдэнэ, Х.Тэлмэн нар ажиллаж, орон нутгийн эмч, мэргэжилтнүүдэд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

Зайн оношилгооны төв нь үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш 2025 оны 1, 2 дугаар сард 17 эрүүл мэндийн байгууллагад дүрс оношилгооны чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, нийт 556 шинжилгээний хариуг телемедициний технологиор зайнаас гаргасан байна. Үүнд толгой, хүзүү, сээр, хэвлий, цээж, бүсэлхий нурууны тодосгогчтой болон тодосгогчгүй КТ, цээжний рентген зураг, шөрмөсний хэт авиан шинжилгээ зэрэг оношилгоо багтжээ.

4.8. ЗАЙН ОНОШИЛГООНЫ ТӨВ:

“Орон нутагт оношилж, эмчлэх боломжгүй өвчин эмгэгийг оношлох, эмчлэх хүний нөөцийг бэхжүүлэх, технологи нутагшуулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг аймаг, дүүрэгт нутагшуулах ажлыг эрчимжүүлсэн. Энэ хүрээнд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дүрс оношилгооны хариуг зайнаас бичих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, нэгдсэн мэдээний сан үүсгэх чиг үүрэг бүхий “Зайн оношилгооны төв” 2024.12.17-нд байгуулагдав.”

Иймхүү өндөр түвшний мэргэжлийн оношилгоог орон нутагт хүргэснээр төвлөрлийг бууруулах, оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн эмч, мэргэжилтнүүдэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон юм.

2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс Зайн оношилгооны төвийн үйл ажиллагааг Улсын хоёрдугаар төв эмнэлэгт шилжүүлсэн нь тусламж, үйлчилгээний залгамж чанарыг хадгалан үргэлжлүүлэх дараагийн үе шат болсон.

НЭГЭН ТҮҮХИЙН ХОЛБООС — НЭГЭН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ЗАЛГАМЖ

Эрүүл мэндийн салбарын хөгжил нь байгууллагын нэр, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөхөөс үл хамааран мэдлэг, туршлага, хүний нөөц, үнэт зүйлсийн залгамж чанараар үргэлжилдэг онцлогтой. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эхлэлтэй эдгээр алба, нэгжүүд нь өөр өөрийн чиглэлээр бие даасан хөгжилд хүрсэн ч нэгэн цаг үед мөр зэрэгцэн ажиллаж, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих үндэсний бодлогыг хэрэгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулжээ.

Өнгөрсөн он жилүүдэд хуримтлуулсан туршлага, хүний нөөцийн чадавх, хамтын ажиллагааны үнэт өв нь эдгээр байгууллагын өнөөгийн хөгжлийн бат бөх суурь болж, өнөөдөр ч эрүүл мэндийн салбарын шинэчлэл, цахим шилжилт, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдсан бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Иймхүү нэгэн байгууллагын хөрсөнд соёолсон эдгээр алба, нэгжүүд өөр өөрийн хөгжлийн замналаар бие даан хөгжсөн хэдий ч эрүүл мэндийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр, хуримтлуулсан мэдлэг, туршлага, нийтлэг зорилгоороо харилцан уялдаатай байж, эрүүл мэндийн хөгжлийн түүхийн нэгэн чухал хэсгийг хамтдаа бүтээлцжээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

5

БҮЛЭГ ТАВ

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД 19)-ЫН ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР



Eburtgel.hdc.gov.mn

STATA

5.1. ЦАР ТАХЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Эрүүл мэндийн хөгжлийн төв нь 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 15-ыг дуустал хугацаанд ЭМЯ болон УОК-ын Шуурхай штабт Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хариуцан ажиллалаа.”

Нэг.Тусгаарлан ажиглах байранд резидент эмчийг дайчлан бие даалган ажиллуулсан талаар:

Олон улсын хөл хорионы үеэр БНСУ-аас яаралтай нутаг буцах шаардлагатай хавдрын болон бусад хагалгааны дараах, жирэмсэн, өндөр настай зэрэг иргэдээ хүлээн авах үйл ажиллагаа эхлэхэд УОК-ын шийдвэрээр 2020.03.02-ны өдөр ирсэн 138 иргэнийг хүлээн авч тусгаарлах байранд байршуулах, тусламж, үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн хоол ундыг нь зөөж өгөх, эрүүл мэндийг нь 1 сар хянах, асрамжлах харицлагатай ажил бидэнд хувиарлагдсан.

Энэ үед тусгаарлан ажиглах байранд баримтлан ажиллах эрх зүйн баримт бичиг байхгүй байсан ба мэргэжлийн байгууллагуудтай хамтран тусгаарлан ажиглах байранд баримтлах халдвар хамгаалал, иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зааавар гараагүй байсан бөгөөд бид богино хугацаанд сургалтанд хамруулах, хамгаалах хувцас хэрэгсэл, зайнаас халуун хэмжигч, яаралтай тусламжийн хайрцаг зэргээр ханган Бага баян амралтад тусгаарлах үйл ажиллагаанд 1 их эмч, 8 резидентийг анх удаа дайчлан ажиллуулж билээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төв энэ үеэс эхлэн тусгаарлан ажиглах байранд дайчлагдах резидент эмч нарыг бэлэн байлгах, хувиарлах, нэг сарын хугацаанд ажиллах сургалт явуулах, хамгаалах хувцас хэрэгсэл, зайнаас халуун хэмжигч, яаралтай тусламжийн хайрцаг зэргээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлуудыг хариуцан ажилласан бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Түр зааавар батлах тухай” А/269, “Түр зааавар батлах тухай” А/278 дугаар тушаалаар тус тус батлуулж эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Тусгаарлан ажиглах байранд ажиллах резидент эмч нарын нэрсийг УОК-д хүргүүлэн Шуурхай штабын даргаар баталгаажуулан томилон ажиллуулж байсан ба резидент эмч нар нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

- Иргэдийг хүлээн авах, бүртгэх, өрөөнд хуваарилах;
- Иргэдийн халууныг өдөрт 2-5 удаа хэмжих;
- Архаг хууч өвчтэй иргэдийг хяналтад авах, яаралтай тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх;
- Нарийн мэргэжлийн эмчийн тусламж шаардлагатай иргэдэд төрөлжсөн мэргэжлийн эмчтэй холбогдож, эмчийн удирдлага дор тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Халдварын сэжигтэй иргэдийг тусгаарлах, ХӨСҮТ-д мэдээллэх;
- ЗӨСҮТ-д уламжлан халдвартай өрөө, тасалгааны ариутгал, устгалыг зохион байгуулах;

- Иргэдэд халдвар хамгаалал болон сэтгэлзүйн зөвлөгөө өгөх;
- Иргэд болон буудал, онцгой, цагдаагийн ажилтан албан хаагчдын халдварын сэргийлэлт, хяналтын дэглэм мөрдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд Шуурхай штабт хандан зөрчлийг уламжлан буудал хариуцсан офицерт мэдэгдэн шийдвэрлүүлэх;
- Тусгаарлан ажиглах байрны цэвэрлэгээ, ариутгалд хяналт тавих;
- Иргэдэд өдөрт 5 удаа цай, хоол зөөж үйлчлэх;
- Иргэдийн ар гэрээс ирсэн зөвшөөрөгдсөн эргэлтийг зөөвөрлөн хүргэх;
- Иргэдийн санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- Иргэдийн бүртгэлийг УОК-ын Шуурхай штабын бүртгэл хариуцсан мэргэжилтэн болон burtgel.mohs.mn-д бүртгэх;
- Иргэдийн мэдээллийг анх ирэхэд, дунд үед, тусгаарлалтаас гарах үед шинэчлэн засварлах;
- Тусгаарлах байрны тайлан мэдээг өдөр бүр УОК-ын Шуурхай штаб, ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ-д мэдээллэх;
- Иргэдэд зориулсан зөвлөмжийн баталгааны маягтыг тусгаарлах хугацаа дуусахаас 1-2 хоногийн өмнө иргэдээр үнэн зөв бөглүүлж баталгаажуулах;
- Гэрийн ажиглалтад байх хугацаанд тандалт судалгаа хийх зорилгоор хувийн гар утсанд Eruulmend аппликейшнийг суулгаж, хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгөх.

> *Мөн Нийслэлийн шалган нэвтрүүлэх 6 товчоонд 250 резидент эмчийг 2 сарын 27-ны өдрөөс 3-р сарын 30-ны өдөр хүртэл дайчлан ажиллуулсан. Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоогоор дамжин өнгөрсөн давхардсан тоогоор 500,000 иргэдийн халууныг үзэж, тархвар зүйн судалгаа хийх ажлыг гүйцэтгэсэн.*







Мөн орон нутгийн иргэдээс шинжилгээ авах цэгт 774 резидент эмч тус тус дайчлагдсан байна.

2021 оны 9 сар хүртэлх хугацаанд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан тусламж, үйлчилгээ, тусгаарлан ажиглах байранд ЭМС-ын 17 тушаалаар давхардсан тоогоор 5892 резидент эмч дайчлагдан ажилласан.





> *Улсын онцгой комиссын шийдвэрээр тусгаарлан ажиглах байр, нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан халдварын эсрэг хариу арга хэмжээнд 2020 оны байдлаар 44 тусгаарлан ажиглах байранд 320 удаагийн томилгоогоор 755 резидент эмч давхардсан тоогоор 963 удаа дайчлагдан ажилласан.*

Хоёр. Нөөц, хангамж, санхүүгийн чиглэлээр:

Анх 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Багабаян амралтанд тусгаарлалт авахад 1 их эмч, 8 резидент эмчийн нэг удаагийн хамгаалах хэрэгслийг ЭМХТ-өөс хариуцан 20 төрлийн 26,425,300.00 төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл, эм тариагаар хангасан.

Улсын онцгой комиссын Шуурхай штабаас ирүүлсэн Тусгай үүргийн нислэгийн хуваарийн дагуу тусгаарлан ажиглах байр, түүнд ажиллах резидентийн төлөвлөлт, хуваарийг гарган хамгаалах хувцас хэрэгслийн хангалтын тооцоог тухай бүр боловсруулж, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж ажилласан. Хангалтыг ХӨСҮТ-өөс татан авч, тусгаарлан ажиглах байруудад хуваарилан хүргүүлж ажилласан.

Хангалтыг тасалдалгүй хангах чиглэлээр доголдол гарсан даруй ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад хандан албан бичиг илгээн тасалдсан хамгаалах хэрэгслийн асуудал, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг шийдвэрлүүлэн ажиллаж байв.

Мөн ЭМЯ-тай хамтран зайнаас халуун хэмжигч, түргэвчилсэн оношлуур, даралтын аппарат, чагнуур, тамедины уусмал зэрэг нэмэлт хангалтыг тасралтгүй олгож байсан ба тусгаарлалтын үйл ажиллагаа дуусах бүрд үлдсэн хамгаалах хэрэгслийг буудлын менежерт тоо хэмжээгээр нь хүлээлгэн өгч, дараагийн ээлжинд шилжүүлэн хэрэглэж байсан.

Жишээ нь: Нэг резидент эмчид шаардлагатай 21, 7 хоногийн хамгаалах хувцас хэрэгслийн тооцоог харуулбал:

21 хоног

- Нэг удаагийн халад – 126 ширхэг
- Нэг удаагийн малгай – 126 ширхэг
- Нэг удаагийн маск – 126 ширхэг
- Нэг удаагийн улавч – 126 ширхэг
- Нэг удаагийн бээлий – 150 хос /3 хайрцаг/
- Комбинзон – 6 ширхэг
- Нүүрний хаалт – 4 ширхэг
- N95 маск – 6 ширхэг
- Оношлуур – 9 ширхэг
- Спирт – 0.5 литр

7 хоног

- Нэг удаагийн халад – 20 ширхэг
- Нэг удаагийн малгай – 50 ширхэг
- Нэг удаагийн маск – 100 ширхэг
- Нэг удаагийн улавч – 126 ширхэг
- Нэг удаагийн бээлий – 100 хос /2 хайрцаг/
- Комбинзон – 18 ширхэг
- Нүүрний хаалт – 18 ширхэг
- Нүдний шил-18
- N95 маск – 6 ширхэг
- Оношлуур – 5 ширхэг
- Спирт – 0.2 литр
- Санитол- 0,5







Батлагдсан тохиолдол илрэх, иргэд нэмэгдэх зэрэг урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсч хэрэглээ нэмэгдэх болсонтой холбоотой хамгаалах хувцас, хэрэгслийн хүрэлцээ тасалдахаас сэргийлэн тус төвөөс 2 автомашиныг хангалтын үйл ажиллагаанд дайчлан ажиллуулсан.

Мөн резидент эмч нарыг хамгаалах хувцас хэрэгсэл, бусад хангалтад тооцоотой байх талаар зааварчилга өгснөөр захиалгыг 2 хоногийн өмнө нэгтгэн авч тасалдал үүсгэлгүйгээр шуурхай хүргэлтийг зохион байгуулж ажилласан.

Гурав. Тусгаарлан ажиглах байранд ажиллах хүний нөөцийн судалгааны чиглэлээр:

Тусгаарлан ажиглах байранд болон нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоонд ажиллах хүний нөөцийн судалгаа, мэдээллийг цаг тухайд нь гарган УОК болон ЭМЯ, НЭМГ-т хүргэж, шийдвэр гаргагчдыг мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байв. Үүнд:

Сургалт эрхлэх 21 байгууллагад 30 мэргэшлийн чиглэлээр суралцаж буй 1819 резидент эмчийн дэлгэрэнгүй судалгаа (үндсэн

мэргэшлийн чиглэл, үндсэн болон одоогийн харьяалал, дамжаа, бага насны хүүхэдтэй эсэх, жирэмсэн эсэх, дайчилгаанаас чөлөөлөгдөх бусад шалтгаан);

Нийслэлийн шалган нэвтрүүлэх 6 товчоонд ажиллах АШУҮИС болон Уламжлалт анагаах ухааны технологийн хүрээлэнгийн 250 резидент эмчийн судалгаа;

2020-2021 оны үндсэн мэргэшлийн сургалтын шинэ элсэлт, төгсөлт болсонтой холбоотойгоор 11 дүгээр сард резидент эмч нарын судалгаанд тодотгол хийсэн бөгөөд тухайн үед 1992 резидент эмч суралцаж байснаас дайчилгаанд ажиллах боломжтой 1251 эмчийн судалгаа;

КОВИД-19 халдварын цар тахлын дэгдэлттэй холбоотой тусгаарлан ажиглах байранд ажиллах хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, сургалтад хамруулан, шуурхай дайчилгаанд томилон ажиллуулах 118 резидент эмчийн судалгаа;





Дөрөв. Тусгаарлан ажиглах байранд ажиллах резидент эмч нарт зориулсан сургалтын чиглэлээр:

2020 он:

- ЭМЯ-ны ТЗУГ-ын даргын баталсан сургалтын удирдамжийн дагуу “Коронавирус болон томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн тусламж, үйлчилгээ, халдвар хамгаалал, хариу арга хэмжээ”, “Үжил, үжлийн шок”, “Шингэн нөхөх эмчилгээ”, “Амьсгалын дистресс хам шинж”, “Цар тахлын үеийн иргэдийн болон эрүүл мэндийн ажилтны сэтгэцийн тусламж үйлчилгээ” сэдэвт 5 багц сургалтыг 7 байршилд зохион байгуулж, 1854 резидент эмч;
- Нийслэлийн шалган нэвтрүүлэх 6 товчоонд ажиллах резидент эмч нарт зориулан НЭМГ, НҮБ-ын Монгол дахь шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Тархвар зүйн судалгаа” сэдэвт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, 250 резидент эмч;




- Улсын онцгой комиссын Шуурхай штабын Ажиллагааны багаас ирүүлсэн төлөвлөгөөний дагуу тухайн сард томилогдон ажиллах резидент эмч нарт “КОВИД -19 цар тахлын халдварын үеийн тусгаарлан ажиглах байранд ажиллах арга зүй” сэдэвт сургалтыг 25 удаа зохион байгуулж, тусгаарлалтад ажилласан 741 резидент эмч;






ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны албатай хамтран тусгаарлан ажиглах байрны халдвар хамгаалал, хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах, иргэд болон байрны ариутгал, халдваргүйтгэлийн талаар зааварчилж, дадлага сургуулилалтыг хийлгэж байсан.


Мөн иргэдэд хоол түгээх, тусгаарлан ажиглах байрны цэвэрлэгээ үйлчилгээ, халдвар хамгааллын байдалд хяналт хийх талаар арга зүйгээр хангасан. Сургалтад ЭМЯ-аас тусгаарлан ажиглах байр, цар тахлын үед эмнэлгийн мэргэжилтний гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой ЭМС-ын тушаал, зааврыг танилцуулж, иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн зохион байгуулах талаар чиглэл өгч ажиллаж байв.

Резидент эмч нарын сургалтуудад УОК-ийн Шуурхай штабын иргэдийн бүртгэл, буудлын санал гомдол хариуцсан ажилтан, “Интер актив” ХХК-ны ажилтнууд тогтмол оролцож, burtgel.mohs.mn сайтын хэрэглээ, тусгаарлах байрнаас гарах иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийх, мэдээ тайлан өгөх урсгал, иргэдээс гарсан гомдол

саналыг уламжлан шийдвэрлүүлэх талаар зааварчилга өгч байв.

“КОВИД-19 халдварын хяналт, сэргийлэлт”, “КОВИД-19 халдварын ариутгал халдваргүйтгэл”, Сэтгэлзүйн тусламж үйлчилгээ”, “Цар тахлын үеийн хүүхдийн эрэмбэлэн ангилалт”, “КОВИД-19 халдварын эмнэл зүй, тусламж үйлчилгээ” 5 багц сэдвээр цахим сургалтыг зохион байгуулж, 1901 резидент хамрагдсан. Цахим 5 хичээлийг төвийн цахим хуудсанд байршуулсан.





Тусгаарлан ажиглах байрны халдварын хяналт, сэргийлэлт, ариутгал, халдваргүйтгэл” сэдэвт цахим сургалтыг УОК-ийн Шуурхай штаб, ХӨСҮТ-тэй хамтран зохион байгуулж, тусгаарлан ажиглалтын 27 байранд ажиллаж байгаа 58 резидент эмч нар оролцож, резидент эмч нарын санал, тулгамдаж буй асуудлыг сонсож, холбогдох байгууллагад нь уламжилан шийдвэрлүүлж байв.

Сургалтад УОК-ийн Шуурхай штабын гишүүн Д.Эрдэнэтуяа, Х.Ганцэцэг, ХӨСҮТ-ийн захирал Д.Нямхүү, Тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал Д.Наранзул, тандалт судалгааны албаны эмч нар, ЭМХТ-ийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны мэргэжилтнүүд оролцон заавар зөвлөгөө өгсөн.

2021 он:

Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор Резидент эмч нарын хөдөлмөрийн хөлсийг тогтоон, 2021 оны 1 дүгээр сараас эхлэн Сургалт эрхлэх байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулсантай холбогдуулан “Резидент эмч нарыг суралцан ажиллуулах” шинэ харилцааг зохицуулахад мэдлэг дадлага олгох сэдвээр 2021 оны 5-р сарын 14-нд Эрүүл мэндийн хөгжлийн төвд зохион байгуулсан. Сургалтад Эрүүл мэндийн сайд асан Т.Мөнхсайхан, ЭМХТ-ийн захирал АУ-ны доктор Б.Нарантуяа, Удирдлагын академийн профессор, доктор Б.Уранцэцэг нар оролцож нийт 30 резидент эмчийг хамруулж ажилласан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед дайчлагдан ажиллах Резидент эмч нарын сэтгэл зүйгээ бэлтгэх, үйлчлүүлэгчийн сэтгэл зүйг хэрхэн дэмжих талаар мэдлэг олгох цахим сургалтыг 2021 оны 5-р сарын 08-нд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал АУ-ны доктор

Б.Нарантуяа, АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч, СЭМҮТ-ийн НЭМ, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа эрхэлсэн дэд дарга В.Баярмаа нар оролцож заавар зөвлөгөө өгсөн. Сургалтанд цахимаар нийт 90 резидент эмч хамрагдсан.





"Резидент эмчээ сонсоё" цахим уулзалт, хэлэлцүүлгийн тэмдэглэл сэдэвт сургалтаар Үндсэн мэргэшлийн сургалтанд суралцаж буй резидент эмч нарын саналыг сонсох, санал солилцох чиглэлээр уулзалтанд ЭМХТ-ийн захирал АУ-ны доктор Б.Нарантуяа, Эрүүл мэндийн хөгжлийн зуун ассоциацын тэргүүн Т.Мөнхсайхан, Зөвлөх О.Чимэдсүрэн, 250 резидент эмч нар оролцож санал солилцсон.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Дайчлан ажиллуулах тухай" А/338 дугаар тушаалаар нийслэлийн хэмжээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн тусламж үйлчилгээнд дайчлагдан ажиллах резидент эмч нарт Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн эмнэлзүйн эрэмбэлэн ангилалт, үзлэг, зөвлөгөө, амь тэнссэн үеийн үнэлгээ, тусламж, шок болон анафилаксын үеийн тусламж үйлчилгээний талаар мэдлэг олгох, чадавхижуулах сэдвээр 2021 оны 05-р сарын 31-нд цахимаар зохион байгуулагдсан. Сургалтанд ЭМХТ-ийн захирал АУ-ны доктор Б.Нарантуяа, УНТЭ-ийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, Зөвлөх зэргийн эмч Л.Алтансүх, ХӨСҮТ-ийн Агаар дуслын халварын тасгийн их эмч Г.Дүвчинбаяр нар оролцож сургалтанд нийт 245 резидент эмчийг хамруулж мэдээлэл арга зүйгээр хангаж ажилласан.

"Тусгаарлан ажиглах байранд дайчлагдан ажиллах резидент эмчийн үүрэг, хариуцлага, зохион байгуулалт, халдвараас сэргийлэх, дэглэм" сургалтыг 2021 оны 09-р сарын 03-ны өдрийн 14:00 цагт танхим болон цахимаар зохион байгуулсан.

Сургалтаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед гадаад улсаас ирсэн иргэнийг тусгаарлах байранд тусгаарлан ажиглах үйл ажиллагаанд дайчлагдан ажиллах резидент эмч нарт ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой хууль тогтоомж танилцуулах, тусгаарлах байранд халдвараас сэргийлэх дэглэм мөрдүүлэх талаар мэдлэг олгох зорилгоор төвийн захирал Б.Нарантуяа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ахлах байцаагч Г.Батсүрэн, Цагдаагийн ерөнхий газрын хурандаа О.Чингэсболд, Улсын онцгой комиссын шуурхай

> *Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Дайчлан ажиллуулах тухай" А/223 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган нийслэлийн дүүргүүдэд дайчлагдах резидент эмч нарт коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн эмнэл зүйн эрэмбэлэн ангилалт, үзлэг, зөвлөгөө, дайчилгааны үеийн резидент эмчийн ёсзүй ба эрх зүйн асуудлаар мэдлэг олгох сэдвээр 2021 оны 4-р сарын 21-нд танхим болон цахимаар зохион байгуулсан. Сургалтанд ЭМХТ, ХӨСҮТ, НЭМГ, АУ-ны магистр, хууь зүйн ухааны магистр, Монголын анагаах ухааны эрхзүйн холбооны тэргүүн Э.Ганбат нар оролцож резидент эмч нарт мэдлэг олгож ажилласан.*

штабын А.Саранцэцэг нар оролцож резидент эмч нарт мэдээлэл өгч ажилласан.



Сургалтанд танхимаар 35, цахимаар 50, нийт 85 резидент эмч, сургалт эрхлэх байгууллагын дарга, арга зүйч нар оролцож тусгаарлан ажиглах байранд мөрдөх журам, резидент эмчийн үүрэг, эрх зүйн орчин, халдварын дэглэм мөрдүүлэх, тусгаарлан ажиглах байранд дайчлагдан ажиллахад тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо.

Тусгаарлан ажиглах байранд томилогдсон резидент эмч нарт Резидент эмчийн үүрэг, хариуцлага, зохион байгуулалт, халдвараас сэргийлэх дэглэмийг томилогдсон хугацаа бүрт цахим хэлбэрээр телеграмийн групп үүсгэн мэдээлэл аргазүйгээр хангаж, гарсан санал гомдлыг цаг тухайд нь хэлэлцэж шийдвэрлэж ирсэн.







Тав. Резидент эмч нарт үзүүлсэн дэмжлэг:

2020 он:

Цар тахлын үед ажиллаж буй резидент эмч нарт цалин хөлс болон урамшуулал төсвийн асуудлыг шийдвэрлүүлэн олгосноос гадна тусгаарлан ажиглах байранд ажиллах резидент эмч нарын дархлааг дэмжих зорилгоор хунчир, Витамин Д3, иммунактив, аарцны ундаа зэрэг бүтээгдэхүүнүүдийг олгосон.


Тус төвийн II байрны дотуур байранд амьдардаг резидент эмч нарыг тусгаарлалтын хугацаанд түрээсийн төлбөрөөс бүрэн чөлөөлсөн.


Эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа резидент эмч нараа урамшуулан “Биднийг эх орон дуудсан” аяныг санаачлан хэрэгжүүлж байгууллагынхаа цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулан алдаршуулсан нь тэдний урам зоригийг дэмжсэн ажил болсон юм.





Мөн ажиглалтад байгаа иргэд тус байранд ажиллаж байгаа эмч, цагдаа, онцгой байдлын газрын ажилтан, албан хаагчдын үйл ажиллагааг үнэлж талархлын захидлыг ирүүлж байсныг байгууллагын цахим хуудаст байршуулж талархлыг тухай бүрд нь уламжилж байсан.







Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Эх үрсийн баярыг тохиолдуулан тусгаарлан ажиглах байранд ажиллаж байгаа 39 резидент эмчийн 54 хүүхдэд баярын бэлэг гардуулж цар тахлын аюулаас иргэдээ хамгаалан ажиллаж буй резидент эмч нарт төдийгүй тэдний гэр бүлд анхаарал хандуулсан хэрэг байлаа.





2021 он:

Дайчлагдан ажилласан, ковидын халдвар авсан, улаан бүсэд ажилласан 5521 (давхардсан тоогоор) резидент эмч нарт Эрүүл мэндийн сайдын тушаалаар нийт 550 сая төгрөгийн мөнгөн урамшуулал, хоолны мөнгөнд 298 сая төгрөг олгон, дайчилгааны хугацаанд нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангаж, улсын төсвийн санхүүжилтээр суралцаж буй орон нутгийн резидент эмч нарыг дотуур байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх зэрэг зохицуулалтыг бодлогын түвшинд хэрэгжүүллээ.

“Мөн дайчлагдан ажилласан, төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын багц цаг биелүүлсэн эхний ээлжний 92 резидент эмчид ЭМС-ын 2021 оны А/489 дүгээр тушаалаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эмчлэх зөвшөөрлийг 5 жилийн хугацаатайгаар олгож дэмжлэг үзүүлж ажилласан байна.”

Эрүүл мэндийн сайдын тушаалаар нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг зохион байгуулсан тусламж, үйлчилгээ, тусгаарлан ажиглах байранд дайчлагдан ажилласан 60 резидент эмчийг **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ “ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ”-**ээр шагнаснаас төлөөлөл болгон Улсын нэгдүгээр төв эмнэлэг,Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 12 резидент эмчид шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан ба үйл ажиллагаанд төвийн захирал Б.Нарантуяа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ахлах байцаагч Г.Батсүрэн, Улсын онцгой комиссын шуурхай штабын А.Саранцэцэг, Цагдаагийн ерөнхий газрын хурандаа О.Чингэсболд нар оролцож резидент эмч нарт хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд идэвхи зүтгэл гарган, үр бүтээлтэй ажиллахыг хүслээ.





Зургаа: Мэдээлэл харилцаа, тандалтын чиглэлээр:

Тус төв нь 2020 оны 3 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн “Коронавируст халдварын цар тахлын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний мэдээг” өрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлгүүд зэрэг 21 аймаг, нийслэлийн 478 эрүүл мэндийн байгууллагаас, 2022 оны 8 дугаар сараас эхлэн хувийн эмнэлгүүдийг хамруулан нийт 725 эрүүл мэндийн байгууллагаас burtgel.mohs.mn програм хангамжийн дагуу мэдээг хүлээн авч нэгтгэн өдөр тутамд Эрүүл мэндийн яам болон холбогдох газруудад цахимаар хүргүүлэн ажиллаж байлаа.

Үүнд:

- 2021 оны 01 сарын 01-ны өдрөөс PCR болон антиген илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан эрүүл мэндийн ажиллагсад, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, сайн дурын шинжилгээнд хамрагдсан хүний тоо, нийслэлийн дүүргүүдэд хийгдэж буй шинжилгээний цэгүүдийн мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эдийн засгийн газарт тус тус цахимаар хүргүүлэн ажилласан
- Түргэвчилсэн антиген шинжилгээний мэдээг өдөр тутамд УОК-ын нарийн бичгийн даргад,
- Сар тутмын “Эрүүл мэндийн статистик мэдээлэл”-ийг шинэчлэн, боловсруулж мэдээлэл хэрэглэгчдэд,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд сар тутмын мэдээллийг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулан тоон мэдээллүүдийг цаг тухайд нь,
- ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газар болон Бодлого төлөвлөлтийн газарт хүн амын нас баралтын мэдээлэлд дүн шинжилгээ, график дүрслэлийн хамт сар тутамд,
- Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын мэдээлэлд Төрөлт, нас баралт, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, мэс засал, эрүүл мэндийн байгууллагуудын Коронавирусийн халдварт зориулан хэвтүүлэн эмчлэх орны ашиглалт, орны тоо зэргийн мэдээг нэгтгэж байлаа.
- Мөн Коронавирусийн халдварын сэргийлэлт, хяналт, оношилгоо, эмчилгээнд эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдээг өдөр тутам нэгтгэн хүргүүлж байсан бөгөөд өдөрт дунджаар 602 эмч, 774 сувилагч, 73 орчим тархвар зүйч, 1499 орчим эрүүл мэндийн бусад ажилтнууд нийт 2948 эрүүл мэндийн ажилтнууд ажиллаж байлаа.

Эрүүл мэндийн яам болон байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу шаардсан тоон мэдээлэл болон бусад эрүүл мэндийн

> *“Эрүүл мэндийн сайдын Зөвлөхийн үүрэг даалгаврын дагуу Коронавируст халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын мэдээллээр 6 удаагийн өдөр тутмын болон 7 хоног тутмын мэдээлэл бэлтгэж цахимаар хүргүүлсэн.”*

статистикийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь бүрэн гүйцэд мэдээлж ажилласан. Үүнд:

ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газарт эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 8 удаа, Нийгмийн эрүүл мэндийн газарт хүн амын өвчлөл, эндэгдэлтэй холбоотой 4, Төрийн захиргаа удирдлагын газарт хүний нөөц, хүчин чадлын мэдээлэл 6 удаагийн гэх мэт мэдээллүүдийг цаг тухайд нь гарган цахимаар хүргүүлсэн.

Эрүүл мэндийн статистик бүртгэл, тайлангийн "Health Info v3.0" системд шинэчлэлт өөрчлөлтүүдийг хийж нэмэлтээр Коронавируст халдвар (КОВИД-19)-тэй холбоотой нэмэлтээр дараах хөгжүүлэлтийг хийж мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөн /үйлчлүүлэгч/-д хийх үнэлгээний хуудас /Маягт 1/
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөний өөрийгөө хянах хуудас /Маягт 2/
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөний зөвшөөрлийн хуудас / Маягт 3/
- Коронавируст халдвар /КОВИД-19/-тай гэрийн тусгаарлалтад байгаа өвчтөний эмчилгээ, хяналт;
- Коронавируст халдвар /КОВИД-19/-тай өвчтөний магадлагаа үүсгэж eMongolia, Түц машин аар гаргах сервис үйчилгээний хур системтэй холболтын үйл ажиллагаа;
- ХУР системээс магадалгааны QR холболт хийх;
- Гэрийн хяналтын ЭМДааталын нэхэмжлэлийг .xml-ээр илгээж ЭМДаатгалын мэргэжилтэнгүүдэд Эмнэлзүйн мэдээллийг хянах боломжийг бүрдүүлсэн.
- БАТЛАГДСАН COVID19 Эмнэлэгт хэвтсэн, ГЭРИЙН ХЯНАЛТЫН ЭМЧИЛГЭЭНИЙ болон ойрын хавьтлын магадлагаа;
- Магадлагааг иргэнд хүргэх үйлчилгээ Өрхийн эмнэлэг, E mongolia,ТҮЦ машин;
- COVID-19-ын шалтгаант нас баралтын нэмэлт мэдээлэл зэргийг нэмэлтээр оруулсан мэдээ, мэдээллээр ханган ажилласан.

> *"ЭМЯ-ны 2021.04.19-ний өдрийн 4/1940 албан бичгийн дагуу Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үеийн мэдээ, мэдээллийг цуглуулах, дамжуулах, хянах, тайлагнах болон байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж, ор бүхий эмнэлгүүдийн бүртгэлийг хийх ажлыг зохион байгуулах, тоо мэдээнд хяналт тавих үүрэг өгөгдсөний дагуу өдөр тутамд ЭМБ-ын мэдээлэлд хяналт тавьж ажилласан."*

Долоо. Бусад үйл ажиллагаа

Коронавируст халдвар (ковид 19)-ын цар тахлын салбарын хүний нөөцийн судалгаа, мэдээлэл гаргах, сургалт зохион байгуулах, тусгаарлан ажиглах байранд ажиллах резидент эмч нарын томилгоо, тэдний өдөр тутмын удирдлага, зохион байгуулалт, хангалтыг хариуцаж, өвчлөлийн мэдээ, мэдээллийг нэгтгэх, дархлаажуулалт болон шинжилгээ авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байв.



Ахлах мэргэжилтэн Д.Баярхүү, Б.Батнаран, мэргэжилтэн Б.Болдбаатар, Т.Түмэнбаяр, П.Мидриймаа, Н.Энхцэцэг нар Улсын онцгой комиссийн Шуурхай штабт, "Зөвлөгөө өгөх 119" төвд мэргэжилтэн Б.Отгончимэг, Ц.Даваахүү, Л.Оюунбилэг нар ажиллаж үүрэг гүйцэтгэв.

Энэхүү ажлын хүрээнд нийслэлийн хэмжээний 100 цэгт сорьц авах багийг бүрдүүлэх, багийн бүрэлдэхүүнийг бэлтгэх, бэлэн байдлыг хангах үүднээс доорхи сургалтуудыг зохион байгуулж, хүний нөөцийг бэлтгэсэн.

- Тандалт шинжилгээний сорьц цуглуулах, тээвэрлэх арга зүй, био аюулгүйн үйл ажиллагаа;
- Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага;
- Гэрэгэ системс программтай ажиллах, бүртгэл хийх арга зүй;
- Ариутгал, халдваргүйтлийн ажилтан бэлтгэх;
- Хөл хорионы үед утсаар үйлчлүүлэгчдэд Ковид-19 өвчний зөвлөгөө өгөх арга зүй.

Хөдөө орон нутгаас их дээд сургуульд суралцаж, сургуулийн дотуур байранд тусгаарлагдсан оюутнуудыг гэрт нь буцаах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд төвийн албан хаагчид, резидент эмч нартай хамтран 6000 оюутнаас түргэвчилсэн оношлууараар шинжилгээ авах ажлыг зохион байгуулсан.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компанийн 3000 гаруй ажилчдаас шинжилгээ авлаа.

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны хүсэлтээр БНХАУ-аас ажиллахаар ирж байгаа болон нутаг буцаж буй 500 гаруй иргэнээс Ковид19-ын шинжилгээ авч, сорьцыг НЭМҮТ болон ЗӨСҮТ-д хүргэн, хариуг англи хэл дээр олгох ажлыг зохион байгуулан ажиллажээ.

"Тус төвийн албан хаагчид цар тахлын үеийн үйл ажиллагаанууд идэвхтэй оролцож ирсэн ба Улсын онцгой комиссын даргын 2021.02.06-ны өдрийн 12 дугаар тушаалаар нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хязгаарлалтын дэглэм тогтоосон 11 хоногийн хугацаанд "Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээг зохион байгуулан ажилласан."





Hr.hdc.gov.mn

acc.hdc.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

6

БҮЛЭГ ЗУРГАА

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



1313.mn
hinfo.mn

6.1. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн түүх нь эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэлтэй салшгүй холбоотой төдийгүй олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнууд, мэргэжлийн болон судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үе шаттайгаар өргөжүүлж ирсэн түүхэн замналтай.”

Тус төв нь байгуулагдсан үеэс эхлэн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, чадавхжуулах чиглэлээр ДЭМБ, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Дэлхийн зөн, Азийн хөгжлийн банк, Хил хязгааргүй эмч нар, АДРА зэрэг олон улсын байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж ирсэн.

Мөн Дэлхийн банкны “Санхүүгийн бүртгэлийг шинэчлэх”, Германы GTZ-ийн “Эрүүл мэнд-боловсрол”, Францын Санте-Сюд ТББ–ын “Сумын эмнэлгийг хөгжүүлэх”, Люксембург-Монголын засгийн газрын хоорондын “Зүрх судасны өвчний оношилгоо теле-анагаах ухаан”, Норвегийн тусламжийн байгууллагын “Эрүүл мэндийн хөгжил”, Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийг дэмжих, бохир гарын өвчнөөс сэргийлэх” АНУ, Мерси-Корпус хөгжлийн агентлагийн “Мал амьтнаас хүнд халдварлах өвчин”, Туркийн Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Бага насны болон сургуулийн насны хүүхдийг ахуйн болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх” (хүүхэлдэйн кино), Монгол-Италийн “Эмнэлгийн яаралтай тусламж ба анагаах ухаан” зэрэг төслийг хэрэгжүүлжээ.

Түүнчлэн ДОХ-ын үндэсний төв, ДОХ-той тэмцэх үндэсний сан, Монголын нээлттэй нийгэм форум (МННХ), Японы Жайка, Глобаль сан, Японы JOICEP, JBC (Japanese business center), Tokushima Их сургууль, БНСУ-ын Эрүүл мэндийг дэмжих нийгэмлэг, Рафаэл Интернейшнл клиник ТББ зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлж, судалгаа шинжилгээ хийх, хүний нөөцийг чадавхжуулах, сургалт семинар зохион байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг чиглэлээр зөвхөн өөрийн байгууллага төдийгүй эрүүл мэндийн салбарын бусад байгууллагуудтай хамтран ажиллах нөхцлийг нь бүрдүүлэн хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна.



ЭМЯ-ны дэд сайд Н.Удвал, ТНБ-ийн дарга Ц.Содномпил нар БНХАУ-ын ЭМ-ийн дэд сайд болон газрын дарга нарын хамт, 2004 он



Австрийн ЭМ-ийн Сайдын айлчлал, ЭМХҮТ-ийн захирал С.Дуламсүрэн, албадын дарга нар, 2004 он


1996–2006 оны хооронд ЭМХТ нь эрүүл мэндийн бодлого боловсруулах, хүний нөөцийн сургалт, эрүүл мэндийн боловсрол, магадлан итгэмжлэл, лицензийн тогтолцоог хөгжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд Азийн хөгжлийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол-Германы хамтарсан НҮЭМ-ийн төсөл зэрэг олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн төслүүд хэрэгжүүлж Ази, Европын олон улсын түншүүдтэй мөн Монголын Нээлттэй нийгэм хүрээлэн, Дэлхийн Зөн, ADRA, Францын Хил хязгааргүй эмч нар зэрэг олон улсын Төрийн бус байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн салбарын чадавхийг бэхжүүлж ирсэн түүхтэй.

2007-2019 оны хооронд тус төв нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, эрүүл мэндийн статистик, мэдээлэл, судалгаа, цахим хөгжил, телемедицин, магадлан итгэмжлэл зэрэг олон чиглэлээр олон улсын туршлага, аргачлалыг Монгол Улсад нэвтрүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, салбарын шинэчлэлийг дэмжих чиглэлээр Солонгос, Япон, Хятад, Америк, Австрали, Энэтхэг, Тайвань, Итали, Франц, Орос, Турк зэрэг олон улс орнуудтай болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), НҮБ-ын Хүн амын сан (UNFPA), НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Дэлхийн зөн, Азийн хөгжлийн банк (ADB), Хил хязгааргүй эмч нар (Médecins Sans Frontières), ADRA, ЖАЙКА, КОЙКА зэрэг олон улсын нэр хүндтэй байгууллагуудтай урт хугацааны, үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн байна.

2020 оноос эхлэн гадаад хамтын ажиллагаа тогтвортой өргөжиж, Люксембургийн Вант Улсын Засгийн газар, БНСУ-ын Гёнги мужийн Тамгын газар, БНСУ-ын Эрүүл мэндийн нийгмийн халамжийн яам

> *“2018 оноос төвийн чиг үүрэгт эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа, 2024 оноос салбарын цахим шилжилт, 2025 оноос иргэдийн гадаад эмчилгээний зохицуулалт зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд эдгээр чиг үүргээ уялдан гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаа улам бүр өргөжиж байна.”*







болон KHIDI (БНСУ-ын эрүүл мэндийг хөгжлийн хүрээлэн), International education exchange association (IEEA), Soonchunhyang Их сургууль NSD KOTRA, KOREA Их сургуулийн Ансан эмнэлэг, Chung-Ang Их сургууль, "NSDevil", Meere компани, First eye center, Gangnam brand Eye Clinic, Apgujeong S&B eye clinic, Япон улсын Засгийн газар, Францын олон улсын ФЕРДИ, Энэтхэг улсын топ эмнэлгүүд болох Фортис, Аполло, Макс эрүүл мэндийн групп, Турк улсын USHAS ULUSLARARASI, Global medical, Ажибадем их сургууль, Ажибадем эмнэлэг, Medicana, Лив эмнэлэг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын эмнэлгийн хүрээлэн, Олон улсын Монгол эмнэлгийн хороо, Казакстан улсын Accreditation center for Quality In Healthcare, ОХУ-ын Rosatom Medscan зэрэг байгууллагуудтай тогтвортой хамтын ажиллагаатай ажиллаж байна.











ДЭЛХИЙН ТУРШЛАГЫГ МОНГОЛД НУТАГШУУЛСАН ҮНДЭСНИЙ БАГ

Энэ хүрээнд 2024-2025 онд 6 эрүүл мэндийн байгууллагын 9 багийн 40 гаруй эмч, мэргэжилтэн 5 улсад 9 чиглэлээр суралцсан. Үүнд:

- “Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээ” чиглэлээр ЭНЭҮТ-ийн 5 их эмч, дүрс оношилгооны техникч, сувилагч БНЭУ-ын Сарвадоя эмнэлэгт 1 сар;
- “Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээ” чиглэлээр УХТЭ-ийн 5 их эмч, сувилагч, дүрс оношилгооны техникч БНХАУ-ын И да эмнэлэгт 2 сар;
- “Дээд болон доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил, гэмтлийн мэс засал” чиглэлээр ГССҮТ-ийн 2 эмч БНХАУ, ӨМӨЗО-ны АУИС-ийн гэмтлийн эмнэлэг, БНХАУ-ын Сүжоу их сургуулийн гэмтлийн эмнэлэг, Хунан хүүхдийн эмнэлэг, Жишуйтаны хүүхдийн ортопедэд 3 сар;
- “Тархи нугасны гүний, төвөгтэй байрлалтай, нэвчсэн, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар эмчилгээ шаардагдах хавдар, хавдар төст эмгэгийн мэс засал, эмчилгээ” чиглэлээр УГТЭ-ийн 3 их эмч, сувилагч БНТУ, Чок их сургуулийн эмнэлэг, Истанбулын Америк эмнэлэгт 2 сар;
- “Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн, хуулралын эмчилгээ” чиглэлээр УГТЭ-ийн 4 их эмч, сувилагч БНСУ, Йонсэй Их сургуулийн Северанс эмнэлэгт 1 сар;
- “Нейронавигацийн систем, нейромониторийг ашиглан тархины гүний төвөгтэй байрлалтай, гавлын суурийн хэсгийн хавдрын мэс засал эмчилгээ” чиглэлээр ХСҮТ-ийн 6 их эмч БНХАУ, Чанжоугийн Ардын Эмнэлэгт 1 сар;
- “Толгой хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл төвөнх), нармайн хавдрын мэс заслын эмчилгээ” чиглэлээр ХСҮТ-ийн 5 их эмч, сувилагч АНУ, NYU Langone Health Center-т 1сар;

> *“2024 онд Монгол улсад оношлох, эмчлэх боломж хязгаарлагдмал байсан өвчний оношилгоо, эмчилгээг эх орондоо нутагшуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын түвшинд хүргэх зорилгоор ЭМЯ-тай хамтран дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын тухайн чиглэлээр тэргүүлэгч эмнэлэг, их сургуульд 13 үндэсний багийг чадавхжуулах бодлогын томоохон алхмыг эхлүүлсэн нь эрүүл мэндийн салбарт дэлхийн шилдэг туршлага, дэвшилтэт технологи, эмчилгээний арга зүйг эх орондоо нэвтрүүлэх чухал арга хэмжээ болсон юм.”*

- “Аутизм эмгэгийн оношилгоо, эмчилгээ” чиглэлээр СЭМҮТ-ийн сэтгэцийн 5 эмч БНТУ, Кануни Их сургуулийн эмнэлэгт 1 сар;
- “Хүзүү, сээр, бүсэлхий нурууны төрөлхийн хүнд хэлбэрийн мурийлт эмгэгийн мэс засал”-ийн чиглэлээр ГССҮТ-ийн мэс заслын 3 их эмч БНСУ-ын Кореа Их Сургуулийн Ансан эмнэлэг, Сүнчинхян Их Сургуулийн Бучён эмнэлэгт 1 жилийн хугацаагаар тус тус суралцжээ.





Ийнхүү гадаад сургалтад хамрагдсан үндэсний мэргэшсэн багуудын сургалтын үр дүнг Монгол улсад нутагшуулах ажлын хүрээнд тухайн сургалтыг зохион байгуулсан орны мэргэжилтнүүдтэй тогтмол цахим зөвлөгөө, хэлэлцүүлэг хийх, хамтарсан мэс засал, оношилгоо, эмчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шинээр эзэмшсэн дэвшилтэт арга, технологийг эмнэлзүйн практикт үе шаттай нэвтрүүлэхийн зэрэгцээ тухайн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд нийцсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа хийх, техникийн шаардлагыг тодорхойлох, худалдан авах, нийлүүлэх үйл явцыг үе шаттай шийдвэрлэж байгаа нь гадаад сургалтыг зөвхөн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаагаар хязгаарлахгүйгээр хүний нөөц, технологи, тоног төхөөрөмж, эмнэлзүйн практикийг цогцоор нь хөгжүүлэхэд чиглэж, Монгол улсад өмнө нь оношлох, эмчлэх боломжгүй байсан өвчин, эмгэгийг эх орондоо оношлон эмчлэх боломжийг үе шаттай бүрдүүлэн ажиллахыг зорьж байна.





ЯПОНЫ ЖАЙКА ОУБ-ТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭМХТ-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны 30 жилийн замналд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага болох ЖАЙКА-тай 2006 оноос эхлэн мэргэжилтэн сургах болон хөгжлийн чиглэлээр хамтран ажилласан он жилүүд онцгой байр суурь эзэлдэг.

Энэ хамтын ажиллагаа 2011 онд хөгжлийн шинэ шатанд гарах болсон. Тухайн үеийн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын дарга Ш.Энхбат, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Исогай Тошинори нар хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурснаар хоёр байгууллагын урт хугацааны түншлэлийн суурь тавигдсан байна.

Тэрхүү гарын үсэг зөвхөн хоёр байгууллагын хамтын ажиллагааг эхлүүлсэн үйл явдал байсангүй. Харин Монголын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын чанар, эмнэлзүйн сургагч багшийн тогтолцоо, сувилахуйн болон эх барихуйн мэргэжлийн хөгжлийг шинэ шатанд хүргэх олон жилийн хамтын ажиллагааны суурь болсон юм.

Ийнхүү эхэлсэн түншлэл олон жилийн турш тасралтгүй үргэлжилж, хэрэгжүүлсэн төсөл, сургалт бүр нь дараагийн шинэ алхмын суурь болон өргөжсөөр иржээ.

Ерөнхий мэргэшил судлал сургалтыг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, сургалтын чанарын хяналтын тогтолцоог бий болгож, чанарын хяналтаар баталгаажсан сургалтыг зохион байгуулсан нь

2015 оноос эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах зорилгоор “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл” хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг төслийг Эрүүл мэндийн яам, Жайка төслийн нэгж, ЭМХТ хариуцан загвар аймаг Орхон аймгийн БОЭТ, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийг Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллага болгосон. ж сургалтын тогтолцооны шинэ үед шилжсэнээр эдүгээ эрүүл мэндийн 20 байгууллага энэхүү сургалтыг явуулж байгаагаас 10 нь хөдөө орон

> “
> ***Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх тогтолцоо***
> *Төслийн хүрээнд эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг 2016 оноос эхлэн зохион байгуулж, 1550 орчим их эмч, 500 гаруй сувилагч, 100 шахам эх баригчийг сургаж эмнэл зүйн сургагч багшаар бэлтгэгдсэний 83 эмч, 46 сувилагч, 10 эх баригч нь чиглүүлэгч багшаар бэлтгэгдсэн.*
> ”







“Төслийн хүрээнд Монгол Улсын төгсөлтийн дараах сургалтын тогтолцоонд томоохон шинэчлэлүүд хийгдэж, ерөнхий мэргэшил судлалын сургалт, эмнэлзүйн сургагч багшийн тогтолцоо, сургалт эрхлэх байгууллагын сүлжээ амжилттай хөгжсөн байна. Энэхүү шинэчлэл нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан ба цаашид хувь нэмрээ оруулсаар байх болно.”

нутагт буюу Бүсийн оношилгоо эмчилгээний 5 төв, 5 аймгийн Нэгдсэн эмнэлэг сургалт эрхлэх байгууллага болон өргөжсөн.

Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх тогтолцоо

Төслийн хүрээнд эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг 2016 оноос эхлэн зохион байгуулж, 1550 орчим их эмч, 500 гаруй сувилагч, 100 шахам эх баригчийг сургаж эмнэл зүйн сургагч багшаар бэлтгэгдсэний 83 эмч, 46 сувилагч, 10 эх баригч нь чиглүүлэгч багшаар бэлтгэгдсэн.

Төслийн хүрээнд чаралтай тусламжийн чиглэлээр амь насанд аюултай эрсдэлд орсон өвчтөний биеийн байдалд үнэлгээ өгөх, амилуулах лавшруулсан тусламжийн арга техникийг эзэмшүүлэх (Advanced Assessment for Life Support - AALS) сургалт зохион байгуулаа. Сургалтыг Япон улсад зохион байгуулагддаг AALS сургалтын хөтөлбөрөөр ЭМХТ-ийн захирлын баталсан удирдамжийн хүрээнд 36 удаа зохион байгуулж нийт нийслэл, орон нутгийн яаралтай тусламжийн 337 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн.





Мөн Тусгай багаж хэрэгсэл ашиглахгүй, зүрх уушигны сэхээн амьдруулах тусламж үйлчилгээг үзүүлэх арга техникийг эзэмшүүлэх, Хүүхдийн амилуулах суурь тусламж үзүүлэгч /PBLS/" сургалтыг 16 удаа зохион байгуулж, нийт 156 яаралтай тусламжийн эмч нар хамрагдсан байна.

Сувилагч болон Эх баригчийн төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог сайжруулсан нь

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/445 дугаар тушаалаар Эх баригчийн мэргэшүүлэх сургалтын 5 чиглэл, мэргэшлийн индекс батлагдсаны дагуу төслийн хүрээнд Эх барихуйн мэргэшүүлэх сургалтын 5 хөтөлбөр ЭМХЗ-ийн 2022 оны тогтоолоор зөвшөөрөгдсөн.

1. Бэлгийн болон нөхөн үржихүйн зөвлөгч – Эх баригч,
2. Жирэмсэн ба төрсний дараах үеийн зөвлөгч – Эх баригч,
3. Жирэмслэлтэд бэлтгэхэд зөвлөгч – Эх баригч,
4. Хөхөөр хоололтын зөвлөгч – Эх баригч,
5. Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгч – Эх баригч

Энэхүү хөтөлбөрөөр 2023 оноос сургалтууд эхэлж, сургалтыг ЭХЭМҮТ, "Өргөө", "Амгалан" амаржих газрууд эрхлэн явуулж байна.

Шинэ сувилагч, шинэ эх баригчийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт

Шинээр ажилд орж байгаа сувилагчийг ажлын байран дээр нь дагалдуулан сургах, байгуулагадаа ээнэгшүүлэн дасгаж авах, сэтгэл зүйг нь бэлдэх, тогтвор суурьшилтай, үр бүтээмжтэй ажиллах, эзэмшсэн мэргэжлээрээ бахархах, үнэ цэнийг ойлгуулахад энэхүү нэгдсэн сургалтын хөтөлбөрийг зорилго оршиж байсан.





“Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн түүхэн дэх гадаад хамтын ажиллагаа нь байгууллага хоорондын энгийн харилцаанаас илүү өргөн утга агуулгатай. Энэ бол Монгол Улсын эрүүл мэндийн салбарыг дэлхийн эрүүл мэндийн хөгжлийн чиг хандлага, шинэ мэдлэг, шинэ технологи, стандарт, инновацитай холбосон стратегийн гүүр юм.”

Шинэ сувилагч, Шинэ эх баригчийн сургалтын хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлсэн ба шинэ сувилагчийн анхны сургалтыг төслийн загвар байгууллага болох Орхон аймаг, УХТЭ амжилттай зохион байгуулж, үр дүнг тооцож, цаашид хөтөлбөрийг улсын хэмжээнд нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Энэ хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2023 оны 451 дүгээр тушаалаар Сувилагч мэргэжилтний чадамж, Эх баригч мэргэжилтний чадамж, 2024 оны А/289 дүгээр тушаалаар Эх баригч мэргэжилтний албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт шинэчлэгдэн тус тус батлагдсан.

Төслийн хүрээнд Монгол улсын төгсөлтийн дараах сургалтын тогтолцоонд томоохон шинэчлэлүүд хийгдэж, ерөнхий мэргэшил судлалын сургалт, эмнэлзүйн сургагч багшийн тогтолцоо, сургалт эрхлэх байгууллагын сүлжээ амжилттай хөгжсөн байна. Энэхүү шинэчлэл нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан ба цаашид хувь нэмрээ оруулсаар байх болно.

Төслийн нэг чухал зорилго нь Япон Улсын төгсөлтийн дараах сургалтын сайн туршлагыг шууд хуулбарлах бус, Монголын эрүүл мэндийн тогтолцооны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн судалж, нутагшуулах явдал байсан бөгөөд энэ зорилго нь амжилттай хэрэгжсэн.







БНСУ-ЫН РАФАЭЛ ИНТЕРНЭЙШНЛ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2013 оноос Рафаэл Интернэйшнл, Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Анагаах ухааны сургууль болон холбогдох байгууллагуудтай хамтран “Мэргэжилтний тасралтгүй хөгжил—CPD (Continuing Professional Development)” төслийг эхлүүлсэн. Эхний шат буюу 2013 онд Улаанбаатар хотын Баянзүрх, Сүхбаатар дүүргийн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулж, сургалтын хэрэгцээг тодорхойлох, эмнэлзүйн сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх аргачлалыг туршсанаар төслийн дараагийн шат өргөжих эхлэл тавигдсан.

2014–2017 онд УБ хот болон Дархан-Уул аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч, сувилагчдын эмнэлзүйн болон байгууллагын чадавхыг бэхжүүлэх сургалт, мөн хоёр, гуравдугаар шатлалын эмнэлэг болон АШУҮИС-ийн багш нарыг бэлтгэсэн нь монгол мэргэжилтэн өөрийн мэргэжил нэгтнээ сургадаг тогтвортой загварт шилжсэн чухал үр дүн байлаа.

Энэ хугацаанд Рафаэл Нанүм сан Монголын эмч, мэргэжилтний солилцоо, мэргэшүүлэх сургалтыг санхүүгийн хувьд дэмжиж байв. Тухайлбал, 2015 оны Raphael Fellowship хөтөлбөрөөр Монголын эмч нар БНСУ-д мэргэжлийн сургалтад хамрагдсанаас гадна Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Анагаах ухааны номын санд эрүүл мэндийн мэдээлэл, номын сангийн чиглэлээр сургалтад хамрагдсан байна. Энэ нь хамтын ажиллагаа зөвхөн эмнэлзүйн ур чадвараар хязгаарлагдалгүй, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, байгууллагын чадавхыг зэрэг хөгжүүлж байсныг харуулдаг.

2017 оноос Рафаэл Интернэйшнл нь эрхтэн шилжүүлэн суулгах сургалт, олон улсын хурал, тархины үхэлтэй донорыг тодорхойлох, донорын менежмент болон мэс заслын дараах хяналтын чиглэлээр мэдлэг, туршлага солилцох ажлыг дэмжиж ирсэн.

Ийнхүү хамтын ажиллагаа нь “гадаадаас эмч ирж тусламж үзүүлэх” хэлбэрээс монгол эмч нар өөрөө сургагч багш болж, орон нутагтаа мэдлэгээ түгээх тогтолцоонд шилжсэнээрээ онцлог юм. Мэргэжилтний тасралтгүй сургалт, сургагч багш бэлтгэх тогтолцоо, гадаад мэргэшүүлэх сургалт, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлийн олон улсын мэргэжлийн сүлжээ нь энэхүү хамтын ажиллагааны хамгийн тогтвортой үр дүн болж үлджээ.

> *“БНСУ-ын Рафаэл Интернэйшнл байгууллага 2007 онд байгуулагдаж, анхны гадаад хамтын ажиллагаагаа Монгол улсаас эхлүүлсэн бөгөөд эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, мэргэжлийн сургалт, туршлага солилцоо, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн урт хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. Монгол дахь энэхүү хамтын ажиллагаа нь нэг удаагийн эмнэлгийн тусламжаас илүүтэйгээр Монголын эрүүл мэндийн салбарын дотоодын хүний нөөц, сургалтын тогтолцоог бэхжүүлэх чиглэл рүү үе шаттай өргөжсөн.”*

6.2. ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

World Health Organization

UNDP

unicef

JICA

GYEONGGI-DO

라파엘인터내셔널 Raphael International

SCH 순천향대학교 SOON CHUN HYANG UNIVERSITY

DT DONATION & TRANSPLANTATION INSTIT

TÜRKİYE ORGAN NAKLİ VAKFI Turkish Transplant Foundation 30 YIL ANNIVERSARY

AST ASIAN SOCIETY OF TRANSPLANTATION

Marengo Asia Healthcare

KOTRY Korean Organ Transplantation Registry

ROTARY INTERNATIONAL

GODT Global Observatory on Donation and Transplantation

ISODP International Society for Organ Donation Professionals

liv HOSPITAL

KIMA Korea International Medical Association

KHIDI Korea Health Industry Development Institute

IHM Australia Powered by Arizona State University®

GANGNAM BRAND EYE CLINIC

徳島大学 Tokushima University

SHINE & BRIGHT EYE CENTER

RUTGERS THE STATE UNIVERSITY OF NEW JERSEY

CHUNG-ANG 1916 CAU UNIVERSITY

FIRST EYE CENTER

上海医大医院 上海大学医学院医大医院

MAX Healthcare

Tilganga INSTITUTE OF OPHTHALMOLOGY

SMC SAMSUNG MEDICAL CENTER

1956

KODA Korea Organ Donation Agency


ADB
ASIAN DEVELOPMENT BANK
THE GLOBAL FUND
KOICA
Korea International Cooperation Agency
kotra
Korea Trade-Investment Promotion Agency
USHAŞ
ULUSLARARASI SAĞLIK HİZMETLERİ A.Ş.
meerecompany
YI ZHOU CANCER HOSPITAL
河北一洲肿瘤医院
IEEA
INTERNATIONAL · EXCHANGE · AND · EDUCATION · ASSOCIATION
THE WORLD BANK
ACIBADEM
HOSPITALS GROUP
IOM
UN MIGRATION
广东省医学科学院
GUANGDONG ACADEMY OF MEDICAL SCIENCES
广东省人民医院
GUANGDONG PROVINCIAL PEOPLE'S HOSPITAL
北京大学肿瘤医院
BEIJING CANCER HOSPITAL
Laurel Surgery & Endoscopy Center
1985
Institute for Health Metrics and Evaluation
50th year
GÜVEN
ROSATOM
Devki Devi Foundation
FUDi
ACQH
ACCREDITATION CENTER FOR QUALITY IN HEALTHCARE
KAZAKHSTAN
FLUKE
Biomedical
NAGOYA UNIVERSITY
원광대학교
WONKWANG UNIVERSITY
Apollo HOSPITALS
TOUCHING LIVES
MUSCAT
KU MEDICINE
KOREA UNIVERSITY ANSAN HOSPITAL
Fortis
HOSPITALS
The Transplantation Society
KIMS
HOSPITALS™

6.3. ХАМТЫН АЖИЛЛАГАА ЗУРГИЙН ЦОМОГ




















THE 5th MONGOLIA-KOREA
INTERGOVERNMENTAL CONSULTATIVE BODY
MEETING












ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ












MEDICALPARK
MEDICALPARK




ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ


Welcome Delegates from Center
for Health Development,

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

7

БҮЛЭГ ДОЛОО

БАХАРХАЛТ ТҮҮХЭЭ БҮТЭЭЛЦСЭН ҮЕ ҮЕИЙН ХАМТ ОЛОН



1313.mn
hinfo.mn

7.1. ТӨВИЙН УДИРДЛАГУУД



Ц.СОДНОМПИЛ

(1996 - 2000, 2007 - 2010)

Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, МАУ-ны Академийн үндэслэгч гишүүн, Академич, Анагаах ухааны доктор (Ph.D), профессор

1996-1997	ЭМУМТ-ийн Захирал
1997-2000	ЭМУМБТ-ийн Захирал
2007-2009	ЭМХҮТ-ийн Захирал
2009-2010	ЗГХА-ЭМГ-ын Дарга



С.ДУЛАМСҮРЭН

(1997 - 2009)

Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Анагаах ухааны доктор (Ph.D)

1997-2000	ЭМУМБТ-ийн Дэд захирал
2000-2002	ЭМХҮТ-ийн Захирал
2003-2004	ЗГХА-ЭТУГ-ын Дарга
2005-2007	ЭМХҮТ-ийн Захирал
2007-2009	ЭМХҮТ-ийн Дэд захирал



Ш.ЭНХБАТ

(2011 - 2012)

Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор (Sc.D)

2011-2012	ЗГХА-ЭМГ-ын Дарга



Ч.БАТ-ЭРДЭНЭ

(2012 – 2016.11.28)

Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч

2012-2016 ЭМХТ-ийн Ерөнхий захирал



Б.НАРАНТУЯА

(2016.11.28–2017.12.22,
2019.08.15-2025.05.07)

Анагаах ухааны доктор (Ph.D), ЭМУЗБ-ын Зөвлөх зэрэг

2016-2017 ЭМХТ-ийн Ерөнхий захирал
2019-2025 ЭМХТ-ийн Захирал



Э.СОДНОМЖАМЦ

(2018.01.18 – 2018.04.17)

Мэргэшсэн нягтлан бодогч

2018.01 -2018.04 ЭМХТ-ийн Ерөнхий захирал



Д.ГАНЦЭЦЭГ

(2018.04.17 – 2019.08.15)

Анагаах ухааны магистр, ЭМУЗБ-ын Тэргүүлэх зэрэг

2018 - 2019 ЭМХТ-ийн Ерөнхий захирал



М.ОДГЭРЭЛ

(2025.05.07-оос хойш одоог хүртэл)

Анагаах ухааны магистр, ЭМУЗБ-ын Ахлах зэрэг

2025 ЭМХТ-ийн Захирал



П.АЛТАНХУЯГ

(2000 - 2007)

Анагаах ухааны магистр

1996-1997 ЭМУМТ-ийн Дэд захирал



С.ГАНСҮХ

(2000 - 2007)

2000-2002 ЭМХҮТ-ийн Дэд захирал
2003 - 2004 ЗГХА-ЭТУГ-ын Дэд дарга
2005-2007 ЭМХҮТ-ийн Дэд захирал



Д.НАЦАГДОРЖ

(2003 - 2004)

Бизнесийн удирдлагын магистр

2003 - 2004 ЗГХА-ЭТУГ-ын Дэд дарга



Ц.ХУН

(2002 - 2012)

Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэрэг

2008 – 2009 онд ЭМХҮТ-ийн Дэд захирал
2009 - 2012 ЗГХА-ЭМГ-ын Дэд дарга



М.УРАНЧИМЭГ

(2011 - 2012)

Эм зүйн ухааны доктор (Ph.D), профессор, Зөвлөх зэргийн эм зүйч

2011 - 2012 ЗГХА-ЭМГ-ын Дэд дарга



У.ЦЭВЭГМИД

(2013 - 2015)

Хүний гавьяат эмч, Анагаах ухааны доктор (Ph.D), Дэд профессор, ЭМЯ-ны хүүхдийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

2013 - 2015 ЭМХТ-ийн Дэд захирал



Г.МАЖИГСҮРЭН

(1996 - 2010)

Мэргэшсэн нягтлан бодогч

1996 - 1997 Захиргаа, санхүүгийн албаны дарга
1997-2010 Ерөнхий нягтлан бодогч




Б.ОЧИР

(2002 - 2025)

Бизнесийн удирдлагын магистр, Мэргэшсэн аудит

2011 - 2025	Ерөнхий, Ахлах нягтлан бодогч
2025	Санхүүгийн албаны дарга



Д.ГАНТУЯА

(2016 - 2018)

Бизнесийн удирдлагын магистр,

2016-2018	Ерөнхий нягтлан бодогч

7.2. НЭГЖИЙН УДИРДЛАГУУД

ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН ТӨВ 1996.10.04		
1	Эрдэм шинжилгээний төслийн баг	М.Шагдарсүрэн
2	Статистик мэдээллийн төв	П.Алтанхуяг
3	Сургалтын алба	Н.Удвал
4	Санхүү, хангамжийн алба	Г.Мажигсүрэн
5	Эмч нарын байр	Г.Алтанцэцэг
ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, МЭДЭЭЛЭЛ, БОЛОВСРОЛЫН ТӨВ 1997.09.11		
1	Эрүүл мэндийн сургалт, судалгаа, боловсролын алба	М.Туяа, Ш.Оюунбилэг
2	Статистик мэдээллийн алба	Ц.Ганбаатар
3	Магадлан итгэмжлэх алба	Л.Жигжидсүрэн
4	Нийтлэг үйлчилгээний алба, Эмч нарын байр	Г.Лхагвадорж, Г.Алтанцэцэг
5	ЭСС ТВ студи	А.Сарантуяа
Төвийн захирлын 1999.03.12-ны 10 дугаар тушаалаар		
1	Боловсролын алба	В.Гармаа
2	ЭСС ТВ студи	Ю.Дамбадорж
3	Магадлан итгэмжлэл, лицензийн алба	Л.Жигжидсүрэн
Төвийн захирлын 2000 оны 30 дугаар тушаалаар		
1	Захиргаа, аж ахуйн алба	Ц.Мөнхдалай, Л.Оюунчимэг
2	Сургалт, судалгаа, боловсролын алба	Б.Булганчимэг
3	Статистик мэдээллийн алба	Д.Нямхорол
4	Магадлан итгэмжлэлийн алба	Л.Жигжидсүрэн
5	Төгсөлтийн дараах сургалтын алба	С.Өлзийсайхан
6	ЭСС ТВ студи	Ю.Дамбадорж
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ Эрүүл мэндийн сайдын 2000.12.22-ны 106 дугаар тушаалаар		
1	Эрүүл мэндийн удирдлагын алба	Я.Гантөмөр
2	Статистик мэдээллийн алба	Д.Нямхорол
3	Эрүүл мэндийг дэмжих алба, ЭСС Теле радио студи	Ю.Дамбадорж
4	Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх алба Акредитацийн тасаг, Лицензийн тасаг	Л.Жигжидсүрэн
5	Төгсөлтийн дараах сургалтын алба	С.Өлзийсайхан
6	Захиргаа, үйлчилгээний алба	Л.Оюунчимэг
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙГ УДИРДАХ ГАЗАР Эрүүл мэндийн сайдын 2002.12.09-ний 285 дугаар тушаалаар		
1	Эдийн засаг, технологийн алба	Ж.Алтантуяа, Т.Болормаа, Н.Оюунгэрэл
2	Чанарын баталгаажилтын алба	Л.Жигжидсүрэн, Я.Буянжаргал
3	Эмгэг судлалын алба	Ч.Батсайхан
4	Хүний нөөцийн хөгжлийн алба	Ш.Оюунбилэг
5	Төгсөлтийн дараах сургалтын алба	С.Өлзийсайхан
6	Эм зүйн алба	В.Лхагвадорж
7	Статистик, мэдээллийн алба	Д.Нямхорол

8	Эрүүл мэндийг дэмжих алба	Д.Жаргалсайхан
9	Захиргаа, үйлчилгээний алба	Л.Оюунчимэг
10	ЭСС теле-радио студи	Ю.Дамбадорж
11	Барилга захиалагчийн товчоо	Н.Чулуунбат
12	Эмч нарын дотуур байр	Г.Алтанцэцэг
Эрүүл мэндийн сайдын 2004.04.08-ны өдрийн 81 дүгээр тушаалаар		
1	Нийслэлийн яаралтай тусламжийн төвийн Алсын түргэн тусламжийн нэгж шилжиж ирсэн.	
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ Эрүүл мэндийн сайдын 2005.01.24-ний 11 дүгээр тушаалаар		
1	Эрүүл мэндийн удирдлагын алба	Н.Нарангэрэл
2	Статистик мэдээллийн алба	Д.Нямхорол, П.Оюунцэцэг
3	Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл, сургалтын алба, Эмч нарын байр	С.Өлзийсайхан
4	Магадлан итгэмжлэлийн алба	Ө.Ганчимэг
5	Эрүүл мэндийг дэмжих алба, ЭСС теле-радио студи	Д.Жаргалсайхан
6	Захиргааны алба	Л.Оюунчимэг
ЭМС-ын 2005-01-18-ны “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 09 дүгээр тушаалаар		
1	АХБ-ны “Ажлын байрны зэрэглэл хөгжүүлэх нэгж”	С.Лхагвасүрэн
ЭМС-ын 2005-10-13-ны өдрийн “Эрүүл мэндийн үндэсний тооцооны талаар авах арга хэмжээний тухай” 253 дугаар тушаалаар		
1	Эрүүл мэндийн үндэсний тооцооны нэгж	
ЭМС-ын 2006-02-16-ны өдрийн “ЭСС ТВ радио студийг шилжүүлэх тухай” 44 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн яаманд шилжсэн.		
Эрүүл мэндийн сайдын 2007-03-20-ны өдрийн “Бүтэц, дүрэм батлах тухай” 67 дугаар тушаалаар		
1	Эрүүл мэнд, санхүүгийн удирдлагын алба	Н.Нарангэрэл
2	Статистик мэдээллийн алба	Х.Нарантуяа
3	Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл, сургалтын алба	С.Өлзийсайхан
4	Магадлан итгэмжлэлийн алба	С.Гансүх, Г.Оюунцэцэг
5	Эрүүл мэндийг дэмжих алба	Л.Оюун
6	Эмийн бүртгэл, мэдээллийн алба	Д.Уранчимэг
7	Захиргааны нэгж	Л.Оюунчимэг
8	Санхүү, үйлчилгээний алба	Г.Мажигсүрэн
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР МУЗГ-ын 2008.12.24-ний 64 дүгээр тогтоолоор		
1	Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн хэлтэс	Н.Нарангэрэл
2	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтэс	Л.Авирмэд
3	Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн хэлтэс	Г.Ганчимэг
4	Эрүүл мэндийн статистик мэдээллийн хэлтэс, Телемедициний баг	Д.Нямхорол
5	Магадлан итгэмжлэлийн хэлтэс	С.Гансүх, Б.Цэцэгмаа
6	Эрүүл мэндийг дэмжих хэлтэс	Л.Оюун
7	Эмийн бүртгэлийн хэлтэс	Д.Оюунтуяа
8	Захиргааны хэлтэс, Санхүү, үйлчилгээний алба	Ц.Уранчимэг

ЭМС-ын 2009.05.08-ны “Алсын түргэн тусламжийн үйлчилгээг шилжүүлэх тухай” 144 дүгээр тушаалаар		
1	ЭМЯ-ны Алсын түргэн тусламжийн нэгж 2009.05.01-ний өдрөөс шилжиж ирсэн.	
ЭМС-ын 2010.04.26-ны өдрийн “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай” 151 дүгээр тушаалаар		
1	Эрүүл мэндийн салбарын бодлогын шинжилгээний хэлтэс	Н.Сэвжид
2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн хэлтэс	Ш.Баттөр
3	Эрүүл мэндийг дэмжих хэлтэс	Л.Оюун
4	Эрүүл мэндийн статистикийн хэлтэс	С.Ариунтуяа
5	Эрүүл мэндийн ажилтны сургалт, судалгаа, зөвшөөрлийн хэлтэс	Д.Баярмаа
6	Эмийн бүртгэл, баталгаажуулалтын хэлтэс	Д.Оюунтуяа
7	Зайн анагаах ухааны хөгжлийн хэлтэс	Ч.Бат-Эрдэнэ
8	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Д.Жаргалмөнх
ЭМС-ын 2011-09-02-ны “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай” 278 дугаар тушаалаар		
1	Эмнэлгийн тусламжийн хэлтэс	Б.Цэцэгмаа
2	Эмнэлгийн техник, технологи, эдийн засгийн хэлтэс	Ө.Баяр
3	Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс	Ц.Хандармаа
4	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтэс	С.Өлзийсайхан
5	Эрүүл мэндийн статистикийн хэлтэс	С.Ариунтуяа
6	Эмийн зохицуулалтын хэлтэс	Д.Оюунтуяа
7	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Д.Жаргалмөнх
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ МУЗГ-ын 2012.09.22-ны “Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай” 50 дугаар тогтоолоор		
1	Төгсөлтийн дараах сургалтын алба	С.Өлзийсайхан
2	Түргэн тусламжийн үйлчилгээний алба	Г.Ганбаатар
3	Статистик мэдээллийн алба	С.Ариунтуяа
4	Телемедициний алба	Ө.Баяр
5	Тогтолцооны судалгааны алба	Н.Сэвжид
6	Захиргаа, аж ахуйн алба	Г.Цэцэнсанаа
ЭМС-ын 2012-11-29-ний “Дүрэм, стратеги зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” 398 дугаар тушаалаар		
1	Төгсөлтийн дараах сургалтын алба	С.Өлзийсайхан
2	Эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн сүлжээний зохицуулалтын алба	Г.Ганбаатар
3	Статистик мэдээллийн алба	С.Ариунтуяа
4	Телемедициний алба	Ө.Баяр
5	Тогтолцооны судалгааны алба	Н.Нарангэрэл
6	Захиргаа, аж ахуйн алба	Г.Цэцэнсанаа
Эрүүл мэндийн сайдын 2013.11.21-ний 440 дүгээр тушаалаар		
1	Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтэс	Н.Нарангэрэл
2	Төгсөлтийн дараах сургалтын зохицуулалтын хэлтэс	Ц.Амарзаяа
3	Мэдээлэл технологи, телемедициний хэлтэс	Ө.Баяр

4	Яаралтай тусламжийн зохицуулалтын хэлтэс	Ж.Энхзул
5	Захиргааны хэлтэс	Г.Цэцэнсанаа
Эрүүл мэнд, спортын сайдын 2015.02.27-ны 79 дүгээр тушаалаар		
1	Судалгаа, төлөвлөлт, статистик мэдээллийн алба	Ч.Зулцэцэг
2	Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба	С.Солонго
3	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн алба	Д.Уранчимэг
4	Эмийн зохицуулалтын алба	Д.Бямбадорж
5	Захиргаа, аж ахуйн алба	Л.Оюунчимэг
Эрүүл мэндийн сайдын 2016.12.26-ны А/203 дугаар тушаалаар		
1	Бодлогын судалгаа, удирдлагын сургалтын алба	Д.Баттулга
2	Статистик, мэдээллийн технологийн алба	Х.Ганцэцэг
3	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба	Д.Тамир
4	Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба	Ж.Тогтохбаяр, Д.Дондогмаа З.Наранбаатар
5	Эм, эмнэлгийн хэрэгслийн алба	Г.Цэцэнсанаа
6	Чанар, магадлан итгэмжлэлийн алба	Н.Нарангэрэл
7	Захиргаа, санхүү-үйлчилгээний алба	Л.Оюунчимэг
8	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг	Ч.Баттулга
ЭМС-ын 2017-10-16-ны өдрийн “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/397 дугаар тушаалаар		
1	Бодлогын судалгаа, удирдлагын сургалтын алба	Д.Баттулга
2	Статистик, мэдээллийн технологийн алба	М.Цэнгүүн
3	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба	Ж.Баатар
4	Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба	З.Наранбаатар
5	Эм, эмнэлгийн хэрэгслийн алба	Ш.Энхзаяа
6	Чанар, магадлан итгэмжлэлийн алба	Н.Нарангэрэл
7	Захиргаа, санхүү-үйлчилгээний алба	Л.Оюунчимэг
8	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба	Ч.Баттулга
Эрүүл мэндийн сайдын 2018-01-31-ний А/21 тушаалаар		
1	Хөгжлийн төлөвлөлт, хамтын ажиллагааны алба	Н.Нарангэрэл
2	Эрүүл мэндийн мэдээллийн алба	Х.Ганцэцэг
3	Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба	Ш.Энхзаяа
4	Хүний нөөцийн бодлого зохицуулалтын алба	Д.Бямбасүрэн, Д.Амарсайхан, Т.Учрал, Н.Сэвжид
5	Магадлан итгэмжлэл, лицензийн алба	Д.Баттулга, Н.Нарангэрэл Н.Сэвжид
6	Захиргаа, санхүү, дотоод хяналтын алба	Л.Оюунчимэг, Т.Содгэрэл
Эрүүл мэндийн сайдын 2018.03.01-ний А/70 тушаалаар		
7	Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба	П.Батчулуун
МУЗГ-ын 2020.12.16-ны өдрийн 222 дугаар тогтоолоор		
	Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны чиг үүрэг ЗГХА-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт шилжсэн.	
Эрүүл мэндийн сайдын 2021.01.20-ны А/26 дугаар тушаалаар		
1	Эрүүл мэндийн эдийн засаг, бодлогын судалгааны алба	Д.Баттулга, Т.Учрал, Б.Отгончимэг, С.Мөнхсүх
2	Эрүүл мэндийн мэдээллийн алба	Х.Ганцэцэг, Б.Доржмягмар

3	Хүний нөөцийн бодлого зохицуулалтын алба	Б.Дашлхүмбэ, Д.Ичинхорлоо Б.Батцоож, Б.Отгончимэг
4	Магадлан итгэмжлэлийн алба	М.Одгэрэл, Н.Сэвжид
5	Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба	П.Батчулуун
6	Дуудлага зохицуулах алба	Д.Бямбасүрэн
7	Захиргаа, санхүү, удирдлагын алба	Л.Оюунчимэг
8	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба	Э.Цацрал, Б.Ариунзаяа, Ш.Алтанцэцэг
Эрүүл мэндийн сайдын 2024.03.05-ны өдрийн” тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/113 дугаар тушаалаар		
1	Эрүүл мэндийн мэдээллийн алба өргөжиж Мэдээлэл технологийн алба байгуулагдсан.	Б.Доржмягмар Б.Үзмээ
Эрүүл мэндийн сайдын 2025-02-06-ны А/38 дугаар тушаалаар		
1	Их өгөгдөл, судалгааны алба	Ч.Мичидмаа, Г.Дамба
2	Цахим хөгжлийн алба	Б.Үзмээ, О.Мөнхбадрал
3	Хүний нөөцийн хөгжлийн алба	Б.Отгончимэг, Д.Дондогмаа
4	Тусламж үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэлийн алба	Ш.Алтанцэцэг, Б.Болортуяа
5	Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба	Б.Алтантулга
6	Гадаад эмчилгээг зохицуулах алба	Б.Жаргалтуяа, Ш.Алтанцэцэг
7	Захиргааны алба	Н.Энхтайван, Б.Доржмягмар, Ш.Солонго
8	Санхүүгийн алба	Б.Очир, С.Лхагвасүрэн
9	Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба	Л.Оюунчимэг

7.3. ТӨВИЙН АХМАДУУД

“Эрүүл мэндийн хөгжлийн төв гучин настайгаа золгож байна. Бид өнгөрсөн хугацаанд эрүүл мэндийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хөгжил дэвшлийн замд багагүй хувь нэмрээ оруулжээ.

Тус төвийн үйл ажиллагааны өнөөдрийн амжилт нь ахмад үеийнхний оруулсан хувь нэмэртэй салшгүй холбоотой.”

Тус төв байгуулагдсан 1996 оноос эхлээд тэтгэвэрт гартлаа тасралтгүй ажиллаж энэ байгууллагыг бэхжүүлэн хөгжүүлэхэд бүтээлч хөдөлмөрийнхөө олон жилийг зориулсан ууган ахмадуудаар манай хамт олон бахархаж байдаг юм. Тухайлбал: Ц.Содномпил, С.Дуламсүрэн, Л.Жигжидсүрэн, М.Шагдарсүрэн, И.Ядамсүрэн, Д.Лхайжав, Г.Даваажав, Г.Дашдулам, Г.Мажигсүрэн, Д.Дулмаа, Г.Алтанцэцэг, Х.Бадамрагчаа, В.Гармаа, Ч.Батнасан, Ю.Дамбадорж, Ц.Март, Х.Оюунбилэг, Д.Алтанцэцэг.

С.Нарантуяа, Л.Ширнэн, Б.Цэцэгмаа, С.Өлзийсайхан, Ш.Бямбабаатар, Ц.Саранцэцэг, Н.Нарангэрэл зэрэг олон албан хаагчид үр бүтээлтэй ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан билээ.

Мөн Т.Зориг, Б.Мөнхтуяа, К.Тунгалаг, Г.Ганчимэг, Э.Оюунбат, Ж.Төмөрбаатар, П.Мидриймаа, П.Алтанхуяг, Д.Баттулга, Н.Сэвжид, Т.Батчулуун, Д.Чимэддолгор, Ц.Тунгалаг, Ө.Баяр, Ц.Дариймаа, Б.Банзрагч, Б.Наранцэцэг, Ё.Тунгалаг, Г.Дорждагва, Д.Нарангэрэл зэрэг ахмад үеийнхний оруулсан хувь нэмрийг хүндэтгэж, тэдний санал зөвлөгөөг авч, байнгын харилцаатай ажиллаж байна. Бид төв байгуулагдахаас өмнөх үеийн Эрүүл мэндийн сургалт арга зүйн төв, Эмнэлгийн ажилчдын соёлын ордон, Статистикийн машинт станцад ажиллаж байсан ахмад эмч Д.Гонгор, М.Долгорсүрэн, Л.Баяр, С.Нэргүй, Б.Оюунчимэг, Б.Цэрэндаваа, С.Марина, Б.Дэнсмаа, н.Янжив, С.Ломбо, Б.Туулайхүү, Ш.Ванчаарай, н.Гэрэлчулуун, н.Ичинхорлоо, Б.Майхүү, н.Дашдэндэв, Н.Должинсүрэн, нарын эхлүүлсэн ажлыг залгамжлан үргэлжлүүлж байгаадаа талархаж явдаг.

Манай ахмад ажилтнуудын дундаас ЭЗУ-ны доктор И.Ядамсүрэн гуай маань 2026 онд Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртэж биднийг баярлууллаа.



“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖИЛ” АХМАДЫН ЗӨВЛӨЛ


Тэргүүн
С.Өлзийсайхан


Үүсгэн байгуулагч
Ц.Содномпил


Гүйцэтгэх захирал
Ч.Батнасан


УЗ-ийн гишүүн
Г.Мажигсүрэн


УЗ-ийн гишүүн
Л.Ширнэн


П.Алтанхуяг


Д.Лхайжав


В.Гармаа


Д.Дулмаа


С.Нарантуяа


И.Ядамсүрэн


К.Тунгалаг


Х.Оюунбилэг


Г.Алтанцэцэг


Ц.Март


Б.Цэцэгмаа


Ш.Бямбабаатар


Б.Оюунчимэг


Г.Дорждагва


С.Цэрэндаваа


Б.Банзрагч


Э.Оюунбат


Д.Нарангэрэл


Б.Наранцэцэг


Б.Мөнхтуяа


Д.Оттонбулаг


Ё.Тунгалаг


П.Батчулуун


Ц.Дариймаа


Ө.Баяр


Ц.Саранцэцэг


Н.Должинсүрэн


Ж.Төмөрбаатар


Г.Ганчимэг


Д.Баттулга


Н.Сэвжид


Н.Нарангэрэл


П.Мидриймаа



2017 он





2018 он



2019 он



2019 он


2022 он


2024 он


2024 он






















2006.10.05. Улаанбаатар хот. Баянгол ресторан


2006.10.05. Улаанбаатар хот. Баянгол ресторан









Түүхийн жинхэнэ үнэ цэнэ нь тухайн цаг үеийг бүтээлцэж, зорилго нэгтэйгээр зүтгэсэн хүмүүсийн хөдөлмөр, сэтгэл, итгэл үнэмшилд оршдог билээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түүхэн замналд байгууллагын суурийг тавьж, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, салбарын шинэчлэл бүрийн эхлэлд манлайлан оролцсон үе үеийн удирдлага, эрдэмтэн судлаачид, эмч мэргэжилтнүүд, нийт хамт олны хөдөлмөр бүтээл онцгой байр суурь эзэлдэг.

Энэ бүлэгт байгууллагын алтан үеийнхний төлөөлөл болсон анагаах ухааны доктор, салбарын ахмад зүтгэлтнүүд болон үе үеийн ажилтнуудын дурсамж, үзэл бодол, сургамжийг багтааж байна. Тэдний хүүрнэсэн дурсамж бол зөвхөн өнгөрсөн үеийг эргэн санах төдий бус, эрүүл мэндийн салбарын хөгжлийн нэгэн чухал үеийг гэрчлэх үнэт баримт юм.

Тэдний туулсан замналд шинэ байгууллагын суурь тавигдсан мөч, шинэ тогтолцоо бүрэлдсэн үе, салбарын бодлого, удирдлага, мэдээлэл, сургалт, чанар, магадлан итгэмжлэл, хүний нөөцийн хөгжлийн шинэчлэлүүд хэрхэн бий болсон түүхэн агшин бүхэн шингэн үлджээ.

Хөдөлмөрлөсөн он жилүүд, хамт олны эв нэгдэл, эрүүл мэндийн салбарын төлөөх чин сэтгэл нь өнөөдрийн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үнэт өв болон үлдсэн билээ.

7.4. ТҮҮХ ӨГҮҮЛЭХ ЯРИЛЦЛАГУУД

1990-ээд оны шилжилтийн хүнд цаг үед Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийг байгуулах санаа хэрхэн төрсөн бэ? Тухайн үед ийм байгууллага зайлшгүй шаардлагатай гэж үзэхэд хүргэсэн үндэслэл юу байсан бэ?

Би 1990-ээд оноос өмнө Москва хотод аспирантурт сурч, 1989-1992 оны хооронд Засгийн газарт референтээр ажиллаж байгаад 1992 онд өөрийн хүсэлтээр Хэрэг эрхлэх газраас гарч яамандаа ирж ажилласан. Энэ хугацаанд Засгийн газар, яам хэд хэдэн удаа бүтэц, нэрээ өөрчилсөн ч эрүүл мэндийн салбарын ажлыг тасралтгүй авч явдаг мэргэжлийн байгууллага хэрэгтэй гэж үзээд гадаадын улс орнуудын туршлагыг судалж, ялангуяа АНУ-ын CDC зэрэг мэргэжлийн байгууллагын тогтвортой үйл ажиллагааг сонирхон судалсан.

1996 онд Засгийн Газар болон эрүүл мэндийн яамны бүтэц өөрчлөгдөж, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам болсон үед мэргэжлийн, тогтвортой ажиллах байгууллага байгуулах шаардлага бүр илүү тодорхой болсон. Тиймээс 1996 оны намраас өмнө нь боловсруулж бэлтгэсэн дүрэм, журмаа ашиглан шинэ байгууллагыг хэрхэн байгуулах, үйл ажиллагааг нь эхлүүлэх талаар ажиллаж



1996-2009 онд тус байгууллагын Захирал, Даргаар ажиллаж байсан АУ-ны доктор, профессор, Монголын Анагаах ухааны академийн үндэслэгч гишүүн, академич ***Ц.Содномпилтэй ярилцлаа.***

> **“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ БАЙГУУЛАГДАХ БОЛСОН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА”**

эхэлсэн. Түүний хэлснээр шинэ байгууллагыг байгуулахад хамгийн чухал нь “цөм” буюу үндсэн мэргэжлийн баг, хамт олон байсан.

Өмнө нь “Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв”-ийг Эмч нарын мэргэжил дээшлүүлэх институтын бүрэлдэхүүнд байгуулсан. Тухайн үед хэд хэдэн чадварлаг залуусыг шинээр авч ажиллуулсан бөгөөд Н.Удвал, Л.Оюун, М.Туяа, Ш.Оюунбилэг, Э.Эрдэнэчимэг, Д.Лхайжав зэрэг хүмүүс байгууллагын үндсэн багийг бүрдүүлж байв.

Энэ багийг шинэ байгууллагын бүрэлдэхүүнд оруулахын тулд Эмч нарын мэргэжил дээшлүүлэх институтын захирал Л.Жигжидсүрэн багштай уулзсан. Л.Жигжидсүрэн захирал миний багш байсан. Би багшдаа “Эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр сургалт явуулж, үйл ажиллагаа хэрэгжүүлэх байгууллага байхгүй байна. Энэ чиглэлийн сургалтын үйл ажиллагаа ч хангалтгүй байна. Тиймээс эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр ажиллах байгууллага байгуулах шаардлагатай байна” гэж тайлбарласан.

Багш маань эхэндээ эргэлзэж, тодорхой хариу өгөөгүй. Дараагийн уулзалтаар Н.Удвал, М.Туяа нарын хамт энэ асуудлыг дахин ярилцаж, багшаас зөвшөөрөл авсан. Гэхдээ байгууллагыг хэрхэн зохион байгуулах, санхүүжилтийг хэрхэн шийдэх зэрэг олон асуудал тулгарсан.

“Анагаах ухааны хүрээлэн”-ийн Эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын секторын эрхлэгчээр Шинжлэх ухааны доктор, профессор Ц.Мухар ажиллаж байв. Би Ц.Мухар доктортой санал солилцож, цөмөөрөө хүчээ нэгтгэн судалдаг, сургадаг хэрэгжүүлдэг 3 үндсэн чиглэлтэй байгууллагыг байгуулж яамандаа туслах саналаа тавьсан. Ц.Мухар доктор уг санааг дэмжсэн боловч секторын харьяаллын асуудлыг хүрээлэнгийн захирал шийдэх ёстойг хэлсэн. Ингээд хүрээлэнгийн захирал Ё.Бодьхүү доктортой уулзаж, секторыг шинэ байгууллагад шилжүүлэх зөвшөөрөл авсан. Ингэснээр байгууллагын судалгааны чиглэлийн үндсэн бүрэлдэхүүн урьдчилан бүрдсэн.



Ингээд эмч нарын мэргэжил дээшлүүлэх институтын бүрэлдэхүүнд байгаа “Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв”-ийг тус сектортой нэгтгэн, судалгаа, сургалт, практик хэрэгжилтийг хослуулсан мэргэжлийн байгууллага байгуулах санал боловсруулсан.

Дараагийн алхам нь ЭМЯ-ны харьяанд статистикийн мэдээлэл боловсруулдаг Машинт станцыг одоогийн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнд шилжүүлсэн байсан.

Тухайн үед Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирлаар шинжлэх ухааны доктор, профессор Л.Нарантуяа ажиллаж байсан. Бид түүнтэй уулзаж, нэгтгэх асуудлаар зөвшилцсөн бөгөөд ерөнхийдөө зарчмын хувьд ойлголцолд хүрсэн. Үүний дараа нэгтгэгдэх албадын орон тоог ажиллагсдын тоог судалж, тухайн орон тоонд харгалзах төсөв, цалингийн зардлыг хамтад нь шилжүүлэхээр тооцсон. Ингээд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн нягтлан бодогч Шархүүтэй уулзаж, холбогдох мэдээлэл болон тооцоог танилцуулсан. Мөн багш Л.Жигжидсүрэнтэй хамтран тооцооллыг сайн гаргасан. Үүнийгээ ЭМНХХЯ-ны сайд Л.Зоригт танилцуулж, сайд маань намайг дагуулан Сангийн яаманд очиж, холбогдох хүмүүстэй уулзаж танилцуулсанаар энэ ажлыг хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг болсон. Дашрамд сайд асан Л.Зоригт дээрх ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэнд би талархаж явдаг.

Үүний дараа шинээр нэгтгэгдэх ажилтнууд, эд хөрөнгийг хаана байрлуулах байр, эмч нарын зохион байгуулалттай холбоотой зарим асуудлыг мөн шийдвэрлэх шаардлага гарч өмнө нь хамтран ажиллаж байсан байгууллага, хүмүүстэй зөвшилцсөн. Эмч нарын байрыг Л.Жигжидсүрэн багш зөвшөөрсөн тул тухайн байрыг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж, Засгийн газрын шийдвэрээр өмчийн шилжилтийг хийсэн.

Эмч нарын мэргэжил дээшлүүлэх институт татан буугдаж, Анагаах ухааны хүрээлэн (М.Шагдарсүрэн, И.Ядамсүрэн, К.Тунгалаг)-тэй нэгдэн, үйл ажиллагаагаа III эмнэлгийн байранд шилжүүлэхээр Л.Зориг сайд өөрөө санаачилж байсан бөгөөд би тэр үед уг ажлыг хэрэгжүүлэхэд оролцсон.

Эмч нарын мэргэжил дээшлүүлэх институтийг татан буулгаснаар тус байгууллагын хэрэгжүүлж байсан сургалт, бодлого, хөгжлийн чиг үүргийг шинээр байгуулагдах төвд шилжүүлэн хариуцуулахаар болсон. Ингэснээр анх төлөвлөж байсан чиг үүргээс өргөжиж, эмч нарын мэргэжлийн бүх шатны сургалтыг хариуцах болсон. Үүний дараа Хүрээлэнг III эмнэлгийн байранд шилжүүлэх яамны шийдвэр гарсан. Байрны асуудлыг шийдвэрлэхийн тулд Төрийн өмчийн хороонд хүрээлэнгийн байр, эмч нарын байрны талаар шаардлагатай мэдээлэл, тооцоог танилцуулж, холбогдох ажлуудыг зохион байгуулсан. Байрны эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн тооцоог гаргаж, барилгын насжилт болон үндсэн хөрөнгийн үнэлгээг хийлгэсэн.

> ***“1992–1996 онд НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, эрүүл мэндийг хөгжүүлэх чиглэлд тодорхой суурь бий болгосон.”***

> **БИ МОНГОЛЫН АЛДАРТАЙ ДӨРВӨН ХУТАГТ МЭНДЭЛСЭН ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ СУМАНД ТӨРЖ ӨССӨН ИХ ХУВЬТАЙ ХҮН.**

Ингэж байрны асуудлыг шийдвэрлэснээр байгууллага хоёр байртай болж, ажилтнуудаа бүрэн байршуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Мөн 1997 онд "Эмнэлэг гэгээрлийн ордон"-ыг татан буулгаж тухайн үед ажиллаж байсан ЭМУМ-ийн ажилтнуудыг төвд шилжүүлэн ажиллуулсан.

Ийнхүү ЭМХТ 1996 онд анх байгуулагдсан түүхтэй. Байгуулагдсан цагаасаа хойш Засгийн газар хэд хэдэн удаа солигдох бүрд байгууллагын бүтэц, статусыг өөрчлөх, татан буулгах зэрэг асуудал яригдаж байсан. Гэсэн хэдий ч байгууллагын үйл ажиллагааг хэвээр хадгалж, хөгжүүлэх чиглэлээр ажилласны үр дүнд ЭМХТ-ийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай болгосон. Улмаар агентлагийн статустай болгосны дараа би тэтгэвэртээ гарсан.

Таны хүүхэд нас Цаст Очирваань уулсын тэргүүн зулай сүндэрлэсэн, цагийн цагт орших их Очирваань бурханы шүншиг, ариуслын халуун голомтонд өсөж торнисон. Төрсөн нутаг, гэр бүлийн хүмүүжил, багш нарын тань үлгэр дуурайлал хожмын төрийн албаны манлайлал, эрүүл мэндийн салбарт зориулсан амьдралын үзэл баримтлалд тань хэрхэн нөлөөлсөн бэ?

Би Завхан аймгийн Нөмрөг сумын хүн. Хуучин Засагт хан аймгийн Цогтоо вангийн хошуу гэж байсан. Нөмрөг сум бол Монголын түүхэнд чухал байр суурь эзэлдэг. Яагаад гэвэл манай сумаас төрж гарсан 4 алдартай Хутагт, Гэгээнтнүүд бий. Монголын анхны Ерөнхий сайд Жалханц Хутагт Дамдинбазар, Дилов Хутагт Жамсранжав, Ари гэгээн, Ялгуусан гэгээн. Тэр их Хутагтуудын нутагт төрж өссөн бид бол их хувь заяатай. Миний төрсөн аав 24 жил Хатавчийн хүрээнд суусан. 1000-аад ламтай их том хүрээ байсан юм билээ. Аав маань 12 настайгаасаа 36 нас хүртлээ 24 жил суугаад 1938 оны 7 сарын 29-нд жинхэнэ хар болсон. Аав минь 1902 онд төрсөн. Тэгээд манай ээжтэй гэр бүл болоод 6 хүүхэдтэй болсон. Аав минь намайг бага байхад эрт өнгөрсөн дөө. Харин ээж минь биднийг өсгөсөн зүйрлэшгүй гавьяатан.

Би бол энэ эрүүл мэндийн салбарыг өөрөө сонгоогүй. Хөгжилтэй гэх юм уу нэг сонин түүх байгаа юм. Би 10-р ангиа Нөмрөг сумандаа төгссөн тэр жил 1965-1966 оны шилжих өвөл айхтар зуд болсон юм. Мал бэлчиж чадахаа байгаад Зөвлөлтийн Улаан армийн дайчид, Монголын ардын армийн дайчид машинтай ирж малчдад тусламж үзүүлсэн. Сумын захиргаа Зөвлөлтийнхөн уулзаж ярилцаад малчдад очихоор хэл нэвтрэхгүй, ярилцахгүй дээр нь зам мэдэхгүй учраас Орос хэл мэддэг хүүхдүүдээс авахаас өөр аргагүй болж Товуужав багш намайг сонгосон. Би тэр үед Орос хэлэндээ гайгүй сайн байсан.

Орос цэргийн машинд сууж тэр их цасыг туулж малчдын өвөлжөөнд очиж тусламж үзүүлсэн минь бахархалтай. Манай ангиас 2,3 хүүхэд дайчлагдаад явсан. Тэрнээс болсон юм уу буцаж ирээд хичээл ном гэж байгаад хавар төгсөх болоод эрчүүд маань "Цөмөөрөө ер нь нээх сайхан машины жолооч больё" гэцгээсэн. Тэгээд Эвлэлийн төв хорооноос бид хэдийг трактерын жолоочоор Ар хустайд илгээлт

болголоо. Би тэр үед эцэг, эх маань эрт өөд болсон болохоор нагац ахындаа амьдарч байсан үе. Тэгсэн нагац ахдаа хэлсэн чинь бүх л юмтайгаа бууж байна шүү. "Чи юу ярьж байна вэ" гээд. 10 төгсөөд аттестатаа аваад явах болсон чинь "Чи аймаг явж хуваарь юмаа янзлуулж ир" гээд намайг нэгдлийн машины кабинд суулгаад аймгийн төв явууллаа. Аймагт очоод "Боловсролын хэлтэс" дээр ороод "Манай ах намайг хуваариа янзал гээд явууллаа, би яах ёстой вэ?" гэж хэлтэл миний аттестатын дүнг үзээд надад гадаадын хуваарь өгсөн. Тэр нь Эрхүүгийн Политехникийн дээд сургуулийн уурхайн агааржуулалтын инженер. Томилолтон дээр бичсэнээ буцаж очоод нагац ахдаа үзүүлсэн. Тэгсэн чинь " Өө чи энэ уурхайд дарагдана. Болохгүй". Нагац ах минь л аавыг нас барсны дараа ээжид тусалж биднийг өсгөж хүмүүжүүлсэн хүн л дээ. Бид ах зах улсуудын л үгээр явж байсан. Дахиад л буцаад хуваариа солиулж ир гээд аймаг руу явуулсан.



Тэгээд очсон хуваарь бүгд дууссан байсан тул би аймгийн 10-н жилийн үүдэн дээр зар бичсэн. "Би Нөмрөг сумын 10 төгссөн. Надад ийм хуваарь байна. Энийг би солино. Надтай ирж уулзаач" гээд нэг газар цаг бичсэн. Тэндээ л өдөр өнждөг. Тэгсэн Будхүү гэж нэртэй хүүхэд ирээд хувиараа сольё гэсэн. Би "Чи өөрөө хаана хуваарилагдсан бэ" гэсэн "Багшийн дээдийн Орос хэлний ангид хуваарилагдсан". Тэгээд би Орос хэл жаахан гадарлах учир тэр хуваарийг авч ирсэн юм. Би хотод авга эгчийндээ ирлээ. Гэр нь Зайсанд. Эгч, ах нар маань намайг энэ одоо Орос хэлний багш болох юм байна. Энийг Анагаах руу оруулья гэсэн.

Тэгж байтал конкурс зарлагдаад АУДС дээр конкурс өгөхийг зөвшөөрсөн шалгалтын хуудас хүргэн ах маань авч өглөө. АУДС дээр очиж 4 шалгалт өглөө. 8 сарын 13-нд хамгийн сүүлийн шалгалтаа өгч дуустал зарлал бичсэн байна. "Шалгалт өгсөн бүх хүүхдүүд 8 сарын 15-нд сургууль дээр ирнэ үү" гэж байна. Хүрээд ирсэн чинь "Нэг хэсэг хүүхдийг материалаа ав, нөгөө хэсэг нь аж ахуйд явна" гэсэн байна. Өөрийнхөө нэрийг харсан чинь аж ахуйд явах дээр нэр гарсан байна. Ийм байдлаар би энэ Анагаах ухааны сургуульд орсон түүхтэй. Эхний 1, 2 жил оюутны амьдралд дасах чинь явдалтай шүү дээ. Ялангуяа би хөдөөний хүүхэд байсан учраас анагаахад ороход анатомийн хичээлийг үзэхэд их хүндрэлтэй. Хүний яс бүх юмтай л ажиллана шүү дээ. Тэрлүү орж чаддаггүй байлаа. Багшийн заасан онолын хичээл дээр нь болоод байдаг. Хүний цогцос руу орохоор л чаддаггүй. Тэгээд

сүүлд нь шалгалтаа өгөхийн тулд хонодог болдог юм байна. Тэгж байж сурдаг. Тэгээд яах вэ дасаад л, сураад л явсан даа. Би анагаахыг улаан дипломтой онц төгссөн. Тэгээд хөдөө Завханы Тосонцэнгэл суманд 5 жил ажиллаад тэндээсээ ЭМЯ-аас намайг дуудаад би нэг сар унжаад аймгийн ЭМГ-ын дарга Оросоо гэж хүн намайг машинтайгаа давхиж ирж аваад Тосонцэнгэлээс онгоцонд суулгаад явуулсан даа. Гэр орон тэнд үлдчихлээ. Тэгээд хотод ирээд хэсэг ажиллаж байтал яамнаас нэг машин гаргаж өгөөд би явж гэр орноо нүүлгэж ирээд хуучин Циркийн зүүн талд айлын хашаанд гэрээ барьсан. Яаманд 1976 оны 5 сарын 29-нд ажилд орсон. Тэр үед би уг нь хөдөөний хүүхэд хөдөөгөө байж л ажиллах сонирхолтой байсан даа. Ийм байдлаар би ЭМЯ-нд ажиллаж эхэлсэн юм. Тэгээд би эрүүл мэндийн удирдлага, менежмент гэдэг мэргэжлээр явсан хүн дээ.

> **“МОНГОЛ УЛСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР АНХ УДАА ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭВТРҮҮЛСЭН”**

Монгол Улсад эмнэлгийн байгууллагын магадлан итгэмжлэл болон эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоог анх бий болгосон нь эрүүл мэндийн чанарын удирдлагын шинэ эрин үеийг эхлүүлсэн гэж үздэг. Энэ шинэчлэлийн үндсэн философи юу байсан бэ?

Би ЭМЯ-нд ажиллаж байх хугацаандаа хүсэлт тавьж, олон улсын туршлага судлах зорилгоор хэд хэдэн улс оронд ажилласан. Тухайн үед дэлхий нийтэд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал онцгой анхаарал татаж байсан. Тиймээс эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг хэрхэн сайжруулах, үүнд ямар тогтолцоо, арга механизм шаардлагатайг судалж байлаа.

Эндээс “Чанар гэж юу вэ, түүнийг хэрхэн хангаж, хэн баталгаажуулах вэ?” гэсэн асуудал гарч ирсэн. Тусламж, үйлчилгээний чанар нь иргэдийн эрэлт болон байгууллагын нийлүүлэлттэй шууд холбоотой. Зах зээлийн зарчим чинь эрэлт, нийлүүлэлт дээр явдаг шүү дээ. Эрэлт бол чанартай сайн үйлчилгээ авах, нийлүүлэлт нь тэрэнд тохирсон үйлчилгээ үзүүлэх ёстой. Тэгэхээр тусламж үйлчилгээ авч байгаа хүн бол хаан. Хамгийн сайн үйлчилгээтэй газрыг сонгож үйлчлүүлнэ. Тэгэхээр энэ эрэлт нийлүүлэлтийн зарчим дээр үндэслээд үйлчилгээний чанар явдаг.

Тиймээс эмч, эмнэлгийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаагаа тодорхой шалгуур, шаардлагын дагуу хэрэгжүүлж, тусламж, үйлчилгээний чанараа баталгаажуулсан байх шаардлагатай. Тусламж, үйлчилгээ үнэхээр чанартай, аюулгүй байгаа эсэхийг хараат бусаар үнэлж, баталгаажуулах тогтолцоо зайлшгүй хэрэгтэй болсон. Энэ үндэслэлээр эрүүл мэндийн салбарт магадлан итгэмжлэлийн тогтолцоог нэвтрүүлсэн.

Энэ нь Монгол улсад эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлсэн анхны магадлан итгэмжлэлийн тогтолцоо болсон. Үүний дараа боловсрол болон бусад үйлчилгээний салбарууд магадлан итгэмжлэлийн тогтолцоог нэвтрүүлсэн. Тухайн үед манай төв дээр боловсролын салбарын төлөөлөл ирж, багшлах эрх олгох тогтолцоог нэвтрүүлэх

талаар зөвлөгөө, туршлага судалж байсан. Тиймээс энэ ажил нь зөвхөн эрүүл мэндийн салбарын төдийгүй Монгол улсын хэмжээнд шинэ тогтолцооны эхлэл болсон гэж үздэг.

Энэ тогтолцоог бий болгохын тулд БНСУ, Австрали, Сингапур зэрэг орны туршлагыг судалж, өөрийн орны нөхцөл, хууль эрх зүйн орчинтой уялдуулан хэрэгжүүлэх загварыг боловсруулсан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь хүний амь нас, эрүүл мэндтэй шууд холбоотой учраас мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүний шалгуур шаардлагыг тодорхой болгох нь онцгой ач холбогдолтой байсан.

2000 онд ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллахдаа энэ чиглэлээр холбогдох хуулийг боловсруулж, батлуулах ажлыг хийсэн. Ингэснээр тусламж, үйлчилгээний чанар, мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөл, тэдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Таны үед ЭМЯ-ны бодлогыг хэрэгжүүлж байсан сайд нартай хамтарч ажиллаж байсан тухайгаа дурьдвал?

Тухайн үед ажиллаж байсан Эрүүл мэндийн сайд, академич П.Нямдаваа энэ хөгжлийн төвийн үйл ажиллагааг тууштай дэмжиж ажилласан. Тэрээр зөвхөн Монголын төдийгүй дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн байсан бөгөөд төвийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Мөн дэд сайд Н.Удвал тус төвийг байгуулах үйл явцад оролцож, үйл ажиллагааг нь дэмжин ажилласан. Сангийн сайд Ч.Улаан ч мөн төвийн үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажилласан.

Түүнчлэн Б.Батсэрээдэнэ, Д.Туяа нар Эрүүл мэндийн сайдаар ажилласан богино хугацаандаа тус төвийг дэмжиж ажилласан. Эдгээр хүмүүсийн дэмжлэг, хамтын ажиллагаанд талархаж явдаг.

Эрүүл мэндийн хөгжлийн төв үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндийг хамтран ажиллаж байсан үе үеийн мэргэжилтнүүд, удирдлагуудад хүргэе. Та нартаа ажлын амжилт хүсье.





2016-2025 онд ЭМХТ-ийн даргаар ажиллаж байсан Анагаах ухааны доктор Б.Нарантуяагийн ажлын замнал, хэрэгжүүлсэн шинэчлэлийн талаар ярилцлаа.

Та ЭМХТ-д хэзээ анх ажиллаж эхэлсэн бэ? Тухайн үеийн байгууллагын эрх зүйн орчин, бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ ямар түвшинд байв?

Би анх 2016 оны 11 дүгээр сард ЭМХТ-ийн захирлын албыг хүлээн авч байлаа. Тэр үед миний сэтгэлд олон өөр мэдрэмж зэрэгцэн төрж байсан. Эрүүл мэндийн салбараа бүхэлд нь хөгжүүлэхсэн гэсэн гэнэн атлаа чин үнэн хүсэл, хурдан өөрчлөлтийг бий болгохсон гэсэн залуу хүний эрч хүч, тэмүүлэл нэг талд нь байхад, нөгөө талд нь байгууллагыг удирдана гэдэг олон хүний итгэл, хөдөлмөр, мөрөөдлийг нэгэн зорилгын төлөө зангидаж авч явах асар их хариуцлага гэдгийг улам тод мэдэрсэн.

Эргээд бодоход тэр өдөр миний хувьд эрч хүч, итгэл найдвар, хариуцлагын мэдрэмж зэрэгцэн оршсон, мартагдашгүй он жилүүдийн эхлэл байжээ.

Харин ЭМХТ-д ажилласан он жилүүдээ эргэн дурсахад хийж бүтээсэн ажил, гаргасан амжилтаас илүүтэй нэгэн зорилгын төлөө нэгдэж чадсан хамт олны маань дүр төрх хамгийн тод үлджээ.

Миний хувьд "хөгжлийн үндэс нь хүний хөгжил" гэсэн итгэл үнэмшил үргэлж тэргүүнд байсан. Тиймээс салбарын хөгжил, байгууллагын чадавх, албан хаагчдын мэдлэг, ур чадвар, манлайллыг зэрэг хөгжүүлэхийг үйл ажиллагааныхаа гол чиглэл болгож, түвшин бүрд хүнээ хөгжүүлэхэд онцгойлон анхаарч ажилласан.

Байгууллагын чиг үүрэг хууль, дүрэм, журмын хүрээнд хэрэгждэг ч байгууллагыг хөгжүүлдэг нь хүн. Харин зарчимтай байх нь хүнийг холдуулах бус, хамтын итгэлцлийг хамгаалдаг түшиг тулгуур юм. Харилцан итгэлцэлтэй баг хамгийн хүнд ачааг ч хамтдаа үүрч чаддаг гэдгийг би хамт олноосоо сурсан.



Таны ажилласан он жилүүд эрүүл мэндийн салбарын өөрчлөлт, шинэчлэлийн эрчимтэй үе байжээ. Энэ хугацааг та хэрхэн дүгнэдэг вэ?

Эдгээр он жилүүдэд эрүүл мэндийн салбар өөрчлөлт, шинэчлэлийн хүчтэй давалгаанд орж, хөгжлийн шинэ үеийг түүчээлэн хөтлөх үүрэг бидний өмнө ирсэн. Цахим шилжилт эрчимжиж, мэдээлэл хөгжлийн чухал нөөц болж байсан тэр үед дэлхий нийтийг хамарсан цар тахал биднийг урьд өмнө байгаагүй сорилттой нүүр тулгасан.

Гэсэн хэдий ч бид хамт олноороо сорилт бүрийг хөгжлийн боломж, өөрчлөлт бүрийг урагшлах алхам болгон харахыг хичээж ажилласан. Тэр он жилүүдэд бидний хамтдаа хүрсэн амжилт, хэрэгжүүлсэн ажил олон.



Судалгаа, нотолгоонд суурилсан бодлогын талаар ямар байр суурь баримталж ажилласан бэ?

Эрүүл мэндийн салбар бол шинжлэх ухаан, судалгааны үр дүнтэй салшгүй холбоотой. Шинэ мэдлэг, шинэ арга технологи тасралтгүй бий болж байдаг учраас салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бодлогын судалгааны ач холбогдол өндөр.

Тиймээс үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг хөндсөн бодлогын судалгааг хэрэгжүүлж, судалгааны үр дүнг бодлого, шийдвэр гаргалтын үндэс болгоход анхаарч ажилласан.

Судалгааны үнэ цэнэ нь зөвхөн шинэ мэдлэг бүтээхэд бус, бодлого, шийдвэрийг илүү нотолгоонд тулгуурлан гаргах боломж бүрдүүлэхэд оршдог гэдгийг энэ хугацаанд улам тод ойлгосон.

Олон улсын туршлагыг Монголд нутагшуулах чиглэлээр ямар ажил хийсэн бэ?

> ***“ХӨГЖЛИЙН ҮНДЭС НЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ БАЙДАГ” ГЭСЭН ИТГЭЛ ҮНЭМШЛЭЭР САЛБАРЫН ХӨГЖИЛ, БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ, АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ, УР ЧАДВАР, МАНЛАЙЛЛЫГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛЭХИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫХАА ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БОЛГОН АЖИЛЛАСАН.”***

Олон улсын сайн туршлагыг нутагшуулахын тулд зочин профессорын сургалтыг тогтмолжуулж, Монгол Улсад эмчлэгддэггүй өвчний чиглэлээр олон салбарын мэргэжилтнүүд хамтран суралцах шинэ хандлагын эхлэлийг тавьсан.

Мөн эрүүл мэндийн ажилтнууд дэлхийн түвшний, эмнэлзүйн нотолгоонд суурилсан мэдээллийг өдөр тутмын ажилдаа ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор UpToDate мэдээллийн санг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн.

Цахим шилжилтийн хүрээнд ямар өөрчлөлтийг чухалчилж байв?

Цахим шилжилт зөвхөн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, эмнэлгийн дотоод үйл ажиллагаагаар хязгаарлагдах ёсгүй. Харин иргэдэд хүрэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, шуурхай байдалд бодит өөрчлөлт авчрах ёстой гэж бид үзэж байсан.

Энэ үзэл баримтлалын хүрээнд амбулаторийн цаг товлох нэгдсэн үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. Үүний тулд зөвхөн цахим шийдэл бий болгоод зогсохгүй эрх зүйн орчныг бүрдүүлэх, чиг үүргийн нэгж байгуулах, байгууллага хоорондын хамтын ажиллагааны механизмыг төлөвшүүлэх зэрэг цогц ажлыг хэрэгжүүлсэн.

Өнөөдөр иргэдийн өдөр тутмын хэрэглээ болсон энэхүү үйлчилгээ нь эрүүл мэндийн салбарын үйлчилгээний шинэ соёлыг төлөвшүүлэх, иргэдэд илүү ээлтэй, хүртээмжтэй үйлчилгээг бий болгоход тодорхой хувь нэмэр оруулсан гэж боддог.



Та эрүүл мэндийн хөгжлийн төвд хэзээ анх ажилд орж байсан бэ?

За би 1999 оны хавар ЭМХТ-д ажилд орсон. Тэгэхэд анх “Эрүүл мэндийн студи” гэж байсан. Тэдний жолоочоор ажиллаж эхлээд 3 жил тэрэг барьсан. Ю. Дамбадорж гэж миний дарга байлаа. Дарга намайг аваад студийн хүүхдүүд цуг явж орон нутагт болон Улаанбаатар хотод эрүүл мэндийн тухай нэвтрүүлэг хийж Үндэсний телевизэд өгч орон даяар цацагддаг байсан.

Тэгээд 2003 оноос эхлээд манай захирал С.Дуламсүрэн гэж хүн болоод намайг жолоочоор авсан. 2003-2020 он хүртэл энэ байгууллагынхаа үе, үеийн бүх захирлын жолоочийг хийсэн. Гадаад, дотоодын бүх төлөөлөгчдийг авч орон нутагт явлаа. Хөгжлийн төвийнхөө анхны магадлан итгэмжлэлийн албаны жолоочоор орон нутагт явж байлаа. Дараа нь төгсөлтийн дараах сургалтын алба гэж байсан. Тэрний жолоочоор мөн орон нутагт явсан. Тоног төхөөрөмж гээд 2014 онд боллоо. Тэрний бас анхны жолоочоор баахан тоног, төхөөрөмж, залуу ажилчидаа аваад бүх аймгуудаар явсан даа.



Жолооч хэмээх хариуцлагатай ажлыг сонгож энэ байгууллагад олон жил тасралтгүй ажилласан мэргэжлийнхээ онцлогийн талаар ярина уу?

За ер нь анхнаасаа л жолооч болох их сонирхолтой байсан. 1980 онд жолоочийн мэргэжлийг цэргийн ангид эзэмшсэн. Тэр цагаас хойш жолоочоо хийгээд л явсан даа. Жолооч гэдэг бол их сайхан мэргэжил шүү дээ. Хүмүүсийн аюулгүй байдлыг хангаад хүрэх газар нь хүргэж өгөөд ажлыг нь бүтээж өгөөд буцаад ирэх нь хамгийн сайхан. Жолооч хүний аз жаргал энэ л байдаг юм.

Жолоочийн ажил энэ мэргэжил энгийн мэт харагдах боловч байгууллагын үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Миний хамгийн хариуцлагатай зүйл машин техникээ бүрэн бүтэн байлгах. Энэ улсуудын амь нас, аюулгүй байдлыг хангах. Энэ бол миний үүрэг. Онц байдал зарласан зудтай хүнд үе, зун, намар, хавар бүх цаг үед аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж явдаг.

Мөн дарга нарыг ч бай мэргэжилтнүүдийг ч бай дуудсан цагт нь бэлэн байж цагийг маш сайн баримтлаж ажилласан. Би ер нь ажиллаж байх хугацаандаа чөлөө авч үзээгүй, эмнэлэгт ч хэвтэж үзээгүй хүн дээ.

> ***“АЖИЛТНУУДЫНХАА АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХЫН ТУЛД МАШИН ТЕХНИКЭЭ БҮРЭН БҮТЭН БАЙЛГАХ НЬ МИНИЙ ҮҮРЭГ БАЙСАН.”***



> *“1999-2020 онд ЭМХТ-д жолоочоор ажилласан Ш.Бямбабаатартай түүний ажил мэргэжлийн онцлогийн талаар ярилцлаа.”*

> “ ***ҮЕ, ҮЕИЙН УДИРДЛАГА, МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙГЭЭ ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР ХАМТ ЯВЖ БАЙСАН ҮЕЭЭ ЭРГЭН БОДОХОД ХАМГИЙН САЙХАН ДУРСАМЖТАЙ САНАГДАЖ БАЙНА.*** ”

ЭМХТ-ийнхөө удирдлага, эмч, мэргэжилтнүүдтэй хамт явсан томилолт хөдөө орон нутагт ажиллаж байсан дурсамжаасаа хуваалцаач?

Миний үе, үеийн дарга нар байна, мэргэжилтнүүд байна. Хөдөө гадаа орон нутаг руу үргэлж цуг явж байсан сайхан дурсамжтай. Ер нь одоо бодоход залуу насандаа мэргэжилтнүүд, дарга нартайгаа хөдөө гадаа явж байсан бүгд л их сайхан санагддаг, бүгд л дурсамжтай сайхан байна.

Тэр дундаа 2003 онд ЭМЯ-ны томилолтоор Дууяа даргатай одоо энэ Халдвартын эмнэлгийн дарга хийж байгаа С.Энхболд дарга бид хэд Өмнөговь аймаг руу явсан юм. Тэгэхэд одоотой адил засмал зам гэж байгаагүй. Шөнө харанхуй болоод би төөрч давхиад тэгсэн нэг фургон ирж байхаар нь зогсоож жолоочоос нь замаа асуусан. “Өмнөговь ордог зам мөн үү” “Мөн, мөн ингээд яваарай” л гэж байна.

Тэгээд яваад л байдаг, яваад л байдаг 2, 3 ахиад л машины гэрэл гараад. Говь чинь тал газар давхиж, давхиж байгаад л эргээд ирэхэд ахиад л нөгөө фургон. Тэгээд фургоны жолооч сүүлдээ надаас залхаад “Үгүй ээ та чинь ямар хаашаа юм бэ? Намайг дагаад л яваад байх юм. Таны явах зам чинь энэ замаараа л явна шүү дээ” гэлээ. Нэг төөрчихсөн хүн чинь тэгээд толгойны төөрөө гардаггүй. Говийн жолоочид загнуулаад Энхболд дарга сонсоод бид хэд машин дотроо нилээн сайн инээлдсэн. Говьд цэлийсэн тал дээр ямар ч баримжаа байхгүй. Уул, ус харагдахгүй. Тэр гэхийн тэмдэггүй Олдохын тал дээр төөрч байсан минь хамгийн дурсамжтай.



Мөн 2004 онд “Хүний нөөцийн хөгжлийн алба”-ны дарга Ш.Оюунбилэг бид хоёр Австралийн нэг мэргэжилтнийг аваад Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум руу томилолтоор явсан. Өмнөдэлгэрээс гарч яваад зам асуутал “Энэ жоохон голыг гараад төв замтай нийлнэ” гэлээ. Тэр гол руу орсон чинь юун жоохон гол биш машин далд ороод өргөндүү гол байна. 4,5 минут яваад гараад ирсэн чинь нөгөө гадны мэргэжилтэн гайхаад “Үгүй нээрээ Монгол жолооч ямар мундаг юм бэ? Машин далд орсон усанд зам байхгүй газраар яваад гараад ирдэг. Засмал байхгүй газар энэ олон салаа замаас сонгож явсаар байгаад очих газартаа хүрдэг юм байна. Монгол жолооч нарын ур чадвар үнэхээр сайн байна” гэж хэлж байсан. Дараа нь Австралдаа очоод тэр үед дарсан зургуудаа угааж надад явуулж байсан. Олон ч гадаадын төлөөлөгч, мэргэжилтнүүдтэй цуг явсан даа.

Дууяа даргын жолоочоор би 8 жил ажилласан. Дарга гол, уснаас их айдаг. Гол гатлах гэхээр л айгаад сүүлдээ дассан. Баруун аймгууд руу томилолтоор явахад намар эрт болно. Мод шарласан байгааг хараад





Дууяа дарга “Манай говьд дулаан зунаараа байгаа. Хангай газар ийм эрт намар болдог юм байна” гээд нутгаа их санагалзаж яриж явдаг байсан.

Энэ хариуцлагтай албыг хашиж явахад таны ар албыг таны сайхан хань залгуулж явсан байх. Хажууд тань нөмөр түшиг болсон ханийнхаа тухай дурсаж ярина уу?

Миний хань худалдааны мэргэжилтэй хүн. Арын албыг минь их сайхан авч явсан. 3 хүүхдээ өсгөхөөс эхлээд гэрийн бүх ажлыг нугалсан даа. Хотод байхдаа би өглөө эрт гараад шөнө хүүхдүүдүүдээ унтсан хойно орно. Хүүхдүүд “Аав минь хэзээ ирэх вэ? аав яасан бэ?” гэж их асууна. Зарим үед томилолтоос дөнгөж ирээд 22-ын товчоогоор орж байхад “Маргааш өглөө нэг баг явна шүү” гэдэг байлаа. Би гэрт ямар ч роль байхгүй очиж унтах л үүрэгтэй. Гэрийн бараа хардаггүй, цаг наргүй ажиллаж, улсын ажил, ажил гэж явсаар байгаад тэтгэвэртээ гарсан хүн дээ.

За ингээд манай ЭМХТ их ээлтэй сайхан байгууллага. Ye, үеийн ажилчид маань их хариуцлагатай, үнэнч шударга, цаг их баримталдаг хаана ч очсон нэр хүндтэй албан газар. Одоо энэ залуучууд энэ бүгдийг залгамжлаад авч явж байгааг харах сайхан байна. Хамт олондоо 30 жилийн ойн байярын мэндийг хүргэж сайн, сайхныг хүсье.

Шагдарын Бямбабаатар, Улаанбаатар хот, 2026 он



2018 оноос эхлэн ЭМХТ-д “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба”-ны даргаар ажиллаж байсан П.БАТЧУЛУУН эмчтэй ярилцлаа.

2018 онд “Донорын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн ЭМХТ-ийн бүтэц дотор “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба”-ыг байгуулсан. Тэр үед Монгол Улсын ЭМ-ийн тогтолцоонд эрхтэн шилжүүлэх үйл ажиллагааны нөхцөл байдал ямар байснаас яриагаа эхэлье?

Би 2014 онд УНТЭ-ийн “Эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн даргаар ажилласан. Тухайн үед УНТЭ нь Монгол Улсад эрхтэн, эс, эд шилжүүлэн суулгах үйл ажиллагаа явуулдаг цорын ганц төв байлаа.

Төвийн даргаар томилогдоод үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, ямар журмаар ажиллах талаар тодорхой удирдамж, журам байгаагүй. Тиймээс үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, дарааллыг тодорхойлсон нэлээд дэлгэрэнгүй удирдамж, журмын төсөл боловсруулж, тухайн үеийн УНТЭ-ийн захирал Б.Бямбадорж, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Д.Чулуунбат нарт танилцуулсан. Манай захирал “Батчулуун аа, энэ бол зөвхөн УНТЭ-ийн хэмжээнд батлах журам биш байна. Яамны хэмжээнд авч үзэж байж шийдэх асуудал байна. Таны боловсруулсан удирдамж, журмыг албан бичгээр дагалдуулаад ЭМЯ руу явуулъя” гээд яам руу хүргүүлсэн.

Тухайн үед ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргаар ажиллаж байсан, миний бага насны найз О.Баяр “Батчулуунаа, чи ямар их зүйл бичээ вэ. Ирж уулзаач” гэсэн. Тэгээд очтол О.Баяр дарга: “Энэ бол ЭМЯ ч дангаараа гаргаж болохооргүй журам байна шүү” үүнийг би Төрийн нарийн бичгийн дарга болон сайдад танилцуулъя” гэсэн. Тухайн үед Г.Шийлэгдамба сайд байсан. Тэгээд “Энэ асуудлыг хуульчилж, Цусны донорын тухай хуульд заалт болгон оруулж байж л эрх зүйн хүрээнд зохицуулах боломжтой” гэж үзээд, Г.Шийлэгдамба сайдын тушаалаар хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан.

Дараа нь Г.Шийлэгдамба сайд солигдож, А.Цогцэцэг сайд болсон. Ажлын хэсэг 2014-2018 он хүртэл нэлээд эрчимтэй ажилласан. Салбарын нэр хүндтэй олон мэргэжилтэн оролцсон томоохон ажлын хэсэг байлаа. Д.Нямсүрэн профессор, Л.Жамбалжав, Б.Бямбадорж, О.Сэргэлэн, Н.Оюундэлгэр, Д.Баян-Өндөр, Ц.Саранцэцэг зэрэг хүмүүс ажилласан.

Улмаар Д.Сарангэрэл сайдын үед хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, 2018 оны нэгдүгээр сарын 19-нд хууль батлагдсан. “Цусны донорын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах алба” байхыг хуульчилж өгсөн.

Ингэж эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах албаны эрх зүйн үндэс тавигдсан даа.

Тэгэхэд би эрүүл мэндийн шалтгаантай байлаа. 2011 онд зүрхний шигдээсээр өвдөж 2016 онд дахиж шигдээс болоод зүрхний өвчин хүндэрсэн үед би гэртээ байсан. Хууль батлагдсанаас 10-аад хоногийн

дараа Д.Сарангэрэл сайд надтай яриад "Батчулуун эмч бие чинь сайн уу. Та юу хийж байна. Та нэг ирж уулзаач" гэсэн. Сайдтай уулзахад "Танай хууль батлагдсан. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн алба байгуулах шаардлагатай. Гэтэл танай албыг байгуулъя гэхээр хаана байгуулах, хэн удирдаж авч явах, ямар бүрэлдэхүүнтэй байх вэ гэсэн асуудал үүсээд байна.

Та өөрөө анхнаас нь санаачилж явсан хүний хувьд санаа оноогоо хэлээч" гээд сайд бид хоёр ярилцаж байгаад ЭМХТ-ийн бүрэлдэхүүнд оруулаад энэ албыг байгуулъя гэсэн. Тэгээд 2018 оны гуравдугаар сарын 01-нд ЭМС-ын тушаал гарч ЭМХТ-ийн бүтцэд "Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйлчилгээг зохицуулах алба" байна гээд тэр үед ЭМХТ-ийн захирал байсан Э.Содномжамц захирал тушаал гаргаад энэ албыг зургаан хүний бүрэлдэхүүнтэй баталж байлаа.

Ингэж манай алба ЭМХТ-ийн бүтцэд байгуулагдан, өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд Э.Содномжамц дарга болон үе үеийн удирдлагууд манай албыг тогтмол дэмжиж ирсэн. Тухайлбал, Г.Ганцэцэг, Б.Нарантуяа, одоо ажиллаж байгаа М.Одгэрэл дарга нар ажлын байр, нөхцөлөөр хангах, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх зэрэг бүхий л талаар дэмжиж ажилласан. Энэ дэмжлэгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Нөгөө талаас манай хамт олон өөрсдөө ч идэвх санаачилгатай ажилласан. Миний удирдлаган дор ажиллаж байсан залуучууд олон шинэ ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. Өнөөдрийн байдлаар манай алба байгуулагдсанаас хойш Монгол Улсад өмнө нь хэрэгжиж байгаагүй 34 ажлыг шинээр нэвтрүүлж, ажил хэрэг болгосон байна.

Энэ бол эрүүл мэндийн салбарт оруулсан тодорхой хувь нэмэр төдийгүй эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний салбарт гарсан шинэ дэвшил гэж би үздэг. Бид эдгээр үйл ажиллагааг Монгол Улсад нэвтрүүлснээр өмнө нь гадаад улс оронд хийлгэдэг



> ***"АМЬГҮЙ ДОНОРООС ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАДАГ БОЛСНООР ГАДААД РУУ УРСАХ 45 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ БИД ХЭМНЭЖ ЧАДСАН."***

> ***“ДЭМБ-ААС ГАРГАСАН СУДАЛГААГААР МОНГОЛ ЭМЧ НАР ЭНЭ САЛБАРТАА ДЭЛХИЙН ДУНДЖААС ДЭЭГҮҮР ҮНЭЛЭГДДЭГ.”***

байсан эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний зардлаас ихээхэн хэмжээгээр хэмнэх боломж бүрдсэн. Өөрөөр хэлбэл, эмчилгээний тодорхой үйлчилгээг эх орондоо хөгжүүлж, иргэдэд дотооддоо авах боломжийг бий болгосноор гадагш чиглэдэг байсан олон тэрбум төгрөгийн урсгалыг бууруулахад хувь нэмэр оруулсан.

“Донорын тухай хууль”-ийн хэрэгжилтийг бодит ажил болгоход хамгийн их хүндрэлтэй асуудал юу байсан бэ?

Хамгийн хүнд байсан асуудал нь амьгүй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээг хөрсөн дээр буулгах байсан. Ард олон түмэнд зөвөөр ойлгуулах, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг амьгүй донороос хийх ойлголтыг таниулахын төлөө дорвитой ажлыг хийсэн. ДЭМБ, “Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг”-ээс зөвлөхдөө “Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хийхдээ аль болох амьгүй донороос хийх ёстой” гэж зөвлөдөг.

Тийм учраас “Танай улсад тархины үхэлтэй донор, тархинд нь цус харвасан, авто ослоор нас барсан хүмүүсийнхээ эрүүл эрхтэнг бусдын амь насыг аврах энэ үйл хэрэгт ашиглах хэрэгтэй. Энэ үйл хэрэг хаа байсан 1963 оноос дэлхийн практикт хэрэгжээд эхэлсэн. Энийг л та нар хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй” гэсэн чиглэл өгсөн. Эрдэнэт хүний амийг аврахын төлөө л бид ажилласан.

2019 онд бид маш үр дүнтэй ажиллаж чадсан гэж боддог. Амьгүй донороос гарсан эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хамгийн ололттой жил байсан. Дараа нь корона залгаад 2,3 жил боллоо. Тэр хооронд ажиллаж байсан хүмүүс маань хэсэг завсарлага авсан. Дараа нь надтай холбоотой нэг асуудал гарч ирээд хэлмэгдэж, ойлголцлын зөрүүний асуудал үүссэн. Үүнээс болж сошл ертөнцөд баахан буруу, зөрүү ойлголт явсанд эмзэглэж явдаг.

Харин өнөөдөр 2026 оны эхний хагас жилд бид хоёр амьгүй донороос дөрвөн хүнд бөөр, хоёр хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг хийсэн байна. Ямар ч байсан хуучин байдал сэргэх төлөвтэй явж байгаад баяртай байна. Монгол улсын шарын шашин болоод бидний уламжлалт ухамсар сэрэхүйд бие, биедээ туслах дэмжих, хүний эрүүл мэндийг аврах, буян хийх гэдэг бол буяны дээд буян, өглөгийн дээд өглөг гэж үздэг. Үл ойлголцлын гогцоог л арилгах хэрэгтэй байгаа юм. Амьдрал бол баялаг. Монголчууд боловсролтой, сайхан сэтгэлтэй.

Энэ үйл ажиллагааг тун удахгүй ард түмэн маань ойлгоод амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг улам нарийн хийдэг болох нь дамжиггүй. Монголд жил болгон даралт ихсэх өвчнөөр тархинд нь цус харваж нас барж байгаа 2500 орчим тохиолдол, аавто осол, ахуйн ослоос болж 400 гаруй хүн нас барж байна. Харамсалтайгаар цаг бусаар бурхан болж байгаа хүмүүсийнхээ зөвхөн таван хувийг л эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд донор

болгоод ашиглахад бид 100 гаруй хүний амь насыг аврах бололцоотой л байгаа. Бид улс эх орондоо амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хийснээс хойш нийтдээ 18.000 орчим удаа УГТЭ, ГССҮТ, хөдөө орон нутаг, УНТЭ гээд донор гаргадаг эмнэлгүүдтэйгээ холбоо тогтоож донорын үйл хэргийг өрнүүлсэн түүхтэй. Үүнээс бид 35 бодит донор илрүүлж одоогийн байдлаар 75 хүний 47 хүнд бөөр шилжүүлэн суулгах, үлдсэн 25-д нь элэг шилжүүлэн суулгах эмчилгээ хийсэн. Түүнээс 170 гаруй хүнд бид амьгүй донороос шөрмөс шилжүүлэн суулгажээ.



Ингээд дүгнэхээр нэг хүний эмчилгээг гадны улсад хийлгэх онгоцны зардал, гэр бүлийн хамт явах хүний зардал, хоол унааны зардлыг оролцуулахгүйгээр зөвхөн нэг сарын эмчилгээ хийлгэх, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний зардлыг тооцоод үзэхэд Монгол Улсаас урсаж гарах нийтдээ 45 тэрбум төгрөгийг хадгалж үлдсэн.

Манай эрхтэн шилжүүлэн суулгах баг, бөөр шилжүүлэн суулгах баг, ХСҮТ-ийн элэг шилжүүлэн суулгах баг, бөөр шилжүүлэн суулгах баг, УХТЭ-ийн бөөр шилжүүлэн суулгах баг, ЭХЭМҮТ-ийн баг, ЦТЭ гээд зургаан эмнэлэг нийлээд Монгол Улсдаа 1500-аад хүнд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хийжээ.

Гэтэл энэ 1500 хүний 75 нь амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэсэн. Үлдсэн 97-98 хувь нь амьд донороос хийсэн. Тиймээс бид аль болох амьгүй донороос авдаг болох хэрэгтэй. Амьгүй донороос хийдэг мэс заслаа 90 гаруй хувь болгоод амьд донороос хийдэг мэс заслаа багасгах ёстой. Яагаад гэвэл бид амьд донорыг эрсдэлд оруулаад хос эрхтэнийх нь нэгийг цуллаг эрхтэнийх нь талыг авч байгаа тул амьд донорын амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Монгол Улсдаа эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийдэг болсноос хойш манай иргэд дэлхийн жишигт нийцсэн чанартай, хүртээмжтэй эмчилгээг хийлгээд хамгийн гол нь сэтгэл, санааны болон эдийн засгийн дарамтаас тодорхой хэмжээгээр хөнгөлөгдөж байгаа нь маргаагүй үнэн. Өнөөдөр манай багуудын үр дүн дэлхийн дунджаас дээгүүр дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын үр дүнтэй ижил түвшинд явж байгаа.

Дэлхийн улс оронд хаана ч яваад очиход Монголчууд эрдэм мэдлэг, ур чадвар, эв нэгдэл, үр дүнтэй хамтарч ажиллаж чаддаг. ДЭМБ, “Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг”, Монгол Улсын ҮАБЗ, ЭМЯ-нд үнэн бодитой мэдээллүүдийг өгч, үр дүнгийн

> ***“ӨНӨӨГИЙН БАЙДЛААР eHealth, eMongolia ПЛАТФОРМООР ДАМЖУУЛАН 7000 ГАРУЙ ИРГЭН ДОНОР БОЛОХ ХҮСЭЛТЭЭ ӨГСӨН.”***

тайлангаа тавьдаг бөгөөд үнэн зөв мэдээллийг ДЭМБ, “Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг” хоёрын хамтарсан GODT байгууллага жил бүр дэлхий даяар цацдаг. Дэлхийн 220 орноос 93 оронд эрхтэн, эс, эд шилжүүлэн суулгах эмчилгээг хийж байгаа. Энэ орны хүмүүс Монгол хаана явж байгааг хардаг. Бидний гаргасан үр дүн ингээд дэлхий даяараа нээлттэй, ойлгомжтой мэдэгддэг болсон учраас манай багийн гишүүд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг урам зоригтой хийн ажиллаж байна.

Бид 2026 оны тавдугаар сарын 8-нд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай анхны бие даасан хуулийг батлуулж чадлаа. Ер нь хууль батлуулна гэдэг тийм амархан ажил биш юм байна билээ. Гэхдээ ямар ч хууль, дүрэм, журам яг бүрэн дүүрэн төгс төгөлдөр болдоггүй. Дахиад болохгүйг нь шинэчлээд, өөрчлөөд, нэмэлт өөрчлөлтүүд оруулж болдог. Ийм учраас амьдралын явцад улам сайжраад төгөлдөржөөд явна гэдэгт итгэлтэй байна. Хамгийн гол нь эхний санаа нь гараад ингээд батлагдана гэдэг бол их том амжилт гэж ойлгож байна**.**

Энэ тогтолцоог бүрдүүлэхэд төв эмнэлгүүд, донор эмнэлгүүд, ЭМЯ, ЭМХТ болон ОУ-ын байгууллагуудын хамтын ажиллагаа ямар үүрэг оролцоотой ажиллаж ирсэн бэ?

Их сайхан асуулт байна. Би УНТЭ-ийн “Эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн даргаар ажиллаж байхад гадаадын эрхтэн шилжүүлэн суулгах дэлхийн байгууллага, Азийн эрхтэн шилжүүлэн суулгах байгууллагынхан бидэнд маш их тусалсан. Миний багш нар болох Австрали улсын иргэн Жереми Чапмен, профессор О.Коннел, БНСУ-ын Сөүлийн Их Сургуулийн профессор Кури Ан, АНУ-ын “Эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг”-ийн профессор Нэнси Ашер гээд олон эрхэм хүмүүс ингэж ажиллах ёстой гэдэг саналуудыг надад зөвлөж, хичээл зааж ажилласан.

Би энэ бүхнийг бичиж, судалж, сурч боловсорсны үндсэн дээр УНТЭ-ийн анхны “Эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн үйл ажиллагаанд баримталж ажиллах журмыг боловсруулж батлуулснаар уг журам явсаар өнөөдөр Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай бие даасан анхдагч хуулийн суурь болсон.

Гэхдээ энэ чиглэлээр бусад хүмүүсийн зааж, зөвлөсөн зүйлсийг Монгол Улсын хөрсөн дээр хэрхэн буулгах, өөрийн орны онцлогт хэрхэн нийцүүлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулж Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийж буй багийнхаа гишүүдтэй нягт хамтран ажиллаж, тэдний санал, санаачилгыг тусган боловсруулсан.

Мөн төр, захиргааны байгууллагууд, тухайлбал Засгийн газар, УИХ, ЭМЯ, ЭМХТ болон олон улсын хүний эрхийн байгууллагуудаас олон санал ирж байсан. Эдгээр саналыг бүгдийг нь авч үзэн нэгтгэж, “эхийг нь эцээхгүй, тугалыг нь тураахгүй” гэдэг шиг боломжтой бүх саналыг тусган хуульд оруулж өгсөн.

Монгол Улсад эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хамгийн их дэмжиж, амьгүй донорын үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон ажилладаг хоёр эмнэлэг бий.

Нэгдүгээрт, Ц.Төмөр-Очир захиралтай УГТЭ. Тус эмнэлэг дангаараа амьгүй донорын тохиолдлын 90 орчим хувийг илрүүлэн оношилж, донорын үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс бидний аварч байгаа олон хүний амь насны цаана УГТЭ-ийн эмч, эмнэлгийн ажилтнуудын хөдөлмөр, зүтгэл бий.

УГТЭ-ийн Г.Байгалмаа ахлагчтай "Тархины харвалтын төв", Ш.Энх-Амгалан ахлагчтай "Эрчимт эмчилгээний тасаг", Л.Аваажигмэд ахлагчтай "Тархины мэс заслын тасаг"-ийн эмч, мэргэжилтнүүд маш сайн ажилладаг. Эдгээр багийн үйл ажиллагааг бодлого, зохион байгуулалтаар чиглүүлж ажилладаг гол хүн нь эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир.

Мөн хамгийн олон донор гаргадаг эмнэлэг бол ГССҮТ. Энэ эмнэлгийн дарга Э.Галбадрахыг дурдахгүй өнгөрч болохгүй. Өмнө нь Т.Мөнхсайхан сайдаар ажиллаж байх үед ч энэ чиглэлд бодлогоор дэмжиж ажилласан.

ГССҮТ-ийн хувьд тархины хүнд гэмтэл авсан өвчтөний амь нас, эрүүл мэндийг юуны өмнө аврахын төлөө бүх боломжоо дайчилдаг. Хэрэв эмчилгээ үр дүнд хүрэхгүй болж, тухайн хүн донор болох боломжтой нөхцөл үүсвэл дараагийн асуудал нь эрхтнийг нь шилжүүлэн суулгаж, цаана нь амь насаа авруулах шаардлагатай байгаа бусад хүний амь насыг аврах явдал болдог. Нэг донороос гурваас найман хүний амь насыг аврах боломжтой тохиолдол ч бий.

Монгол хүн бол Монгол Улсын хамгийн үнэт баялаг. Тиймээс эрдэнэт хүн маань юуны өмнө эрүүл байх ёстой. Мөн боловсролтой байх ёстой. Эрүүл, боловсролтой монгол хүн бол Монгол Улсын хамгийн үнэт баялаг. Түүнээс биш алт, нүүрс, газрын тос бидний хамгийн том баялаг биш.

Тийм учраас монголчууд маань өөрийнхөө биеийг өөрийн эрхэм зүйл хэмээн хайрлаж, хамгаалж, зөв арчилж, эрүүл мэнддээ анхааралтай гэж хүсдэг. Биеэ өөрийнх биш юм шиг хэрэглэж болохгүй. Урьдчилан сэргийлэх үзлэгтээ цаг тухайд нь хамрагдаж, эрүүл мэндээ хамгаалах хэрэгтэй. Мөн төр, засгаас хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн бодлого, үйл ажиллагааг дэмжиж, өөрсдийнхөө эрүүл мэндийн төлөө идэвхтэй оролцмоор байна.

Эцсийн эцэст хүн өөрийнхөө биед өөрөө эзэн болж, эрүүл мэндээ хамгаалж, өөрийгөө өөд нь татаж авч явах ёстой. О.Дашбалбар зохиолчийн "Амьддаа бие, биеэ хайрла, хүмүүс ээ" гэсэн үгийг би их хэлэх дуртай.

> *"Бид цөөхүүлээ. Тиймээс бие биедээ хайртай байж, бие биенээ хүндэлж, хамгаалж, олуулаа болохын төлөө хичээх ёстой."*

Манай хуульд хэрэв хэн нэгэн иргэн золгүй байдлаар нас барсан тохиолдолд бусдын амь насыг аврахын төлөө өөрийн эрхтнийг донор болгох хүсэлтэй байгаагаа урьдчилан илэрхийлэх боломжийг тусгасан. Энэ заалт 2018 оны хуульд ч байсан.

Өнөөдрийн байдлаар eHealth, e-Mongolia платформоор дамжуулан 7000 гаруй иргэн энэ хүсэл зоригоо илэрхийлээд байна. Тэдний дийлэнх нь залуучууд. Манай шинэ залуу үе энэ асуудлыг зөвөөр ойлгож, хүлээн авч эхэлж байгаа нь сайшаалтай.

Тиймээс залуучууд маань нэгдүгээрт өөрийгөө хайрлаж, хоёрдугаарт бусдыг хайрлах, амьдралаа зөв авч явахын төлөө төлөвшиж, хүмүүжиж байна гэж би хардаг.

Бидний ирээдүй гэгээлэг, сайхан байна.

Монгол Улсын эрүүл мэндийн салбарт шинэ тогтолцоог бүрдүүлж ажиллахдаа үе, үеийн сайд нартай хамтран ажиллаж явсан үйл хэргийнхээ дурсамжаас хуваалцана уу?

Тэр дундаас надтай хамтран ажилласан С.Ламбаа, Д.Сарангэрэл, А.Цогцэцэг сайд нартаа, мөн оюутан цагийн анд Н.Хүрэлбаатартаа чин сэтгэлээсээ талархаж явдаг. Тэд энэ хуулийн төслийг анхнаас нь дэмжиж, өнөөдрийн түвшинд хүрэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Миний шавь нар дотроос С.Энхболд сайд, мөн Ж.Чинбүрэн гишүүнээрээ бахархдаг. Ж.Чинбүрэн бол элэг шилжүүлэн суулгах багийн анхны гишүүдийн нэг бөгөөд ХСҮТ-д өөрийн багаа байгуулж, өнөөдөр амжилттай ажиллуулж байна.

Мөн миний сайн ах С.Сонин эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг тууштай дэмжиж ирсэн хүн. Тэрээр 2000 онд “Цусны донорын тухай хууль”-ийг өргөн барихдаа эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой заалтыг анх оруулж өгсөн гавьяатай.

Өнөөгийн шинэ сайд Э.Батшугар ч энэ чиглэлийн талаар ойлгож, дэмжихийг хүсэж, надаас нэг цаг хагасын турш дэлгэрэнгүй мэдээлэл авч байсан. Залуу хүн энэ ажлыг ойлгож, дэмжих чин сэтгэл гаргасанд нь би үнэхээр их баярласан.

ЭМХТ-ийн түүхт 30 жилийн ой болж буй алтан босгон дээр үе үеийн захирлууд болон ажилтан, албан хаагчиадаа ойн баярын мэнд хүргэж эрүүл энх, сайн сайхныг хүсье! Ажил хөдөлмөрийн амжилтыг хүсье! Дахиад хэзээ нэгэн цагт та нартайгаа хамтраад ажиллах бол би хэзээд бэлхэн, хамтарч үйл хэргийг бүтээхэд бэлэн байна.

> *“Би эв эеийг эрхэмлэж, үнэнч шударга, үзэл бодолдоо тууштай байхыг амьдралынхаа зарчим болгож ирсэн. Энэ бол эцэг, эхээсээ өвлөсөн үнэт зүйлс минь. Тиймээс үе үеийн сайд нар болон хамтран ажиллаж байсан хүмүүстэйгээ үргэлж ойлголцож, сайхан хамтарч ажиллахыг хичээдэг.”*

ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ АНХ БАЙГУУЛАГДАЖ БАЙХ ҮЕИЙН ДУРСАМЖ

Тус багийн бүрэлдэхүүнд Н.Удвал (багийн ахлагч), эрдэм шинжилгээний ажилтан Ш.Оюунбилэг, Э.Эрдэнэчимэг, Ц.Лхайжав, эрдэм шинжилгээний туслах ажилтан О.Пагам нар байсан ба эрдэм шинжилгээний ажилтан М.Туяа Хоол судлалын төвөөс шилжин ирж багийн бүрэлдэхүүнд орж ажилласан.





ЭАМДИ нь өмнө нь анагаах ухааны дунд сургууль байсан одоогийн НИК компанийн байранд байрлаж байлаа. Төвийн даргаар ЭМЯ-ны НЭМГ-ын дарга, доктор Ц.Содномпил ажиллаж байлаа. Эрүүл мэндийн удирдлагын сургалт эрдэм шинжилгээний төвийн гол үүрэг нь эрүүл мэндийн удирдах ажилтануудын чадавхийг бэхжүүлж, системтэй сургалт явуулах, энэ чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх байлаа. Удирдлагын сургалтуудыг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийж эхэлсэн ба анхны сургалтуудыг 21 хоногоос нэг сарын хугацаатайгаар төлөвлөн явуулж байв.



Сургалтын нээлтүүд дээр Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа энэхүү төвийн үйл ажиллагааны зорилго, ач холбогдлыг “Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа шилжилтээс эрүүл мэндийн салбар хоцорч үлдэж болохгүй. Иймээс энэхүү сургалтууд нь эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудыг зах зээлийн үеийн эрүүл мэндийн удирдлагад сургаж, нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шинэ нөхцөлд хэрэгжүүлэн авч явахад чухал ач холбогдолтой юм” гэж онцлон тэмдэглэж байсныг дурсахад таатай байна. “Эрүүл мэндийн удирдлага” сургалтанд бүх аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, удирдах ажилтанууд, сумын эмнэлгийн ерөнхий эмч нарыг үе шаттайгаар хамруулан сургасан юм.

7.5. ДУРСАМЖ, ТҮҮХ БОЛОН ҮЛДЭЭСЭН МӨР

“Эмнэлгийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институт (ЭАМДИ)-ийн бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн удирдлагын сургалт, эрдэм шинжилгээний төвийг 1993 онд байгуулсан. Энэ төвийн анхны багийг одоогийн Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Эх нялхасын эрдэм шинжилгээний секторийг ЭАМДИ рүү шилжүүлэн бүрдүүлж байсан юм.”





Сургалтыг Эрүүл мэндийн яам, ДЭМБ бүх талаар дэмжиж байсан ба анхны 4 сургагч багшийг (Ц.Мухар, Н.Удвал, М.Туяа, Э.Эрдэнэчимэг) Тайланд улсын Махидолын их сургуульд 1993-1994 онд сарын хугацаатайгаар сургаж бэлтгэснээс гадна олон улсын багш зөвлөхүүд ирж сургалт явуулахад хамтран ажиллаж байсан юм. Сургалт нь эрүүл мэндийн удирдлагаас гадна нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үндсэн найман элэментүүд гэх мэт сэдвүүдийг хамарч сургагч багш нар сэдвээ хуваан авч хичээлээ Махидолын их сургуулиас сурсан “насанд хүрэгчдийн сургалтын арга”-аар явуулж байлаа. Мөн сургагч багш нар улаан пиджак, улаан хүрэн майк зэргээр ижилсэж байсан нь сургалтын шинэлэг соёлыг тухайн үедээ нэвтрүүлж байсан юм.

Баг маань өргөжиж Н.Удвал, М.Туяа, Э.Эрдэнэчимэг, Ш.Оюунбилэг, Чулуунбаатар, туслах ажилтан О.Пагам нар дээр программист Б.Нэрмөнх, Д.Алтанчимэг, сургалт зохион байгуулагч Ж.Алтанцэцэг нар нэгдэн хамтарч ажиллаж байлаа.

Төвийн бүтцэд эрдэм шинжилгээ, сургалтын багийг хэвээр үлдээсэн ба энэ баг удирдлагын сургалтыг үргэлжлүүлэн явуулахын зэрэгцээ эрдэм шинжилгээ судалгааны ажлууд хийж, судалгааны үр дүнг сургалтандаа хэрэглэж байлаа. Тус багт Б.Булганчимэг, Н. Оюунгэрэл, И.Бат-Эрдэнэ, Э.Анурад Т.Болормаа, Я.Гантөмөр, С. Энхтуяа зэрэг шинэ боловсон хүчин нэмэгдэн ирж үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байлаа.



1996-1997 оноос “Эрүүл мэндийн удирдлага сургалт” улам өргөжиж, агуулга нь баяжин ЭМХТ-ийн үндсэн үйл ажиллагааны нэг хэсэг болон мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтын түвшинд очсон бөгөөд тухайн үедээ нэг хэсэг манай

байгууллагын бараг “нэрийн хуудас” буюу “брэнд бүтээгдэхүүн” болсон байж билээ. Тус сургалтаар бэлтгэгдэж суралцсан хүмүүс ЭМЯ, аймаг орон нутгийн түвшинд удирдах ажлыг олон жил амжилттай хийж байлаа. Тэр үед бэлтгэгдсэн удирдах ажилтнуудаас орон нутагтаа Архангай аймгийн ЭМГ-ын дарга Р.Гандиймаа, Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Доржготов, Сүхбаатар аймагт Д.Мөнхзул, Баянхонгор аймагт Д.Бямбасүрэн нар одоо ч тогтвортой амжилттай сайн ажиллаж байна.

Сургалт судалгааны багийг ЭМЯ (сайд П. Нямдавааг онцлон дурдаж байна), ЭМХТ-ийн удирдлага (Ц. Содномпил, ЭМЯ-ны газрын даргаар ажиллаж байхдаа төвийг гардан байгуулж бүх талын дэмжлэг үзүүлж байсан) дэмжин хүний нөөцийг хөгжүүлж чадавхид нь анхаарч байсан юм. Мөн олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлуудад оролцуулж байсан нь төвийн болон сургалт судалгааны багийн чадавхи сайжрахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1995 оноос ДЭМБ-ын хүний нөөцийн хөгжил (М.Шагдарсүрэн, С.Дуламсүрэн, Ш.Оюунбилэг), НҮБ-ын Хүүхдийн сангийн “Бамакогийн санаачлага буюу Хамт олон-Эрүүл мэнд” (Э.Эрдэнэчимэг, Ш.Оюунбилэг), Германы GZT-ийн нөхөн үржихүйн эрүүл мэнд (М.Туяа, Д.Алтанчимэг), Дэлхийн зөн ОУ-ын байгууллагын Эрүүл мэндийн боловсрол (М.Туяа, Ш.Оюунбилэг), 1997 оноос ДЭМБ-ын Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоо, олон улсын өвчний ангилал нэвтрүүлэх (Ч.Нэрмөнх, П.Алтанхуяг, Д.Нямхорлоо, Ш.Оюунбилэг) зэрэг төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, нийгмийн эрүүл мэндийн олон салбарын судалгаа, сургалт, бодлогын баримт бичгүүд, шинэ арга аргачлалыг өөрийн улсдаа оруулж ирж хөгжүүлэхэд гар бие оролцон ажиллаж, манай байгууллага тэр хэмжээгээрээ хөгжлийн хүрээгээ улам тэлж байсан.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх, хамт олон эмийн эргэлтийн сангаа хэрхэн удирдах хянах, хамт олны эрүүл мэндийн асуудалд гүйцэтгэх

> *“1996 онд ЭАМДИ-ийг Анагаах ухааны хүрээлэнгийн байр (одоогийн ЭМХТ) руу нүүлгэсэн бөгөөд мөн П.Алтанхуяг даргатай Статистик мэдээллийн алба, АУХ-ийн ЭХЗБ-ын сектор тус тус ирж, эдгээр байгууллагуудыг нэгтгэн Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвийг ЭМЯ-ны шийдвэрээр байгуулсан.”*





> *Тухайлбал, Хамт олон-Эрүүл мэнд төслийн эхний жилүүдэд Эмийн эргэлтийн санг төслийн 6 аймгийн 12 суманд байгуулан туршиж улмаар бүх аймгийн 330 гаруй суманд байгуулсан нь зах зээлийн эдийн засагт шилжих үед хүндхэн нөхцөлд байсан эрүүл мэндийн салбарт түүхэн үүрэг гүйцэтгэж бүх сумын эмнэлгийг зайлшгүй шаардлагатай эмээр хангаж чадсан юм.*

үүргийн талаархи сургалтуудыг зохион байгуулахаар ЭМЯ дээр байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Э.Эрдэнэчимэг орж ажиллан, улмаар гардан зохион байгуулж явуулж байлаа.

Манай байгууллага эрүүл мэндийн удирдлага, нийгмийн эрүүл мэнд, эдийн засаг, санхүү, статистик мэдээлэл, тусламж үйлчилгээний чанар, магадлан итгэмжлэл, эмийн аюулгүй байдлын чиглэлээр бодлогын түвшинд ажиллах залуу боловсон хүчнийг бэлтгэсэн байгаа нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд (Н.Удвал), ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Алтантуяа, Г.Ганчимэг), сайдын зөвлөх (М.Туяа, Ц.Нацагдорж), газрын дарга (П.Алтанхуяг, Э.Эрдэнэчимэг, Д.Жаргалсайхан, Я.Буянжаргал, П.Оюунцэцэг, П.Эрхэмбаяр) болон хэлтсийн дарга (Б.Булганчимэг, Т.Болормаа, М.Уранчимэг, И.Бат-Ирдэнэ), мэргэжилтнээр (Н.Оюунгэрэл, Д.Чимэддолгор, М.Хишгээ, Б.Байгалмаа, Ө.Энхмаа, Ц.Хандармаа, Ч.Амаржаргал, Д.Оюунцэцэг, Д.Баясгалан, С.Ариунтуяа, Х.Өлзий-Орших г.м) олон хүмүүс ажиллаж байсанаас харагдана.

Тус төвийг байгуулахад залуу байсан мэргэжилтнүүд маань мэргэжлийн хувьд өсч хөгжиж, улмаар 1999 оноос Монгол дахь олон улсын хөгжлийн түнш байгууллагад эрүүл мэндийн салбарын удирдлага, төлөвлөлт, бодлогын чиглэлээр ажиллаж эхэлсэн. НҮБ-ын Хүүхдийн сан (М.Туяа, Д.Болорчимэг), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (Э.Эрдэнэчимэг), Азийн Хөгжлийн банк (Ж.Алтантуяа, Д.Жаргалсайхан, Б.Булганчимэг, Ш.Оюунбилэг), Дэлхийн банк (С.Уранчимэг, Ш.Намхайнямбуу), НҮБ-ын Хүн амын сан (Л.Оюун)-д олон хүмүүс ажилласан, зарим нь одоо ч ажилласаар байна.



Бид тус төвийг тогтвортой удирдаж байсан Ц.Содномпил (Со) С.Дуламсүрэн (Дууяа) дарга нартайгаа олон жил хамтдаа ажилласан бөгөөд ЭМХТ-д өсч хөгжин, өөр өөрийн ажилласан чиглэл, салбартаа туршлага мэдлэг хуримтлуулснаар гадаадын нэртэй их сургуулиудад 20 гаруй мэргэжилтнүүд магистр, докторын зэргийг хамгаалсан. (М.Туяа Thailand Mahidol University, Э.Эрдэнэчимэг Thailand Chulalongkorn University, Б.Булганчимэг Малайзын ХХХ, Ш.Оюунбилэг UK University of Leeds, National Taiwan University, И.Бат-Эрдэнэ National University of Malaysia, Australia University of Queensland, Т.Болормаа UK London School of Hygiene and Tropical Medicine, С.Энхтуяа UK London School of Hygiene and Tropical Medicine, Л.Оюун , Э.Анууурад Japan Shimane University, Ж.Алтантуяа Japan Nagoya University, С.Уранчимэг Australia University of Queensland, Ч.Оюун Australia Monash University).

Дурсамжаа тэрлэсэн: Ш.Оюунбилэг, Э.Эрдэнэчимэг, М.Туяа, Д.Лхайжав

ХАМТЫН ЗҮТГЭЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ОН ЖИЛҮҮД



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлаар 2012–2016 онд ажиллаж байсан он жилүүд миний ажил амьдралын хамгийн дурсамжтай, бүтээлч үеийн нэг байлаа. Тухайн үед эрүүл мэндийн салбарын хөгжлийн хэрэгцээ, тулгамдсан асуудлыг судалж, бодит мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, хүний нөөц, сургалт, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн олон ажлыг эхлүүлж, хөгжүүлэхийг зорьж ажилласан.

Эдгээр ажлын амжилт нь нэг хүний хөдөлмөр бус, мэдлэг, туршлага, сэтгэл зүтгэлээрээ нэгдсэн олон сайхан мэргэжилтэн, хамт олны маань хамтын бүтээл байсан юм. Тогтолцооны судалгааны албанаас Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны судалгаа, салбарын хүний нөөцийн судалгаа зэрэг чухал судалгааг боловсруулахад Л.Ширнэн, Ч.Батнасан зэрэг туршлагатай мэргэжилтнүүд идэвх санаачилгатай ажиллаж байсныг өнөөдөр дурсахад таатай байна.

ЭМСХХ-3, JICA, KOICA, KOFIH төслүүдийн хүрээнд төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, эмнэл зүйн удирдамж боловсруулах, сургагч багш бэлтгэх, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтыг хөгжүүлэх, эмийн зохицуулалтыг бие даалгах, эмнэлгийн засаглал, менежментийн өөрчлөлтийг эхлүүлэх зэрэг олон шинэ ажлын суурийг тавьж байлаа. Энэ бүхэнд С.Өлзийсайхан, Ц.Амарзаяа, У.Цэвэгмид, Д.Уранчимэг, П.Эрхэмбаяр, Ц.Даваахүү нар маань цаг наргүй хичээн ажилласныг талархан дурсдаг.

Гадаад сургалтыг цаг тухайд нь, үр дүнтэй зохион байгуулж, олон эмч, сувилагчийг хөгжлийн боломжид хамруулах ажлыг Х.Ганцэцэг, Г.Батцэцэг нар амжилттай хэрэгжүүлж, салбарын мэргэжилтнүүдийн талархлыг хүлээж байлаа. Харин эдгээр төсөл, ажлын бэлтгэл, санхүүжилтийг хууль, журмын дагуу төсөвт тусган хэрэгжүүлэхэд Ерөнхий нягтлан Б.Очир агсан, Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Г.Цэцэнсанаа, Л.Оюунчимэг нартай гар сэтгэл нийлэн ажилласан минь сайхан дурсамж болон үлджээ.

Тухайн үеийн хамт олныхоо дэмжлэг, идэвх санаачилгын үр дүнд “Сэрэлт-2” реалити нэвтрүүлгийг санаачлан эхлүүлж, ард иргэд болон эрүүл мэндийн салбарынхны анхаарал, талархлыг хүлээсэн нь мөн л хамтын хүчээр бүтсэн ажлын нэг байв.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эмч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Америкийн мэс заслын нийгэмлэгийн Advanced Trauma Life Support (ATLS) буюу гэмтэгсдэд үзүүлэх амилуулах лавшруулсан тусламжийн гарын авлагыг мэргэжлийн эмч нараар орчуулан Монгол Улсад анх удаа хэвлүүлж,

> *Цахим эрүүл мэнд, телемедицин, яаралтай тусламжийг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байсан Х.Нарантуяа, Л.Бор, Б.Гантөмөр, Ц.Мөнхбаяр, Ө.Баяр зэрэг нөхдөө ч дурсах ёстой. Мөн H-Info 3.0 системийг өргөтгөн сайжруулж, H-Info 4.0 системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байсан Статистик мэдээллийн албаны хамт олноороо бахархаж явдаг.*

анхан, дунд шатны болон клиникийн эмнэлгүүдэд түгээн сургалт зохион байгуулсан нь тухайн үеийн хамт олныхоо хүч хөдөлмөрөөр бүтээсэн ажлуудын нэг юм.

Эргээд харахад бидний хийсэн олон ажил тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагаас урган гарч, цаашдын хөгжлийн эхлэлийг тавьсан байжээ. Хамгийн үнэ цэнтэй нь хийсэн ажлаас илүүтэйгээр тэр бүхний ард хамтдаа зүтгэж, шинэ зүйл эхлүүлэхээс айлгүй, өөрчлөлтийг хийхийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажилласан олон сайхан мэргэжилтэн, хамт олон минь байсан явдал юм.

Эдгээр хүмүүсийнхээ хөдөлмөр, хичээл зүтгэлийг өнөөдөр дурсаж, талархаж явдгаа илэрхийлье. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн түүхэнд бидний ажилласан он жилүүдийн нэгээхэн хэсэг нь ийнхүү хамтын хөдөлмөр, нөхөрлөлийн сайхан дурсамж болон үлджээ.

Ч.Бат-Эрдэнэ, УИХ зөвлөх

Бид-Би, Би-Бид

“Аливаа бүхний цаана Бид-Би, Би-Бид ямагт оршдог. “Бид” нь хүн бүрийн доторх “Би”-г бүтээж, төлөвшүүлдэг шигээ байгууллагыг бүтээж, хөгжлийг урагшлуулдаг. Энэхүү бодол, сэтгэлд минь мөнхөд орших С.Дуламсүрэн даргын тухай гэгээн дурсамжийг хөврүүлж, түүнийгээ бичиглэн үлдээхээр зориглов.”



“Эрүүл мэндийн хөгжлийн төлөө -20 жил” түүхэн номоо дахин дахин эргүүлэв. Өнөөдөр миний байгууллагын 30 жилийн ой тохиож буй. Ном түүхийг хүүрнэж, гэрэл зураг дурсамж амилуулдаг аж. Түүхэн номын 66 дугаар хуудсанд миний зураг, миний дурсамж, 67 дугаар хуудсанд эрхэм хүн С.Дуламсүрэн даргын маань зураг, түүний дурсамж.

Миний амьдралын хувь зохиол энэ эрхэм хүнтэй хоёр жимээр холбогдож, насан өөд болтол нь хамтран ажиллах хувь тохиосон юм. 1984 онд Анагаах Ухааны дээд сургуулийг хүүхдийн эмч мэргэжлээр төгсөхөд, сургуулийн декан “Дорноговь аймгийн Анагаах ухаан”-ны коллежид багшаар ажиллах санал тавихад, би нутагтаа (Дундговь аймаг) очиж ажиллахыг илүүд үзсэн билээ.

Аймгийн ЭМГ-ын дарга нь анагаах ухааны доктор С.Дуламсүрэн. Тэр жил хүүхдийн эмчээр төгссөн ганц мэргэжилтэн нь би, аймгийн эмнэлэгт ажиллах нь тодорхой гэсэн бодолтой, “том эмч” дарга дээр орлоо. Тэгтэл дарга “Адаацаг сумын хүүхдийн эндэгдэл улс, аймгийн дунджаас өндөр, өвчлөл ихтэй, Чи тэнд ажиллана” гэв. Би “Гурван настай охинтой, бие давхар, нөхөр хамт очих боломжгүй, ээждээ ойрхон нэгдсэн эмнэлэгт л” ... гэлээ. Дарга зөвшөөрсөнгүй. Миний ажлын гараа ингэж эхэлсэн түүхтэй. Хожим бодоход ажлын шаардлага, бодит хэрэгцээг нэгдүгээрт тавьдаг нь түүний зарчим байсан. Нэг удаа “Залуу хүн гэхэд чи шаргуу, сайн ажиллаж байна

шүү" гэж хэлсэн нь хөдөөгийн эмнэлэгт 13 жил тууштай ажиллаж, сумынхаа хүүхдийн эндэгдлийг бууруулж чадсан зүтгэлийн минь урам зориг, дэмжлэг болсон байх.

1997 онд ЭМХТ-ийг үүсгэн байгуулагч Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, академич, АУ-ны доктор, профессор Ц.Содномпил даргын удирдлага дор, сумын эмчээс эрдэм шинжилгээний ажилтан болж, нийслэлд дараагийн ажлын гараагаа эхлүүлэв. Тун удалгүй С.Дуламсүрэн дарга маань орлогч даргаар ажиллах болсноор бид хоёрын хоёрдох зам нэгдсэн түүхтэй.

Мэдээж, бид хоёр нэг нутаг, би тэр хүнийг, тэр хүн намайг мэднэ, бид дахин 28 жил гар нийлэн ажиллаж, их ажлын ард хамтдаа гарсандаа. Дарга маань хэл бичиг, уг найруулгын өндөр мэдрэмжтэй, судалгаа, бүтээлийн ажилд өндөр шаардлага тавьдаг удирдагч байв. Эрүүл Мэндийн хөгжлийн төвд ажилласан он жилүүдэд 40 гаран томоохон судалгааны ажлын аргачлал, үр дүнгийн тайлан боловсруулж, эрүүл мэндийн удирдлага, байгууллагын хөгжлийн чиглэлээр 19 ном, гарын авлагад бүтээл хэвлүүлэн, дотоод, гадаадын олон улсын эрдэм шинжилгээний 13 хуралд илтгэл хэлэлцүүлсэн, их хөдөлмөрийн ард редактор, зөвлөх, хамтран бүтээгчийн нэг нь С.Дуламсүрэн дарга минь байв.

Тиймээс л "Бид-Би", "Би-Бид"-ийн учир энэ. Хувь хүний бүтээл, амжилтын ард хамт олон, хамтын хөдөлмөр, харилцан дэмжлэг байдаг. С.Дуламсүрэн даргын мэдлэг, туршлага, ажилдаа хандах зарчим нь зөвхөн надад бус, ЭМХТ-ийн хамт олонд үнэт өв болон үлджээ.

Өнөөдөр бидний, түүний бүтээн байгуулсан байгууллага маань 30 жилийн түүхт ойгоо тэмдэглэж байна. Байгууллагынхаа үе үеийн хамт олонд ойн баярын мэнд хүргэж, эрүүл мэндийн салбарын хөгжлийг түүчээлсэн үйл хэрэг нь улам өргөжин тэлэхийг хүсэн ерөөе.

Лхамсүрэнгийн Ширнэн, XVII жарны "Сүрээр дарагч" хэмээх Гал морин жил, Зуны тэргүүн сарын цагаагчин гахай өдөр Улаанбаатар хот. 2026 оны 06 сарын 06-ны өдөр болой.





ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ АЖИЛЛАСАН ДУРСАМЖААС...

“1997 оноос Ц.Содномпил даргатай Эрүүл мэндийн удирдлага мэдээлэл боловсролын төвтэй нэгтгэн ЭМЯ ны харьяанд одоогийн эмч нарын байранд нүүж С.Өлзийсайхан даргатай Төгсөлтийн дараах албанд эрүүл мэндийн арга зүйч багшаар ажилласан. Олон сайхан өндөр мэргэжилтэй хүмүүстэй танилцаж эрүүл мэндийн боловсрол олгох хүрээ маань улам тэлж өргөн хүрээнд ажиллах мэдээлэл боломж нээгдсэн явдалд хамт олондоо баярлаж талархаж явдгаа илэрхийлье.”



1989 онд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөд орж БТСУХорооны нийтийн биеийн тамирын хэлтэс ЭМЯ-д шилжиж, анх эрүүл мэндийн салбарын IY их хуралд оролцож байж билээ. 1990 оны 8-р сард н. Галсандорж даргатай Улсын Ариун Цэвэр Гэгээрлийн ордонд биеийн тамирын арга зүйч багшаар шилжүүлж, тэр үед охид эмэгтэйчүүдийн дунд хөгжиж эхэлсэн чийрэгжүүлэх аэробик гимнастикаар анх төлбөртэй үйлчилгээ эхлүүлж ЭМЯ-ы хурлын зааланд хийдэг байлаа.

ЭМЯ-ны мэргэжилтэн уламжлалтын эмч Батчулуун өвөр монголын хийн дасгалын багш Эрдэмтэй хамтран аймаг дүүргийн эрүүл мэндийн арга зүйч нарыг бэлдэх үндсийг эхлүүлж байсан юм. 1994 оноос ”Эрүүл мэндийн сургалт арга зүйн төв” болж тэр үед Ч.Уртнасан даргалж байлаа. Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа 1992 онд тушаал гаргаж “Бие бялдрыг чийрэгжүүлэх хөтөлбөр”, “Бие бялдрын түвшин тогтоох сорил”, “Бие бялдыг чийрэгжүүлэх дасгал хөдөлгөөн боловсруулж орон нутгийн чийрэгжүүлэх арга зүйч багш нарыг бэлдэх сургалтыг зохион байгуулж эхэлсэн билээ.

Бие бялдрыг хөгжүүлэх дасгал хөдөлгөөний жор боловсруулж өвчнөөс урдчилан сэргийлэх насанд нь тохирсон дасгал хөдөлгөөн болон өвчинд тохирсон дасгал хөдөлгөөнүүдийг боловсруулж өөрөөр хэлбэл эрүүл байх үндэс хөдөлгөөнөөр өөрийгөө эүүлжүүлэн чийрэгжүүлэх дасгал хөдөлгөөнүүдийг Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүд, ЕБС сурагчид, 6- 12 ангийн хүүхдүүд, насанд хүрсэн 15-аас 60 хүртэлх насны хүмүүст тохирсон өдөр бүр өөрийнхөө эрүүл мэндэд тустай дасгал хөдөлгөөн болон сорил оо өгөөд хангалтгүй байгаа биеийн чанаруудаа хөгжүүлэх гэх мэт дасгалуудыг өөрчлөлөгдөн хөгжиж байгаа цаг үетэй нь дүйцүүлэн 600 гаруй дасгал боловсруулжээ .

”Хөдөлгөөн-Эрүүл Мэнд“ сургалт маань зөвхөн дасгал хөдөлгөөнөөр хязгаарлаад зогсохгүй Эрүүл мэндийн Удирдлага, Эрүүл мэндийг дэмжих гээд л маш өргөн хүрээнд багш нар оролцсоноор арга зүйч нар маань сүүлдээ төлбөртэй ч болсон сургалт нэмж явуулаач гэж хүсдэг болж билээ.



Бие бялдрыг чийрэгжүүлэх танхим, саун душтэй болсноор өдөрт хөдөө орон нутгаас сургалтад ирсэн суралцагч нар ажлын дараа ЭМЯ-ны ажилтан болон манай байгууллагын хамт олон чийрэгжүүлэх аэробикээр хичээллэх боломжоор хангагдсан нь байгууллага хоорондын асуудал хурдан хугацаанд асуудал шийдэгддэг болсон.

Ер нь эрүүл мэндийн салбарт олон сайхан төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсанаас хамгийн анхны мартагдахгүй сургалт бол Монголын нээлттэй нийгмийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Эрүүл Мэндийн Боловсрол - Багш нарыг бэлдэх” сургалт Нүхтэт болж 60 гаруй эрүүл мэндийн салбарынхан оролцож билээ. Халдварт бус өвчний шатгаант эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын 2006, 2009, 2013, 2019 онуудад хийгдсэн нийт 4 удаагийн судалгаанд судлаачаар ажиллажээ.

2006 онд Эрүүл мэндийг дэмжих албанд шилжиж хөдөлгөөн чийрэгжилтээр эрүүл мэндээ дэмжих асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж сайхан шижигнэсэн залуучууд хамт олонтой ажиллаж эхэлсэн. Маш хүчтэй эелдэг сайхан хамт олон Д.Жаргалсайхан даргатай дараа нь Л.Оюун гээд л чадвартай зохион байгуулагч хамт олноо нэгтгэж нэг гэр бүл шиг сайхан байж билээ. Дэмжих албанаас намайг дэмжиж байгууллага хамт олонтойгоо хамт Хайнан явах шагналаар урамшуулж амьдралдаа мартагдахааргүй сайхан аялж билээ. Идэвхтэй Хөдөлгөөнөөр Эрүүл мэндээ дэмжих нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 22 гаруй жил тасралтгүй ажиллажээ.

Цэрэндоржийн Марта, Улаанбаатар хот,
2026 оны 06 сарын 22-ны өдөр



“Хүний гавьяат эмч, Анагаах ухааны доктор, Эрүүл мэндийн бодлого удирдлагын магистр, Эмнэлгийн менежер, Дэд профессор, ЭМЯ-ны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал У.Цэвэгмид”

ДУРСАМЖ

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн 30 жилийн түүхийг бүтээлцсэн Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн дэд захирлаар ажилласан цаг үе бол миний амьдралд томоохон сорилт болж, салбарынхаа хөгжил, дэвшилд гар бие оролцох боломж олгож, олон үйл явдлын гэрч, дурсамж, туршлага болон үлдсэн юм.

ЭМХТ-ийн дэд захирлаар 2013-2015 онд ажиллахдаа баримт бичгийн стандартыг мөрдүүлэх гэж мэргэжилтнүүдийнхээ боловсруулсан бичгийг ихэд хичээнгүйлэн засаж, зарчимч ханддаг байжээ. Энэ хугацаанд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, нотолгоот мэдээллээр хангах, яаралтай тусламж, мэдээллийн технологи, телемедициныг хөгжүүлэх чиглэлээр захирал Ч.Бат-Эрдэнэ, Захиргааны хэлтсийн дарга Г.Цэцэнсанаа, Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтсийн дарга Н.Нарангэрэл, Төгсөлтийн дараах сургалтын зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Амарзаяа, Яаралтай тусламжийн зохицуулалтын хэлтсийн дарга Ж.Энхзул, Мэдээлэл технологи, телемедициний хэлтсийн дарга Ө.Баяр нартай хамтран ажиллаж байлаа.

“Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээг зохион байгуулсан.

Монгол улсын иргэн бүрт чиглэсэн эрүүл мэндийн зөв дадал, хэвшил төлөвшүүлэх, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, иргэдэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх, эрүүл, урт наслах боломжийг нэмэгдүүлэх, 2014 онд батлагдсан “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2014 оны 127 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах үүргийг ЭМХТ гүйцэтгэж, миний бие ажлын хэсгийн ахлагчаар ажилласан. Аймаг, дүүрэг бүр “Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээг орон нутагтаа үр дүнтэй хэрэгжүүлэх, иргэд, засаг захиргаа, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан ажиллах үүднээс аймаг, дүүргийн Засаг даргын захирамж гаргуулан, удирдамж, төлөвлөгөөтэйгээр үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан.

Эрүүл мэндийн довтолгоо арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийг шийдвэрлэхийн тулд Эрүүл мэндийг дэмжих сангийн зарцуулалтын эрхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд шилжүүлэн санхүүжилтийг СЭМТ, ӨЭМТ-ийн хүрээнд шийдвэрлэж өгсөнөөр “Нэг иргэнд” ногдох санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, орон нутагт хяналт хийх зардлыг тооцож шийдвэрлэсэнээр Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Арга хэмжээг зохион байгуулахаас өмнө болон хойно “Эрүүл мэндийн боловсролын түвшин тодорхойлох” судалгааг 4000 хүнээс авч, үр дүнг тооцоход судалгааны үр дүнд иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, боловсрол 25.04%-иар өссөн. Арга хэмжээний явцын хэрэгжилтийг

үнэлэх зорилгоор 1300 иргэнээс асуумж судалгааг авч, үр дүнг тооцоход судалгаанд оролцсон иргэдийн 30% нь “Заавал хэвшүүлэх 21 дадал”-ыг хэвшүүлж эхэлсэн, 14% нь хэвшүүлэх талаар бодож байгаа, 8% нь ямар нэгэн оролдлого хийсэн ч хэвшүүлж чадаагүй, 37% нь хэвшүүлээгүй байсан. “Заавал хэвшүүлэх 21 дадал” гарын авлагыг өрх бүрт хүргэсэн нь иргэн бүр мэдээллийг хурдан шуурхай авах нөхцөл бүрдэж, сурталчилгааг шинэлэг аргаар хийсэн. Эрүүл мэндийн довтолгоо арга хэмжээг зохион байгуулах аймгуудын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг 88.2% ханган ажиллаж байлаа.

Эрүүл мэндийн салбарын бүх шатанд тогтолцооны судалгааг хийж, бодлогын түвшинд нотолгоот мэдээллийг бий болгосон.

Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн зургаадугаар хурлаар “Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд хийж буй ажлын явц, нийслэлийн эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудлууд, хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын чиглэлийн талаар авч хэлэлцсэн юм. Энэхүү хурлын шийдвэрээр хүүхдийн өвчлөл, эндэгдлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, оношилгоо тавилт, оношийн зөрөөний байдалд чанарын судалгаа хийж, шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах зорилгоор “Нялхсын эндэгдлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх чанарын судалгаа”-г зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, нялхсын эндэгдэл гарах болсон нөхцөл/шалтгааныг нарийвчлан тогтоож, цаашид хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр гаргах шийдвэр гаргалт, бодлого томъёолох, тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ хийхэд суурь мэдээлэл болсон юм.



Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг шинэчилж, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн төрийн сангийн санхүүжилтээр суралцах нөхцлийг бүрдүүлсэн.

Улсын хэмжээнд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, эмнэлгийн мэргэжилтний эмчлэх, сувилах эрхийн зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн сорилын цахим санг мэргэжлийн чиглэл тус бүрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн мэргэжилтнийг төрийн сангийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад суралцах боломжийг бүрдүүлсэн.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 168 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн загвар, зураглал”-д эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3

> *“Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах журам”-ыг боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 119 дугаар тушаалаар батлуулан төрийн сангийн санхүүжилтээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй гадаад оронд төрийн сангийн болон эрүүл мэндийг дэмжих сангийн зардлаар мэргэжлийн сургалтанд хамруулж эхэлсэн.*

чиглэлээр хөгжих боломжтой гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор эмнэлгийн удирдах ажилтнуудыг (захирал/дарга, дэд захирал/орлогч дарга, төвийн дарга, төв ба хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хэлтэс, албаны дарга, тасгийн эрхлэгч) урт, богино хугацааны удирдлагын сургалтад хамруулснаар төрийн албан хаагчийн хувьд ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг ханган мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэлийг гол хэмжүүр болгосон “мерит зарчим”-ын дагуу эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд ажиллах, шатлан ажиллах боломжийг бүрдүүлсэн. Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн ангилал батлах тухай” 2013 оны 441 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбарын удирдах ажилтанд хамаарах албан тушаалтныг тодорхойлсны дагуу эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн мэдээний маягтад холбогдох өөрчлөлийг оруулж, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 тоот тушаалаар баталсан тушаалын хүрээнд эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны талаарх мэдээллийн санг бүрдүүлсэн.

Бага эмч бэлтгэхгүй болсонтой холбоотой ЭМХТ-ийн захирлын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 216 дугаар тушаалаар багийн бага эмчийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр баримжаа олгох сургалтад 1100 мэргэжилтэнг ажлын байранд төрийн сангийн санхүүжилтээр АШУҮИС-ийн нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нартай хамтран нийт 17 аймагт зохион байгууллав.

Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн ажилтнуудад 2011 оноос хойш хүний нөөцийн менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулагдаагүй, нөгөөтэйгүүр ЭМЯ-ны харьяа байгууллагууд, аймаг/нийслэлийн ЭМГ болон БОЭТ, аймаг/нийслэлийн нэгдсэн эмнэлгүүдийн хүний нөөцийн ажилтнуудын 70 гаруй хувь шинэчлэгдсэн учир хүний нөөцийн ажилтнуудад Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Хүний нөөцийн боловсрол олгох төвтэй хамтран сургалтыг зохион байгуулж байв.

ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн хэлтэс ЭМЯ-ны харъяа эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, нийслэлийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, орон нутгийн ЭМГ-ын ерөнхий нягтлан бодогч, эдийн засагчдын дунд “ЭМС-ын төсвийн төлөвлөлт зарцуулалт, тайлагналын шинэчлэлт, НББ-ийн бодлогын баримт бичиг” сэдэвт сургалт ЭМХТ-ын тогтолцоо судалгааны алба зохион байгуулсан.

Япон улсын Засгийн газрын хөгжлийн агентлаг ЖАЙКА-тай хамтран төгсөлтийн дараах сургалтын төслүүдийг эхлүүлж байлаа. АШУҮИС-ийн харъяа Монгол-Япон сургалтын эмнэлгийн бүтцийг бий болгох, сургалт эрхлэх чиглэлд Ялоны сайн дурын сувилагч, эх баригч, хөдөлгөөн засалч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хоол тэжээл судлаачид Өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны хүрээнд Монголд ажиллаж байв. Монгол улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл (2015-2020)-ийн хүрээнд төгсөлтийн дараах

сургалтын хөтөлбөрийг шинэчилэн боловсруулсан. Япон улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулдаг сургагч багшийн сургалтыг Монгол улсад нэвтрүүлэх зорилгоор эмнэлзүйн сургагч багшийг бэлтгэх (ТОТ) сургалтыг зохион байгуулахаар гэрээ байгуулж байлаа..

Одоогийн Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын шийдвэрийн дагуу 50 хүүхдийн эмчийг 1 жилийн хугацааны эрчимжүүлсэн сургалтаар бэлтгэхээр ЭХЭМҮТ-тэй хамтран сургалтын хөтөлбөрийг боловсруулж байв.

Яаралтай тусламжийн тасгуудыг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулж, алсын түргэн тусламжийн тогтолцоог бий болгосон.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 сарын 30-ны өдрийн 496 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл" стратеги (2014-2019)-т Эрүүл мэндийн салбарын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд өвчтөн, үйлчлүүлэгчдийг эмнэлэг хооронд явуулж чирэгдүүлж байдаг хүнд суртлын тогтолцоог халахын тулд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, бүсийн оношлогоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн дэргэд яаралтай тусламжийн тасаг, нэгжийг шинэчлэн зохион байгуулж, тэдгээрийн ажиллах үлгэрчилсэн журмыг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375 дугаар тушаалаар батлуулан ажиллаж, эмнэлгийн яаралтай тусламжийн ор, монитор, зохиомол амьсгалын аппарат, хүчилтөрөгчийн аппарат, түрдэг дамнуурга, зөөврийн эхо аппарат, зөөврийн рентген аппарат, хэрэглэгдэж байгаа аппарат, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байв.

Телемедициний үндэсний сүлжээг бий болгосон.

Цахим эрүүл мэндийн стратегийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2013 оны 09 сарын 11-ний өдрийн 330 дугаар тушаалаар "Телемедициний үндэсний сүлжээний ажиллах журам"-ыг баталсан. Телемедициний үндэсний сүлжээнд холбогдсон эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн тусламжтайгаар төрөлжсөн мэргэжлийн зөвлөгөө өгөх, оношлох, үйлчилгээ үзүүлэх, төгсөлтийн дараах сургалтыг зайнаас зохион байгуулах, цахим мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн.

Байгууллагынхаа хөгжил дэвшил, үнэт зүйл бүрийн ард зогсож байдаг эрхэм хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье.

> *"Эрүүл мэндийн сайдын 2014 оны 08 сарын 11-ний өдрийн "Алсын дуудлага, явуулын эмнэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 263 дугаар тушаалаар алсын түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээ үзүүлэх журам, алсын дуудлагын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын хуваарь, явуулын эмнэлгийн үйлчилгээний хуваарийг баталж, 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс алсын түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв хариуцан ажиллаж эхэлсэн юм."*



ДУРСАМЖ

Гүрбазарын Алтанцэцэг би эмч болох мөрөөдлөө биелүүлж 1972-1976 онд АУДуС-ийг Эх барих-бага эмч, 1977-1983 онд АУДС-ийг Эрүүл ахуйч их эмч мэргэжлээр төгсөж эрүүл мэндийн салбарт тасралтгүй 40 шахам жил ажилласан. 1991 оноос тус төвийн 2-р байр буюу Эмч нарын байрны зохион байгуулагч, Үйлчилгээний албаны даргын ажлыг хийж байгаад 2011 онд өндөр насны тэтгэвэртээ гарсан. Ажиллах хугацаандаа оюутны байрыг хөдөө орон нутгаас эмнэлгийн мэргэжил олгох, дээшлүүлэхээр ирсэн эмч нарыг байраар хангах зорилгоор байрны дотоод зохион байгуулалтыг өөрчилж, өрөө тус бүрийг халуун хүйтэн ус, душ, ариун цэврийн өрөөтэй болгож, нэг өрөөнд 2-4 эмч байрлах 45 өрөө, 110 эмч байрлуулах хүчин чадалтай, сургалтын 4 танхим, номын сан, цайны газар, интернэттэй иж бүрэн тохилог орчныг бүрдүүлж, сурах бүрэн нөхцөл бололцоогоор хангаж 1992 оноос анх эмч нарыг байрлуулах ажлыг зохион байгуулж, томоохон бүтээн байгуулалтын ажлыг анх удаа хийж дуусгаснаараа үргэлж бахархаж явдаг юм.

> *Баг хамт олныхоо хайр энэрэл, хүнлэг сайхан зан чанар, хүндлэл дунд олон жилийг хамтдаа өнгөрүүлсэн он жилүүд сайхан дурсамж болон үлдэнэ.*



Эрүүл мэндийн салбарын бүхий л сургалт семинарыг энэхүү байранд хүлээн авч, зохион байгуулан эмнэлгийн олон арван удирдах ажилтныг энэ л байрнаас бэлтгэн гаргаж, эмч нарынхаа талархалын олон үгсийг сонсож байсан нь мартагдашгүй дурсамж болон үлдэнэ.

Байгууллагынхаа цэвэрлэгээ үйлчилгээ, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, ажиллах тав тухтай орчныг бүрдүүлж, ажилчдынхаа эрүүл мэндийг дэмжих зэрэг олон арван ажлыг хийхэд байгууллагын удирдлага, хамт олны ажилч хичээнгүй, чин сэтгэл, ажлыг тулталхийдэг, хүнлэг сайхан, соёлч боловсон харьцаа, хүндлэл зэргийг эргэн дурсахад таатай байна.

Та бүхэндээ маш их баярлаж, талархаж явдгаа дахин илэрхийлье.

Гүрбазар овогтой Алтанцэцэг, 2026 оны 06 сарын 12-ны өдөр

"БАРИМТ БИЧИГ БОЛ БАЙГУУЛЛАГЫН ОЙ САНАМЖ, АРХИВ БОЛ ТҮҮНИЙ ТҮҮХ ЮМ"



Ажилд орсон эхний жилүүдэд албан бичиг, тушаал шийдвэр, тайлан мэдээг гараар болон бичгийн машинаар боловсруулдаг байлаа. Архивын баримтыг ангилан төрөлжүүлж, хадгалалт хамгаалалтыг хариуцах ажил нь өндөр хариуцлага, нягт нямбай байдлыг шаарддаг байсан. Учир нь баримт бичиг бүхэн байгууллагын түүх, үнэт өв, үйл ажиллагааны үнэ цэнтэй баримт байдаг.

Даргын туслахаар ажиллах хугацаандаа өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, албан уулзалт, хурлын бэлтгэлийг хангах, иргэд болон хамтран ажиллагч байгууллагуудтай харилцах зэрэг олон талын ажлыг хийж байлаа. Энэ ажлын явцад байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагаанд арын албаны ажилтан ямар чухал үүрэгтэйг илүү гүн ойлгож, мэдэрсэн.

Он жил өнгөрөхийн хэрээр эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн хөгжил эрчимжиж, уламжлалт цаасан архив цахим хэлбэрт шилжих томоохон өөрчлөлт өрнөсөн. Энэ шинэчлэлийн хүрээнд 2009 оноос байгууллагын албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах ажлыг эхлүүлж, программ хөгжүүлэгчидтэй хамтран ажиллаж, системийг байгууллагынхаа онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулсан нь миний ажлын замналын нэгэн сайхан дурсамж болон үлджээ.

Архивын талаарх мэдлэг маань байгууллагынхаа түүхийн номыг бүтээх санаа төрүүлж, энэ тухайгаа тухайн үеийн төвийн захирал Ц.Содномпил, дэд захирал С.Дуламсүрэн нарт танилцуулж, мөн төвийн боловсон хүчнээр ажиллаж байсан, Сувилахуйн нийгэмлэгийн дарга асан М.Шагдарсүрэн гуайтай санал солилцсоноор байгууллагын түүхийг ном болгон бүтээх ажлын эхлэл тавигдсан юм. Төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хөгжлийн замналыг баримтжуулсан тэрхүү анхны бүтээлийн эхийг хамтран боловсруулж байсан үеэ эргэн дурсахад өнөө ч бахархал төрдөг.

Миний хувьд ном бүтээхэд шаардлагатай архивын болон бусад эх сурвалжийн мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, гэрэл зургаар баяжуулах, эх бэлтгэл хийх, хувилан олшруулж албан хэрэгцээнд ашиглах ажлыг хариуцан ажилласан. Ингэснээр байгууллагын анхны түүхэн эмхэтгэлийг бүтээхэд өөрийн хувь нэмрээ оруулах завшаан тохиосон билээ. Мөн төвийн захирал Ц.Содномпил, С.Дуламсүрэн, Б.Бат-Эрдэнэ, албаны дарга Л.Оюунчимэг, Н.Нарангэрэл, мэргэжилтэн Л.Ширнэн, Г.Дариймаа болон хамт олонтойгоо хамтран байгууллагын 10, 20 жилийн ойд зориулсан түүхэн ном, эмхэтгэлүүдийг бүтээх ажилд гар бие оролцсон.

> *Би 1984 онд эрүүл мэндийн салбарт ажил хөдөлмөрийн гараагаа эхэлж, техникч, эх бэлтгэгч, даргын туслах, архив, бичиг хэргийн эрхлэгчээр 2022 он хүртэл тасралтгүй 38 жил ажилласан билээ. Энэ хугацаанд салбарынхаа хөгжил, шинэчлэлийн олон үеийг хамтдаа туулж, байгууллагынхаа түүхэн үйл явдлын гэрч болж явснаараа бахархдаг.*

> *Ялангуяа 1996–2006, 2006–2016 оны хөгжлийн замнал, ололт амжилт, онцлох үйл явдлыг архивын баримт, гэрэл зураг, дуу дүрсний эх сурвалжид тулгуурлан эмхэтгэж, баримтжуулсан нь зөвхөн өнгөрсөн түүхийг хадгалаад зогсохгүй байгууллагын үнэт өв, туршлага, уламжлалыг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх эрхэм үйлс болсон гэж боддог. Ийм ажилд хамт олонтойгоо мөр зэрэгцэн ажиллаж, байгууллагынхаа түүхийг бүтээл болгон үлдээхэд өөрийн хувь нэмрээ оруулсандаа би үргэлж бахархаж явдаг.*

Олон жилийн турш хуримтлагдсан архивын баримт, мэдээлэлд тулгуурлан 1996–2022 он хүртэлх “Байгууллагын архивын түүхчилсэн лавлах”-ыг эмхэтгэн бичсэн нь миний нэгэн томоохон ажил болсон. Уг лавлахад байгууллагын үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, үе үеийн удирдлагууд, үндсэн чиг үүрэг, хэрэгжүүлсэн томоохон судалгаа, төсөл, хөтөлбөрүүд болон төрийн архивт хадгалагдаж буй баримтын талаарх мэдээллийг архивын эх сурвалжид тулгуурлан нэгтгэн оруулсан юм.

Байгууллагынхаа түүхэн өвийг ажилтан, албан хаагчид болон үйлчлүүлэгчдэд таниулах зорилгоор тухайн үеийн төвийн захирал Б.Бат-Эрдэнийн санал, дэмжлэгээр, IT инженер Мөнхбаяртай хамтран байгууллага үүсэн бий болсон үеэс эхлээд салбартаа анхдагчаар хэрэгжүүлсэн ажлуудыг өгүүлсэн тайлбар бүхий гэрэл зургийн үзүүлэнг төвийн 2 давхарт байгуулсан.

Энэ нь өнгөрсөн ба өнөөгийн хөгжлийг холбож, хамт олныхоо хөдөлмөр бүтээлийг алдаршуулахын зэрэгцээ залуу үед байгууллагынхаа түүх, уламжлалыг танин мэдэхэд хувь нэмэр оруулсан ажил болсон гэж боддог. Мөн байгууллагын 1996-2016 оны хөгжлийн замналыг харуулсан түүхэн тайлбар бүхий гэрэл зургийн гурван цомог альбомыг эмхэтгэн баримтжуулсан нь архивын үнэт санг улам баяжуулж, ирээдүй хойч үедээ өв болгон үлдээсэн бас нэг зурагт түүх юм.

ЭМС-ын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, баримт бичгийн хадгалах хугацааг зөв тогтоон мөрдүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт” боловсруулах ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд нэгдсэн жагсаалтыг ББНШК-ын хурлаар хэлэлцүүлж, ЭМЯ болон Архивын ерөнхий газарт хүргүүлэн дэмжлэг авч ажилласан. Үүний үр дүнд салбарын онцлогт нийцсэн “Баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт” ном 2014 онд анхлан хэвлэгдэн гарч, мөрдөгдөж эхэлсэн юм.

Энэхүү жагсаалтыг боловсруулахад ЭМХТ-ийн бүх алба нэгжүүдийн оролцоо, дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал, салбарын анхан шатны маягтын хадгалах хугацааг тодорхойлох, холбогдох мэдээллийг нэгтгэх, санал боловсруулах ажилд СМА-ны мэргэжилтэн С.Даваажаргал, Х.Нарантуяа нар идэвхтэй оролцож, харьяа байгууллагуудаас санал авч хэлэлцүүлэн тусалсан нь салбарын хэмжээнд ижил түвшинд мөрдөх гарын авлагатай болоход чухал түлхэц болсон билээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн чиг үүргээс гадна байгууллагын мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг дэмжих хүрээнд олон төрлийн бүтээл, хэвлэлийн эх бэлтгэлийн ажилд идэвхтэй оролцож ирсэн. Энэ хугацаанд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг үнэлэх шалгалтын сорилын номуудын эхийг бэлтгэх, сургалтын гарын авлага, материалуудыг

олшруулан хэвлэх ажлыг ТДСА-ны дарга С.Өлзийсайхан, мэргэжилтэн Д.Дондогмаа, Г.Алимаа, Ц.Уранчимэг нартай хамтран гүйцэтгэж байлаа.

Мөн НҮБ-ын ХАС-ийн төсөл, ЭМДА-ны хамт олон, төвийн захирал С.Дуламсүрэн нартай хамтран Нийгмийн эрүүл мэнд, мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр 20 гаруй ном, гарын авлага, товхимол, танилцуулгын эхийг бэлтгэж, хэвлэн олшруулах ажилд оролцсон нь тухайн үеийн салбарын мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсан гэж боддог. Эдгээр бүтээлүүд нь зөвхөн тухайн үеийн хэрэгцээг хангаад зогсохгүй байгууллагын мэдлэг, туршлага, мэдээллийн санг баяжуулж, ирээдүйд ашиглагдах үнэт өв болон үлдсэн билээ.



Олон арван жилийн хөдөлмөрийн замналдаа би байгууллагынхаа үе үеийн удирдлагууд, хамт олны дэмжлэг, туслалцааг үргэлж мэдэрч ирсэн. Ялангуяа архивын ажлын ач холбогдлыг үнэлж, архивын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад онцгой анхаарч ирсэнд гүн талархал илэрхийлье. Тухайлбал, Эрүүл мэндийн яам болон төвийн удирдлагын дэмжлэгээр архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр ажиллаж байсан 3 ажилтан орон байртай болж, амьдралын нөхцөлөө сайжруулах боломж бүрдсэн нь бидний хөдөлмөрийг бодитоор үнэлсэн чухал дэмжлэг байсан юм. Мөн архивын ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь тогтвор суурьшилтай ажиллах, мэргэжилдээ үнэнч байх урам зориг өгч ирсэн юм.

Иймд миний хөдөлмөрийн замналд үнэтэй хувь нэмэр оруулж, үргэлж дэмжин ажилласан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үе үеийн удирдлагууд, хамт олон, санхүү, захиргаа болон мэргэжлийн нэгжүүдийн нийт ажилтан, албан хаагчдад чин сэтгэлийн талархал илэрхийлж, төв байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Сундуйжавын Нарантуяа,
XVII жарны “Сүрээр дарагч” хэмээх Гал морин жил,
Улаанбаатар хот, 2026 оны 06 сарын 10-ны өдөр

Хамт олны алиа хошин дурсамжийг ЭРГЭН ДУРСАХУЙ...

Аливаа байгууллагын түүхийг зөвхөн тайлан, тоо баримт, амжилт бүтээлээр нь хэмжих боломжгүй. Тэр байгууллагыг амьд, өнгөлөг, дурсамжтай болгож байдаг зүйл нь хамт олны нөхөрлөл, инээд хөөр, өдөр тутмын ажлын амьдралд тохиолдсон хөгжилтэй мөчүүд байдаг.

Олон арван жил нэг хамт олонтойгоо мөр зэрэгцэн ажиллах хугацаанд бид зөвхөн ажил төрлийн асуудал ярилцаад өнгөрөөгүй.

Заримдаа ажилдаа яарч сандран хөгжилтэй алдаа гаргана, заримдаа бие биеэ ойлголгүй инээдтэй будлиан үүсгэнэ, бас хааяа нөхөрсөг тоглоом шоглоом хийж хамт олноо хөгжөөдөг байлаа. Тэр бүх үйл явдал тухайн үедээ энгийн мэт санагдсан ч өнөөдөр эргэн дурсахад хамгийн дулаахан, хамгийн үнэ цэнтэй дурсамж болон үлджээ.

Манай хамт олны дунд ажилдаа үнэнч, хариуцлагатай хүмүүс олон байсан ч аливааг хөгжилтэйгээр хүлээн авч чаддаг, инээж баясах сэтгэлтэй хүмүүс бүр ч олон байв. Тийм ч учраас ажлын ачаалал ихтэй өдрүүдэд ч бид инээд хөөрөө алдалгүй, бие биедээ урам өгч, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж чаддаг байсан юм.

Энэ бүлэгт өгүүлэх дурсамжууд нь хэн нэгнийг шоолох, шүүмжлэх зорилготой бус, харин хамт олны маань энгийн бөгөөд хөгжилтэй зан чанар, хүний мөс, нөхөрлөлийн үнэ цэнийг харуулах зорилготой билээ. Эдгээр дурсамжид гарч буй хүмүүсийн нийтлэг нэг чанар нь бүгд ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, байгууллагынхаа төлөө зүтгэдэг, сайхан сэтгэлтэй хүмүүс байсан явдал юм. Өнөөдөр бидний зарим нь гавьяныхаа амралтад гарч, зарим нь өөр салбарт ажиллаж, зарим нь хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн ч хамтдаа инээж, баярлаж, хөдөлмөрлөж өнгөрүүлсэн он жилүүд хэзээ ч мартагдахгүй.

Харин эдгээр хөгжилтэй дурсамжууд тэр үеийн хамт олны уур амьсгал, нөхөрлөлийн халуун дулааныг хойч үед үлдээх жижигхэн боловч үнэ цэнтэй гэрч болох биз ээ. Инээд бол хамт олныг нэгтгэдэг хамгийн сайхан хүч байдаг.

Тиймээс эдгээр дурсамжийг унших бүртээ тухайн үеийн инээд хөөр, нөхөрсөг уур амьсгал, сайхан хүмүүсээ эргэн санаж, хамтдаа өнгөрүүлсэн он жилүүдээрээ бахархах болно гэдэгт итгэлтэй байна.

Хуушуур, цув хоёрын хөгжилтэй явдал

Даргын туслахаар ажиллаж байх үед шинэхэн төгссөн Саран хэмээх залуу эмч манай байгууллагад ажиллахаар ирж байлаа. Албаараа цайны цагаар хуушуур захиалж идэхээр шинэ ажилтан Саран эмчид хуушуур авах газрыг зааж өгөөд явуулсан юм.

Тэр өдөр дарга Японулсын зочидтой уулзалттай байсан бөгөөд зочдын нэг нь үүдний өрөөний хувцасны шүүгээнд цагаан өнгийн богино цуваа өлгөчихсөн байлаа. Саран эмч хуушуур авахаар яаравчлан гарахдаа өөрийн цувтай андуурч, тэрхүү зочны цагаан цувыг өмсөөд гарчихжээ.

Хуушуурын газар хүн ихтэй, урт дараалалтай байсан тул захиалгаа өгөөд хүлээж байхдаа цувныхаа халаасыг ухаж үзтэл танихгүй машины түлхүүр гарч ирсэн байна. Дээрээс нь ханцуй нь өөрт нь арай урт санагдаад нэг л биш байгааг анзаарчээ. Тэгээд л өөрийн цуваа биш болохыг мэдээд ихэд сандарсан гэдэг.

Удалгүй нүүр нь цонхийсон, ихэд түгшсэн байдалтай буцаж орж ирээд:

- Би зочны хувцсыг өмсөөд гарчихсан байна. Яана аа? гэж хэлэхэд бид ч мөн адил сандарч,
- Чи яаж мэдсэн юм бэ? гэж асуухад,
- Халаасанд нь машины түлхүүр байсан, бас ханцуй нь урт байсан гэж хариулж билээ. Бид бүгд яаран хувцасны шүүгээг шалгахад үнэхээр түүний цувтай өнгө загвар нь маш төстэй байсан юм. Саран эмч тэр дор нь цуваа тайлж өлгөөд:
- Яана аа, хуушуурын үнэр шингэчихсэн болов уу даа гэж санаа зовнин ярьж байтал яг тэр үед Япон зочин уулзалтаасаа гарч ирсэн юм.
- Аз болоход бүх зүйл эвтэйхэн өнгөрч, хэн ч анзаараагүй мэт болсон ч энэ явдал

манай хамт олны дунд олон жил яригдсан хөгжилтэй дурсамж болон үлдсэн билээ.

- Одоо ч тэр үеэ дурсан ярих бүртээ бид инээлдэж, хамт олныхоо нөхөрсөг уур амьсгал, залуу насны сайхан мөчүүдийг эргэн санадаг юм.

Нэр нэгтэйгээс болсон хөгжилтэй явдал

Манай байгууллагад ажиллаж байх хугацаанд хамт олны дунд инээд хөөр бэлэглэсэн хөгжилтэй явдлууд цөөнгүй тохиолддог байлаа. Тэдгээрийн нэг нь Дуламсүрэнтэй холбоотой дурсамж юм.

Тухайн үед Дуламсүрэн маань Дууяа даргын туслахаар ажиллаж байв. Нэг өдөр гаднаас нэг эмэгтэй ирээд жижүүрт:

- Дуламсүрэнтэй уулзана гэж хэлжээ.
- Жижүүр ч энэ мэдээллийг дамжуулсан байна. Харин Дуламсүрэн маань тухайн үед ирсэн хүн өөрийг нь биш, даргатай уулзахаар ирсэн гэж бодоод шууд Дууяа даргын өрөөнд орж:
- Доор тантай нэг хүн уулзахаар ирсэн байна гэж хэлжээ.
- Дарга гайхан:
- Надаас цаг аваагүй л юм байна. Ямар учиртай хүн юм бол, ямар ажлаар ирснийг нь асуугаарай гэжээ. Дуламсүрэн ч гарч ирээд жижүүрээс дэлгэрэнгүй асуутал өнөөх эмэгтэй нь Дууяа даргатай биш, харин өөртэй нь буюу туслах Дуламсүрэнтэй уулзахаар ирсэн хүн байж таарчээ. Тэгээд удалгүй эргээд даргын өрөөнд орж:
- Өө, уучлаарай даргаа. Надтай уулзахаар ирсэн хүн байж гэж хэлэхэд дарга ч, өрөөнд байсан хүмүүс ч бөөн инээд болсон гэдэг.

  Энэ явдал тухайн үедээ багахан төөрөгдөл үүсгэсэн ч хамт олны дунд удаан хугацаанд яригдсан хөгжилтэй дурсамж болж үлдсэн юм.

Дөрөвдүгээр сарын 1-ний "дуудлага"

Би Дууяа даргын туслахаар ажиллаж байх үед болсон нэгэн хөгжилтэй явдал санаанаас ер гардаггүй юм.

Нэг өдөр ЭМДА-ны мэргэжилтэн Байгалаа над дээр ирээд:

- Нараа эгч ээ, хоёулаа Алтангэрэлийг жаахан хууръя. Цаадах чинь намайг чадчихлаа шүү дээ. Та захирал дуудаж байна гээд оруулаарай гэж билээ.
- Тэр өдөр нь дөрөвдүгээр сарын 1, инээдмийн өдөр байсныг бид ч мартсангүй.
- Удалгүй би Алтангэрэл дээр очоод:
- Алтангэрэл ээ, захирал дуудаж байна гэж хэлэхэд ямар асуудлаар юм бол та мэдсэн үү гэлээ. Би ямар нэгэн юм хэлээгүй дуудчих гэсэн дээ гэж хэлээд даргын өрөөнд орууллаа.

Бид ч гадна нь юу болох бол гэж чих тавин хүлээж байв. Өрөөн дотор эхэндээ нам гүм. Хэсэг хугацааны дараа Дууяа даргын хоолой сонсогдов.

- За Алтангэрэл, ажил сайн уу? Сонин юу байна?
- Ажлаа хийж байна даргаа. Тайван даа гэж Алтангэрэл хариуллаа. Дахиад л хэсэг чимээгүй болов.

Дарга ч гайхаж байгаа бололтой.

Удалгүй:

- За Алтангэрэл ээ, ямар асуудлаар орж ирэв дээ? гэж асуухад,

  Алтангэрэл ч үнэнээ хэлж:
- Үгүй даргаа, Нараа эгч таныг дуудсан гэж хэлсэн юм аа гэв. Тэр агшинд бүх учир тайлагдаж, дарга чангаар инээгээд:
- За тэгвэл чамайг дөрөвдүгээр сарын 1-нд чадчихаж дээ! гэж хэлсэн гэдэг.
- Ингээд өрөөн дотор ч, гадна хүлээж байсан бид ч бөөн инээд болж билээ.
- Алтангэрэл ч инээгээд өнгөрөөсөн бөгөөд энэ явдал манай хамт олны дунд олон жил яригдсан хөгжилтэй дурсамжуудын нэг болсон юм. Ажлын ачаалал ихтэй өдрүүдэд иймэрхүү хөгжилтэй мөчүүд хамт олны уур амьсгалыг сэргээж, биднийг улам ойр дотно болгодог байжээ.

Монитагийн бэлгийг хүлээсэн нь

Шинэ жилийн баяр дөхөхөөр манай байгууллагад "монита" тоглож, нууцаар бэлэг

солилцдог сайхан уламжлалтай байлаа. Ихэвчлэн хэд хэдэн удаагийн бэлэг өгч, эцэст нь хэн хэнийгээ сугалсан нь ил болдог байв.

Нэг жил эхний ээлжийн бэлгүүд тараад эхэлсэн ч Захиргааны албаны Саранд бэлэг ирсэнгүй. Тэгтэл манай өрөөнд орж ирээд:

- Нараа эгч ээ, намайг шал мэдрэмжгүй хүн сугалсан юм уу, эсвэл бүр хүн сугалаагүй юм болов уу? гэж их л гомдолтой хэлэв.

Би:

- Зүгээр ээ, ирнэ биз дээ гэж тайвшруулахыг оролдлоо. Нэг өдөр өнгөрлөө, бас л бэлэг байдаггүй.

Сарангийн бухимдал улам нэмэгдэж:

- Би ёстой гомдож байна. Гуравдугаар давхарт гараад хүмүүсээс асууя байз гэж хүртэл хэлээд гарч байлаа.

Удалгүй дахин орж ирээд:

- Би бүр дургүй хүрчихлээ. Хоёулаа надад тал вино байна уух уу? гэж хагас тоглоом, хагас үнэн хэлж билээ.

Би ч:

- Чамд том бэлэг бэлдэж байгаа юм байлгүй дээ гэж аргадаж суулаа.
- Удалгүй нэг жижигхэн ном бэлгэнд ирэв. Саран номоо аваад өрөөндөө орчихлоо.

Тэгээд удалгүй чангахан дуугаар:

- Манай монита ямар мэдрэмжгүй юм бэ! Ийм ном өгөөд! Ёстой тэнэг хүн байна! Гэж хэлээд толгой руугаа заан "тэнэг" гэж дохио зангаа хүртэл хийж байсан гэдэг. Харин хамгийн хөгжилтэй нь түүний ингэж ярьж байхад монита нь болсон хүн буюу хамт өрөөнд нь суудаг О гэдэг мэргэжилтэн яг хажууд нь байсан явдал юм.
- Дараагийн бэлэг нь бас л жаахан оройтож ирж, Саран дахин хэд хэдэн удаа орж ирэн гомдоллож, таамаг дэвшүүлж, бухимдаж байлаа. Харин эцэст нь торт, вино зэрэг илүү том бэлэг ирж, шинэ жилийн уур амьсгал сайхан болсон юм.
- Монитагийн эзэн нь хэн болохыг мэдсэний дараа Саран өмнө нь хэлсэн үгсээ санаж багагүй ичингүйрч, эвгүй байдалд орсон ч бид бүгд инээлдэж өнгөрүүлсэн.
- Харин түүний бэлэг ирэхийг хүлээсэн тэр хэд хоногийн сэтгэл хөдлөл, байн байн орж ирж гомдоллон ярьдаг байсан нь өнөөдөр ч бидний дунд хамгийн хөгжилтэй дурсамжуудын нэг болон үлджээ.

"Сайн байна уу, Со гуай"

Эрүүл мэндийг дэмжих албаны дарга О манай байгууллагад ажилд ороод удаагүй байх үеийн хөгжилтэй дурсамж бий.

Нэг өдөр над дээр их л баяртай орж ирээд:

- Нараа, би өнөөдөр яамны их том хүнтэй танилцсан шүү гэж байна.

Би ч сонирхоод:

Хэнтэй юм бэ? гэж асуув.

Тэгтэл:

- Манай яамны "Со" гэдэг хүнтэй гэж их л итгэлтэй хариуллаа.

Би тухайн үед нэг их анзааралгүй:

- Өө тийм үү, тийм байна шүү дээ гэж өнгөрөөсөн юм. Хожим нэг өдөр ажил тараад бид хоёр хамт явж байтал Нөхөн үржихүйн асуудал хариуцсан мэргэжилтэн "Да" өөдөөс алхаж ирэв.

Гэнэт "О" их л баяртайгаар, танил хүнээ олж харсан мэт:

- Сайн байна уу, Со гуай! гэж чангахан мэндчиллээ.

Нөгөө хүн нь ч гайхсан шинжгүй:

- Сайн, сайн байна уу гэж хариулаад өнгөрөв. Харин би тэр үед л учрыг нь ойлголоо. "О" маань хүний нэрийг андуурч, өөр хүнийг "Со" гэж бодоод явсан байжээ.

Би инээдээ арай гэж барин:

- Чи сая мэндэлсэн хүн чинь "Со" гуай биш шүү дээ гэж тайлбарлахад сая л үнэн учрыг ойлгосон юм. Гэхдээ энэ явдлын хамгийн хөгжилтэй нь хүний нэрийг андуурсандаа биш, харин:
- Сайн байна уу, Со гуай! гэж ямар ч эргэлзээгүй, маш итгэлтэйгээр мэндэлсэн явдал байлаа. Тэр өдрөөс хойш "Со гуай" гэдэг үг манай хамт олны дунд хөгжилтэй дурсамж болон үлдэж, "О"-г харахаараа заримдаа тэр явдлыг санан инээлддэг

байсан юм. Иймэрхүү энгийн мөртлөө хөгжилтэй явдлууд ажлын өдрүүдийг илүү өнгөлөг болгож, хамт олны уур амьсгалыг улам дотно болгодог байжээ.

Орчуулагчийн "Азарганы" асуулт

Манай хамт олны дунд хөгжилтэй дурсамжууд олон бий.

Тэдгээрийн нэг нь Эрүүл мэндийг дэмжих албаны дарга "О"-тай холбоотой явдал юм. Нэгэн удаа "О" манайд ажилд орохоос өмнө хөдөө аж ахуйн төслийн шугамаар ирсэн гадаадын төлөөлөгчдөд орчуулагчаар дагалдаж хөдөө орон нутагт ажиллахаар явжээ.

Малчидтай уулзаж, нутаг ус, мал сүргийнх нь талаар ярилцан, хөөрөг зөрүүлэн хуучилж суух үеэр малчид хоорондоо:

- Хуц ухнаа тэдийд тавьсан,
- Малынхаа хээлтүүлгийг ингэж зохион байгуулсан гэх мэтээр ярилцаж байсан байна. "О" ч мал аж ахуйн талаар багагүй зүйл ойлгож авсан мэт санагдаж, өөрийгөө нэлээд туршлагатай хүн болсон гэж бодсон бололтой.

Тэгээд нэгэн малчин ахаас их л итгэлтэйгээр:

- Ахаа, танайх азаргаа хэдийд тавьдаг вэ? гэж асуужээ.

Гэтэл өнөөх малчин ах гайхан харснаа инээмсэглэн:

- Үгүй хүү минь, манай азарга чинь жилийн дөрвөн улирал адуутайгаа цуг байдаг шүү дээ гэж хэлсэн гэдэг. Тэр үед "О" өөрийнхөө асуултыг ямар хөгжилтэй болсныг ойлгож, хамт явсан хүмүүс ч инээсэн гэдэг.
- Энэ явдал хожим нь хамт олны дунд олонтаа яригдаж, уулзалт, баяр ёслолын үеэр дурсагдах хөгжилтэй түүхүүдийн нэг болж үлдсэн юм. Заримдаа мэддэг зүйлээ бусад салбарт шууд хэрэглэх гэж оролдохоор ийм хөгжилтэй алдаа гарах нь ч бий гэдгийг энэ явдал харуулсан билээ.

"Дэмчигийн Оюун"-ыг хайсан нь

Манай хамтран ажиллагч Дууяа ажилд анх орсон үеийн нэг хөгжилтэй явдал бий.

Нэг өдөр Дууяа дарга Дуламсүрэнг дуудаад:

Дэмжихийн Оюуныг дуудаад ир гэжээ.

Шинэхэн ажилтан байсан Дууяа ч даргын хэлснийг яг сонссоноороо ойлгож аваад байгууллагын албадуудаар явж:

Дэмчиг овогтой Оюуныг дуудаж байна гэж хэлж эхэлжээ.

Хүмүүс ч гайхан:

Манайд Дэмчигийн Оюун гэж хүн байдаггүй шүү дээ. Л.Оюун, Ч.Оюун бол бий, гэхдээ Дэмчигийн гэдэг хүн байхгүй гэж хариулж байв.

Дууяа хэд хэдэн өрөөгөөр орж асуусан ч өнөөх "Дэмчигийн Оюун" нь олдсонгүй. Тэгээд бүр доошоо бууж 1 давхрын үүдний хэсэгт байрлах нэг өрөө рүү орж дахин асууж:

Дэмчиг овогтой Оюуныг дуудаж байна аа гэжээ. Тэгтэл хүмүүс учрыг нь олох гэж нэлээд ярилцсаны эцэст:

Байз, дарга чинь "Дэмжих албаны Оюун"-ыг хэлсэн юм биш үү? гэж асуусан байна. Тэр үед л Дууяа сая ойлгож, "Дэмжихийн Оюун" гэдгийг "Дэмчигийн Оюун" гэж сонссоноо мэдсэн гэдэг.

Ингээд байгууллага даяар эрэл болсон "Дэмчигийн Оюун" олдохгүй байж байгаад эцэст нь "Дэмжих албаны Оюун" болж хувирсан нь хамт олны дунд удаан хугацаанд яригдсан хөгжилтэй дурсамж болсон юм. Ажилд шинээр орсон хүн байгууллагын бүтэц, албадын нэрийг бүрэн мэдэхгүйгээс ийм хөгжилтэй будлиан гарах нь бий. Харин энэ явдал Дууяагийн тухай яригдах бүрт инээд хөөр дагуулдаг сайхан дурсамж болон үлдсэн билээ

"Цус алдах гээд явчихсан"

Манай даргын нөхөр эмэгтэйчүүдийн эмч мэргэжилтэй хүн байлаа. Түүний нутагтаа ажиллаж байсан үеийн нэг хөгжилтэй явдлыг хүмүүс одоо ч дурсан ярьдаг юм.

Нэгэн өдөр нутгийн нэг айлын бэр төрөхөөр өвдөж эхэлжээ. Ар гэрийнхэн нь сандарч, эмчийг дуудахаар яаран гүйж явтал эмчийн бага хүү Батаа гэрийнхээ гадаа элсэн дээр тоглож байсан байна. Тэр хүн Батааг хараад:

Батаа, аав нь гэртээ байна уу? гэж асуужээ.

арин Батаа огтхон ч эргэлзэлгүйгээр:

Аав байхгүй ээ, цус алдах гээд явчихсан! гэж хариулсан гэдэг.

Үнэндээ аав нь төрөх гэж буй эхэд эмнэлгийн тусламж үзүүлэхээр явсан хэрэг байж.

Харин бага насны хүүхэд томчуудын ярианаас сонссон үгээ өөрийнхөөрөө ойлгон хэлсэн нь тэр аж. Тухайн хүн ч эхэндээ ихэд гайхаж, дараа нь учрыг ойлгоод бөөн инээд болсон гэдэг.

Харин энэ явдал нутгийнхны дунд удаан хугацаанд хөгжилтэй дурсамж болон яригддаг талаар дарга маань бид бүгдэд сонин болгон ярьдаг байсныг сийрүүлэн бичлээ.

Батаагийн гэнэн цайлган хариултыг хүмүүс олон жил дурсан инээлддэг байжээ. Хүүхдийн гэнэн томоогүй атлаа үнэн сэтгэлээсээ хэлсэн үг заримдаа насанд хүрэгчдийн бодож оломгүй хөгжилтэй дурсамжийг бүтээдэг юм байна гэдгийг энэ явдал харуулсан билээ.

Даргаа өрөөнд нь түгжчихсэн нь

Би Ариун цэвэр, гэгээрлийн ордны даргын туслахаар ажиллаж байх үедээ нэг хөгжилтэй мөртлөө тухайн үедээ нэлээд сандаргасан явдалтай учирч байлаа.

Тэр үед манай байгууллага Эрүүл мэндийн яамтай нэг байранд байрладаг, дотуур коридорооров орж гардаг байсан үе юм. Гар утас гэж байгаагүй, бүх харилцаа суурин утас, хүнээр хэл дамжуулах байдлаар явагддаг байлаа.

Нэг өдөр яамны сайд "Га" даргыг маань яаралтай дуудаж байна гэж сайдын туслах над руу утасдаж хэлэв. Би ч даргаа дуудах гээд өрөөнд нь ортол байхгүй байлаа. Дарга маань ойрхон өрөөнүүдээр орж гараад явсан байх гэж бодоод өрөөг нь түгжчихээд эрэлд гарсан юм. Эмч нарын өрөө, бусад өрөөнүүдээр орж асууж, жижүүрээс хүртэл лавлав.

Жижүүр:

Дарга гараагүй байна гэж хэлэв.

Би бүр гайхаж:

Яамнаас дуудсаныг мэдээд шууд орчихсон юм болов уу гэж бодоод буцаад өрөөндөө орж суув.

Удалгүй сайдын туслах дахин утасдаж:

Нараа эгч ээ, дарга чинь яасан бэ? Сайд дуудаад байна шүү дээ гэв. Би ч арга барагдаж, даргын өмнөөс ямар нэг ажилтай байгаа байх гэж тайлбарлан түр аргалаад өнгөрөөв. Уг нь дарга ямар нэгэн арга хэмжээтэй бол явахдаа надад заавал хэлдэг хүн байсан болохоор улам их гайхаж байлаа.

Хэсэг хугацааны дараа гэнэт даргын өрөөний хаалга дотроосоо онгойж, дарга гараад ирдэг байгаа!

Би бүр алмайрч:

- Таныг сайд дуудаад байсан. Би таныг хайгаад байгууллагаараа явлаа. Жижүүрээс хүртэл асуусан гэж болсон бүх явдлыг ярьж өглөө.
- Дарга ч гайхсан байдалтай:
- Үгүй тэгээд чи намайг яагаад гаднаас түгжээд явчихдаг байна аа? гэв. Тэгэхэд л би учрыг ойлгож, өрөөнүүдээр орж гарах хоорондарга өрөөндөө орж ирснийг анзааараагүй байж, гаднаас нь түгжээд явчихсанаа мэдсэн юм. Аз болоход дарга маань энэ явдлыг нэг их асуудал болгосонгүй. Харин би тухайн үед сайдын дуудлагад даргаа олж чадахгүй сандарч, яахаа мэдэхгүй байсан айдас түгшүүрээсээ салж, ёстой нэг санаа амарч билээ.
- Одоо эргэн дурсахад инээд хүрмээр ч тухайн үедээ миний ажил амьдралын хамгийн сандарсан өдрүүдийн нэг байсан юм. Хамгийн хөгжилтэй нь би байгууллага даяар даргаа хайж явахад дарга маань өрөөндөө тайван сууж байсан явдал байлаа.

"Бүжин хүүхэн уулзъя гэнээ..."

Манай найз Дуламсүрэн нэгэн дээд сургуульд суралцаж төгсөөд Эрүүл мэндийн яаманд Төрийн нарийн бичгийн даргын туслахаар ажилд орсон юм.

Ажлынх нь анхны өдрүүдийн нэгэнд болсон хөгжилтэй явдлыг бид одоо ч дурсан инээлддэг. Тэр өдөр гаднаас нэгэн эмэгтэй орж ирээд

өөрийгөө:

- Би Мастер төлөвлөгөө төслөөс явж байна. Бүжин гэдэг. Даргатай төслийн асуудлаар уулзах гэсэн юм гэж танилцуулан, байгууллага, төсөл, уулзалтын зорилгоо нэлээд дэлгэрэнгүй тайлбарлажээ.
- Дуламсүрэн ч бүх яриаг нь анхааралтай сонсоод даргадаа уламжлахаар өрөөнд нь орсон байна. Гэтэл Төрийн нарийн бичгийн дарга нь их л сүрлэг, төв байдлаар ширээнийхээ ард сууж байж. Даргын өрөөнд ороод л нөгөө сонссон бүх мэдээллээ хэлэх гэтэл сандарснаас болж хамаг зүйл нь толгойноос нь арчигдчихжээ.
- Байгууллагын нэр, төслийн нэр, уулзалтын зорилго гээд юу ч санаанд үлдсэнгүй.
- Харин ганцхан "Бүжин" гэдэг нэр л санаанд нь үлдсэн байв.
- Хэсэг дуугүй зогсож мэдээллээ санах гэж оролдож байтал дарга:
- За Дуламсүрэн, ямар ажил байна? гэж асуужээ.
- Сандарсан Дуламсүрэн ч бодож амжилгүй:
- Бүжин хүүхэн уулзъя гэнээ... гэж хэлээд тавьчихаж ядаж байхад хүүхэн гэдэг үг орж ирээд л.... Дарга эхлээд гайхсанаа:
- Үгүй ээ, Дуламсүрэн минь. Наад хүн чинь гудамжны хүн биш байлгүй дээ. Ямар байгууллагаас, ямар асуудлаар, ямар ажлаар ирснийг нь хэлэх хэрэгтэй шүү дээ гэж тайвнаар хэлжээ.
- Аз болж дарга тухайн хүнийг нэрээр нь мэддэг байсан тул уулзалтыг ойлгосон байна.

Харин Дуламсүрэнд хандан:

Би бол ойлголоо. Гэхдээ наад хүн чинь өөрөө сонсвол юу гэж бодох вэ. Гудамжинд явж байсан хүн уулзах гэж байгаа юм шиг л хэлчихлээ шүү дээ гэж сургамжилсан гэдэг.

Дуламсүрэн ч ихэд ичингүйрч, сандарсан хэвээрээ гарч очоод Бүжинг уулзалтад урьж оруулсан байна.

Хожим нь энэ явдлаа ярих болгондоо:

- Ажлын анхны өдрүүдэд ямар их сандардаг байсан юм бэ дээ. Бүх мэдээлэл мартагдаад ганцхан "Бүжин хүүхэн" л үлдсэн байдаг гэж өөрөө инээн ярьдаг байлаа.
- Шинэ ажил, шинэ орчин, өндөр албан тушаалтны өмнө орж тайлагнана гэдэг хэн бүхэнд амаргүй. Харин тэр үеийн энэ жижигхэн будлиан хожим нь бидний хамгийн хөгжилтэй дурсамжуудын нэг болж үлдсэн юм.

Даргад зориулсан "сонгины дайллага"

Манай байгууллагад удирдлага, хамт олон өвдөж эмнэлэгт хэвтсэн тохиолдолд хамт олноороо эргэж очдог сайхан уламжлалтай байлаа.

Нэг удаа төвийн захирал Оргил сувилалд хэвтэж байхад алба нэгжүүдийн төлөөлөл болсон хэд хэдэн хүн дэд захирал Дууяа даргын хамт эргэхээр очсон юм.

Бид гэрээсээ чанасан мах, цай, жимс зэрэг идээ, ундаа бэлтгээд очлоо.

Дарга маань нэлээд том өрөөнд хэвтэж байсан тул бүгдээрээ тухтай сууж, авчирсан зүйлсээ дэлгэж тавиад ажил төрлийн тухай ярилцаж эхэлсэн юм.

Яриа өрнөсөөр ажлын сэдвээс хальж, сонин хачин дурсамж, хөгжилтэй явдлууд яригдаж, өрөө дүүрэн инээд хөөр болж байлаа. Яриа хөөрөө болсоор байтал авч очсон чанасан махыг бүгд хуваааж идээд дуусгав. Цаг ч оройтож, буцах тухай яриа гарч эхлэв. Цайгаа ч хуваааж уугаад бараг юм бүх юмаа хураачихсан байлаа. Харин мах байсан том тавган дээр хэдэн хэрчсэн сонгино л үлдсэн байв. Бид аяга таваг хурааж, өрөө тасалгааг цэвэрлэж эхлэхэд найз Дууяа маань өнөөх үлдсэн сонгиныг нэг дор бөөгнүүлж овоолоод захирлын өмнө тавьчихлаа.

Дарга сонирхолтой яриагаа үргэлжлүүлэн ярьж байсан тул сонгинотой тавгийг нэг их анзааралгүй өөрөөсөө холдуулан түлхчихэв.

Төдөлгүй сонгины овоолго нурж, тавган дээр тарчихлаа.

Дууяа маань дахиад л бөөгнүүлэн овоолж байгаад захирлын өмнө дахин тавив.

Дарга яриагаа таслалгүй нүдээрээ ширвэн энэ яагаад миний өмнө тавиад байгаа юм гэсэн байдалтай дахин түлхлээ.

Ингээд энэ үйл явдал хоёр, гурван удаа давтагдсан юм.

Эцэст нь Оргил дарга гайхан:

Дууяа чи яагаад над руу энэ сонгиныг овоолоод тавиад байгаа юм бэ? гэж асуув. Тэгтэл Дууяа тун энгийнээр:

Даргаа, би тавгаа угаах гэсэн юм. Та сонгиноо идчих гэж байгаа юм аа гэж хэллээ. Тэр агшинд өрөөнд байсан бүх хүн зэрэг шахуу тас тас инээлдлээ.

Дарга ч инээгээд:

Заавал би тэр сонгиныг идэж байж та нарын таваг угаагдах ёстой юм уу? гэж хариулсан нь бүр ч хөгжилтэй болсон юм.

Үнэндээ тэнд байсан хүмүүс бүгд Дууяагийн юу хийх гээд байгааг харж ойлгож байсан.

Гэхдээ даргын ярьж байсан сонирхолтой ярианданхаарал хандуулчихсан болохоор хэн нь ч дуугарч тайлбарлаагүй юм. Тиймээс л өнөөх сонгины таваг захирал руу дахин дахин "аялал" хийсээр байсан хэрэг.

Одоо найзынхаа энэ хөгжилтэй явдлыг эргэн дурсахад бидний авч очсон хамгийн үнэтэй зүйл нь мах, цай биш, харин хамт олны инээд хөөр, нөхөрлөлийн халуун дулаан уур амьсгал байсан юм шиг санагддаг.

Энэ явдал өнөөдөр ч бидний уулзах бүрт дурсан ярьдаг хөгжилтэй дурсамжуудын нэг хэвээр үлджээ.

"Элгэнд дуртай зүйл" ба хан боргоцойн "Амттай шийтгэл"

Байгууллагынхаа бичиг хэрэг, архив, даргын нарийн бичгийн ажлыг хариуцан ажилласан он жилүүдэд би олон сайхан хүмүүстэй мөр зэрэгцэн хөдөлмөрлөжээ. Цаг хугацаа өнгөрөх тусам ажил, амьдралын эгэл атлаа дулаахан дурсамжууд л сэтгэлд хамгийн тод үлддэг юм байна. Тэр олон сайхан хүмүүсийн дундаас нэгэн эрхэм найзтай минь холбоотой хоёр хөгжилтэй явдал өнөө хэр нь сэтгэлд тодхон хадгалагдан үлджээ.

1990-ээд оны үед манай байгууллагад англи, орос хэлтэй, европ хүмүүжил, соёлтой нэгэн залуу мэргэжилтэн ажилд орсон юм. Олон жил Орос улсад сурч, ажиллаж амьдарсан болохоор гадаад хэлний мэдлэг сайтай ч монгол хэлний мэргэжлийн нэр томьёо, өвөрмөц хэллэгийг тэр бүр сайн эзэмшээгүй байлаа.

Ажилд орсон эхний өдрөө хамт олонтойгоо танилцахдаа:

- Би монголоор ярьж чадна. Гэхдээ мэргэжлийн нэр томьёо, хэллэг дээр алдаа гаргаж магадгүй. Та бүхэн алдааг минь хэлж, зөвлөж, ажилд минь тусалж байгаарай гэж ихэд элдэгээр хэлж байсан нь одоо ч тодхон санаанд үлджээ.

Удалгүй бид нэг хороололд амьдардгаа мэдэж, ажил тарахаар хамт харьдаг болов. Тэр зуур ажил хэргийн болон амьдралын олон сэдвээр хуучилна. Тухайн үед манай байгууллага олон улсын төсөл, хөтөлбөрүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж, англи хэл дээрх эрүүл мэндийн сурталчилгааны материал, гарын авлагыг орчуулах ажил цөөнгүй гардаг байлаа.

Нэг удаа тэр орчуулсан материалаа надад үзүүлэхэд **"Элгэнд дуртай зүйл", "Элгэнд дургүй зүйл"** гэж бичсэн байв. Уншаад инээд хүрсэн ч

- Энэ нь элэгний дуртай, дургүй зүйл гэсэн үг биш ээ. "Элэгт үзүүлэх ашигтай болон гаж нөлөө" гэсэн санааг илэрхийлж байгаа юм байна гэж тайлбарлаж өгсөн юм.

Тэр ч өөрөө инээгээд:

- Би яг үгчлээд орчуулчихаж гэж билээ.

Түүнээс хойш бид орчуулсан материалыг нь хамтдаа ярилцаж, заримдаа орой болтол нэр томьёо, үг хэллэгээ нягталдаг байв. Ийнхүү хичээнгүй суралцаж, алдаа оноогоо зассаар удалгүй монгол хэлний мэргэжлийн хэллэг нь эрс сайжирч, бүр биднээс ч илүү сайн болсон юм. Харин өнөөх **"элгэнд дуртай зүйл"** гэсэн хөгжилтэй орчуулга нь олон жилийн дараа ч инээд бэлгэлсээр, нэгнийгээ дэмжиж, хамтдаа суралцан өсөн дэвжиж явсан он жилүүдийг санагдуулах дулаахан дурсамж болон сэтгэлд үлджээ.

Түүнтэй холбоотой бас нэг хөгжилтэй дурсамж бий. Нэг өдөр ажил тараад хоёулаа тухайн үед ховорхон олддог хан боргоцой авч идэхээр болов. Өрөөндөө орж гаднах хальсыг нь цэвэрлээд, юм ярьж хөөрсөөр нэлээд их идчихэж. Эхэндээ

үнэхээр амттай санагдсан ч удалгүй хэл хорсож, хөндүүрлээд эхлэв.

- Чиний хэл зүгээр байна уу?

- Нэг л сонин болоод байх юм... гэж бие биенээсээ асууж байснаа

"За, дуустал нь идчихье" гээд инээлдэн үргэлжлүүлсэн ч хэл улам хорсоод, сүүлдээ бараг ярьж ч болохгүй болов. Ингээд үлдсэнийг нь гялгар уутанд хийж аваад гэрийн зүг алхлаа. Замдаа тультраа хэлтэй хоёр хүн, инээлдсээр гэрийнхээ ойролцоох нэгэн сандал дээр сууж, өнөөх хан боргоцойгоо дуустал нь идчихсэн юм. Харин дараа нь хэлний арьс хуурч байгаа мэт болж, хэд хоног эвгүй мэдрэмжтэй явсан санагдана.

Одоо бодоход ховорхон олдсон жимсээ хайран гэж бодоод, хэл амаа хорсгож байж дуустал идсэн маань үнэхээр хөгжилтэй дурсамж болж үлджээ. Тэр үеийн хамт олны нөхөрлөл, ажилдаа бие биедээ түшиг болж, хамдтаа суралцан хөгжиж байсан он жилүүд, ажлын дараах ийм эгэл атлаа хөгжилтэй мөчүүд л хүний сэтгэлд хамгийн тод үлддэг юм байна.

Энэ дурсамж надад нэг зүйлийг үргэлж сануулдаг. Хүн мэдэхгүй зүйлээ нуухгүйгээр хүлээн зөвшөөрч, бусдаас суралцах хүсэлтэй байвал богино хугацаанд маш ихийг сурч хол явж чаддаг. Тэр найзын минь ажилдаа хандах чин сэтгэл, суралцах эрмэлзэл, хамтдаа өсөн дэвжиж явсан тэр он жилүүд өнөөдөр ч миний сэтгэлд нандин дурсамж болон хадгалагдсаар байна.

Дурсамж бүхэнд минь хамт байсан эрхэм найздаа чин сэтгэлийн талархал илэрхийлье. Өнөөдөр ч тэр инээдтэй орчуулга, хан боргоцойн "амттай шийтгэл" бидний хамтдаа өнгөрүүлсэн сайхан он жилүүдийг сануулж, эрхэм найзын минь нөхөрлөл, суралцах эрмэлзэлд өөрийн эрхгүй талархах сэтгэл төрүүлдэг юм."

Бас гэгээн сайхан сэтгэлийн дурсамж "Монитагийн бэлэг"

Байгууллагын шинэ жил болох дөхөж, уламжлал ёсоороо "монита" тоглон, хүн бүр сугалсан хүндээ нууцаар гурван удаа бэлэг өгөхөөр болов. Эхний бэлгүүд ирж эхлэхэд хүмүүс ширээн дээрээ тавигдсан бэлгээ сонирхон үзэж, хэн нь хэнийг сугалсан бол гэж таамаглан хөгжилдөж байлаа. Харин манай өрөөний нэгэн залууд бэлэг ирсэнгүй. Эхэндээ тэр, тоогоогүй дүр үзүүлж байсан ч, бусад нь бэлгээ авч баярлаж байхад өөрт нь бэлэг ирэхгүй болохоор дотроо багагүй хүлээлттэй, бас жаахан сэтгэл зовж буй нь анзаарагдаж байлаа.

- Намайг хүн сугалаагүй юм болов уу, эсвэл намайг сугалсан хүн маань их завгүй яваа юм болов уу, Хэрэв ерөөсөө сонгоогүй бол яадаг юм бол? үе үе хошигноно. Ингээд гурав дахь буюу сүүлийн бэлгийн өдөр ирлээ. Бусад хүмүүс бэлгээ авсаар байсан ч өнөөх залууд эхэндээ мөн л юм ирсэнгүй. Бараг найдвараа алдах шахаж байтал бэлэг тарааж дуусахын өмнөхөн маш гоё боодолтой томхон хайрцаг орж ирэв. Нээж үзтэл дотор нь хийц сайтай, чанартай хүрэм байлаа. Хамгийн гайхалтай нь яг захиалгаар хийлгэсэн мэт биед нь яв цав таарч, өмсөхөд үнэхээр сайхан зохиж байв. Хожим учрыг сонсоход, түүнийг сугалсан хүн нь хэмжээг нь тааруулан тусгайлан хийлгэж өгсөн учраас бэлэг нь жаахан оройтож ирсэн байжээ.

Тэр бол зүгээр нэг бэлэг биш хүнийг баярлуулах гэсэн чин сэтгэл шингэсэн бэлэг байсан юм. Түүний баярлаж байгааг хараад бид ч бас хамтдаа баярлаж, инээд хөөрөөр дүүрэн тэр өдрийн уур амьсгалыг тодхон санаж байна. Одоо эргээд бодоход тэр хүрэмнээс илүү үнэ цэнтэй нь нэгнийгээ баярлуулахын төлөө тэгтлээ хичээсэн, тэр "Сайхан сэтгэл" байжээ.

Тэр жилийн шинэ жил, монитагийн тэр бэлэг, олон хоногийн хүлээлтийн дараах баяр хөөр өнөөдөр ч бидний сэтгэлд гэгээн сайхан дурсамж болон хадгалагдсаар байна. Хамгийн сайхан бэлэг гэдэг үнэтэй зүйл биш, харин хүнийг бодож, сэтгэлээ зориулж өгсөн бэлэг байдаг юм байна. Миний энэ гэгээн дурсамжуудыг хамт бүтээлцсэн үе үеийн хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та нартаа эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

“1999 оны 3 дугаар сарын 1-ний Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль,УИХ-ын 1998 он 53, Засгийн газрын 1998 оны 181 дүгээр тогтоолыг үндэслэн ЭМНХ сайдын 1999 оны А/42 дугаар тушаал, 1999 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, бололвсролын төвийн захирлын 10 дугаар тушаалар 5 хүний бүрэлдэхүүнтэй Магадлан итгэмжлэл, лицензийн алба /МИЛА/ байгуулагдсан.”



ДУРСАМЖ

Тус албаны даргаар Л.Жигжидсүрэн, эмнэлгийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтнээр С.Гансүх, Ө.Ганчимэг, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл лицензхариуцсан мэргэжилтэн Б.Цэцэгмаа, статистик-бүртгэл хариуцсан мэргэжилтнээр Б.Болдбаатар нар тус тус томилогдон ажиллаж энэ байгууллагын суурь эрх зүйн үндсийг хамтран бүрдүүлж ирсэн билээ.

Энэхүү шинэ тутам байгуулагдсан алба нь байгуулагдсан эхний жилүүдэд эмнэлгийн магадлан итгэмжлэл, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлуулах, эмнэлэгийн мэргэжилтний лицензболон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалттай холбоотой дүрэм журам, шалгуур үзүүлэлт болон эмнэлгийн мэргэжилтнүүдээс мэргэжлийн шалгалт авах, манай улсад урт богино хугацаагаар ажиллах гадаадын эмч, эмнэлгийн мэргэжилтний лицензийн эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг шуурхай, цаг алдалгүй богино хугацаанд гүйцэтгэж ирсэн бөгөөд тэдгээрийг нийтэд түгээн сурталчлахад онцгой анхаарч байв. Энэ дашрамд, тухайн үеийн Дээд боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн ажлын туршлага, зөвлөгөө нь Эрүүл мэндийн магадлан итгэмжэлийн цоо шинэ энэхүү үйл ажиллагаанд санаа, оноо өгч байсныг онцлох нь зүйтэй болов уу.



Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн дарга Ц. Содномпилын 1999 оны 01 дүгээр тушаалаар эмнэлгийн анхны Магадлан итгэмжлэлийг Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэгт, Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх лицензийг АУИС-ын багш нарт, гадаадын эмч нарын лицензийг БНСУ-ын KYUNG HEE их Сургуулийн профессор Ли, Кан нарын 5 багш-эмчид олгохоор шийдвэрлэж, зохих бэлтгэлийг хангаж магадлан итгэмжлэл, лицензийн үйл ажиллагааг анх эхлүүлсэн байдаг.

Бадамжавын Цэцэгмаа, Улаанбаатар хот, 2026 он



ДУРСАМЖ

ЭМХҮТ-д ажиллах хугацаандаа Хүн амыг хөдөлгөөний хомсдолоос гаргах, эрүүл урт наслуулах дэвшилтэт арга болох нь дэлхий нийтэд тогтоогдсон Хийн дасгалыг хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, хамгаалах, сэргийлэх, чийрэгжүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа хийж, өвчнийг хөдөлгөөнөөр эмийн бус аргаар өртөг багатай эмчлэх боломжтой "Дорнын Хийн дасгал"-ыг өөрийн оронд анх удаа хөгжүүлж хэрэгжүүлсэн юм. Бие чийрэгжүүлэх Хийн дасгалын болон, Эмчилгээний хийн дасгалын багшийн мэргэжил эзэмшин анх удаа 1992 оноос 2008 он хүртэл Бие чийрэгжүүлэх хийн дасгалын багшаар 16 жил ажиллаж тэтгэвэр тогтоолгосон. ЭМХҮТ нь 1992 оноос Хийн дасгалын сургагч арга зүйч багшийн сургалтыг жил бүр 2 удаа зохион байгуулснаар 21 аймгийн ЭМГ, ӨЭМТ, СЭМТ, Нийслэлийн 9 дүүргийн ЭМН-ийн чийрэгжүүлэлтийн төвүүдэд, Нөхөн сэргээх тасаг, Амралт сувиллын газар, Хувийн хэвшлийн эмнэлэг, Ахмадын нөхөн сэргээх төвүүд, Нийслэлийн ахмадын танхим, Ерөнхий боловсролын сургуулийн Биеиин тамирын багш нарыг оролцуулан 650 гаруй сургагч арга зүйч багшийг улсын хэмжээнд бэлтгэсэн. 2001 онд ӨМӨЗО-ны нийслэл Хөх хотод 8 аймгийн сургагч багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд оролцуулан төгсгөсөн.

ЭМЯ, НЭМГ, БТСХ-той хамтран Бие чийрэгжүүлэх хийн дасгалыг хүмүүст ойлгуулах, арга зүйч болон сургагч багшийн сургалтыг зохион байгуулж, аймаг, хот, орон нутгийн ЭМБ-ын Чийрэгжүүлэлтийн төв, БТСХ-д анхны сургагч багш нарыг бэлтгэснээр аймаг, сум, хотын чийрэгжүүлэлтийн танхим, гадаах талбайд хүн бүхний хийх дуртай сурах юмсан гэж хүсч байдаг дасгалийн нэг болон хөгжүүлж чадсан юм.

ЭМХТ-Д ажиллах хугацаандаа Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан үндэсний III наадамын уралдаанд Хийн дасгалыг оруулснаар уралдааныг 5 бүсэд явуулж уралдаант үзлэгт аймаг сум нийслэлийн дүүргээс 15000 гаруй Ахмад оролцож 6000 Ахмадууд алт, мөнгө, хүрэл медаль хүртэж хүрээ нь улам өргөжсөн. 2008 онд тэтгэвэртээ гарсаны дараа 2011 онд Хийн дасгалын холбоог байгуулан Тэргүүнээр өнөөг хүртэл ажиллаж БТСХ, Нийслэл, дүүргийн БТСХ, ЭМГ, дүүргийн ЭМТ, Ахмадын хороодтой хамтран жил бүр тэмцээн уламжлал болгон явуулдаг болсон.

2012 оноос Нийслэлийн Нийтийн БТСХ-той хамтран Нийслэлийн Биеийн тамир спортын Иргэдийн Наадамын тэмцээнд Хийн дасгалыг оруулснаар Дүүргүүдийн бүх Хороодын иргэд 35-55 нас, 55-аас дээш насны хязгааргүй тэмцээнд оролцдог болсноор иргэдийн идэвхи улам сайжран Нийслэлийн 1 хорооноос 36 хүн оролцож, Иргэдийн наадамд оролцох хүний тоо жилээс жилд нэмэгдсээр байна.

2013 онд ЭМЯ, СХД-ЭМН-тэй хамтран 15-85 насны хүмүүс оролцсон 1000 хүний үзүүлэх тоглолт Сүхбаатарын талбайд хийсэн. Өөрийн амьдарч байгаа Сонгинохайрхан дүүргийн 14-р хорооны хүүхдийн тоглоомын талбайд жил бүр иргэдтэй хамт дасгалыг хийж хэвшил болгосон. Хятад улсын Бээжин хотын Бие тэтгэх хийн дасгалын холбооноос Хийн дасгалын багшийн дээд цол болох Бие чийрэгжүүлэх Хийн дасгалын ач холбогдол, үр дүнгээр 2005 онд Хийн дасгалын Доктор, Хүндэт профессор цол, 2008 онд заах аргачлал, ур чадварыг үнэлж Олон улсын хэмжээний багш, Олон улсын хэмжээний шүүгч цолуудыг хүртээсэн. 2018 онд Олон улсын Хийн дасгалын холбоонд 100 дахь гишүүн орноор орж Дэлхийн Олон улсын холбоодтой хамтарч ажиллаж байна. Олон улсын багш нарын хуралд оролцож Дасгалыг заах арга зүй, аргачлалаар Тэргүүн байр эзэлж Болор цомоор, 2025 онд Анхдагч шилдэг удирдагч, Анхдагч шилдэгийн шилдэг дасгалжуулагч багш цомоор шагнагдсан. Монгол улсынхаа нэр хүндийг Олон улсын хэмжээнд Хийн дасгалаар гаргаж яваа багш юм.

Хорлоо овогтой Оюунбилэг,

Улаанбаатар хот, 2026 он



Миний бие Цэвэгмид овогтой Хун би 2002 оны 6 дугаар сараас Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн хяналтын албанаас Эрүүл мэндийн яамны харьяа Эмнэлгийн тусламжийн удирдах газрын (ЭТУГ) чанарын баталгаажуулалтын албанд (ЧБА) эрүүл ахуй, халдвар хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтнээр ирж ажилласан юм.

ДУРСАМЖ

Тухайн үед ЭТУГ-ын даргаар АУ-ны доктор С.Дуламсүрэн, дэд дарга С.Гансүх, ЧБА-ны дарга, АУ-ны доктор, багш Л.Жигжидсүрэн нар ажиллаж, намайг элэгсэг найрсагаар хүлээн авсан нь саяхан мэт санагдаж байна. ЧБА нь олон талаас эрдэм мэдлэг, ажлын туршлагаараа шалгарсан мэргэжилтнүүдээс бүрдэж, богино хугацаанд ажил хэрэгч элэгсэг, эв нэгдэлтэй хамт олон болж төлөвшин, улсын түвшинд эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн ажлыг эхлүүлсэн.

Богино хугацаанд шатлалын эмнэлгийн стандартыг шинэчлэх, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах, шинжээчдийг бэлтгэх сургалтыг явуулах зэрэг ажлуудыг хийсэн юм.

Эхний ээлжинд төрийн өмчийн 600 орчим эмнэлгүүдийн ирүүлсэн материалыг судалж, дүгнэлт гарган магадлан итгэмжлэлийг олгох хугацааг тогтоох ажлын хүрээнд олон цагаар өдөржин, шөнөжин ажиллаж, магадлан итгэмжлэлийг олгож байв.

Дараа нь хувийн хэвшлийн 80 гаруй эмнэлгийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг газар дээр нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, магадлан итгэмжлэл олгох ажлыг хэрэгжүүлсэн.

2005 онд бүтцийн өөрчлөлтөөр Эрүүл мэндийн яаманд ажиллаж байгаад Эрүүл мэндийн газрын дэд даргаар 2008-2012 онд эргэн ажилласан юм. Газар маань 2010 оноос ЗГ-ын Хэрэгжүүлэгч Агентлаг Эрүүл мэндийн газар болон зохион байгуулагдаж 2 дэд даргатай, Захиргаа санхүү, Эмнэлгийн техник, технологи эдийн засгийн, Нийгмийн эрүүл мэндийн, Эмнэлгийн тусламжийн, Эрүүл мэндийн статистикийн, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн, Эмийн зохицуулалтын гэсэн 7 хэлтэс, Телемедицин үндэсний сүлжээний, Түргэн тусламжийн үндэсний сүлжээний гэсэн 2 төвийн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. ЭМЯ-ны бүтцэд байсан алсын түргэн тусламж, эм, техник, технологи, телемедициний үндэсний сүлжээний бодлогын хэрэгжилтийг бүхэлд нь гүйцэтгэж эхэлсэн юм.

Агентлаг нь 2010-2011 онуудад үндсэн үйл ажиллагааны үргээ биелүүлэхийн сацуу эрүүл мэндийн салбарын 90 жилийн ойн арга хэмжээний бэлтгэл ажлыг хангуулах, тэмдэглэн өнгөрүүлэх нүсэр их ажлыг хамт олныхоо хүчээр амжилттай хийж гүйцэтгэсэн юм. Хийсэн ажлаас товчхон дурьдвал: Спорт, урлагийн арга хэмжээ, “Эрүүл мэндийн салбарын 90 жилийн 4 үеийн түүхийн замнал, ололт амжилт бүтээлийг харуулсан зургийн цомог”, “ЭМЯ, агентлаг, түүний харьяа байгууллагын хөгжил”, “Нийслэлийн эрүүл мэндийн харьяа байгууллага”, “Аймгуудын эрүүл мэндийн байгууллага”, “ЭМЯ-ны харьяа тусгай албад”, “Анагаах ухааны эрдэм судлал”, “Анагаах ухааны боловсрол”, “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хөгжил”, “Эрүүл мэндийн тусгай албадын хөгжил” нийт 9 боть номыг хамтран боловсруулж, CD цомог, “Хийн дасгал, ажлын байрны дасгалын

цомог", "Ойн медалийн загвар", медалийг хийлгэсэн болно. Мөн анх удаа Монгол Улсын үндэсний фармакопейг хэвлүүлэн, анагаах ухаан, эмийн салбарын мэргэжилтнүүдийн гарын авлага болгосон.

Эрүүл мэндийн салбарын цогц шинэчлэлийн хүрээнд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн салбарыг 2010-2015 онд хөгжүүлэх стратегийн баримт бичигтэй болгох ажлын бэлтгэлийг ханган Архангай, Өмнөговь, Өвөрхангай, Увс, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Говь-Алтай зэрэг аймгуудыг стратегийн баримт бичигтэй болгон Эрүүл мэндийн сайд С.Ламбаа аймгийн Засаг дарга нартай хамтран баталгаажуулах ажлыг хэрэгжүүлэхэд, Эмнэлгийн техник, технологи, эдийн засгийн хэлтсийн хамт олон, тэр дундаа мэргэжилтэн Л.Ширнэн, Н.Нарангэрэл, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтсийн дарга С.Өлзийсайхан нар гол үүргийг гүйцэтгэсэн юм.

Монголын Мянганы сорилтын сангаас хэрэгжүүлсэн "Халдварт бус өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хянах төсөл"-ийн хүрээнд сургалт сурталчилгаа, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг бүхэлд нь Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн хамт олон, тэр дундаа хэлтсийн дарга Ц.Хандармаа, мэргэжилтэн Ч.Батнасан нар голлох үүрэг гүйцэтгэн, амжилттай хэрэгжүүлж дуусгасан юм.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хамт олон албад нэгжүүдийн дунд хэвшсэн ажлын нэг нь томилолтоор хөдөө явахдаа бусад алба нэгжүүдээс удирдамжиндаа хийх ажлын чиглэлийг авч тусгадаг байсан бөгөөд эргэн ажлын гүйцэтгэлээ тайлагнадаг байсан.

Бид их ажлын хажуугаар олон хөгжилтэй явдлууд тохиолддог байсныг эргэн саная. Миний ажиллаж байсан ЧБА-ы мэргэжилтэн Б.Цэцэгмаа (хожим Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга болсон) хамт олныхоо төлөө олон ажил санаачилан зохион байгуулдаг манай албан бус "үйлдвэрчний хорооны дарга Мамка" нэрээр өргөмжлөгдөн хэнээс ч хамаагүй мөнгө нэхэж авч чаддаг, гэхдээ хийсэн ажлаа маш хариуцлагатай тайлагнадаг байлаа. Ямар сайндаа С.Дуламсүрэн дарга хүлээн зөвшөөрчихсөн, инээгээд "Мөнгөө өгье" гээд мөнгөө хураалгадаг байж билээ.

Бидний ажлыг амжилттай шуурхай явуулахад захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийнхэн: ерөнхий нягтлан бодогч Г.Мажигсүрэн, Б.Очир, хүний нөөцийн ажилтан Л.Оюунчимэг, эмч нарын байрны зохион байгуулагч Г.Алтанцэцэг, нярав Т.Дулмаа, бичиг хэргийн эрхлэгч С.Нарантуяа, архивч Б.Дуламсүрэн, жолооч .Бямбаабаатар нарыгаа эргэн санахад сайхан байна.

Цэвэгмид овогтой Хун, Улаанбаатар хот,
2026 оны 07 сарын 05-ны өдөр

> *"2000 онд болсон нэгэн үйл явдал санаанаас гардаггүй. Манай залуу ажилтан Төгсөлтийн дараах сургалтыг хариуцсан туршлагатай ажилтан Б.Ганбаатартай хөдөө томилолтоор яваад, өглөө сэрсэн чинь Ганбаа ах аль эрт босчихсон, сахлаа хусаад унтуулдаггүй, нүдээ нээгээд харсан чинь нүд ам хамар нь ч харагдахгүй сахлын машин нүүрэн дээр нь гүйгээд байхаар нь нүүр нь хавтгай болчихсон байна гээд зүрх амаар гарах шахам цочин, огло үсрээд босоод очсон чинь дагзныхаа үсийг хусаад зогсч байсан хөгжилтэй тохиолдол болж билээ."*



Хүн бүрийн амьдралд хувь заяаг нь өөрчилсөн сонголт, замыг нь чиглүүлсэн хүмүүс байдаг. Миний хувьд эмчийн мэргэжлээс төрийн албанд шилжин ажиллаж, амьдралынхаа 23 жилийг Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй холбон өнгөрүүлсэн замнал маань тийм л он жилүүдийн түүх юм.

"ЭМЧЭЭС ТӨРИЙН АЛБАН ХААГЧ" БОЛСОН МИНИЙ ТҮҮХ

1994 оны хавар Анагаах Ухааны Их Сургуулийн эмчилгээний ангийг төгсөхөд сургуулийн декан багш маань намайг Физиологийн тэнхимдээ багшаар үлдэх санал тавьж байлаа. Харин тухайн үед дундах охин маань дөнгөж есөн сартай, хань минь гадаадад магистрын сургалтад суралцаж байсан учраас би эмчийн мэргэжлээрээ ажиллахыг сонгосон юм.

НЭМГ-т очиход хүссэн эмнэлгээ сонгох боломж олдож, гэрт ойрхон Сансарын ЭМТ 10-р төвийг сонгосон нь миний эмчийн замналын эхлэл болсон билээ. Тэнд би олон сайхан хамт олонтой учирч, туршлагатай ахмад эмч нараасаа эмч хүний ур чадвар төдийгүй хүнтэй ажиллах ухаан, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үнэ цэнийг сурсан. Тэр үеийн хуримтлуулсан мэдлэг, туршлага хожим төрийн албанд ажиллахад минь бат бөх суурь болсон юм.

Эмнэлэгт ажиллах хугацаандаа аливаа асуудлын учир шалтгааныг эрэлхийлэх дуртай байлаа. ***"Яагаад ийм болов?", "Юунаас болов?", "Дахин давтагдахгүйн тулд яах ёстой вэ?"*** гэсэн асуултууд намайг судалгаа, эрдмийн ажил руу хөтөлсөн гэж боддог.

2001–2002 онд эрхэм багш Х.Дамдинжавын удирдлага дор "Эмнэлгийн тусламж үйлчилгээг либеральчлахуй" сэдвээр анагаах ухааны магистрын зэрэг хамгаалсан юм. Ажлаа хамгаалсны дараа багш минь:

"Миний охин, чамд эрдмийн ажил хийх чадавх байна. Энэ ажлаа үргэлжлүүлээд докторын ажил болгоё." хэмээн хэлсэн нь миний амьдралын дараагийн алхмыг тодорхойлсон билээ.

Багшаасаа би эрдмийн ажил хийх арга барилаас гадна ажилд хандах ёс зүй, нягт нямбай байдлыг сурсан. Тэр дундаа хронометражийн аргаар ажлын байрны зураг авалт хийх аргачлалд суралцсан нь хожим төрийн албанд орсны дараах миний хамгийн эхний ажлын чиглэлтэй яг давхцсан нь үнэхээр хувь тохиол байсан юм.

Нэгэн өдөр багш маань: ***"Төрийн албанд ажиллах сонирхол байна уу? Сургуулийн хажууд байгаа байгууллага саяхан шинэ бүтэцтэй болсон. Хоёулаа орж уулзъя."*** гэж хэлэв.

Ингээд бид хоёр өнөөгийн ЭМХТ-ийн дарга, доктор С.Дуламсүрэнтэй уулзсан юм. Багш маань намайг танилцуулахад дарга:

"Х.Дамдинжав багш өөрөө шавиа дагуулж ирсэн байна гэдэг сайн шавь гэсэн үг. Материалаа өг. Бид судалж үзээд эргээд холбоо барья." гэж хэлсэн нь одоо хүртэл санаанаас гардаггүй.

Удалгүй Удирдлагын зөвлөлийн ярилцлагад орж, 2003.03.03-ны өдөр ажлын байрны дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтнээр томилогдон ажиллаж эхэлсэн юм. Ийнхүү би байгууллагынхаа ууган ажилтнуудын нэг болж, төрийн албаны замналаа эхлүүлсэн билээ.

Албаны дарга Ш.Оюунбилэгийн өгсөн хамгийн эхний даалгавар нь ажлын байрны дүн шинжилгээний тухай англи хэл дээрх материалуудыг уншиж, орчуулан тэмдэглэл хөтлөх байв. Өдөржин толь барин сууж, өгүүлбэр бүрийг ойлгох гэж хичээдэг байсан тэр өдрүүд миний мэргэжлийн суурийг тавьсан. Дараа нь ДЭМБ-ын зөвлөх Ronald Wan Konkelenberg-тэй хамтран ажиллах боломж олдож, айдас, догдлол хоёрыг зэрэг мэдэрч байсан минь өнөөдөр сайхан дурсамж болон үлджээ.

2003 оны намар Дундговь аймагт хийсэн анхны томилолт маань ч миний хувьд онцгой. Анх удаа гэрээсээ хол арван хоног ажиллаж, Дэрэнгийн айраг амсаж, УАЗ-69 машинаар сумдаар явж, ПАЗ автобусаар олон цаг аялж, сүм Бүрдэд хос хун харсан гээд амьдралын олон "анхны" минь тэнд үлджээ.

Тэр томилолтын үеэр сүм Бүрд дээр С.Дуламсүрэн даргатайгаа санаандгүй таарахад ямар их баярлаж, нүдэндээ нулимстай золгож байснаа одоо ч мартдаггүй. Холын томилолтод явж байсан залуу мэргэжилтэнд тэр уулзалт гэр бүлийн хүнтэйгээ уулзсан мэт л дулаахан санагдсан юм.

Харин төрийн албаны бичгийн соёлыг надад хамгийн сайн эзэмшүүлсэн хүн бол мөн л С.Дуламсүрэн дарга. Миний боловсруулсан албан бичиг бүр улаан балаар дүүрэн засвартай буцаж ирдэг байлаа. Би дахин засна, дарга дахин уншина. Энэ үйл явц олон удаа давтагдсан ч хэзээ ч төвөгшөөж байгаагүй. Тэр уйгагүй хөдөлмөрийн үр дүнд бичгийн найруулга, төрийн албаны баримт бичиг боловсруулах чадвар минь төлөвшиж, хожим алба, хэлтсийн даргаар олон жил ажиллахад хамгийн үнэтэй хөрөнгө оруулалт болсон юм.

"Өнөөдөр миний эргэн дурсах энэ сайхан замналд үнэтэй мөр үлдээсэн эрхэм багш Х.Дамдинжав агсан, байгууллагын дарга доктор С.Дуламсүрэн агсан, ахмад мэргэжилтэн Д.Чимэддолгор агсан нарынхаа гэгээн дурсгалд хүндэтгэл илэрхийлж, тэдний сургаж, төлөвшүүлсэн бүхэнд насан туршдаа талархан явах болно."

"Хүн өөрийн хөдөлмөрөөр амжилтад хүрдэг ч зөв хүмүүстэй учирсан хувь заяагаар төлөвшдөг юм байна. Эргээд харахад ЭМХТ бол миний ажилласан байгууллага төдий бус, намайг хүн, эмч, судлаач, төрийн албан хаагч болгон төлөвшүүлсэн амьдралын минь том сургууль байжээ. Энэ сургуулиар овоглож яваадаа би өнөөдөр ч бахархдаг."

Энэ байгууллагад ажилласан он жилүүдэд надад итгэж, дэмжиж, сургаж, чиглүүлсэн үе үеийн удирдлага, хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ЭМХТ-ийн хөгжил дэвшил улам батжин бэхжиж, эрүүл мэндийн салбарын хөгжлийн төлөөх эрхэм үйлс нь үеийн үед үргэлжлэх болтугай.

Нацагнямын Нарангэрэл,

Улаанбаатар хот, 2026 оны 07 сарын 19-ны өдөр

> *“Өнөөдөр эргэн харахад миний төрийн албан хаагч болж төлөвшихөд хамгийн их нөлөө үзүүлсэн хүмүүс бол байгууллагын дарга доктор (Ph.D) С.Дуламсүрэн, анхны албаны дарга доктор (Ph.D) Ш.Оюунбилэг, намайг халамжлан чиглүүлж сургасан Л.Ширнэн, Д.Чимэддолгор нар юм. Тэд надад зөвхөн ажил заагаагүй, төрийн албан хаагч ямар байх ёстойг үлгэрлэн харуулсан хүмүүс байлаа.”*

7.6. ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА, ХАМТ ОЛНЫ СЭТГЭГДЭЛ... ДУРСАМЖ... ТАЛАРХАЛ... МЭНДЧИЛГЭЭ



ЖАЙКА (JICA)-гийн мэргэжилтний хувиар Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах нэр төртэй бөгөөд ховорхон боломж олдсонд би туйлын баяртай байдаг. Хамтын ажиллагааныхаа хүрээнд Монголын ард түмний эрүүл мэнд, сайн сайхны төлөө сэтгэл зүрх, мэдлэг чадвараа зориулан ажилладаг хамт олноор тань гүнээ бахархаж, ажилдаа хүндэтгэлтэй, мэргэжлийн өндөр түвшинд ханддаг чанарыг өндрөөр үнэлсэн.

Та бүхэнтэй мөр зэрэгцэн ажиллах хугацаанд сэтгэлд хоногшсон сайхан дурсамжууд олон үлджээ. Ялангуяа спортын наадмаар хамтдаа гүйж, шинэ оны баяраар нэгэн гэр бүл шиг баярлан цэнгэж байсан минь сэтгэлд тодхон байна. Энэхүү дулаан агшин бүр та бүхний ажлын ур чадвараас гадна халуун дулаан сэтгэл, нөхөрсөг чанар, багийн бат бэх нэгдмэл чанарыг мэдрэх боломжийг надад олгосон билээ.

Та бүхний түүхэн замналд хувь нэмрээ оруулж, эдгээр дурсамжтай агшнуудыг хамтдаа бүтээсэндээ хязгааргүй талархаж байна. Энэхүү түүхэн тэмдэглэлт ойг тохиолдуулан чин сэтгэлийн халуун баяр хүргэж, цаашдын ажил үйлст тань арвин их амжилт, бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэе!

Хүндэтгэсэн,

Нобуаки Иноүэ

Профессор, Хүүхдийн эмгэг судлалын тэнхим

Сайтама Анагаахын Төв, Сайтама Анагаахын Их Сургууль

Японы Хүүхдийн Яаралтай Тусламжийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгч



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ЗАЛУУРДАГЧ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭМЖИГЧ, БҮТЭЭМЖИЙГ ИТГЭМЖЛЭГЧ БАЙГУУЛЛАГА...


Архангай аймгийн ЭМГ-ын дарга, Анагаах ухааны доктор (PhD), Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Р. Гандиймаа



Дэлхийн чиг хандлага, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн хөгжил, сургах, арга зүйн дэмжлэгийг тогтвортой үзүүлж ирсэн эрүүл мэндийн салбарын хөгжлийн тулгуур багана юм.

ЭМХТ нь дижитал шийдэл, нотолгоонд суурилсан ОУ-ын жишигт нийцсэн, тэргүүлэгч байгууллага байгаасай.

Дархан-Уул аймгийн ЭМГ-ын дарга, МУ-ын Хүний гавьяат эмч, гэмтлийн Зөвлөх эмч, клиникийн профессор Б.Эрдэнэтулга



ЭМХТ нь эрүүл мэндийн тогтолцоо үйл ажиллагаагаа хэвийн явуулахад чухал үүрэгтэй олон үйл ажиллагааг удирдан хэрэгжүүлдэг цорын ганц байгууллага. Тухайлбал, хүний нөөцийн асуудал, төгсөлтийн дараах сургалт, эрүүл мэндийн мэдээлэл, статистик, цахимжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэл, бодлогын судалгаа зэрэг чухал үүргийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэдэг.

Цаашид эрүүл мэндийн салбарын бодлогын болон тогтолцооны судалгааны чадавхиа улам сайжруулж, салбарын бодлого шийдвэрийг нотолгоонд тулгуурлан боловсруулахад дэмжлэг үзүүлж, судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр түлхүү хөгжих нь маш чухал байна.

ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтэн Э.Эрдэнэчимэг



Эрүүл мэндийн салбарт 34 дэх жилдээ ажиллаж байна. Сумын эмчээс аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах албыг хаших хүртэл Эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх институт, ЗГХА-ЭТУГ, ЭМХТ нэртэйгээр эмч мэргэжилтнүүдийг гадаад дотоодод, урт богино хугацаагаар сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах, хяналт тавих, лицензжүүлэх, эмнэлгийн МИ олгох, сунгах, Эрүүл мэндийн статистик мэдээлэл нэгтгэн гаргах зэргээр нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, эмч мэргэжилтнийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан түүхэн байгууллага юм.

Энэ байгууллагаар дамжиж эх барих эмэгтэйчүүдийн эмч, эрүүл мэндийн удирдах ажилтнаар мэргэшиж олон арван урт богино хугацааны гадаад дотоодын сургалтад хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлжээ.


Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн захирал,
Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Д.Доржготов



“Монгол-Германы хамтарсан НҮЭМ”-ийн төсөлд Үндэсний зөвлөхөөр ажиллаж байхад манай оффис ЭМХТ дээр байрладаг, эрүүл мэндийг дэмжих, өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажилладаг байсан. Би ЭМХТ-ийг эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар, манлайллыг тасралтгүй хөгжүүлдэг, шинэ мэдлэг, нотолгоог бий болгож түгээдэг төв гэж боддог.

Ирээдүйд тус төв нь салбарын хөгжил, шинэчлэлийг манлайлагч, инновацид тулгуурласан мэргэжлийн чадавхыг хөгжүүлэгч, төр, мэргэжлийн байгууллага, иргэний нийгэм, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг найдвартай холбогч гүүр нь болсон Үндэсний тэргүүлэх байгууллага болоосой гэж бодож явдаг.

Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч, клиникийн профессор, Тархвар зүйн шинжлэх ухааны магистр, ЭМЯ, Глобаль сангийн ОНУХ-ын тогтолцоог бий болгох төслийн мэргэжилтэн Б.Цэвэлмаа



Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эмч, мэргэжилтний тасралтгүй хөгжил, тусламж үйлчилгээний чанар, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч, салбарын удирдах ажилтны хөгжил, бодлого, тогтолцооны судалгааны туршлагатай үндэсний хэмжээний байгууллага юм.

Цаашид судалгааны үр дүнг бодлого, практикт үр дүнтэй нэвтрүүлэх бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр чадавхыг бэхжүүлэн манлайлах нь чухал.

АХБ, ЭМЯ -ны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Ш.Оюунбилэг

Анх 2001 онд тухайн үеийн ЭМЯ-ны дэргэдэх Анагаах ухааны боловсролын зөвлөлийн хурлын шийдвэрээр ХӨСҮТ-д үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагын зөвшөөрөл олгогдож 43 дугаар гэрчилгээг хүлээн авснаар төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлж Халдварт өвчний эмч, Сүрьеэгийн эмч, Тархвар судлаач эмч, Нян судлаач эмч, Ариутгал судлал, Дархлаажуулалтын сувилахуй гэсэн 6 чиглэлээр сургалт зохион байгуулсан түүхтэй.

Ийнхүү анхны сургалтаа эхлүүлснээс хойш эдүгээ 25 жил өнгөрч, энэ хугацаанд манай 2 байгууллагын олон жилийн хамтын ажиллагааны үр дүнд 6000 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнийг халдварт өвчний чиглэлээр бэлтгэсэн нь мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах, хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан түүхэн үеийг бүтээсэн байна.

Энэ бол зөвхөн нэг байгууллагын сургалтын үйл ажиллагааны тоон үзүүлэлт бус, Монгол Улсын хэмжээнд халдварт өвчний тусламж, үйлчилгээний хүний нөөцийг бүрдүүлсэн 25 жилийн хамтын ажиллагаа, хичээл зүтгэлийн бодит үр дүн юм. Ялангуяа халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үед мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээ ямар чухал болохыг бид бүхэн КОВИД-19 цар тахлын үед бодитоор мэдэрсэн.

ЭМХТ-тэй хамтран халдварт өвчний цар тахал, дэгдэлтийн үед ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг богино хугацаанд бэлтгэх, дадлагажуулах ажлыг эрчимтэй зохион байгуулсан.

КОВИД-19 цар тахлын үед резидент эмч нарыг сурган дадлагажуулж, хавьтал болон гадаадаас ирж буй иргэдийн тусгаарлалтад ажиллуулах, сорьц авах, "улаан бүс"-д ажиллах зэрэг практик ур чадварыг эзэмшүүлсэн. Дархлаажуулалтын сувилагчдыг багц цагийн болон богино хугацааны сургалтаар бэлтгэж, 21 аймаг, 9 дүүргийн 200 сувилагчийг сурган төгсгөсөн нь КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтыг богино хугацаанд өргөн хүрээнд зохион байгуулахад чухал дэмжлэг болсон юм.

Энэ түүхэн ойн үеэр нэгэн сонирхолтой давхцалыг онцлон тэмдэглэхэд таатай байна. Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга Д.Дондогмаа энэхүү сургалтын үйл ажиллагааг 25 орчим жил хариуцан ажиллаж байгаа бол миний бие сургалт эрхлэгч байгууллагын зүгээс энэхүү ажлыг 21 дэх жилдээ хариуцан ажиллаж байгаадаа баяртай байна.

Эрүүл мэндийн салбарынхаа хөгжилд хамтдаа үнэтэй хувь нэмэр оруулж, цаашид ч мэдлэг, туршлагаа хуваалцан, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх их үйлсээ улам өргөжүүлэн хөгжүүлэхийг хүсье.

Та бүхэндээ 30 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, ажил хөдөлмөрийн өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



ХӨСҮТ-ийн Хүний нөөцийн хөгжил, сургалтын албаны дарга АУ-ны магистр, НЭМ-н тэргүүлэх зэргийн эмч Ж.Баярсайхан

"Энэ бүхний цаана сургалтын чанар, мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжлийн тогтолцоог бүрдүүлэхэд хамтран ажилласан олон арван багш, сургагч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, зохион байгуулагчдын хөдөлмөр бий.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээ шаардлагад үндэслэн шаардлагатай мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх судалгаа хийх, сургалтад элсүүлэн суралцуулах, сургалтын явц болон төгсөлтөд хяналт тавих, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх боломжийг бүрдүүлэх, багц цагийн сургалт зохион байгуулах, мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллаж ирсэн билээ."



ЭМ-ийн байгууллага МИ-д хамрагдах нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг олон улсын болон үндэсний стандартын түвшинд хүргэж, өвчтөний аюулгүй байдлыг хангах хамгийн чухал баталгаа болдог. Ялангуяа, “Чанар-хэмжигдэхүйц байх” зарчмыг баталгаажуулдаг хамгийн гол шалгуур бүхий үнэлгээг магадлан итгэмжлэл гэж бид үздэг.

Хувийн хэвшлийн ЭМБ-ын хувьд магадлан итгэмжлэгдсэнээр үйлчлүүлэгчдэд тухайн эмнэлгийг найдвартай, чанартай гэх урьдчилсан итгэлийг төрүүлж, үйлчлүүлэгчдийн урсгалыг тогтвортой байлгахаас гадна зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх, ЭМД-аас санхүүжилт авах гол хөшүүрэг болдгийг дурьдах нь зүйтэй Түүнчлэн хамт олноороо МИ-ийн бэлтгэл хангаж, шалгуур хангах үйл ажиллагааны явцад тасаг нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо сайжирч, чанарыг эрхэмлэсэн байгууллагын соёл төлөвшдөг давуу талтай.

Иймд технологийн дэвшил, хүний нөөцийн хөгжил нь цаг хугацааны туршид үргэлж өөрчлөгдөж байдаг ч, бид бүхний “ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОРИЛГО” хэзээ ч өөрчлөгддөггүй болохыг магадлан итгэмжлэл нотлон харуулж байдаг

.

Гурван гал нэгдсэн эмнэлэг, ЭМТҮЧАБА-ны дарга,
АУ-ны магистрант Эрчимт эмчилгээний эмч Б.Наранзул

УНТЭ-ийн Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь ЭШСҮАЗА-тай донор илрүүлэлт, эрхтэн хуваарилалт, амьгүй донороос эрхтэн авах үйл ажиллагааны зохион байгуулалт, сургалт, сурталчилгаа, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, эрхтэн шилжүүлэн суулгах тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

ЭШСҮАЗА-ны хамт олон өндөр ёс зүйтэй, хариуцлагатай, мэргэжлийн ур чадвартай бөгөөд аливаа асуудалд шуурхай, нээлттэй ханддаг. Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд байгууллагуудын хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, нэг зорилгын төлөө уялдуулан ажиллуулдаг нь хамтын ажиллагааны гол давуу тал гэж үздэг.

Тус албаны үйл ажиллагаа нь манай төвийн үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Ялангуяа донорын тоог нэмэгдүүлэх, эрхтэн хуваарилалтын ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэх, улсын хэмжээнд эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулсны үр дүнд олон эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндийг сэргээх, амьдралын чанарыг сайжруулах боломжтой болсон нь хамгийн том үр дүн юм.

Цаашид эрхтэн донорын талаарх олон нийтийн боловсрол, сурталчилгааг улам эрчимжүүлэх, орон нутгийн эмнэлгүүдийн чадавхыг бэхжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан болон дижитал шийдлүүдийг хөгжүүлэхэд анхаарна гэдэгт итгэж байна. ЭМХТ-ийн хувьд эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр олон улсын сайн туршлагыг нутагшуулах, хүний нөөцийн чадавхыг тасралтгүй хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн
Эрхтэн шилжүүлэн суулгах төв



Орхон аймгийн БОЭТ нь ЭМЯ, ЭМХТ, Япон улсын "Жайка" ОУБ-ийн дэмжлэгээр 2015 оноос хэрэгжүүлсэн "Анхан ба хоёрдох шатлалын эмнэлгийн мэргэжилтний ТДС-ыг сайжруулах төсөл"-ийг орон нутагт хэрэгжүүлэх эмнэлгээр сонгогдож, ТДС-ыг анх удаа аймгийн хэмжээнд загвар болгон зохион байгуулж эхэлсэндээ туйлын баяртай байдаг. Би энэ үеэс одоог хүртэл ТДС хариуцан ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд ХНХА-ны хамт олон болон "Жайка" төслийн нэгжийн баг нь ТДС-ыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, өдөр тутмын арга зүйгээр ханган хамтран ажиллаж байсан болохоор сургалт зохион байгуулах бэлтгэлийг бүрэн хангаж, 2018 онд ЭМЯ-ны дэргэдэх ЭМХЗ-ийн тогтоолоор "Ерөнхий мэргэшил судлал" сургалт эрхлэх байгууллагын зөвшөөрлөө авч, 10-р сард анхны элсэлтээр 4 эмч хүлээн авч, сургалтаа эхлүүлж байсан.

Төслийн хүрээнд "Эмнэл зүйн сургагч багш" бэлтгэх сургалтыг 2016 онд анх удаа орон нутагт зохион байгуулж, төслийн анхны ахлах зөвлөх Охара Хироши, төслийн зохицуулагч Нода Хироюки, ЭМХТ-өөс ахлах мэргэжилтэн Ц.Даваахүү, чиглүүлэгч О.Батгэрэл багш нар хичээл зааж, манай 24 эмч маань анхны сургалт удирдах сургагч багш нар болж байсан.

Түүнээс хойш сургалтыг манай БОЭТ-ийн Сургалтын албаны дарга асан, Хүний гавъяат эмч Батсүх эмчээр ахлуулсан сургагч багш эмч нар төслийн зөвлөх, сургалт хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран резидент эмч нарт зориулсан хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн тойролтын өврийн ном болон сургалтын хөтөлбөрт тусгагдсан зайлшгүй суралцах 21 гардан үйлдлийг Монгол улсын болон олон улсын стандартад нийцүүлэн видео хичээл бүхий гарын авлага боловсруулж, эмнэлзүйн сургагч багш нараа нэмж бэлтгэн, анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг татан оролцуулж сүлжээ эмнэлэг үүсгэн, эмнэл зүйн ур чадварын танхим байгуулж, цогц чадамжтай эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцооны суурь тавигдсан.

Энэ бүх үйл ажиллагаанд ХНХА-ны хамт олон тэр дундаа Д.Дондогмаа дарга, тэр үед ажиллаж байсан П.Эрхэмбаяр, Б.Мөнхцэцэг, Д.Баярхүү зэрэг мэргэжилтнүүд биднийг байнга чиглүүлэн дэмжиж, багш нарын маань ур чадварыг нэмэгдүүлж, авъяас чадавхийг нь нээж, урам зориг өгч байсан нь сургалтын чанар, тогтвортой байдлыг хадгалахад их нөлөөлсөн гэж би бодож явдаг.

Улмаар энэхүү сургалтыг өргөжүүлэх зорилгоор ЭМЯ, ЭМХТ болон төслийн нэгжийн багаас 2019 онд Ховд, Өвөрхангай, Өмнөговь, Дорнод аймгийн БОЭТ, 2021, 2023, 2024 онуудад бусад аймаг, дүүргийн НЭ, ЭМТ-ийн удирдлага, эмч мэргэжилтнүүдэд туршлага солилцох уулзалт, сургалтыг хамтран зохион байгуулж, сургалтын тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан, одоогоор 19 байгууллага болж өргөжсөнийг харахад таатай байна.

Мөн төслийн хоёр дахь үе 2021-2024 онд "Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах" төслийн хүрээнд эмч нараас гадна сувилагч, эх баригч нарыг эмнэл зүйн сургагч багшаар бэлтгэн, манай хамт олон 2022 онд анх удаа сувилахуйн мэргэшүүлэх сургалтыг эхлүүлж, орон нутгийн ЭМБ-ыг түүчээлэн туушатай, ур дүнтэй ажиллаж байгаа хамт олноороо бахархаж байна.

Энэ хугацаанд та бүхний мэргэжлийн дэмжлэг, хамтын ажиллагаа, уйгагүй хөдөлмөрийн үр дүнд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын шинэ тогтолцоог орон нутагт хөгжүүлэх, бэхжүүлэх үйлсэд өнөөг хүртэл хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлээд, ЭМХТ-ийн хамт олонд түүхт 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга, Нийгмийн эрүүл мэндийн ахлах зэргийн мэргэжилтэн М.Ундрахсайхан

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН БӨӨР ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ БАГ

Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба байгуулагдсан нь манай улсын эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний тогтолцоог шинэ түвшинд хүргэсэн чухал алхам болсон гэж үздэг. Тус алба байгуулагдахаас өмнө бөөр шилжүүлэн суулгах багийн зохицуулагч амьгүй донорын ар гэрийнхэнтэй уулзаж, зөвшөөрөл авах зэрэг олон талын зохицуулалтыг бие даан хариуцдаг байсан нь нэлээд төвөгтэй, хариуцлага өндөртэй ажил байлаа.

Өнөөдөр ЭШСҮАЗА-ны хамт олонтойгоо маш сайн ойлголцож, бие биенээ хүндэтгэн, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хөгжүүлэх, олон хүний амь насыг аврахын төлөө нэг зорилгын дор харилцан ойлголцож, хамтран ажиллаж байгаадаа баяртай байдаг.

Албаны дарга, зөвлөх, мэргэжилтэн, ажилтан бүр ёс зүйг эрхэмлэн, хууль, журмыг дээдэлж, ажилдаа тууштай, хариуцлагатай хандаж ирсэнд талархаж явдаг. Түүнчлэн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, донорын хууль тогтоомжийг шинэчлэн найруулж, өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхийн төлөө идэвх санаачилгатай ажиллаж байгаад баярлаж явдгаа илэрхийлье.

ЭШСҮАЗА нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг бууруулж, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор олон эмнэлэгт эрхтэн шилжүүлэн суулгах багийг шинээр байгуулан ажиллуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, мэргэшүүлэх, гадаадад мэргэжил дээшлүүлэхэд тууштай дэмжлэг үзүүлж ирсэн. Мөн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийж, алдаа, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад анхаарч ажилладагт талархаж байна.

Ялангуяа орон нутагт тархины үхэл тодорхойлох багийг байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сурган чадавхжуулж байгаа нь эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг орон нутагт хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болж байна.

ЭМХТ-ийн 30 жилийн ойг тохиолдуулан ЭШСҮАЗА-ны нийт хамт олондоо чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье. Энэ бол амаргүй, өндөр хариуцлага, тэвчээр, сэтгэл шаардсан ажил. Та бүхнээс илүү энэ ажлыг чин сэтгэлээсээ хийж чадах хүн ховор гэдэгт итгэдэг. Тиймээс цаашид ч мохошгүй сэтгэл, нэгдмэл зорилго, өндөр хариуцлагатайгаар үйл ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлж, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Цаашид ЭШСҮАЗА-ны хэрэгжүүлж буй бүхий л ажил, үйл ажиллагааг Бөөр шилжүүлэн суулгах багийн хамт олон эргэлзэлгүй, тууштай дэмжин, хамтран ажиллах болно.

Хөгжлийн төлөө, Монгол хүний төлөө — УРАГШАА!

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЦУСНЫ ӨВЧИН, ЯСНЫ ЧӨМӨГ–ЦУСНЫ ҮҮДЭЛ ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ БАГ

Манай цусны өвчин, ясны чөмөг–цусны үүдэл эс шилжүүлэн суулгах баг нь Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албатай олон жилийн турш мэргэжлийн өндөр түвшинд, нягт хамтран ажиллаж ирсэн. Монгол Улсад цусны үүдэл эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, эрх зүй, зохион байгуулалтын орчныг бүрдүүлэх, донорын асуудлыг шийдвэрлэх, олон байгууллагын уялдаа холбоог хангах зэрэг олон чиглэлд тус албаны оролцоо, дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэнд бид талархдаг.

Ялангуяа шинэ, өндөр технологид суурилсан тусламж, үйлчилгээг нутагшуулахад зөвхөн нэг эмнэлгийн багийн хүчин чармайлт хангалтгүй байдаг. Эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалт, эмнэлэг болон бусад холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг нэгдсэн чиглэлээр уялдуулах шаардлагатай бөгөөд энэ чиглэлд тус албатай хамтран ажилласан туршлага бидэнд үнэтэй дэмжлэг, сургамж болж ирсэн.

Тус албаны хамт олон мэргэжлийн өндөр хариуцлагатай, шинэ санаа, өөрчлөлтөд нээлттэй, асуудлыг хамтран шийдвэрлэх эрмэлзэлтэй ажилладаг гэж бид үнэлдэг. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа нь эмнэлзүй, ёс зүй, хууль эрх зүй, зохион байгуулалтын олон асуудлыг зэрэг хамардаг онцлогтой. Ийм нарийн төвөгтэй салбарт оролцогч талуудын саналыг сонсож, харилцан ойлголцлыг бий болгон, бодитой зохион байгуулалтын шийдэлд хүргэх нь тус албаны чухал давуу тал юм. Манай багийн хувьд аливаа асуудлыг зөвхөн хяналт, зохицуулалтын өнцгөөс бус, эмч, мэргэжилтнүүдийн бодит хэрэгцээ, өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний онцлогтой уялдуулан хэлэлцэж, хамтран шийдвэрлэхийг эрмэлздэгт нь талархаж явдаг.

Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ нь өндөр эрсдэлтэй, олон мэргэжлийн багийн оролцоо шаарддаг, нарийн зохицуулалт бүхий үйл ажиллагаа юм. Иймээс тус албаны дэмжлэг нь манай багт зөвхөн өдөр тутмын зохион байгуулалтын хувьд төдийгүй цаашдын тогтвортой хөгжлийг хангахад ч ихээхэн ач холбогдолтой байсан. Хамтын ажиллагааны үр дүнд шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт, донорын асуудал, мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо, салбар хоорондын хамтын ажиллагаа илүү системтэй болж, Монгол Улсад энэхүү өндөр технологийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх суурь бэхжихэд бодит хувь нэмэр оруулсан гэж үздэг. Хамгийн чухал үр дүн нь өвчтөнүүд эх орондоо олон улсын түвшинд нийцсэн өндөр технологийн тусламж, үйлчилгээ авах боломжийг үе шаттайгаар өргөжүүлж байгаа явдал юм.

Цаашид эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах салбарын хөгжил улам эрчимжихийн хэрээр тус албаны үүрэг, хариуцлага улам нэмэгдэнэ гэж үзэж байна. Ялангуяа дараах чиглэлүүдэд хөгжлийн дараагийн шатны ажлуудыг хэрэгжүүлэх нь чухал юм. Үүнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эрх зүйн орчныг олон улсын жишигт улам ойртуулах, донорын тогтолцоо болон бүртгэлийг боловсронгуй болгох, шилжүүлэн суулгах төвүүдийн нэгдсэн мэдээллийн сан, үр дүнгийн бүртгэл, чанарын хяналтын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай. Мөн цаашид зөвхөн эрхтэн болон цусны үүдэл эс шилжүүлэн суулгалтаар хязгаарлагдахгүй, эсийн эмчилгээ, генийн эмчилгээ, дархлааны эсийн эмчилгээ зэрэг анагаах ухааны шинэ технологийг Монгол улсад нэвтрүүлэх нөхцөл бүрдэж байна.

Иймээс эдгээр шинэ технологийг аюулгүй, ёс зүйтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалтын тогтолцоог урьдчилан бүрдүүлж, мэргэжлийн багуудтай нягт хамтран ажиллахыг хүсэж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түүхт 30 жилийн ойг тохиолдуулан Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны үе үеийн удирдлага, хамт олон, мэргэжилтнүүдэд чин сэтгэлийн баяр хүргэе. Монгол Улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх үйлс нь олон хүний мэдлэг, хүчин чармайлт, тууштай хөдөлмөр, байгууллага хоорондын итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурладаг. Энэхүү хариуцлагатай салбарын зохицуулалт, хөгжлийн ард та бүхний хөдөлмөр, зүтгэл чухал байр суурь эзэлдэгт талархаж байна. Цаашид Монголын шилжүүлэн суулгах анагаах ухаан олон улсын түвшинд улам хөгжиж, илүү олон өвчтөн эх орондоо амь насыг аврах, амьдралын чанарыг сайжруулах өндөр технологийн тусламж, үйлчилгээ авах боломжтой болно гэдэгт итгэлтэй байна. Та бүхний цаашдын ажил үйлсэд өндөр амжилт хүсье. Бид өмнөхийн адил нэгдсэн зорилгын төлөө үр бүтээлтэй хамтран ажиллаж, Монгол Улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах анагаах ухааны дараагийн үеийн хөгжлийг хамтдаа бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАСАН ИРГЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ МЯГМАРЖАВЫН ӨЛЗИЙБАЯР

Би диализ эмчилгээнд 2010-2021 онд эмчлүүлж байсан, 2021 онд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгуулсан иргэн М.Өлзийбаяр байна.

ЭШСҮАЗА-тай анх байгуулагдсан 2018 оны 3-р сараас эхлэн одоог хүртэл 8 жил тасралтгүй хамтран ажиллаж байна. Цөөн албан хаагчтай ч чадварлаг, харилцаа хандлага сайхан хамт олон. Маш өндөр сэтгэгдэлтэй байдаг шүү.

Энэ алба байгуулагдсанаар энд ажиллагсдын ажлын үр дүнд амьгүй донорын удирдлага зохицуулалт гэсэн цоо шинэ харилцаа-үйл ажиллагаа хэлбэршин тогтворжиж олон хүн бөөр шилжүүлэн суулгуулж шинээр амьдарсны нэг нь би, надазд хоёр дахь амьдрал бэлэглэсэн алба юм.

Цаашид албан хаагчдын орон тоог нэмж, үйл ажиллагааны нарийн чиглэлээр мэргэшүүлэн тогтвортой ажиллуулах. Хиймэл оюун ухаан, нийгмийн сүлжээ гээд хэвлэн нийтлэх медиа салбарын нөлөөлөл маш их болсон тул үүгээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх нэгж байгуулагдаж өшөө үр дүнтэй олон ажил хийгээсэй гэж хүсэж байна

Чадварлаг, мэргэшсэн том байгууллага болохыг хүсэн ерөөе.

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ШӨРМӨС, ЯС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ БАГ

Манай төв 2019 оноос эхлэн тус албатай хамтран донорын шөрмөс, яс ашиглан ясны том хэмжээний дутмагшил болон олон холбоос, шөрмөсний гэмтлийг эмчилж эхэлсэн. Өнөөдрийг хүртэл 100 гаруй өвчтөнд аллографт шөрмөс, яс шилжүүлэн суулгах мэс засал хийж, өмнө нь эмчилгээ нь төвөгтэй, өндөр өртөгтэй эсвэл эмчлэх боломжгүй байсан тохиолдлуудыг амжилттай эмчилсэн.

Тус албаны ажилтнууд мэргэжлийн өндөр ур чадвартай, харилцааны соёл сайтай бөгөөд байгууллага хоорондын хамтын ажиллагаанд идэвхтэй, хариуцлагатай оролцдог.

Энэ төрлийн мэс заслыг нэвтрүүлсэн нь манай байгууллага төдийгүй гэмтэл, ортопедийн салбарын хөгжилд томоохон дэвшил болсон. Өмнө нь шөрмөс, ясны их хэмжээний дутмагшилтай өвчтөнийг гадаад улсад эмчлүүлэхээр илгээх, эсвэл өндөр өртөгтэй гадны биет (эндопротез, синтетик материал)-ээр орлуулах шаардлагатай байсан. Аллографт яс, шөрмөс ашиглах болсноор эдгээр өвчтөнийг эх орондоо эмчлэх боломж бүрдэж, тэднийг санхүүгийн их дарамтаас чөлөөлсөн. Мөч, түүний үйл ажиллагааг хадгалж үлдэх нь өвчтөн хөдөлмөр эрхлэх, нийгэмд хувь нэмрээ оруулах чадвараа хадгалахад чухал ач холбогдолтой.

Зүрхний үхэлтэй (цусны эргэлт зогссоны дараах) донороос эд, эрхтэн авч шилжүүлэн суулгах үйл ажиллагааг нэвтрүүлэхийг хүсэж байна. Ингэснээр донорын тоо нэмэгдэж, илүү олон өвчтөнд эмчлүүлэх боломж бүрдэнэ.

Эрүүл мэндийн хөгжлийн төв үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндийг Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн яс, шөрмөс шинжлүүлэн суулгах багийн өмнөөс Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны хамт олонд халуун дотноор өргөн дэвшүүлье.

Та бүхэн эрхтэн, эд шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохион байгуулах, донорын тогтолцоог хөгжүүлэх, эмнэлгүүдийн хамтын ажиллагааг уялдуулах чиглэлээр салбарт үнэтэй хувь нэмэр оруулсаар ирлээ. Олон өвчтөний эрүүл мэнд, амьдралын чанар сайжирсны ард та бүхний мэргэжлийн мэдлэг, ажлын хариуцлага, хүмүүнлэг сэтгэл оршдогийг бид өндрөөр үнэлдэг.

Тус албатай хамтран ажиллах бүрд мэргэжлийн өндөр түвшин, харилцааны соёл, шуурхай дэмжлэг, туслалцааг мэдэрсээр ирсэн. Энэ нь бидний хамтын ажиллагааг улам бэхжүүлж, өвчтөнд чиглэсэн тусламж, үйлчилгээг сайжруулахад бодит нөлөө үзүүлсэн гэдэгт итгэлтэй байна.

Ойн баярын энэ сайхан үеэр та бүхэнд ажлын өндөр амжилт, шинэ санаачилга, бүтээлч эрч хүч, эрүүл энх, аз жаргал хүсье. Цаашид ч эрүүл мэндийн салбарын хөгжлийн манлайлагч байж, Монгол Улсын иргэдийн эрүүл мэндийн төлөө үр бүтээлтэй ажиллахыг хүсэн ерөөе.



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үе үеийн хамт олны дурсамж бол өнгөрсөн түүхийн хуудсыг сөхөхөөс илүү өргөн утга агуулгатай. Энэ бол нэгэн үеийнхний мэдлэг, туршлага, хариуцлага, эх орныхоо эрүүл мэндийн салбарын төлөөх зүтгэлийн бодит илэрхийлэл юм.

Тэдний бүтээсэн зам мөр өнөөдөр шинэ үеийн мэргэжилтнүүдийн үргэлжлүүлэх хөгжлийн суурь болж, байгууллагын үнэт зүйл, ажлын соёл, мэргэжлийн ёс зүй болон өвлөгдөн үлджээ.

Цаг үе өөрчлөгдөж, байгууллагын нэр, бүтэц зохион байгуулалт шинэчлэгдсэн ч эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжих, нотолгоонд суурилсан бодлого, чанартай тусламж үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөцийг төлөвшүүлэх эрхэм зорилго хэвээр хадгалагдан ирсэн.

Ахмад үеийнхний үлдээсэн мэдлэг, сургамж, залуу үеийнхний шинэ санаа, эрч хүч нэгдэн нийлж чадсанаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дараагийн түүхэн хуудсууд бичигдсээр байх болно.

Энэ бүлэгт өгүүлсэн дурсамж бүхэн байгууллагын түүхийн нэгэн үнэ цэнтэй хэсэг бөгөөд "ХАМТ ОЛОН" хэмээх хамгийн эрхэм баялаг мөн болохыг гэрчилж байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

8

БҮЛЭГ НАЙМ

ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ



Hr.hdc.gov.mn

acc.hdc.gov.mn


"ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН
ДАРААХ СУРГАЛТЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ НЬ"
СЭДЭВТ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ








ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ











ЭРҮҮД МЭНДИЙГ ДЭМЖИГЧ
ОРЧИН, БҮРДҮҮЛЭХЭД
ИРГЭДИЙН ОРОЛЦОО












"Яаралтай болон мэс
заслын тусламж үйлчилгээ"
сэдэвт сургалт










2012/07/19




ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР








САЛБАРТАА АНХ УДАА
1996 ОНООС ХОЙШХИ


ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛ ЙН ТӨВ






ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
"ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ
БАЙГУУЛЛАГА"




ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ
















ДҮҮДЛАГЫН ТӨВ




ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ






МОНГОЛ УЛСЫН
"ГУРВАН САЯ ДАХЬ ИРГЭН"
ЁСЛОДЫН УЙЛ АЖИЛЛАГАА






ЭМХТ





















ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ








ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ӨДӨРТ ЗОРИУЛСАН
ЭНЭРЭНГҮЙ ҮЙЛСТЭН ТАНАА
ХҮНДЭТГЭЛ ЕСЛОЛЫН АЖИЛЛАГАА












ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ








ЭРҮҮЛ МЭНД
СПОРТЫН ЗАА














ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ
THE
OSCAR
2018


HAPPY






ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ









ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

9

БҮЛЭГ ЕС

ИХ ҮЙЛСИЙН ЗАМД





1313.mn

hinfo.mn

ЭМХТ



Өнгөрсөн... Одоо... Ирээдүй... Гурван цагийн хэлхээ нэгэн цэг дээр огтлолцож байна. Өнгөрсөн нь бидний бахархал, өнөөдөр нь бидний хариуцлага, харин ирээдүй нь бидний бүтээх учиртай шинэ түүх юм.

ЭМХТ ирэх он жилүүдэд ямар амжилт бүтээлээрээ улсынхаа хөгжлийг манлайлах бол?

Ямар шинэ технологи Монголын эрүүл мэндийн салбарт нутагшуулах бол?

Ямар инновац дэлхийн хөгжлийг Монголтой холбох бол?

Ямархан шинэ нээлтээр Монгол эмч нар дэлхийн түүхэнд бичигдэх бол?

Хичнээн мянган иргэний амь нас, эрүүл амьдралын ард энэ байгууллагын хөдөлмөр үлдэх бол?

> ***“Бид гучин жилийн түүхээ энэхүү номын хуудсанд шингээн баринтаглаж танд өргөн барьж байна.***
>
> ***Энэ бол төгсгөл биш.***
>
> ***Энэ бол шинэ эхлэл.”***

Эдгээр асуултын хариуг цаг хугацаа бичих ч, тэрхүү түүхийг бүтээх хүмүүс нь өнөөдрийн бид юм.

Өнгөрсөн гучин жилд ЭМХТ зөвхөн байгууллага болж хөгжсөнгүй. Монгол Улсын эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн гол тулгуур,

бодлогын хэрэгжилтийн түшиц, мэдлэгийн сан, мэдээллийн үнэт баялаг, хүний нөөцийн хөгжлийн голомт болон төлөвшсөн юм.

Өнөөдөр энэ их айл нэгэн зорилгын төлөө зүтгэдэг олон зуун мэргэжилтнийг эгнээндээ нэгтгэн, эх орныхоо эрүүл мэндийн салбарын хөгжил дэвшлийг манлайлан, өдөр бүр үнэт хувь нэмрээ оруулсаар байна.

Бидний бүтээсэн статистик бүрийн цаана хүний амь нас бий.

Бидний хөгжүүлсэн мэдээллийн систем бүрийн цаана эмчийн зөв шийдвэр бий.

Бидний хэрэгжүүлсэн сургалт бүрийн цаана чадварлаг мэргэжилтэн бий.

Бидний шинэчилсэн стандарт бүрийн цаана аюулгүй тусламж үйлчилгээ бий.

Бидний судалгаа, инновац бүрийн цаана Монгол хүний эрүүл ирээдүй бий.

Бид ирээдүйн эрүүл Монголыг бүтээж буй.

Өнөөдөр дэлхий дөрөв дэх аж үйлдвэрийн хувьсгал, хиймэл оюун ухаан, их өгөгдөл, геномик анагаах ухаан, алсын зайн оношилгоо, дижитал эрүүл мэндийн эринд шилжин хөгжиж байна.

Энэхүү асар их өөрчлөлтийн төвд Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоо ч шинэ шатанд гарч байна.

Тиймээс ЭМХТ-ийн эрхэм зорилго улам тодорхой болж байна.

Эрүүл мэндийн мэдээллийг хөгжүүлэх

Инновацыг бүтээх

Шинэ технологийг нутагшуулах

Хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх

Тусламж үйлчилгээний чанарыг баталгаажуулах

Нотолгоонд суурилсан бодлогыг төлөвшүүлэх

Цахим шилжилтийг манлайлах

Энэ бол зөвхөн нэг байгууллагын үйл ажиллагаа биш

Энэ бол үндэстний эрүүл ирээдүйг бүтээх эрхэм үйлс юм.

"Өгөгдөл мэдлэг болж, мэдлэг бодлого болж, бодлого нь Монгол хүн бүрийн эрүүл амьдралын баталгаа болно."

Энэ номын хуудсуудыг эргүүлэх бүрд бид гучин жилийн хөдөлмөр, зүтгэл, эрэл хайгуул, шинэчлэл, амжилтын мөрийг хамтдаа харж байна.

Энд эх орныхоо эрүүл мэндийн төлөө амьдралаа зориулсан олон үеийн хүмүүсийн хүсэл мөрөөдөл, хичээл зүтгэл, үнэнч сэтгэл, мэргэжлийн нэр төр, хариуцлагын түүх оршиж байгаа.

Нэгэн эмчийн итгэл... Нэгэн судлаачийн нойргүй шөнө...

Нэгэн багшийн заасан хичээл... Нэгэн мэргэжилтний боловсруулсан стандарт...

Нэгэн инженерийн хөгжүүлсэн мэдээллийн систем...

Нэгэн албан хаагчийн хариуцлагатай шийдвэр...

Тиймээс манай байгууллагын хамгийн үнэт өв нь барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж биш.

Архивын зузаан хавтас ч биш....

Хамгийн үнэт зүйл нь хүн юм.

Мэдлэгтэй хүн.... Ёс зүйтэй хүн....

Хариуцлагатай хүн.... Эх орноо гэсэн сэтгэлтэй хүн.

Ийм хүмүүсийн хүчин зүтгэлээр гучин жилийн түүх бичигджээ.

Харин дараагийн гучин жилийг өнөөдөр энд ажиллаж буй хүмүүс болон тэдний араас ирэх шинэ үеийнхэн бичнэ.

Ийнхүү гучин жилийн өмнө асаасан нэгэн гэрэл өнөөдөр улам тод асч байна.

Тэр гэрлийг үе үеийн хүмүүс гар дамжуулан хамгаалж иржээ.

Одоо тэр гэрлийг ирээдүй үеийнхэн үргэлжлүүлэн асаасаар байх болно.

Учир нь түүх дуусдаггүй, зогсдоггүй.

Түүхийг үргэлж дараагийн үе нь үргэлжлүүлэн бичдэг.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 30 жилийн түүх ийнхүү бичигдвэй ...

Өчигдрөөс эхэлсэн.

Өнөөдөр үргэлжилнэ.

Маргааш улам гэрэлтэн мөнхөрнө.

Энэ бол ИХ ҮЙЛСИЙН ЗАМ...

ЭМХТ-ИЙН ЗАХИРАЛ **М.ОДГЭРЭЛ**





Hr.hdc.gov.mn

acc.hdc.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

10


БҮЛЭГ АРАВ

ХАВСРАЛТ



1313.mn
hinfo.mn

10.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР ГАРСАН ТУШААЛ ШИЙДВЭР



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

19 96 оны 10 р сарын 04 ны өдөр

Дугаар А/233

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв байгуулах тухай

Сайдын зөвлөлийн 1996 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Анагаах Ухааны Үндэсний хүрээлэнгийн Эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийн гүйцэтгэгчид Эрүүл Ахуй Халдвар Нян Судлалын Үндэсний төвийн "Эрүүл мэндийн статистик мэдээллийн төв"-ийн нэгтгэн Эрүүл мэнд нийгмийн хамгаалын яамны харьяа "Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв" болгон 1996 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвийн дүрмийг нэгдүгээр хавсралтын ёсоор батлуулсугай.

3. Эрүүл мэндийн удирдлага мэдээллийн төвийн захирлаар Ц.Содномпилийг томилж, сарын үндсэн цалинг ТУ-11-ээр 32300 төгрөгөөр тогтоосугай.


4. Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвд, Анагаах ухааны Үндэсний Хүрээлэнгийн төв байр (12.3 сая төгрөгийн үндсэн өртөгтэй) ах ахуйн хашаа болон хоёрдугаар хавсралтаар дурьдсан хөрөнгийг балансаас балансад шилжүүлсүгэй.

5. Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвд шилжих хөрөнгө, хүн хүч, эд аж ахуйг хүлээлцэх ямны комиссыг доорх бүрэлдэхүүнтэй батлаж, 1995 оны тооллогын үндсэн материалыг үндэслэн хөрөнгө, хүч шилжүүлэх ажлыг энэ оны 10 сарын 10-ны дотор дуусгаж, дүнг сайдын зөвлөлд танилцуулахыг комисс /Д.Баярсайхан/-т даалгасугай.

Комиссын дарга: Д.Баярсайхан - Эдийн засаг, зохицуулалтын газрын дарга

Гишүүд: Б.Бурмаа - Анагаах ухаан, эмнэлгийн хөгжлийн газрын мэргэжилтэн
Д.Чойжилсүрэн - Эдийн засаг, зохицуулалтын газрын мэргэжилтэн
Ж.Дэмбэрэлсүрэн - Хүн ам, нийгмийн эрүүл мэндийн газрын орлогч дарга
Г.Мажигсүрэн - АУҮХ-ийн ерөнхий нягтлан бодогч
Г.Дашдулам - ЭАХНСҮТ-ийн операторч

6. Эрүүл мэндийн статистик мэдээллийн төвийг 6 аймаг, Улаанбаатарын 9 цэгтэй холбосон компьютерын факсмодемын сүлжээ болон аймгуудаас мэдээ явах утасны ажиллагаа тасралтгүй байхаар зохион байгуулахыг ЭАХНСҮТ /Ц.Сододол/, Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төв /Ц.Содномпил/ нарт даалгасугай.




- 2 -

7. Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвд шилжиж буй хүмүүст шилжүүлэхийг Анагаах ухааны үндэсний хүрээлэнгийн захирал Ц.Мухар, ЭАХНСҮТ-ийн захирал С.Цоодол нарт даалгасугай.

8. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, УБ хотын захирагчийн 1994 оны А/110/А-183 тоот тушаал, захирамжийн нэгдүгээр заалтын "...мэдээлэл тооцооллын төв...", үг тушаал, захирамжийн нэгдүгээр хавсралтын 16 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 1995 оны А/119 тоот тушаалын 3 дугаар заалтын "...Анагаах ухааны хүрээлэнгийн байр,..." гэсэн хэсгүүдийг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД Л.ЗОРИГ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМГААЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

17 09 11 А/311

Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв байгуулах тухай.

ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сургалт арга зүйн төвийг Эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн төвтэй нэгтгэн Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв байгуулж ЭМНХЯ-ны харьяанд ажилуулсугай.

2. Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн дүрмийг хавсралтын ёсоор батлуулсугай.

3. Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн захирлаар Ц.Содномпилийг томилж, үндсэн цалинг албан тушаалын ангилалтай ТУ-11 -ээр тогтоосугай.

4. Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийг зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй батлаж, байрны ашиглалт, санхүүжилт, эд хөрөнгө шилжүүлэх ажлыг энэ оны 9 дүгээр сарын 20-ны дотор дуусгаж дүнг сайдын зөвлөлийн хуралд танилцуулахыг комисс (и. Жамбалжав) -т даалгасугай.


Комиссын дарга: Л.Жамбалжав - Мэдээлэл, хэвлэл, шинжилгээ, үнэлгээний газрын дарга

Гишүүд:
Д.Байгалмаа - Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ажилтан
Д.Амар - Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ажилтан
Ц.Энхбаяр - Мэдээлэл, хэвлэл шинжилгээ, үнэлгээний газрын ажилтан
Ц.Долоонжин - Нийгэмлэгийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн ажилтан

5. Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв нь Эрүүл мэндийн байгуулагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах болон эмч нарт мэдлэг эрх олгох ажлыг зохион байгуулах үүрэг шинээр хүлээж байгаатай холбогдож шаардагдах орон тоог 1998 оны төсөв, төлөвлөгөөндөө тусгаж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтанг сургах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг сайжруулахыг төвийн захирал Ц. Содномпилд үүрэг болгосугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 1994 оны А/91 тоот тушаал, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалын сайдын 1996 оны А/233 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД З.ЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 03 сарын 04 ны өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

Хууль, тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль, Улсын Их Хурлын 1998 оны 53, Засгийн газрын 1998 оны 181 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ:**

1.Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх албыг Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн бүрэлдэхүүнд байгуулж, Засгийн газрын 1998 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан Магадлан итгэмжлэх байгууллагын дүрмийн дагуу ажиллуулахыг Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв /Ц.Содномпил/-д даалгасугай.

2. Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд явуулах журам, тогтсолт, шаардлагатай бусад баримт бичгийг 3 дугаар сарын 15-ны дотор боловсруулан батлуулахыг Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв /Ц.Содномпил/-д даалгасугай.

САЙД С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

1999 оны 04 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар А/83 | Улаанбаатар хот Утас: 321559

Хууль тогтоол хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль, УИХ-ын 1998 оны 53 дугаар тогтоол, Засгийн газрын 1998 оны 181 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ:**

1. Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв /Ц.Содномпил/-д үүрэг болгох нь:

1/ Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5, 6, 7, 8 дахь хэсэгт заасан эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах эвшээрлийг 1999 онд багтаан олгох;

2/ Төгсөлтийн дараахь сургалтад 1998 оноос өмнө хамрагдаж нарийн мэргэшил эзэмшсэн бөгөөд Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 6 дугаар хэсэгт үл хамаарах эмнэлгийн мэргэжилтнийг шалгаруулалтад хамруулж тэдэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах нарийн мэргэшлийн эвшээрлийг 2000 онд багтаан олгох;

3/ Төгсөлтийн дараахь сургалтад хамрагдаж нарийн мэргэшил 1999 оноос шинээр эзэмшиж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг нарийн мэргэшлийн үйл ажиллагаа явуулах эвшээрлийн шалгалтад хамруулж, уг эвшээрлийг олгож байх;

4/ Эмнэлгийн нэг мэргэжилтэнд ерөнхий болон нарийн мэргэшлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эвшээрлийг тус тусад нь олгох ба нэг мэргэжилтэнд 3-аас илүүгүй эвшээрэл олгож байх.

2. Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Баярсайхан/, Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл боловсролын төв /Ц.Содномпил/-д даалгах нь:

1/ Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх эвшээрэл бүхий сургуулийг 1999, 2000 онд төгсөх эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эвшээрэл олгох мэргэжлийн шалгалтыг тухайн сургуулийн төгсөлтийн шалгалттай уялдуулан зохион байгуулах;

2/ 2001 оноос эхлэн анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх эвшээрэл бүхий сургуулийг хүний эмчийн мэргэжлээр төгсөгчдөөс дадлагажих сургалтын дараа, бусад мэргэжлээр төгсөгчдийг сургууль төгссөнийх нь дараа магадлан итгэмжлэх байгууллага мэргэжлийн шалгалт авч эмчлэх сувилах, эм барих эвшээрэл олгох журмыг шилжих хугацаанд зохион байгуулах;

3/ Магадлан итгэмжлэх эвшээрэл олгох асуудлаар холбогдох байгууллагын удирдах ажилтанд зориулсан семинарыг 1999 оны 2 дугаар улиралд зохион байгуулах.

3. "Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах эвшээрэл олгох мэргэжил, мэргэшлийн жагсаалт"-ыг 1 дүгээр, "Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх эвлелийн ажиллах журам"-ыг 2 дугаар, "Магадлан итгэмжлэх эвлелийн бүрэлдэхүүн"-ийг 3 дугаар, "Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх орон нутгийн салбар эвлелийн бүтэц, ажиллах журам"-ыг 4 дүгээр, "Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах эвшээрэл, эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгоход төлөх үйлчилгээний хөлсний жишиг"-ийг 5 дугаар хавсралтын ёсоор тус тус батлуулсугай.

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний технологи, стандартыг 1999 онд багтаан боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, мөрдүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /А.Зангад/-д даалгасугай.

5. Энэхүү тушаалын 1, 2 дугаар заалтад заасан хугацааны дотор мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эвшээрэл аваагүй эмнэлгийн мэргэжилтэнг эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа эрхлэхийг зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын удирдлагад даалгасугай.

6. Эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалтыг ёс зүйн хорооны дүгнэлтийг, 2 дахь заалтыг шүүхийн шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж байхыг эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллагад эвшээрсүгэй.

САЙД С.СОНИН

Хуулбар үнэн: Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.БАЯРСАЙХАН

УХА 0237

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2000 оны 06 дугаар сарын 29-ны өдөр | Дугаар 193 | Улаанбаатар хот Утас 325751

***Үндэсний эрүүл мэндийн
газар байгуулах тухай***

Эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын эвлелийн 2000 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 8 дугаар, мөн оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэр, Засгийн газрын эвшээрлийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийг 2000 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өөрчлөн зохион байгуулж, Эрүүл мэндийн үндэсний бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, зохицуулах үүрэг бүхий "Үндэсний эрүүл мэндийн газар"-ыг байгуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын дэргэд ажиллуулсугай.

2. Үндэсний эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, орон тоог нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус батлуулсугай.

3.Үндэсний эрүүл мэндийн газрын даргаар Ц.Содномпилийг 2000 оны 7дугаар сарын 1-ний өдрөөс томилж, албан тушаалын зэрэглэлийг ТЗ-11-ээр тогтоосугай.

4. Үндэсний эрүүл мэндийн газарт шаардагдах нэмэлт төсвийг 2000 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга А.Зангад, Үндэсний эрүүл мэндийн газрын дарга Ц.Содномпил нарт даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв байгуулах тухай Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны А/311 тоот тушаал, Үндэсний эрүүл мэндийн тусламжийн алба байгуулах тухай 2000 оны А/123 тоот тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙДЫН ТУШААЛ

2000 оны 12 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 166 | Улаанбаатар - 210648 Утас - Факс - 320916

Бүтэц, дүрэм батлах тухай

Эрүүл мэндийн сайдын эвлелийн 2000 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үндэсний эрүүл мэндийн газрыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв болгон зохион байгуулж, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, орон тоог нэгдүгээр, төвийн дүрмийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус батлуулсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 193 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД П.НЯМДАВАА

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 12 сарын 09 өдөр Дугаар 285 Улаанбаатар хот

Үйл ажиллагааны стратеги, зохион
байгуулалтын бүтэц батлах тухай

"Терийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий будуувчийг шинэчлэн батлах тухай " Улсын Их Хурлын 2002 оны 58-р тогтоол, "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай " Засгийн газрын 2002 оны 162-р тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийг Эмнэлгийн тусламжийг удирдах газар (хэрэгжүүлэгч агентлаг) болгон зохион байгуулж үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлогдсон 2002 оны 12 дугаар сард багтаан боловсруулан батлалж, мөрдүүлэхийг Эмнэлгийн тусламжийг удирдах газар (С. Дуламсүрэн) -т даалгасугай.

3. Эрүүл мэндийн салбарын бүтцийн өөрчлөлтийн чиглэлд тохируулан Эмнэлгийн тусламжийг удирдах газарт Эрүүл мэндийн яам , салбарын бусад байгууллагаас шилжүүлэх үйл ажиллагаа, орон тоо, цалингийн сан, байр, тоног төхөөрөмжийн асуудлыг судлаж 2002 оны 12 дугаар сард багтаан шийдвэрлүүлэхийг дэд сайд Н.Удвал, төрийн нарийн бичгийн дарга Ц.Содномпил нарт даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын "Хууль тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1999 оны А/42 тоот, Эрүүл мэндийн сайдын "Бүтэц дүрэм батлах тухай" 2000 оны 106 тоот тушаалууд, "Хууль хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 100 дугаар тушаалын 2 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД П. НЯМДАВАА

02 0739

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 20 өдөр Дугаар 363 Улаанбаатар хот

Төсөв, орон тоог шилжүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12. 16 дугаар, Эмийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. 6.3 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн улсын хяналтын албанаас Эмийн мэдээллийн төв, Эмчилгээний болон Эмийн чанарын хяналтын лабораториос хавсралтад дурьдсан орон тоог Эмнэлгийн тусламжийг удирдах газар (хэрэгжүүлэх агентлаг)-т шилжүүлсүгэй.

2. Шилжүүлэх ажлыг зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Н.Удвал- дэд сайд
Орлогч дарга Т.Эрхэмбаатар – БХЗГ-ын дарга
Гишүүд Д.Байгальмаа – Тамгын хэлтсийн дарга
Ч.Менхдэлгэр – ЭМЯ-ны мэргэжилтэн
Ц.Цолмонгэрэл – ЭМЯ-ны мэргэжилтэн

3. Эрүүл мэндийн улсын хяналтын албанаас Эмнэлгийн тусламжийг удирдах газарт шилжих орон тоог цалингийн сан, үйл ажиллагаанд зардал, байр, тоног төхөөрөмж, эд хөрөнгийн хамт жагсаалт гарган хүлээлцүүлэх комисс (Н.Удвал)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн улсын хяналтын албаны үйл ажиллагааны стратеги, дүрэм, бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах тухай" 2000 оны 109 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД П.НЯМДАВАА

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 04 сарын 28 өдөр Дугаар 81 Улаанбаатар хот

Алсын түргэн тусламжийн үйлчилгээг шилжүүлэх, зохицуулах журам, жагсаалт батлах тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2004 оны 01 тоот тогтоолыг үндэслэн нийслэлээс хөдөө орон нутагт дуудлагаар очиж үзүүлэх эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэшлийн тургэн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор ТУШААХ НЬ:

1.Нийслэлийн яаралтай тусламжийн төвийн алсын тургэн тусламжийн нэгжийн үйл ажиллагаг Эмнэлгийн тусламжийг удирдах газарт 2004 оны 4 дүгээр сард багтаан шилжүүлсүгэй.

2.Алсын тургэн тусламжийн үйлчилгээг зохицуулах журмыг нэгдүгээр, алсын дуудлага дуудах өвчний жагсаалтыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус батлагсугай.

3.Алсын тургэн тусламжийн үйлчилгээг зохицуулах журам, алсын тургэн тусламж дуудах өвчний жагсаалтыг мердэж ажиллах, бүсийн оношлогоо, эмчилгээний төв болон аймгийн нэгдсэн эмнэлэгт шаардагдах мэдрэлийн мэс засал, гэмтэл согогийн мэргэжлийн эмчийг 2004-2006 онд төлөвлөгөөтэйгээр бэлтгэн, тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээ авахыг Эмнэлгийн тусламжийг удирдах газар (С.Дуламсүрэн), Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал, аймгийн нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч нарт үүрэг болгосугай.

4.Уг тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар (Б.Баяр)-т үүрэг болгосугай.

САЙД П.НЯМДАВАА

08 0285

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 08 сарын 18 өдөр Дугаар 187 Улаанбаатар хот

"Эрүүл мэндийн салбарын хөгжил - 2"
төслийн зээлийн гэрээг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

"Эрүүл мэндийн салбарын хөгжил-2" төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай Монгол Улсын хууль, Монгол улс, Азийн хөгжлийн Банкны хооронд 2003 оны 8 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан Зээлийн гэрээний 6 дугаар хавсралтын 12-16 дугаар заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол улсын эрүүл мэндийн салбарт Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа "Эрүүл мэндийн салбарын хөгжил-2"(ЭМСХ-2) төслийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эмнэлгийн тусламжийг удирдах газар(ЭТУГ)-т 2004 оны 9-р сарын 1-ний өдрөөс эхлэн "Ажлын байрны зэрэглэл дээшлүүлэх нэгж"(АБЗДН)-ийг 3 орон тоотойгоор байгуулан ажиллуулсугай.
2. АБЗДН-д ажилпах ажилтнуудын цалингийн сан, албан хэрэгцээний болон сургалтын техник хэрэгслээр хангахад шаардагдах зардлыг "ЭМСХ-2" төслийн холбогдох зардлын зүйл ангиас гаргаж, санхүүжүүлэхийг төслийн гүйцэтгэх захирал (С.Сонин)-д даалгасугай.
3. "Эрүүл мэндийн салбарт ажлын байрны зэрэглэл дээшлүүлэх үйл ажиллагааны зарчим" бодлогын баримт бичиг, холбогдох заавар, журмыг Азийн Хөгжлийн Банктай байгуулсан гэрээнд нийцүүлэн боловсруулж, 2004 оны 10 дугаар сарын 1-ний дотор батлуулахыг ЭТУГ(С.Дуламсүрэн)-т даалгасугай.
4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг төрийн нарийн бичгийн дарга, төслийн удирдах хорооны дарга (Ц.Содномпил)-д үүрэг болгосугай.

САЙД П.НЯМДАВАА

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2005 оны 01 сарын 24 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

Бүтэц, дүрэм батлах тухай

Улсын их хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2004 оны 236 дугаар тогтоолын 5 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тусламжийг удирдах газрыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв болгон зохион байгуулж, "Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц"-ийг нэгдүгээр, "Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн дүрэм"-ийг хоёрдугаар, "Эрүүл мэндийн яаманд шилжүүлэх мэргэжилтэн, тоног төхөөрөмжийн жагсаалт"-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай.

2. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн захирлаар Самдангийн Дуламсүрэнг томилсугай.

3. Төвийн төсвийг Сангийн яамаар хянуулж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн газар /Д.Чимэддавга/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2002 оны 285 дугаар тушаал, 296 дугаар тушаалын 2,4 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Т.ГАНДИ

104

08 0734

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Дугаар 41 Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, бүтэц батлах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 236 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн "... төвийг байгуулж, үт төвийн" гэснийг "төв болон Эмгэг судлалын төвийг байгуулж, тэдгээрийн" гэж өөрчлөн найруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ц.ЭЛБЭГДОРЖ

Эрүүл мэндийн сайд Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2005 оны 01 сарын 28 өдөр Дугаар 80 Улаанбаатар хот

Төв байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24.1.4 дэх заалт, 2004 оны Улсын Их Хурлын ... дугээр тогтоолыг үндэслэн Эмгэг судлалын албаны мэргэжлийн бие даасан үйл ...киллагаат хангах зорилгоор ТУШААХ нь:

1. "Эмгэг судлалын төв"-ийг байгуулж, даргаар нь Ч.Батсайхан-ыг 2005 оны 1 ...дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

2. Тус төвийн дүрмийг нэгдүгээр, Шүүх эмнэлгийн магадлах төвөөс ажил ...үргийн хуваарийн хамт шилжүүлэх орон тоог хоёрдугаар, Эмгэг судлалын төвийн ...киллах орон тоо бүтцийг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус батлалсугай.

3. Эмгэг судлалын албаа, Шүүх эмнэлгийн магадлах төвийн одоогийн хамтран ...эмшиж буй байрыг "Эмгэг судлалын төв"-ийн үндсэн хөрөнгөнд нь бүртгүүлэх ...клыг зохион байгуулахыг Санхүү, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн газар /Д.Чимэддавга/-т даалгасугай.

4. Шүүх эмнэлгийн магадлах төвд ажилтнуудынх нь одоогийн байрлаж буй өрөө, ажлын байрыг хэвээр ашиглуулахыг "Эмгэг судлалын төв"-ийн дарга /Ч.Батсайхан/-д үүрэг болгосугай.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт ...шинжилгээ үнэлгээний газар (О.Сэмэр)-т үүрэг болгосугай.

САЙД Т.ГАНДИ

08 0962

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2005 оны 10 сарын 13 өдөр Дугаар 453 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн үндэсний тооцооны талаар авах зарим арга хэмжээний тухай

Эрүүл мэндийн санхүүгийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож үндэсний тооцооны системийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Дэлхийн Банкны тусламжтайгаар хэрэгжүүлсэн "Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлагын удирдлагыг бэхжүүлэх нь" төсөл дуусч байгаатай холбогдуулан эрүүл мэндийн үндэсний тооцооны асуудлыг хариуцан хэрэгжүүлэх нэгжийг байгууллагынхаа бүтцэд байгуулж, цалингийн сандаа багтаан ажиллуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв (С.Дуламсүрэн)-д даалгасугай.

2. Төсөлд ашиглагдаж байсан хавсралтанд дурдсан 5063.6 мянган төгрөгийн өртөг бүхий компьютер, принтерийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв (С.Дуламсүрэн)-д даалгасугай.

3. Эрүүл мэндийн үндэсний тооцооны хүрээнд цуглуулах мэдээлэл, түүний урсгалыг дамжуулах, мэдээллийг түгээх асуудлыг зохицуулсан журам боловсруулж батлуулах, түшаалын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн газар (Д.Чимэддавга)-т даалгасугай.

4. Эрүүл мэндийн үндэсний тооцоонд шаардлагатай мэдээ, мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд улирал тутамд гарган ирүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүдийн дарга, клиникийн эмнэлгийн захирал нар-т тус тус даалгасугай.

САЙД Т.ГАНДИ

УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2003 оны 04 сарын 15 өдөр Дугаар 157 Улаанбаатар хот

Эмийн бүртгэл мэдээллийн төвийн тухай

Монгол улсын Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын мэргэжлийн хяналтын албанаас Эмийн бүртгэл, мэдээллийн төвийн хавсралтанд дурдсан орон тоо, эд хөрөнгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эмнэлгийн тусламжийг удирдах газарт шилжүүлсүгэй.

2. Улсын мэргэжлийн хяналтын албанаас Эмнэлгийн тусламжийг удирдах газарт шилжүүлэх эд хөрөнгийг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг ерөнхий няпглан зохицуулагч Ц.Орхонтамирт даалгасугай.

ДАРГА Д.БАТБААТАР

09 0451

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2006 оны 2 сарын 16 өдөр Дугаар 44 Улаанбаатар хот

"ЭСС" ТВ радио студийг шилжүүлэх тухай

ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн бүтцэд ажиллаж байсан "ЭСС" ТВ Радио студийг Эрүүл мэндийн яаманд шилжүүлж, шилжүүлэх ажиллагсдын нэрс, цалингийн санг нэгдүгээр, Тоног төхөөрөмжийн жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус батлагдсугай.

2. "ЭСС" ТВ Радио студийг ажлын өрөө, бусад шаардагдах нөхцөлөөр хангаж, дүрэм, бүтцийг батлуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Баярт)-т үүрэг болгосугай.

3. "ЭСС" ТВ Радио студийн цалин, тесвийг Сэнгийн яамаар хянуулж хуваарилуулан хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн газар (Д.Чимэддагва)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2005 оны "Бүтэц, дүрэм батлах тухай" тушаалын "Эрүүл мэндийг хөгжлийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц"-ийг батлагдсан нэгдүгээр хавсралтын 2.5 дахь заалтаас "ЭСС" ТВ Радио студи гэснийг хассугай.

САЙД Л.ГҮНДАЛАЙ

08 0037

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 24-ний өдөр *Дугаар 64* *Улаанбаатар хот*

Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 5.1, 6.3-т заасныг болон "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудыг хавсралтын ёсоор байгуулан ажиллуулсугай.

2. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлан мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд шинээр болон өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв, Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, Тээврийн үйлчилгээний төв, Авто замын хяналт, судалгааны төв, Усны хэмнэлтийн төв, Усны институт, Ой, усны хайгуул судалгааны төв, Банкны ёр барагдуулах газар, Сорьцын улсын хяналтын алба, Цөм сүргийн үржлийн төвийг тус тус татан буулгаж, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв, Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, Тээврийн үйлчилгээний төв, Авто замын хяналт, судалгааны төв, Усны хэмнэлтийн төв, Усны институт, Ой, усны хайгуул судалгааны төвийн чиг үүргүүдийг шинээр байгуулагдсан холбогдох агентлагуудад, Банкны ёр барагдуулах газрын чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт, Сорьцын улсын хяналтын албаны чиг үүргийг Стандартчилал, хэмжил зүйн газарт, Цөм сүргийн үржлийн төвийн чиг үүргийг орон нуттийн захиргааны байгууллагад тус тус шилжүүлсүгэй.

3

батлах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 236 дугаар тогтоол, "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв байгуулах тухай" Засгийн газрын 2005 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 160 дугаар тогтоол, "Төв байгуулах тухай" Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 37 дугаар тогтоол, "Малын үдмын сангийн үндэсний төв, цөм сүргийн үржлийн төв байгуулах тухай" Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 172 дугаар тогтоолын 2, 3, 4 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд *С.БАЯР*

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга *Б.ДОЛГОР*

Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГИЙН ЖАГСААЛТ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд	-Тагнуулын ерөнхий газар -Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо -Цэмийн энергийн газар -Төрийн өмчийн хороо -Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газар	
Төрүүн шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Шударга ёсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар -Стандартчилал, хэмжил зүйн газар	-Оюуны өмчийн газар -Улсын бүртгэлийн ерөнхий газар
Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар -Онцгой байдлын ерөнхий газар	-Хүүхдийн төлөө газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		-Удирдлагын академи -Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар -Гадаадын төрөнгө оруулалтын газар
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Гаалийн ерөнхий газар -Татварын ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Цагдаагийн ерөнхий газар -Хил хамгаалах ерөнхий газар	-Архивын ерөнхий газар -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар -Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Ойн газар -Усны газар -Цаг уур, орчны шинжилгээний газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	-Зэвсэгт хүчний жанжин штаб	
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Соёл, урлагийн хороо
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Иргэний нисэхийн ерөнхий газар -Төмөр замын газар -Авто тээврийн газар -Авто замын газар -Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Нийгмийн даатгалын ерөнхий газар -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Жижиг, дунд үйлдвэрийн газар -Мал эмнэлэг, үржлийн газар
Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Ашигт малтмалын газар -Газрын тосны газар -Эрчим хүчний газар
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		-Биеийн тамир, спортын газар -Эрүүл мэндийн газар

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 9 дүгээр

Улаанбаатар

сарын 22-ны өдөр

Дугаар 50

хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН

ТӨВ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.5, 14 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэнд, спортын яамны харьяанд "Эрүүл мэндийн хөгжлийн төв"-ийг байгуулсугай. /Энэ заалтыг ЗГ-ын 2015-9-14-ний өдрийн 376-р тогтоолоор өөрчилсөн/

2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, үйл ажиллагааг нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Н.Удвалд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.АЛТАНХУЯГ

Эрүүл мэндийн сайд Н.УДВАЛ

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 09 сарын 28 өдөр Дугаар 3/220 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн хөгжлийн
төвийг байгуулах тухай

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" 14-р тогтоол, Засгийн газрын 2012 оны 9-р сарын 22-ны өдрийн 50 -р тогтоолыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн ажилтны мэдлэг, мэргэжил, мэргэшил болон ур чадварын хөгжлийг дэмжих, эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлэх, шинэ мэдээлэл, мэдлэг үйлдвэрлэх замаар эрүүл мэндийн салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж үнэтэй хувь нэмэр оруулах үүрэг бүхий Эрүүл мэндийн хөгжлийн төвийг байгуулсугай.

2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг нэгдүгээр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр Чулуунбат овогтой Бат-Эрдэнийг 2012 оны 9-р сарын 28-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

4. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ч.Бат-Эрдэнэд ажил хүлээлцэх комиссыг энэ тушаалын гуравдугаар хавсралтаар батлалсугай.

2012 оны 328 дугаар тушаалаар
Хэд хэдэн хүний үүрэг биелэх.

001055

5. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрмийг боловсруулж Эрүүл мэндийн сайдын эвлэлийн хуралд 2012 оны 10 дугаар сарын 27 –ны дотор оруулж батлуулахыг Эрүүл мэндийн төвийн захирал Ч.Бат-Эрдэнэд даалгасугай

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн яаманд болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв руу шилжин ажилах ажилтнуудын шилжүүлэг, бүтцийн өөрчлөлт, ажлын байрны давхардлаас болж ажлын байргүй болсон ажилтнуудын тэтгэмжийн асуудлыг зохих хууль, журмын дагуу шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Ж. Хатанбаатар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Ч. Бат-Эрдэнэд даалгасугай.

7. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Ж.Хатанбаатарт даалгасугай.

САЙД Н.УДВАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 376 | Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн хөгжлийн төв байгуулах тухай" Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 50 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг "Эрүүл мэнд, спортын яамны харьяанд "Эрүүл мэндийн хөгжлийн төв"-ийг байгуулсугай." гэж өөрчилсүгэй.

2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамбад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.САЙХАНБИЛЭГ

Эрүүл мэнд, спортын сайд Г.ШИЙЛЭГДАМБА

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 01 өдөр | Дугаар А/70 | Улаанбаатар хот

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.4, 1.8 дахь заалт, Донорын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Донорын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтцэд "Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба"-ыг байгуулсугай.

2. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба шинээр байгуулсантай холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зохион байгуулалтын бүтцийг хавсралтаар батлагдсугай.

3. Шинээр алба байгуулагдсантай холбогдуулан төвийн орон тооны хязгаарыг 84 байхаар батлаж, холбогдох зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Эдийн засаг, санхүүгийн хэлтэс (Д.Нарантуяа), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Э.Содномжамц)-д, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой журам, заавар, стандарт, зөвшөөрлийн хуудасны загварыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Амаржаргал)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/21 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

080362

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 15 өдөр | Дугаар А/113 | Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтцэд үйл ажиллагаа явуулж байгаа Эрүүл мэндийн мэдээллийн албыг өргөжүүлэн Мэдээлэл технологийн алба болгон байгуулсугай.

2. Мэдээлэл технологийн алба байгуулж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зохион байгуулалтын чиг үүрэгт нэмэлтээр орох өөрчлөлтийг нэгдүгээр, бүтцийн бүдүүвчийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлуулсугай.

3. Мэдээлэл технологийн алба байгуулагдсантай холбоотойгоор тус төвийн орон тооны хязгаарыг 96 байхаар батлаж, холбогдох зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан), тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн "Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" А/26 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 2.2.2, 7.2 дахь хэсэг, хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

САЙД Ё.ЧИНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 222 | Улаанбаатар хот

АГЕНТЛАГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 183 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.4, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 9.1, Улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг байгуулсугай.

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаарыг 132 байхаар тогтоосугай.

(Энэ заалтад Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

3. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтцийг батлах, үйл ажиллагааг нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд үүрэг болгосугай.

4. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар байгуулагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лаборатори, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалттай холбогдсон чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу шилжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт даалгасугай.

5. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны шаардлагатай зардлыг батлагдсан төсвийн багцаа багтаан шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт"-ын "Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд" гэсэн заалтын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн баганад "25. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар" гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар"-т дор дурдсан агуулгатай 32 дахь заалт нэмсүгэй:

32.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	132

(Энэ заалтад Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Эрүүл мэндийн сайд Т.МӨНХСАЙХАН

0276

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн
ТОГТООЛ

1970 оны 8 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 258 | Улаанбаатар хот

Статистикийн машинт станц байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллагатай хамтарч ажиллах түр улсын төлөөлөгчийн өсөөр ямныхаа дэргэд эмнэлгийн статистикийн машинт станцыг энэ оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн байгуулахыг Эрүүлийг хамгаалах яам /н.ДЭМБЭРЭЛ/-д зөвшөөрсүгэй.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга С.ЛҮВСАН

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын нэгдүгээр орлогч дарга Р.ЦЭРЭНЖАВ

Хуулбар үнэн болохыг анхаар
Эрхлэгч [illegible]

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АРХИВ
Огноо 2020.01.16 № 69
ХУУЛБАР ҮНЭН

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн
ТОГТООЛ

1985 оны 10 дугаар сарын 4-ний өдөр | Дугаар 250 | Улаанбаатар хот

Эрүүлийг хамгаалахын удирдлагын эрдэм шинжилгээний төв байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Эрүүлийг хамгаалах яам /н.НЯМ-ОСОР/-д зөвшөөрөх нь:

а/Анагаах ухааны хүрээлэнгийн эрүүлийг хамгаалахын зохион байгуулалт, хөтөлбөр, байршлын сектор, Эрүүлийг хамгаалах яамны дэргэдэх Эмнэлгийн статистикийн машинт станцыг нэгтгэж батлагдсан орон тоо, цалингийн фондод нь багтаан Эрүүлийг хамгаалахын удирдлагын эрдэм шинжилгээний төв байгуулж ямныхаа харьяанд ажиллуулах;

б/Эрүүлийг хамгаалахын удирдлагын эрдэм шинжилгээний төвд Анагаах ухааны хүрээлэнгээс шилжин очих хэмжээтэй уг ажлаа хийж байх хугацаанд нь авч байсан цалинг нь хэвээр олгож байх.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Статистикийн машинт станц байгуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1970 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 258 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АРХИВ
Огноо 2020.01.16 № 69
ХУУЛБАР ҮНЭН
Т.РАГЧАА

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын орлогч дарга Б.ЦЭДЭВСҮРЭН

10.2 БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ / СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ, НОМ ГАРЫН АВЛАГА, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛУУД (1996-2026)

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ

1994 - 2000 он:

1. Эрүүл мэндийн мэдээллийн удирдлагыг боловсронгуй болгох зарим асуудал, Ш.Оюунбилэг, УФД-02970094
2. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал, К.Тунгалаг, УФД- 02970093
3. Хүн амын өвчлөл, эмнэлгийн тусламжийн бүтэц, К.Тунгалаг, УФД- 02970092
4. Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны удирдлагыг боловсронгуй болгох зарим асуудал, Д.Лхайжав, УФД- 02970092
5. Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, түүнийг компьютерийг ашиглах асуудал, Ч.Нэрмөнх, УФД-02970091
6. Зах зээлийн үеийн хөдөөгийн эмнэлэг, ариун цэврийн тусламж, М.Шагдарсүрэн, И.Бат-Эрдэнэ, Г.Даваажав, УФД- 02970090
7. Ахмадын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн төсөл, настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал хөтөлбөр боловсруулах зөвлөмж, М.Шагдарсүрэн, УФД – 99-00123
8. Эрүүл мэндийн нэгдсэн үйлчилгээний удирдлагыг боловсронгуй болгоход нийт зардлын тооцоог хэрэглэх нь, Ц.Содномпил, Э.Эрдэнэчимэг С.Энхтуяа, УБД 2000-00088
9. Хүн амын эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зарим асуудлууд, Б.Булганчимэг, УБД 2000-00089
10. Хүн амын эрүүл мэндийн мэдээллийн системийн одоогийн байдал, Ц.Содномпил, Б.Булганчимэг, УБД 2000-00090
11. Монгол оронд геронтологи, гериатрийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх үндэслэл, М.Шагдарсүрэн, И.Бат-Эрдэнэ, УБД 2000-00091
12. Монгол улсын настны бүрэлдэхүүн, нийгмийн эрүүл мэндийн байдал, М.Шагдарсүрэн, Л.Ширнэн, И.Бат-Эрдэнэ, Г.Даваажав, УБД 2000-00092
13. Эрүүл мэндийн хүний нөөцийн хуваарилалт, нэг хүнд ногдох зардлаар санхүүжүүлэх аргачлал, К.Тунгалаг, Ц.Содномпил, УБД 2000-00093
14. Хамт олны эрүүл мэнд, Ц.Содномпил, М.Туяа, Э Эрдэнэчимэг, 1997 он
15. Монголын өсвөр үеийхний тамхи таталтын байдал, Ц.Содномпил нарын, 1997 он
16. Монголын өсвөр үеийхний хүчирхийллийн байдалд хийсэн судалгаа, Ц.Содномпил, Ш.Оюунбилэг, Д.Лхайжав, 1997 он
17. Өсвөр үеийнхний эрүүл мэндээ хамгаалах, мэдлэг, зан үйл дадал, хандлага, Ц.Содномпил, Ш.Оюунбилэг, Д.Лхайжав, 1997 он
18. Эрүүл мэндийн үндсэн үйлчилгээний өртөг зардал, К.Тунгалаг, И.Ядамсүрэн, 1998 он
19. Иргэний эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох нь К.Тунгалаг,1998 он
20. Эдийн засгийн үзүүлэлтүүд ба хүн амын эрүүл мэндийн байдлын хоорондын уялдаа, Э.Эрдэнэчимэг, 1998 он

21. Мэдээллийн удирдлагын зарим асуудлууд, эрүүл мэндээ хамгаалахад хамт олны оролцоо, Ц.Содномпил, Ш.Оюунбилэг, М.Туяа, Э.Эрдэнэчимэг, 1998 он
22. Тамхи таталтын тархалтын тухай, К Тунгалаг, Н.Оюунгэрэл, 1998 он
23. Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх үйл ажиллагаа явуулах шалгалтын асуудалд, С.Гансүх, 1998 он
24. Нүдний эвэрлэг бүрхүүлийн эмгэгийн тархалт, урьдчилан сэргийлэх асуудалд, Н.Оюунгэрэл, 1998 он
25. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх тулгамдсан асуудал, Н.Оюунгэрэл, 1998 он
26. Гэмтэл согогийн эмнэлэгт настны нөхөн сэргээх эмчилгээний асуудал, М.Шагдарсүрэн, 1998 он
27. Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн байдал, хүн амын нас баралтын зарим шалтгаан, М.Шагдарсүрэн, 1998 он
28. Монголын өсвөр үеийнхний бэлгийн зан үйлийн зуршил ба хандлага, Ц.Содномпил, Ш.Оюунбилэг, 1999 он
29. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламжийн хангамжийн удирдлага, мэдээллийн тогтолцооны байдал, М.Туяа, Ш.Оюунбилэг, 1999 он
30. Зүрх судасны эмгэгийн халгаат хүчин зүйлсийн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлага, К.Тунгалаг, Ц.Содномпил, 1999 он
31. Амьсгалын замын цочмог халдвар, суулгалт өвчний мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал ашиглалт, цаашдын хэрэгцээ, Ш.Оюунбилэг, М.Шагдарсүрэн, 1999 он
32. Эрүүл мэндийн тогтолцооны үнэлгээ, Б.Булганчимэг, 1999 он
33. Эрүүл мэндийн үндсэн үйлчилгээний удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход зардлын тооцоог хэрэглэх нь Э.Эрдэнэчимэг, С.Энхтуяа, 1999 он
34. Эрүүл мэндийн шинэчлэлийн мэдээлэл, сурталчилгааны кампанит ажлын өмнөх ба дараах судалгаа, Б.Булганчимэг, Т.Болормаа, 1999 он
35. Монгол дахь хүчирхийлэл ба эрүүл мэнд, Ц.Содномпил, 1999 он
36. Өрхийн эмчийн ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох асуудлууд, С.Дуламсүрэн, Б.Цэнгэлмаа, 2000 он
37. Эрүүл мэндийн салбарын шинэчлэл хүн амын ядуу, эмзэг хэсэгт хэрхэн нөлөөлж байгааг хянах судалгаа, Э.Эрдэнэчимэг, 2000 он
38. Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хураамжийн талаар хүн амын ойлголт, хандлага, К.Тунгалаг, Ц.Содномпил, 2000 он
39. ХДХВ/ДОХ/БЗХӨ-ний талаар 15-25 насны залуучуудын мэдлэг, хандлага, дадал, Ц.Содномпил, Н.Оюунгэрэл, 2000 он
40. 15-25 насны залуучуудыг ХДХВ/ДОХ/БЗХӨ-ний талаар мэдлэг, хандлага, дадал Үндэсний судалгаа, Б.Булганчимэг, Н.Оюунгэрэл, 2000 он
41. Хэвлэл, мэдээллийн хэрэглэлт болон эрүүл мэндийн салбарын шинэчлэлд хүмүүсийн хандах хандлага, Б.Булганчимэг, Т.Болормаа бусад, 2000 он
42. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ажилчдын хөдөлмөрийн нөхцлийг мэргэжлийн өвчлөлтэй холбон судалсан нь Д.Болдмаа, 2000 он
43. Настны эрүүл мэндийн үнэлгээ, Л.Ширнэн, М.Шагдарсүрэн, 2000 он
44. Архины хэрэглээний байдал, К.Тунгалаг, 2000 он
45. Ахмад настны бүтэц, нийгмийн асуудал, М.Шагдарсүрэн, И.Бат-Эрдэнэ, 2000 он
46. Ахмад настны хүнсний бүтээгдэхүүн, хэрэглээ М.Шагдарсүрэн, 2000 он
47. Эмнэлгийн тусламжийн хэрэглээ, хүн амын нас хүйсийн бүтэц, К.Тунгалаг, 2000 он
48. Үр хөндөлт, хүсээгүй жирэмсэлт, Б.Булганчимэг, Ч.Оюун, 2000 он
49. Эцэг эх, багш нарын, сурагчдын эрүүл мэндийн хичээлийн талаарх хандлага, хэрэгцээний судалгаа, Б.Булганчимэг, 2000 он
50. Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, эрдэм шинжилгээ-практикийн хурал /илтгэлийн хураангуй,ЭМУМБТ, 2000,Улаанбаатар,65х, С.Дуламсүрэн
51. 0-3 насны хүүхдийг чийрэгжүүлэх зуны зусланд оролцогч эцэг, эхийн мэдлэг, хандлага,дадлын судалгаа, Б.Булганчимэг, 2000 он
52. Монголын хүүхэд эмэгтэйчүүд /Нөхцөл байдлын дүн шинжилгээ/, С.Дуламсүрэн, НҮБ-ын Хүүхдийн сан, 2000, Улаанбаатар, Бүлэг 4. Эмэгтэйчүүд хүүхдийн эрүүл мэндийн байдал, х 51-61

2001 - 2006 он:

53. Хүн амын эмзэг хэсгийн эрүүл мэндийн үнэлгээ, эрүүл мэндийн анхны тусламж, Л.Ширнэн, И.Бат-Эрдэнэ, УБД 2002-00078

54. Монгол улс дахь хүсээгүй жирэмслэлт ба үр хөндөлт, Б.Булганчимэг, Ч.Оюун
55. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн салбар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх, Т.Болормаа, 2001 он
56. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны өнөөгийн байдал цаашдын зорилт, өгүүлэл С.Дуламсүрэн ба бусад, Нийгмийн эрүүл мэнд шинэ мянганд, ЭМЯ,НЭМХ,2001, х 64-77
57. Мал амьтнаас хүнд халдах өвчний талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлага, И.Бат-Эрдэнэ, Б.Булганчимэг, 2001 он
58. Монголын өсвөр үеийнхний бэлгийн эрүүл мэндийг нийгмийн болон соёлын асуудалтай холбон судалсан нь, Ч.Оюун, Ч.Батнасан бусад, 2001 он
59. Ахмад настны эрүүл мэнд нийгмийн асуудал болох нь, С.Дуламсүрэн бусад, ЭМЯ,НЭМХ, 2001, х 120-127
60. Эрүүл мэндийн удирдах ажилтны сургалтын хэрэгцээ, И.Бат-Эрдэнэ, Н.Оюунгэрэл, 2001 он
61. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хэрэгцээ, Т.Болормаа, 2001 он
62. Солонгос улсад амьдарч байгаа монгол иргэдийн эрүүл мэндийн судалгаа, Ц.Содномпил, Б.Булганчимэг, 2001 он
63. Цэргийн албан хаагчдын архи тамхины талаарх мэдлэг, хандлага, дадал, Б.Булганчимэг, 2001 он
64. 0-8 насны хүүхдийн асран хамгаалахуй, Л.Ширнэн, Д.Чимэддолгор, Я.Гантөмөр, 2002 он
65. Аймаг дүүргүүдийн удирдлагуудын өрхийн эмнэлгийн талаарх мэдлэг, хандлага, С.Дуламсүрэн, Н.Оюунгэрэл, Л.Ширнэн
66. Аймаг дүүргийн удирдлагуудын өрхийн эмнэлгийн тогтолцооны талаархи мэдлэг, хандлага судалгаа,С.Дуламсүрэн, 2002, Улаанбаатар, АХБ-ЭМЯ, ЭМХХ-2 төсөл
67. ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх ажлын байран дахь сургалт, сурталчилгааны үр дүн, С.Дуламсүрэн, Л.Ширнэн, 2002 он
68. Эрүүл мэндийн мэргэжлийн хүн хүчний үнэлгээ, Т.Болормаа, Б.Булганчимэг, С.Энхтуяа, Б.Нансалмаа, 2002 он
69. Хүний нөөцийн хангамж ба мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн зарим асуудал, Д.Энхтуяа, 2002 он
70. Монголын өсвөр үеийнхний эрүүл мэнд ба хөгжил, Ш.Оюунбилэг, Н.Сүмбэрзул, 2002 он
71. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын удирдлагын үйл ажиллагаа болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг, ЭМУ алба, 2002 он
72. Өсвөр үеийн эрүүл мэндийн үйлчилгээг тодорхойлох нь, С.Энхтуяа, Б.Нансалмаа, Н.Оюунгэрэл, 2002 он
73. Нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийн зарим асуудлууд, К.Тунгалаг, Н.Оюунгэрэл, 2002 он
74. Өсвөр насны жирэмслэлт, Н.Оюунгэрэл, 2002 он
75. Эрүүл мэндийн мэргэжлийн хүн хүчний хэрэгцээ, Т.Болормаа, С.Энхтуяа, 2002 он
76. Гэр бүлийн эрүүл мэнд,С.Дуламсүрэн, Өнөөгийн Монголын гэр бүлийн хөгжлийн чиг хандлага сэдэвт онол-практикийн хурлын илтгэлийн эмхэтгэл, х 86-95, 2002,Улаанбаатар
77. Монголын хүүхэд эмэгтэйчүүд /Нөхцөл байдлын дүн шинжилгээ/, С.Дуламсүрэн, НҮБ-ын Хүүхдийн сан, 2000, Улаанбаатар, Бүлэг 4. Эмэгтэйчүүд хүүхдийн эрүүл мэндийн байдал, х 51-61
78. Монголын өсвөр үеийн бэлгийн эрүүл мэнд, БЗДХ-аас сэргийлэх зарим асуудал, С.Дуламсүрэн бусад, Эрүүл мэндийн технологийн үнэлгээний Олон улсын байгууллагын 19-р их хурлын илтгэлийн хураангуй, 2003, Канадын Алберта муж Канморе хот.
79. Ахмад настны эрүүл мэндийн боловсрол, М.Шагдарсүрэн, Л.Ширнэн, Г.Даваажав, 2003 он
80. Эмнэлгийн мэргэжилтний ажил үүргийн шинжилгээ, Ш.Оюунбилэг, Л.Ширнэн, 2003 он
81. Эмнэлгийн мэргэжилтний өсөлт хөгжил, ажлын үнэлэмж, Ш.Оюунбилэг, Л.Ширнэн, 2003 он
82. Дотоод шилжих хөдөлгөөн ба түүний нийгмийн эрүүл мэндийн үр дагавар, Н.Удвал, Б.Булганчимэг, 2003 он
83. Determinants of Adolescent Sexual Health and STI prevention in Mongolia, Improving Outcomes through Health Technology Assessment, Epidemiologic study paper to ISTAHC, 2003, 19th Annual meeting presentation, S.Dulamsuren, Lory Laing and Amanda Roberts;
84. Клиникийн нэгдүгээр эмнэлэг дээр хэрэгжсэн төлбөрт үйлчилгээ хавсарсан төлбөрийн аргын үнэлгээ, Б.Булганчимэг, 2003 он
85. Монголын өсвөр үеийн бэлгийн эрүүл мэнд, БЗДХ-аас сэргийлэх зарим асуудал, С.Дуламсүрэн, 2003 он
86. Резидентурын сургалтын байдпыг судалсан нь, С.Өлзийсайхан, Ц.Уранчимэг, 2003 он
87. Монгол улсын эмнэлгийн удирдах ажилтнуудын удирдлагын мэдлэг, ур чадвар, И.Бат-Эрдэнэ, С.Дуламсүрэн бусад, 2004 он

88. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн дунд хугацааны төлөв байдал, И.Бат-Эрдэнэ, С.Дуламсүрэн, 2004 он
89. Багийн бага эмчийн сургалтын хэрэгцээ, Ш.Оюунбилэг, Л.Ширнэн, 2004 он
90. Эрүүл аж төрөх зан үйлийн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлага, В.Гармаа, М.Шагдарсүрэн, 2004 он
91. Иргэдийн эрүүл мэндийн боловсролд зориулсан мэдээлэл, сурталчилгааны хүртээмж, хэрэгцээ, В.Гармаа, М.Шагдарсүрэн, 2004 он
92. "Ийм зан үйл тохиолдоно гэж бодсонгүй" Монгол улсын өсвөр үеийнхний жирэмслэлтийн үнэлгээ, Д.Болорчимэг, Н.Оюунгэрэл, 2004 он
93. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл ба түүний эрүүл мэндийн үр дагавар, Ш.Оюунбилэг, Н.Удвал, 2004 он
94. Ерөнхий мэргэжлийн сувилагчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн шалгалтыг боловсронгуй болгох асуудалд, Г.Алимаа, 2004 он
95. Эмч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын байдлыг судалсан нь, Ц.Уранчимэг, 2004 он
96. Эрүүл мэндийн хоёрдогч шатлалын эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн харьцуулсан судалгаа, Д.Болорчимэг, бусад, 2005 он
97. Эмч нарын мэргэжил дээшлүүлэлт, Л.Ширнэн, С.Өлзийсайхан, 2005 он
98. Төгсөлтийн дараах сургалтын үнэлгээ, Л.Ширнэн, Н.Нарангэрэл, 2005 он
99. Төгсөлтийн дараах сургалтын өнөөгийн байдал, мэргэжлийн хэрэгцээ судалгаа, С.Дуламсүрэн, ЭМХҮТ,ДЭМБ, 2005, Улаанбаатар
100. Эмнэлгийн удирдлагын сургалтын үр дүн, цаашдын хэрэгцээ, Л.Ширнэн, Б.Булганчимэг, 2005 он
101. НҮЭМ-ийн талаарх эрэгтэйчүүдийн мэдлэг, хандлага, дадал, Н.Дэмбэрэлсүрэн, Л.Оюун бусад, 2005 он
102. Peer- review of 7 manuscript for Asia Pacific Family Medicine journal, 2001-2005,Certificate of Appreciation from AFFM Journal, 2005, Kyoto, Japan
103. Сургуулийн насны хүүхдийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох нь В.Гармаа, Ч.Батнасан, бусад 2005 он
104. Хүүхэд залуучуудын Нөхөн үржихүйн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, Канад улсын Альбертийн их сургуулийн багш нар, Л.Оюун, бусад, 2005 он
105. 0-16 насны хүүхдийн хордлогын төлөв байдал, Ө.Баяр бусад, 2005 он
106. Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн тусламжийн түвшин, С.Дуламсүрэн, бусад, 2005 он
107. Aconitum and Delphinium –ын төрлийн зарим зүйл ургамлын дитерпены алкалоидын фитохимийн судалгаа, Ш.Энхзаяа
108. Эмнэлгүүдийн удирдах ажилтны арга барил, манлайлал чадавхи, Л.Ширнэн, 2006 он
109. Эрүүл мэндийн удирдах ажилтны мэргэжил олгох сургалтын үр дүнгийн үнэлгээ Б.Булганчимэг, Л.Ширнэн, 2006 он
110. Эмнэлгийн удирдлага, эрүүл мэндийн удирдлагын гарагийн сургалтын хэрэгцээг тогтоох судалгаа, Н.Нарангэрэл, Л.Ширнэн, Ш.Ганбат, 2006 он
111. Гамшиг, ослын үед эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах чадавхи Л.Ширнэн, Ө.Баярмаа, 2006 он – Монгол улсын гамшигтай тэмцэх, сэргийлэх стратеги төлөвлөгөө гарсан
112. Эрүүл мэндийн салбарын хөгжил-2 төслийн гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх суурь үзүүлэлтийн судалгаа, Н.Нямхорол, Д.Баясгалан, Б.Чулуунзагд, Ц.Ганчимэг, 2006 он
113. Авилгын цонхоор эрүүл мэндийн салбарыг харахад, Ч.Оюун, Л.Ширнэн, 2006 он

2007- 2011 он:

114. Эрүүл мэндийн технологийн өнөөгийн байдал, С.Дуламсүрэн, Б.Бурмаа, Л.Ширнэн, Н.Нарангэрэл бусад УБД 2007-00048
115. Эрүүл мэндийн технологийн талаар төрөөс баримтлах бодлогын үндэслэл, зөвлөмж, Н.Жаргалсайхан, С.Дуламсүрэн, Б.Бурмаа, Л.Ширнэн, 2007 он
116. Улаанбаатар хотод бүртгэгдсэн вирүст гепатитын дэгдэлтийг судалсан нь, Д.Баясгалан бусад, 2007 он
117. Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний 2 дахь илтгэл,Судлаач С.Дуламсүрэн, Зорилго 4,5,6. Зорилт 8-11.х 42-55,НҮБ ХХ, СЭЗЯ, 2007,Улааанбаатар, х 41-55
118. Шувууны томуу, томуугийн цар тахлын бэлэн байдлыг хангахад шийдвэр гаргагчдын мэдлэг, хандлага ба үүрэг оролцоо, Л.Ширнэн, Ч.Оюун, 2007 он
119. Өрхийн эмнэлгээр үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээ, С.Дуламсүрэн ба бусад, Хөгжиж буй

орнуудын нийгмийн эрүүл мэндийн асуудлууд, НЭМХ, ДЭМБ,Улаанбаатар, 2008, х38-40

120. Өрх сумын эмнэлгийн түвшинд нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, Ц.Содномпил, Л.Ширнэн, 2008 он
121. Монгол улс дахь эмийн хордлогын төлөв байдал, Ө.Баяр, Э.Азжаргал, 2008 он
122. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ажилчдын эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны хэрэгцээ, Б.Байгалмаа, Б.Сувд, 2008 он
123. Шувууны томуугийн мэдээлэл сургалт, сурталчилгааны материалын тандалт судалгаа, Г.Ганчимэг, 2008 он
124. Эмнэлгийн ажилтнуудын гарын ариун цэврийн судалгаа, Г.Ганчимэг, М.Цолмон, Б.Төмөрбат, 2008 он
125. Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн нөхцөл, О.Чимэдсүрэн, Э.Золжаргал бусад, 2008 он
126. Эрүүл Монгол хүн Үндэсний хөтөлбөрийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны кампанит ажлын хүртээмж, үр дүн, Б.Майцэцэг, 2008 он
127. Эмнэлгийн мэргэжилтний зайн сургалтын байдал, Д.Энхтуяа, 2008 он
128. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2009 он
129. Quality in health care and accreditation,С. Дуламсүрэн, С.Гансүх, Н.Жаргалсайхан, Г.Ганчимэг, 2008 он
130. Mapping of public health research in Mongolia, 2004-2007 Л.Оюунаа бусад, 2008 он
131. Монгол улсын харилцаа холбооны зохицуулах хорооны хүний нөөцийн хөгжилд хийсэн судалгаа, Г.Ганчимэг бусад, 2009 он
132. Дадлагжигч их эмчийн ажиллах журмын хэрэгжилтийн байдал, Л.Авирмэд, Н.Нарангэрэл, Л.Ширнэн, Г.Ганбаатар бусад, 2009 он
133. Technical assistance projects of ADB on awareness and prevention of HIV/AIDS and human trafficking, 2005-2009, S.Dulamsuren
134. Mid Term Review and end evaluation of the Second health sector development project, funded by ADB in 2006-2009, S.Dulamsuren
135. Current situation of Health Technology, Presentation paper to 6th Annual meeting of HTAi, Singapore, 2009, S.Dulamsuren and others, AAMS, Vol 38, p63
136. Өрхийн эмнэлгээр үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ, Г.Дашзэвэг, С.Дуламсүрэн, Л.Ширнэн, 2009 он
137. Өрхийн эмнэлгүүдийн магадлан итгэмжлэгдсэн байдал, Ц.Дариймаа, Г.Оюунцэцэг, 2009 он
138. Аюурвэдийн доторх найман гишүүнтийн судалгааны асуудалд, Ш.Энхзаяа, бусад, 2009 он
139. Иргэдийн эмийн хэрэглээний байдал, Д.Уранчимэг, 2009 он
140. Эрүүл мэндийн технологийн одоогийн байдал, ЭМТҮ-ний Олон улсын Нийгэмлэгийн 6-р хурал, Сингапур, 2009, Даяаршил ба ЭМТҮ, илтгэлүүдийн хураангуй, х63, С.Дуламсүрэн ба бусад
141. Challenges in quality manager turnover at healthcare facilities of Mongolia, Г.Ганчимэг бусад, 2009 он
142. Increasing male involvement in reproductive health through the implementation of behavior change communication strategy, Л.Оюунаа, Ө.Энхмаа бусад, 2009 он
143. Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдал, Л.Ширнэн, С.Энхтуяа бусад, 2009 он
144. Клиникийн эмнэлгийн менежмент, Л.Ширнэн, А.Бархас, 2009 он
145. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2010 он
146. Baseline Knowledge, Attitude and Practice (KAP) survey on social protection, health seeking behaviour and healthy lifestyle among disadvantaged groups, JFPR 9115– MON TA project funded by ADB, 20108 S.Dulamsuren
147. Эрүүл мэндийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, Н.Сэвжид, Л.Ширнэн, 2010 он
148. The survey on “The mother’s knowledge, attitude and practice on feeding for children in early ages” Project “Reducing Persistent Chronic Malnutrition in children under 30 months of Mongolia funded by Japanese Fund Poverty Reduction”, ADB, 2010, S.Dulamsuren
149. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын бодлогын хэрэгжилт, Л.Ширнэн, Н.Сэвжид, Г.Ганчимэг, Т.Ариунтуяа, 2010 он
150. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарын

зарим асуудлууд, Т.Өнөрцэцэг, Л.Ширнэн, Б.Сансармаа, 2011 он

151. Эрүүл мэндийн салбар дахь албан бус төлбөр, Т.Өнөрцэцэг, Л.Ширнэн, 2011 он
152. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын Үйлчүүлэгч-Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, 2011 он
153. The Final Evaluation, Forth Country Programme of Cooperation for 2007-2011 years, UNFPA, 2011
154. End Evaluation, Telemedicine support on Maternal and Newborn Health in remote provinces of Mongolia project, UNFPA, 2011, S.Dulamsuren

2012- 2016 он:

155. Гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл ажиллагааны өнөөгийн байдал, Ш.Энхзаяа, 2012 он
156. Улаанбаатар хотын эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж. Нөхцөл байдлын дүн шинжилгээ, 2012, Улаанбаатар, ЭМЯ,АХБ,ЯБЯС, МОН-9115 төсөл, Судалгааны багийн ахлагч,С.Дуламсүрэн
157. Зүрх судас, хавдар, чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрсдэлт зан үйлийг бууруулахад өрхийн эрүүл мэндийн төвийн үүрэг, оролцоо, С.Дуламсүрэн, Н.Ширнэн, Н.Сэвжид, Т.Өнөрцэцэг, 2012 он
158. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэг, хандлага, дадал ба эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэгчдийн хандлагыг тодорхойлох" судалгаа, ММСС, ШНЭМН, 2012, Улаанбаатар / Судалгааны багийн ахлагч С.Дуламсүрэн /
159. Гадаадад эмчлүүлэгчдийн судалгаа, Т.Өнөрцэцэг, Л.Ширнэн, 2012 он
160. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын Үйлчүүлэгч-Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, Л.Ширнэн, бусад 2012 он
161. ЭМЯ-ны харьяа байгууллагуудын тусламж, үйлчилгээний хүлээгдэл, Л.Ширнэн, Н.Сэвжид, Б. Сансармаа, бусад 2012 он
162. Бизнесийн байгууллагын санхүүгийн мэдээлэл боловсруулалт, Л.Мөнхбаяр, 2012 он
163. Арилжааны банкны хөрөнгийн хөрвөх чадвар, Л.Мөнхбаяр, 2012 он
164. Эрүүл мэндийн байгууллагуудын орны ашиглалт, хэрэгцээ, Л.Ширнэн, Н.Сэвжид, Т.Өнөрцэцэг бусад, 2013 он
165. Эрүүл мэндийн ажилтныг хариуцлагын даатгалд хамруулах шаардлагатай эрсдэлийн үнэлгээ, Л.Ширнэн, Н.Сэвжид, 2013 он
166. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл, алдаа зөрчил, Ч.Бат-Эрдэнэ, 2013 он
167. Эмнэлгийн тоног төхөөрөмжтэй холбоотой стандартын судалгаа, Б.Сансармаа, 2013 он
168. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тохируулгад ашиглаж буй хэмжих хэрэгсэл ба багаж төхөөрөмжийн судалгаа, Б.Сансармаа, 2013 он
169. Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилчдын судалгаа, Б.Сансармаа, 2013 он
170. Тендерээр нийлүүлэгдэж буй эмийн үнэ болон худалдаж авах ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, Б.Мөнх-Од, 2013 он
171. Эрүүл мэндийн ажиллах хүчний байршил, хангамж ба хэрэгцээ, Ч.Бат-Эрдэнэ, Л.Ширнэн, Н.Сэвжид, Т.Өнөрцэцэг, 2014 он
172. Гадаадад эмчлүүлэх шаардлагатай иргэдийн судалгаа, Л.Ширнэн, П.Эрхэмбаяр, Э.Ундармаа, бусад 2014 он
173. Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтаны судалгаа, Л.Ширнэн, бусад 2014 он
174. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, 2014 он, А.Мөнхсолонго, Ц.Мөнх-Од, бусад 2013 он
175. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний өртөг, Б.Доржмягмар, 2014 он
176. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн чадамжийн индекс, Л.Ширнэн, 2014 он
177. Эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдал ба эрүүл мэндийн даатгалын байгууллагын оролцоо, Л.Ширнэн, Н.Оюунгэрэл, Б.Нансалмаа, 2014 он
178. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, түгээлт, санхүүжилттэй холбоотой бодлого, хууль эрх зүйн орчин, Л.Ширнэн, Т.Өнөрцэцэг, 2014 он
179. Түргэн тусламжийн үйлчилгээ ба тулгамдсан асуудлууд, Ч.Бат-Эрдэнэ, 2014 он
180. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажилчдын сэтгэл ханамж, Э.Ундармаа бусад, 2014 он
181. Уламжлалт анагаах ухааны судалгааны өнөөгийн байдал, Э.Мөнх-Од, 2014 он
182. Нас баралт, хоног болоогүй нас баралтын шалтгаан, П.Эрхэмбаяр, 2014 он
183. Глауком өвчний үед төлбөрийг төр хариуцан үнэ төлбөргүй олгох эмийн хэрэгцээ, Т.Өнөрцэцэг, Л.Ширнэн, 2014 он

184. Зам тээврийн ослын үед жолооч нарын анхны болон амилуулах тусламж үзүүлэх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгаа, Б.Майцэцэг, Ж.Амарзаяа, 2014 он
185. Эмнэлгийн яаралтай тусламжийн сургалтын үр дүн, чанарын үнэлгээ, Б.Майцэцэг, Ж.Амарзаяа, 2014 он
186. Зүрхний холтер хяналтын оношилгооны түвшинг дээшлүүлэх судалгаа, Б.Батцэнгэл, 2015 он
187. Төрийн байгууллага дахь бүтцийн өөрчлөлт, төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд нөлөөлөх нь, Ц.Одончимэг, 2015 он
188. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон төлбөрийг төр хариуцан үнэ төлбөргүй олгох эмийн хэрэгцээ, Т.Өнөрцэцэг, Л.Ширнэн, 2015 он
189. ЭМСЯ-ны харьяа байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа-2015 он, Л.Ширнэн, Т.Өнөрцэцэг, 2015 он
190. Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн үнэлгээ, Л.Ширнэн, Б.Доржмягмар, Б.Энхцэцэг, 2015 он
191. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, Ц.Амаржаргал, 2015 он
192. Нялхсын эндэгдлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс, Ч.Бат-Эрдэнэ, Л.Ширнэн, Н.Нарангэрэл бусад, 2015 он
193. Эрүүл мэндийн байгууллагын статистикч эмч нарын байршил, хангамж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэгцээний өнөөгийн байдал, С.Даваажаргал, Х.Нарантуяа, Д.Уранчимэг, Д.Алтанцэцэг, 2015 он
194. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгаа, Б.Батцоож, 2015 он
195. Амбулаториор үнэ төлбөргүй олгодог эмүүдийн судалгаа, Б.Хишигжаргал, С.Мөнхбат, Р.Цэрэнлхагва, 2015 он
196. Антибиотекийн судалгаа, Ш.Энхзаяа, 2015 он
197. Эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл зүйн ачаалал, дарамт нь хариуцлагад нөлөөлөх нь, Л.Ширнэн, 2016 он
198. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгцээ, боломж, Б.Доржмягмар, 2016 он
199. Сумын эрүүл мэндийн төвийн хүний их эмчийн чадамж, Ц.Амаржаргал, 2016 он
200. Барилгын ерөнхий болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн газардуулгын судалгаа, Б.Батцоож, 2016 он
201. Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийгдэж буй өнөөгийн нөхцөл байдлыг судлах нь, Б.Санж-Очир, Р.Энхсүрэн, 2016 он
202. Хонины сүүлний тосоор индометацинтай тосон түрхлэг хийх технологийн судалгаа, З.Хулан, 2016 он
203. Элэг шилжүүлэн суулгах технологийн үнэлгээ, С.Түмэнбаяр, 2016 он
204. Монгол улсад ашиглагдаж буй зүрхний цахилгаан бичлэгийн аппаратуудын шалгалт, тохируулгын судалгаа, Б.Батцоож, 2016 он
205. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 2011-2015 оны мэдээнд хийсэн дүн шинжилгээ. Б.Норолхоосүрэн, 2016 он.
206. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллаагааны гүйцэтгэлийн өнөөгийн байдлыг олон улсын туршлагатай харьцуулсан судалгаа. Б.Ганчулуун, 2016 он.
207. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын санхүүжилт. Т.Өнөрцэцэг, Ц.Цолмонгэрэл, 2016 он.
208. Концессын төслийн зардал, үр ашгийн шинжилгээ, Б.Доржмягмар, 2016 он.
209. Өрхийг санхүүгийн сүйрэлд оруулах эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр. Б.Доржмягмар, 2016 он.

2017-2026 он:

210. ЭМСЯ-ны харьяа байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа – 2016. Ц.Амаржаргал, Б.Ганчулуун, 2017 он.
211. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, эрэлт хэрэгцээний судалгаа. Ц.Амаржаргал, 2017 он.
212. Удирдах ажилтны сургалтын хэрэгцээ тогтоох судалгаа. Б.Ганчулуун, 2017 он.
213. Ортой хувийн эмнэлгүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгцээний судалгаа. Б.Доржмягмар, 2017 он.
214. Нэгдсэн худалдан авалтаар нийлүүлж буй эмийн үнийн судалгаа. Д.Бямбадорж, 2017 он.
215. Урьдчилан сонголт бүхий ерөнхий гэрээгээр эм худалдан авах ажиллагааны зах зээлийн судалгаа. Д.Бямбадорж, 2017 он.
216. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн

эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагааны үнэлгээ. Б.Сансармаа, Ц.Уянга, Р.Энхсүрэн, Б.Санж-Очир, Б.Батцоож, 2017 он.

217. БЗДХӨ/ХДХВ/ДОХ-ын мэдээллийн тогтолцооны дүн шинжилгээ. Х.Нарантуяа, 2017 он.
218. Хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлын судалгаа. Р.Энхсүрэн, 2017 он.
219. Элэгний өвчлөл, нас баралтад хийсэн тархварзүйн судалгаа 2016, 2017 он. Б.Нарантуяа, Б.Норолхоосүрэн, 2017 он.
220. Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэл, Б.Доржмягмар, 2017 он.
221. Амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, түүнд нөлөөлж буй зарим хүчин зүйлийн судалгаа. Л.Ундрам, Н.Цэндмаа, 2017 он.
222. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, стратегиудын давхцал. С.Мөнхдэлгэр, 2017 он.
223. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн байршил, хангамж, хөгжилийг төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түвшинд харьцуулсан судалгаа. Ц.Амаржаргал, Д.Дондогмаа, 2018 он.
224. Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээний орны хуваарилалт, орны хэрэгцээ, орны ашиглалт. Б.Доржмягмар, Э.Энхцэцэг, 2018 он.
225. Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн үзүүлэлт-2017. Б.Батдэлгэр, 2018 он.
226. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний алдаа, зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо, бодлогын хэрэгжилт, түүний үр дүнг төр-хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түвшинд харьцуулсан судалгаа. Л.Бор, Ц.Амаржаргал, 2018 он.
227. 2017 онд магадлан итгэмжлэгдсэн нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын төлөв байдалд хийсэн дүн шинжилгээний тайлан. Н.Нарангэрэл, 2018 он.
228. Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа. Э.Ундармаа, П.Мидриймаа, Н.Цэндмаа, 2018 он.
229. Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн тогтолцоо, бодлогын хэрэгжилт, түүний үр дүнг төр-хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түвшинд харьцуулан судалгаа. Э.Батжаргал, Л.Бор, 2018 он.
230. "Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагаатай танилцах" ажлын хэсгийн нэгдсэн тайлан. Б.Сансармаа, 2018 он.
231. Хоёр, гурав дах шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа агааржуулалтын системийн өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлагын судалгааны тайлан. Р.Энхсүрэн, 2018 он.
232. Антибиотикийн хэрэглээ ба нянгийн тэсвэржилтийн судалгаа. Л.Бор, 2019 он.
233. Эрүүл мэндийн байгууллагын орны тоог тасаг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан төлөвлөх нь судалгаа. Э.Энхцэцэг, 2019 он.
234. Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа – 2018. Н.Сэвжид, П.Мидриймаа, Ц.Тунгалагтамир, 2019 он.
235. Сургуулийн өмнөх насны хүүхдийн амьсгалын замын өвчлөл. Ц.Бадамхатан, 2019 он.
236. Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон тухай сүүлийн 5 жилийн судалгаа. Т.Одгэрэл, 2019 он.
237. Эрүүл мэндийн технологийн үнэлгээ, түүний хөгжил . Л.Оюунбилэг, 2019 он.
238. Монгол улсын антибиотикийн хэрэглээний тандалт судалгаа. С.Цэцэгмаа, Э.Эрдэнэчимэг, Д.Гэрэлтуяа, Ч.Амаржаргал, Ш.Энхзаяа, Д.Бямбадорж, Ш.Ариунзаяа, 2019 он.
239. Нялхсын эндэгдэл түүнд нөлөөлөх хүчин зүйлс. Ц.Амаржаргал, 2019 он.
240. Эрүүл мэндийн бодлого ба тогтолцооны судалгаа гэж юу вэ? Яагаад чухал вэ? Ц.Бадамхатан, 2019 он.
241. Багц цаг бүрдүүлэлтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ. М.Баттуяа, М.Номингэрэл, 2019 он.
242. Гадаадад эмчлүүлэгчдийн зардлын судалгаа. Э.Энхцэцэг, 2019 он.
243. Монгол эцэг эхийн боловсрол ба хүүхдийн хөдөлмөр . Ц.Бадамхатан, 2019 он.
244. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн чадамжийг тодорхойлох судалгаа. Ц.Бадамхатан, 2019 он.
245. Эмийн чиглэлээр хэрэгжиж буй хууль, эрх зүйн баримт бичигт хийсэн нөхцөл байдлыг дүн шинжилгээ. Л.Бор, 2019 он.
246. Хүний нөөцийн бодлого зохицуулалтын чиглэлээр хэрэгжиж буй зарим эрх зүйн баримт

бичгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ. Ц.Амаржаргал, 2019 он.

247. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа 2019 он. П.Мидриймаа, Б.Бадамхатан, Н.Нарангэрэл, 2020 он.

248. Монгол улсын антибиотикийн хэрэглээний тандалт судалгаа. Д.Гэрэлтуяа, Д.Бямбадорж, Хеге Салвесен Бликс, Ч.Амаржаргал, Э.Эрдэнэчимэг, Такеши Нишижима, С.Цэцэгмаа, 2020 он.

249. Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн. Б.Мөнхцэцэг, Ч.Мичидмаа, Л.Оюунбилэг, 2020 он.

250. Амьсгалын аппаратын ашиглалтын явцад тулгамдаж буй хэмжил зүйн асуудлууд. Р.Энхсүрэн, С.Эрдэнэтуяа, Д.Пүрэвдаш, 2020 он.

251. Гадаад улсад эмчлүүлсэн монгол иргэдийн зардлын судалгаа – 2020. Э.Энхцэцэг, Б.Доржмягмар, П.Бумцэнд, Д.Даваадулам, 2020 он.

252. 2018-2020 онд элэг, бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ хийгдэх донор реципиентийн хамаарал. П.Батчулуун, П.Мидриймаа, Э.Батжаргал, 2020 он.

253. Сумын эрүүл мэндийн төвийн үр ашгийн тооцоо 2017 ба 2018 он. Л.Оюунбилэг, Ч.Мичидмаа, Э.Энхцэцэг, Жаки Матонатт, Марлене Гуйленеь 2020 он.

254. Багц цаг бүрдүүлэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгуулсан эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэлтэд хийсэн үр дүн. Л.Оюунбилэг, Б.Мөнхцэцэг, Л.Мягмардорж, А.Алтантулга, 2020 он.

255. Тархины донорын илрүүлэг Монгол улсад – 2020. П.Батчулуун, Б.Алтантулга, Г.Батцэцэг, Э.Батжаргал, П.Мидриймаа, 2020 он.

256. Эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалт. Л.Оюунбилэг, 2020 он.

2021-2026 он:

257. Эрүүл мэндийн удирдах ажилтны сургалтын эрэлт, хэрэгцээ тогтоох судалгаа. Л.Бор, Б.Цэцэнбилэг, 2021 он.

258. Тархины үхэлтэй донор илрүүлэг, эрхтэн шилжүүлэн суулгасан тохиолдлын үр дүн. Б.Алтантулга, Г.Батцэцэг, Э.Батжаргал, П.Мидриймаа, 2021 он.

259. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн цаг товлох үйлчилгээний хэрэгжилт, одоогийн байдал. Д.Баттулга, О.Чимэдсүрэн, Г.Лувсанцэрэн, Б.Солонго, Х.Мөнхтуяа, 2021 он.

260. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ. М.Одгэрэл, Л.Бор, Г.Лувсанцэрэн, 2021 он.

261. Хавдрын тусламж үйлчилгээний чиглэлээр хувь хүнээс гарах албан ба албан бус зардлын судалгаа. Д.Баттулга, О.Чимэдсүрэн, Б.Солонго,Г.Лувсанцэрэн, Г.Тунгалагтамир, 2021 он.

262. Эмч, эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн байршил, хэрэгцээний судалгаа. Л.Оюунбилэг, Х.Дэлгэрмаа, Б.Солонго, 2021 он.

263. Эмнэлгүүдийн ор ашиглалтад сүүлийн 10 жилийн байдлаар улсын болон аймаг, нийслэлийн түвшинд хийсэн дүн шинжилгээ. О.Чимэдсүрэн, Т.Учрал, Б.Солонго, Г.Лувсанцэрэн, Г.Тунгалагтамир, Ж.Ундрал, 2022 он.

264. Монгол улсад зонхилон тохиолдож буй хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний шинэ технологийн үнэлгээ, судалгаа. О.Чимэдсүрэн, Г.Тунгалагтамир, , Б.Солонго, Г.Лувсанцэрэн. 2022 он.

265. Тусгай дугаарын утсаар "Эмчийн үзлэгийн цаг товлох" үйлчилгээг үнэлэх судалгаа – 2022. Д.Бямбасүрэн, И.Ариунаа, Н.Энхцэцэг, А.Цэрэннадмид, Б.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр, 2022 он.

266. Хэрэглэгчийн үнэлгээнд хийссэн дүн шинжилгээний тайлан. Л.Бор, Б.Мөнхцэцэг, Ц.Болормаа, 2022 он.

267. Тархины үхэлтэй донор илрүүлэг, эрхтэн шилжүүлэн суулгалтын үр дүн – 2022. П.Батчулуун, Б.Алтантулга, , Г.Батцэцэг, Э.Батжаргал, П.Мидриймаа, Я.Бадамсүрэн, 2022 он.

268. Өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэглээг хүний нөөцийн хангамжтай уялдуулан судалсан байдал. О.Чимэдсүрэн, Т.Учрал, Г.Тунгалагтамир, Б.Солонго, Г.Лувсанцэрэн, Ж.Ундрал. 2022 он.

269. Монгол улсад 2017-2021 онд бүртгэгдсэн хорт хавдрын тархвар зүйн судалгаа. Н.Цэндмаа, 2022 он.

270. Тархины цус тасалдах харвалтын эмгэг загварт хүдрийн заарын үзүүлэх нөлөө. Г.Раднаа, 2022 он.

271. Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр

дагаварт хийсэн үнэлгээ

272. Амьгүй донороос эрхтэн, эд шилжүүлэн суулгуулсан иргэдийн амьдралын чанарын судалгаа. А.Оюунзул, Б.Солонго, Э.Хонгорзул, Б.Алтантулга, Я.Бадамсүрэн, Э.Батжарлаг, П.Мидриймаа, 2023 он.

273. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг хүн амын өвчлөл, тоног төхөөрөмжийн хэрэглээтэй уялдуулан судлах нь. Б.Отгончимэг, Б.Солонго, А.Оюунзул, Э.Хонгорзул, Ж.Ундрал, Ц.Болормаа, 2023 он.

274. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт, нас баралтын шалтгаанд хийсэн дүн шинжилгээ. Ш.Алтанцэцэг, А.Оюунзул, Б.Солонго, Ц.Болормаа, 2023 он.

275. Хүлээх жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн суурь өвчлөлийн судалгааны тайлан. П.Батчулуун. Э.Батжаргал, П.Мидриймаа, 2023 он.

276. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх. “Бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэгдсэн тохиолдлуудын дүн шинжилгээ. Н.Сэвжид, С.Мөнхсүх, С.Лхагвадорж, 2023 он.

277. Хэрэглэгчийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээний тайлан – 2023. Н.Сэвжид, Л.Бор, Ц.Болормаа, 2023 он.

278. Тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллагуудын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Н.Сэвжид, Н.Цэндмаа, 2023 он.

279. Хүн амын нас баралтын бүртгэл, мэдээллийн чанарын (ANACONDA) үнэлгээний тайлан, 2010, 2014-2021 он. Б.Доржмягмар, А.Амарбал, С.Даваажаргал, Х.Дэлгэрмаа, Б.Болдбаатар, Б.Баянжаргал, Б.Отгончимэг, Д.Уранчимэг. 2023 он.

280. Орчны бохирдлын шалтгаант хүн амын өвчлөл, нас баралтын мэдээллийн өнөөгийн байдлыг үнэлэх, чиг хандлагыг тодорхойлсон нь. Б.Доржмягмар, С.Даваажаргал, Г.Ган-Эрдэнэ, Д.Сумъяа, Б.Долгормаа, Г.Урангоо, 2023 он.

281. Магадлан итгэмжлэлийн өнөөгийн байдал, баримтын судалгаа. Н.Сэвжид, Н.Наранцэцэг, Б.Мөнхцэцэг, Б.Мөнхбат, Г.Раднаа, Л.Ширнэн, 2023 он.

282. Замын зураглал: эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх. Н.Сэвжид, Л.Баярцэцэг. 2023 он.

283. Монгол Улсын эрүүл мэндийн үндэсний тооцоо 2016-2022, Ц.Болормаа, Хонгорзул, Г.Ундрал, Ч.Мичидмаа, С.Мөнхсүх, 2024 он.

284. Эрүүл мэндийн зардлаас шалтгаалан санхүүгийн эрсдэлд орсон өрх, иргэдийн тооцоолол – 2022, Ч.Мичидмаа, 2024 он.

285. Өвчлөл, нас баралтаар тэргүүлж буй халдварт бус өвчний тусламж, үйлчилгээний хүртээмжийн байдал, Г.Тунгалагтамир, С.Мөнхсүх, 2024 он.

286. Хэрэхийн гаралтай зүрхний эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийн судалгаа, Ч.Мичидмаа, Г.Хулан, Б.Насантогтох, Ч.Батчингис, С.Даваажаргал, Г.Дамба, Т.Болормаа, 2025 он.

287. Эрүүл мэндийн байгууллагын орны ашиглалтын нөхцөл байдлын дүн шинжилгээ 2021-2023 Г.Тунгалагтамир, Г.Дамба, 2025 он.

288. Салбарын хүний нөөцийн хэрэгцээний судалгаа, Г.Хулан, Ч.Мичидмаа, 2025 он.

289. Хүн амын өвчлөл болон хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөлийн судалгаа, Ч.Батчингис, Ч.Мичидмаа, Г.Тунгалагтамир, Г.Дамба, 2025 он.

НОМ, ГАРЫН АВЛАГА

1996-2000 он:

1. “Сэргээн засах эмчилгээ”. 1996 УБ, Гарын авлага, Д.Бямбадорж, С.Гансүх, Э.Санжаа, Д.Сособарам, Я.Хоролгарав
2. Монгол оронд геронтологи, гериатрийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх үндэслэл, УБД 2000-00091, М.Шагдарсүрэн, И.Бат-Эрдэнэ
3. “Биеийн тамир эрүүл мэнд”,1999 он , ДЭМБ, Га Цэрэндорж, Ц.Март, Д. Байгалмаа, Х.Оюунбилэг
4. Өвчнүүдэд хийх дасгал ,1999 он, УБ, Х.Оюунбилэг
5. Хүүхдийн эрүүл мэнд. 2000 он, Албан бус боловсролын зайны сургалтын “Сурч амьдаръя” төсөл, Гэгээрлийн яам, ЮНЕСКО, Ч.Батнасан, В.Гармаа Д.Ганганоров, Д.Лхайжав ба бусад
6. Эрүүл мэндийн удирдлага сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2000, С.Дуламсүрэн
7. Сургалтын хэрэгцээг тогтоох аргачлал, МННХ, ЭМУМБТ,АУИС, Улаанбаатар, 2000, 88 хуудас, С.Дуламсүрэн Боловсруулсан М.Туяа ба бусад
8. Эрүүл мэндийн хүний нөөцийн хуваарилалт, нэг хүнд ногдох зардлаар санхүүжүүлэх аргачлал, УБД 2000-00093,К.Тунгалаг, Ц.Содномпил

2001-2005 он:

9. “ХДХВ/ДОХ өвчний талаарх мэдээлэл ба сургалт, хүртээмж ба хөгжил” илтгэл, 2001 он, Ч.Оюун, Ч.Батнасан
10. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны арга зүй, /сургалтын гарын авлага ДЭМБ,ЭМЯ,ЭМХҮТ, Улаанбаатар, 2001, 6 хх, С.Дуламсүрэн бусад
11. Монгол улс дахь хүсээгүй жирэмслэлт ба үр хөндөлт, Б.Булганчимэг, Ч.Оюун
12. Ахмад настны эрүүл мэндийг хамгаалахад хамт олны оролцоог идэвхжүүлэх аргазүй, 2001 он, Д.Лхайжав. Ч.Оюун ба бусад
13. “Хамт олны сувилагчдын тасралтгүй сургалтын хөтөлбөр”, 2001 он, С.Дуламсүрэн
14. Монголын Анагаах Ухаан-80, ЭШ-ний Бага хурлын материал, 2001, Улаанбаатар, 1-р бүлэг: Эрүүл мэндийн удирдлага, 4-37-р хуудас, С.Дуламсүрэн
15. Гэр бүл – гал голомт”, 2001 он, Л.Ширнэн. Ч.Оюун. В.Гармаа. Б.Булганчимэг
16. Зүрхээ гамнах таван алхам, 2001 он, В.Гармаа. С.Жавзандулам
17. Та хаяж чадна... 2001 он, ЭМДА-ны мэргэжилтнүүд
18. Өрхийн сувилагч, сум, багийн бага эмч, сувилагч нарт зориулсан сургалтын материал, ЭМЯ, ЭМСХХ, 2001, Модуль 3. Хамт олны эрүүл мэндийн сувилахуй, х 133-170, С.Дуламсүрэн
19. Идэвхтэй хөдөлгөөн – таны эрүүл мэнд. 2002 он, ЭМДА-ны мэргэжилтнүүд
20. “Мэдье оролцьё.. ЭМЯ. ЭМХҮТ. МУИА. Оюутны холбоо. 2002 он, В.Гармаа, Ж.Лхамсүрэн, Ч.Оюун
21. Эрүүл мэнд ба зан үйлийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа.. ДЭМБ. ЭМХҮТ, 2002 он, Д.Жаргалсайхан, Ч.Оюун. В.Гармаа, Д.Ганганоров. Б.Баттөгс, Ө.Энхмаа. Ч.Батнасан, Б.Байгалмаа. Д.Болорчимэг, М.Хишгээ
22. Хүн амын эрүүл мэндийн мэдээллийн системийн одоогийн байдал, УБД 2000-00090, Ц.Содномпил, Б.Булганчимэг
23. Хамт олон эрүүл мэндийн анхан шатны тусламж, НҮБ, ХС, 2002, С.Дуламсүрэн
24. Хүний нөөцийн удирдлага ба хөгжил, Сувилахуйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл,2003, 17-68-р хуудас, С.Дуламсүрэн
25. Магадлан итгэмжлэх лицензийн алба (1999-2002), 2002, Л.Жигжидсүрэн
26. Мэдээллийн цомог.. Австралийн УЗН. МУЗН. ЭТУГ, 2003 он, Ө.Энхмаа
27. ”Эрүүл бие урт нас”, 2003 он УБ, Ц.Март , Ч .Эрдэнэтуяа
28. “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн дунд хугацааны төлөв байдал” 2003 он “Монгол улсын эмнэлгийн удирдах ажилтнуудын удирдлагын мэдлэг, ур чадвар”, И.Бат-Эрдэнэ, С.Дуламсүрэн
29. Монголын өсвөр үеийн бэлгийн эрүүл мэнд, БЗДХ-аас сэргийлэх зарим асуудал, 2003 он, С.Дуламсүрэн
30. Эрүүл мэндийн удирдлага, ЭМЯ,ДЭМБ,ЭТУГ, 2003, Улаанбаатар, Модуль 2,4, С.Дуламсүрэн
31. Эсэн мэнд амаржихад.. ЭТУГ. НҮБ-ын ХАС. Канадын сан, 2004 он, Ө.Энхмаа, Б.Баттөгс, Ц.Марта
32. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл ба түүний эрүүл мэндийн үр дагавар, 2004 он, Ш.Оюунбилэг, Н.Удвал
33. Эрүүл бие –Урт нас, гоо сайхан, 2004 он, Ц.Марта, Ч.Эрдэнэтуяа
34. Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрыг

чийрэгжүүлэх нь, 2004 он ЭТУГ. ДЭМБ, Ц.Март, Д.Болорчимэг

35. Эрүүл мэнд 3, 2004 он Ч.Батнасан. М.Хишгээ
36. Ухуулга сурталчилгаа. 2004 он.ЭМЯ. НҮБ-ын ХАС, С.Дуламсүрэн. Д.Жаргалсайхан. М.Хишгээ
37. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын гарын авлага. 2004 он, ЭМЯ. ЭТУГ, В.Гармаа. Д.Ганганоров. Б.Баттөгс. Ө.Энхмаа. Ч.Батнасан. Б.Байгалмаа. Д.Болорчимэг. М.Хишгээ. Б.Майцэцэг
38. Ye тэнгийн сургагач нарт зориулсан гарын авлага. "Глобаль" сангийн сургуулийн боловсрол дэд төсөл, 2004 он, В.Гармаа, Д.Ганганоров, Б.Баттөгс. Ө.Энхмаа,Ч.Батнасан
39. Гараа зөв угааж хэвшье. 2004 он, ЭМЯ. АХБ. ХӨСҮТ, Д.Нарангэрэл. В.Гармаа. Л.Дашцэрэн
40. БЗДХХДХВ/ДОХ-оос сэргийлэх сургалтын хөтөлбөр. 2004 он, ЭМЯ. БСШУЯ. "Глобаль" сангийн ДОХ-ын төсөл, Боловсролын хүрээлэн, В.Гармаа. Д.Болорчимэг. Глобаль сан "Сургуулийн боловсрол" дэд төслийн багийн гишүүд
41. Ухуулга сурталчилгаа, Гарын авлага, ЭМЯ,НҮБ ХАС, 2004, Улаанбаатар, Бүлэг 2. Асуудлыг тодорхойлж дүн шинжилгээ хийх, х16-26, Бүлэг 13. Ухуулга сурталчилгааны ажлын хяналт үнэлгээ, 130-135. С.Дуламсүрэн
42. Aconitum chasmanthum Stapf. –ын дитерпены алкалоид., Монгол улсын Их сургууль., Байгалийн органик нэгдлийн судлал., х.76-80, Улаанбаатар хот, (2004), Д.Батсүрэн, Дүнгэрдорж, Ш.Энхзаяа, Ж.Тунсаг, Н.Батбаяр.,
43. **Delphinium grandiflorum L.** –ын дитерпены алкалоидын судалгаа.,Эрдэм шинжилгээний бичиг., №7/69, х. 38-43,Улаанбаатар хот , 2004, Ш.Энхзаяа, Д.Батсүрэн, Н.Батбаяр, Ж.Тунсаг, Б.Саранчимэг.,
44. Өсвөр үеийн эрүүл мэнд/эрүүл амьдрах ухаан. 2004 он, ЭМЯ. ДЭМБ, Ө.Энхмаа. М.Хишгээ. Д.Болдмаа. Б.Байгалмаа ба бусад
45. Нийгмийн эрүүл мэнд. 2005 он /боть-1/ ЭМЯ. ЭМСХ-2 төсөл, Д.Болдмаа, Д.Жаргалсайхан. М.Хишгээ, Ө.Энхмаа
46. "Эрчүүдээ эрүүл мэндээ хайрлая" 2005 он, ЭМХҮТ. ГТХА НҮЭМ төсөл. НҮБ-ын ХАС, Ө.Энхмаа
47. Монгол улсын хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын шалгуур үзүүлэлтүүд. 2005 он. МУ-ын ЗГХА БТСУХ, Ц.Марта, Ж.Тунгалаг
48. ЕБС-ийн сурагчдын дунд бэлгийн эрүүл мэндийн чиглэлээр явуулж байгаа үе тэнгийн сургалтын үр нөлөө. 2005 он, ЭМХҮТ. Канад сан, М.Хишгээ
49. Ерөнхий мэдээгүйжүүлэг (хүүхдэд). УБ, Гарын авлага, 2005 он, С. Гансүх
50. "Хөдөөгийн эмнэлгийн мэс заслын тусламж", 2005 он, С.Дуламсүрэн
51. Шинэ нийгмийн эрүүл мэнд XXI зууны удиртгал ном, 2005 онд 65 х.х, С.Дуламсүрэн
52. Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн тусламжийн түвшин, 2005 он, С.Дуламсүрэн, бусад
53. Нийгмийн эрүүл мэндийн суурь сургалтын модуль 2005 он. ЭМЯ. ЭМСХ-2 төсөл, Д.Болдмаа, Д.Жаргалсайхан. М.Хишгээ, Ө.Энхмаа
54. Хорт хавдрын эмийн судалгааны шинэ чиглэл хандлага, 2005, Т.Зориг, Юдит Х

2006-2010 он

55. Гамшгийн үеийн хээрийн эмнэлэг,2006 он, Д.Жаргалсайхан, В.Гармаа
56. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны аргазүй, сургалтын модуль. 2006 он /СД/ ДЭМБ. ЭМХҮТ, М.Хишгээ бусад
57. Хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлье. 2006 он /СД/. ЭМЯ. TICA. ЭМХҮТ, Б.Баттөгс
58. Эрүүл мэнд 5-6. Сурах бичиг. 2006 он БСШУЯ. ЭМЯ, Ч.Батнасан ба бусад
59. Эрүүл мэнд 6. Сурах бичиг. 2006 он БСШУЯ. ЭМЯ, Ч.Батнасан ба бусад
60. For issue of probability research about resourse of raw material which is used in traditional medicine under term as Kan-Ta-Ka-Ri
61. "Сувилахуйн удирдлага ба манлайлал", Л.Ширнэн, Б.Булганчимэг
62. Нийгмийн эрүүл мэнд-Багийн бага эмч, Л.Ширнэн, Б.Булганчимэг
63. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт үндэсний 2 дахь илтгэл, 2007 онд, С.Дуламсүрэн
64. Анагаах мэргэдийн мэргэжил дээшлүүлэлтийн түүхэн замнал, 2007, Л.Жигжидсүрэн
65. Пикетт Хэнлон "Нийгмийн эрүүл мэнд" I, II дэвтэр 75 х.х, 2008 онд, С.Дуламсүрэн
66. Монгол улс дахь эмийн хордлогын төлөв байдал, 2008 он, Ө.Баяр, Э.Азжаргал
67. Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн нөхцөл, 2008 он, О.Чимэдсүрэн, Э.Золжаргал бусад
68. Эрүүл Монгол хүн Үндэсний хөтөлбөрийн

мэдээлэл, сургалт, сурталчилгааны кампанит ажлын хүртээмж, үр дүн, 2008 он, Б.Майцэцэг

69. Quality in health care and accreditation (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар ба магадлан итгэмжлэл), 2008 он, С.Дуламсүрэн, С.Гансүх, Н.Жаргалсайхан, Г.Ганчимэг
70. Статистикч их, бага эмчийн олгох сургалтын хөтөлбөр, 2002-2008 он, Д.Нямхорол
71. The effect of same herbal medicines on blood couglation of rafs with liver cirrhozis, 2008, B.Badamsuren, D.Tserendagva, Kh.Oyuntsetseg, T.Zorig
72. "Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн дасгал хөдөлгөөнүүд" 2009 он, Ж.Тунгалаг, Ц.Март, А.Болдмаа, Х.Бакытжан, Л.Туяа
73. "Идэвхтэй хөдөлгөөн идэвхтэй амьдрал", 2009 он, Ж.Тунгалаг, Ц.Март, Д.Байгалмаа
74. Challenges in quality manager turnover at healthcare facilities of Mongolia, 2009 он, Г.Ганчимэг бусад
75. "Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аргачлал " №1 "ЕБС,сурагчид 9-17 нас", № 2 "Насанд хүрэгчид 15-64", №3 "Сургуулийн өмнөх 3-5 нас Ж.Тунгалаг, Ц.Март, А.Болдмаа, Л.Туяа, Л Алтанцэцэг, Х. Бакытжан, Л.Уртнасан

2011-2016 он:

76. ММСС-ийн Эрүүл мэндийн төсөлтэй байгуулсан артерийн гипертензи, чихрийн шинжин хэв шинж 2, умай хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийг эрүүл мэндийн салбарын тогтолцоонд нэвтрүүлэх гэрээ, 2011-2012 он, Ц.Хандармаа, бусад
77. Эрүүл мэндийг дэмжих гарын авлага, 2010, Ц.Хандармаа бусад
78. Биеийн тамирын багш дасгалжуулагч арга зүйч нарт зориулсан дасгалын гарын авлага, 2013, Х.Оюунбилэг
79. "Байгууллагын оношилгоо" хийх аргачлал нь байгууллагын шилдэг ажил, 2014 он, Л.Ширнэн

СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛ

1. Эрүүл мэнд. /хуанли/. НҮБ-ын ХАС, 2004 он, Ө.Энхмаа, С.Дуламсүрэн. Д.Жаргалсайхан. П.Нямдаваа
2. Нэн чухал эмийн товч лавлах, Б.Оргил, Т.Зориг, УБ, 2004
3. Хуурамч эмтэй тэмцэх арга хэмжээг боловсруулах гарын авлага, 2003, УБ
4. АЦХаХ-аас сэрэмжил 2004 он. /наалт/ ЭТУГ. ДЭМБ,. В.Гармаа
5. АЦХаХ болон гэдэсний халдвараас сэрэмжил. 2004 он /наалт/. ЭТУГ. ДЭМБ, В.Гармаа
6. Цэвэр гар аюулгүй - амьдрал 2004 он /наалт/. В.Гармаа
7. Угаагч бодис бүхий буцалгаж хөргөсөн усаар угаавал найдвартай. 2004 он /наалт/. ЭТУГ. ДЭМБ. Солонгосын ЭМДН. В.Гармаа
8. Дам тамхидалт амь насанд хүрч байна 2005 он. /Наалт/, М.Хишгээ
9. Эрүүл мэндийн технологийн талаар төрөөс баримтлах бодлогын үндэслэл, зөвлөмж", Н.Жаргалсайхан, С.Дуламсүрэн, Б.Бурмаа, Л.Ширнэн
10. Гэр бүл дэхь хүчирхийлэл дахин давтагддаг, даамжирдаг юм. 2004 он /санамж/ НҮБ-ын ХАС. ЭТУГ. Ө.Энхмаа ба бусад ХЭҮТ.
11. Эрүүл мэнд-2005. /хуанли/. 2005 он НҮБ-ын ХАС, Ө.Энхмаа, С.Дуламсүрэн. Д.Жаргалсайхан, П.Нямдаваа
12. Шувууны томуугаас сэргийлье. 2005 он / санамж/. ЭМЯ. ЭМХҮТ. БГХӨЭСТ, В.Гармаа
13. Эрүүл мэндийн анхны тусламжийн тогтвортой үйлчилгээ-эмийн эргэлтийн сан. /санамж/ ЭМЯ. НҮБ-ын Хүүхдийн сан. Япон улсын Засгийн газар, Д.Уранчимэг, Ө.Энхмаа Б.Баттөгс
14. Эрчүүд ба эрүүл мэнд-2006 /хуанли 2006 он НҮБ-ын ХАС, Ө.Энхмаа,С.Дуламсүрэн. Д.Жаргалсайхан, П.Нямдаваа
15. АТС ангилал кодыг ашиглах гарын авлага, 2007 он, Т.Зориг, Ч.Мөнхдэлгэр
16. Монгол эмийн жорын эмхэтгэл, 2008, Т.Зориг, Б.Нямаа, П.Лувсаннамжил
17. Гүүн хөх ургамлын хими биологийн судалгааны дүнгээс,2008, Л.Цэрэнтогтох, Д.Цэрэндагва, Т.Зориг, Н.Цэвэгсүрэн
18. Канема эмийн клиникийн судалгааны дүнгээс, 2008, Т.Зориг, бусад
19. Силимарин эмийг хэрэглэх биохими, эмнэлзүйн үндэслэл, 2008, Т.Зориг

КИНО, ДҮРС БИЧЛЭГ

"ЭСС" ТВ студийн Ю.Дамбадорж ахлагчтай Г.Тэмүүжин, П.Анхтуяа, А.Сарантуяа, Ш.Алтангэрэл, Б.Нямсүрэн Г.Батнягт, Ц.Баттөмөр, Ж.Болд, Ө.Гантөмөр, Л.Ганчимэг, Д.Нарантуяа, Д.Наранцэцэг, Ш.Мөнхбат, Г.Цэцэгбазар, Ү.Алтанбагана, Д.Дүгэржав нар 30 гаруй баримтат кино, 330 гаруй нэвтрүүлэг, 24 сэрэмжлүүлэг, 50 гаруй зөвлөлгөө, 15 реклам, 20 гаруй шторк, 50-аад мэдээ г.м... бэлтгэж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төдийгүй салбарын түүхийг дэлгэцэнд мөнхөлсөн байна.

Д/д	Бичлэгийн нэр төрөл	Дүрс бичлэгийн нэр
1		2
1997 он		
1	Баримтат кино	Амьдрах сайхан 1 хэсэг. Хүн болох багаасаа 2 хэсэг. Гэрээ засаад төрөө зас 3 хэсэг.Насны нар жаргах өдий
		Ангир уураг бурхны хишиг
2	Нэвтрүүлэг	Эхийн хэвлий дэх нулимс" Завхан
3		Эрүүл хот-сайхан амьдрал
4		Хамт олон эрүүл мэнд
5		"Авралын од" (вакцин)
6		Аврал уу? Аюул уу?
7		Сайхан хооллоорой
8		Жуулчин говь ХХК
9		Бэлгийн машин
10		Тэнэмэл хүүхэд
11		Вакцин:
12		Найр жаргах болоогүй
13		Төрөлт
14		"Авралын од" реклам
15		Вакцины товлол
16	Бичлэг оригинал	Ralli хаалт
17	Сэрэмжлүүлэг	Дархлаажуулалт
18	Реклам	Ахмадын өдөрт
19		Тэрэлж
20	Мэдээ	ДЭМБ-ын 50 жилд ЭМНХ-ын сайд болон Хятадын ЭМ-ийн сайд нарын гарын үсэг
21		Иоджуулсан давс
22		Нярайн хүйн халдварын тухай
1998 он		
23	Баримтат кино	ДОХ-той амьдрал. Тайланд бидэнд юу өгүүлж чадах бол
24	Хүүхэлдэйн жүжиг	Азтай, азгүй хоёр
25	Нэвтрүүлэг	Ерөнхий утгаараа цайз биш гүүр
26		Бүсгүй минь
27		Шингэн сэлбэх давсны тухай
28		Үндэсний вакцинжуулалтын өдөр
29		Менингококкийн халдвараас сэргийлье

30	Нэвтрүүлэг	Намрын вакцины 10 хоног
31		Тэтгэврийн шинэтгэлийн шинэ хууль. Цуврал 1,2
32		Найдвартай утас сонсож байна
33		Ахмадын явган аялал
34	Нэвтрүүлэг	НҮЭМ. Би хамгийн хөөрхөн №1
35		Хуурамч эм
36		Таны төлөө бид
37		Дутуугүй байх дотно сэтгэл
38		Хог зөвхөн хогийн савандаа
39		Үе тэнгийнхэн
40		Эрүүл сэтгэцээр
41		Монгол улсын дархлалын хөтөлбөрөөс
42		Эх нялхас
43		НҮЭМ №3
44		Иод 3 цуврал
45		Орчин, эрүүл мэнд
46		Хувийн эрүүл мэнд, орчны эрүүл ахуй
47	Зөвлөлгөө	Эмчгүй газарт
48		Түлэгдэлт цус тогтоох
49		Цохиулалт амаар амьсгалах
50		Боолт хэвийн өвчин
51		Хүүхэд эхчүүдийн хоол
52		Зөв хооллох
53		Өвчний үеийн хоол хүнс
54		Ариун цэвэр
55		Нийгмийн ариун цэвэр
56		Шимэгчид
57		Хамрын өвчнүүд
58		Хоолойн өвчнүүд
59		Зүрхний шигдээс
60		Эмчгүй газарт
61		Жирэмслэлт шинж тэмдгүүд
62		Эмэгтэйчүүдэд өгөх зөвлөгөө
63		Цөсний хүүдийн өвчин
64		Хүүхдийн цавины эвэрхий
65		Мухар олгойн үрэвсэл
66		Төмөр дутал, цус багадалтаас сэргийлэх
67	Сэрэмжлүүлэг	Зөвхөн зөвшөөрөгдсөн газраас эм ав
68	Реклам	Иод дутлын эмгэгээс иоджуулсан давс хамгаална
1999 он		
69	Баримтат кино	Хий нас
70		Амьдарсан шиг амьдар
71		Ирээдүй өнөөдрөөс эхэлнэ
72		Автобус комбинат 20 жил
73		ЭАХС-ын хяналтын албаны түүхэн замнал
74		AIFO орчуулга

75	Мэндчилгээ	ЭМНХЯ-ны сайд С.Сонин
76	Хөрөг	Дондог
77		Томуу
78		Хүний төлөө. Эмнэлгийн ажилчдын өдөрт
79		Иодын сургалт. 41-р сургууль
80		Монгол зоог
81		“Хичээлийн дараа” Өсвөр үеийн НҮЭМ-ээр
82		Бидэнд сүрьеэгүй ирээдүй хэрэгтэй
83		Эрүүлийг хүсвэл
84		НҮБ-ын Хүүхдийн сан Хөвсгөлд
85		Булган иод /бичлэг оригналь/
86		Нар жаргах болоогүй
87		Чи хэн бэ? Тамхины тухай
88		ЭМНХЯ-ны сайд С.Сонин тамхины өдөрт зориулж хэлсэн үг
89		Эрүүл мэнд гэж юу вэ?
90		Будгаар гоёхоор булчингаар гоё
91		Цастай гудамж гантиг шиг цайрч
92		Мартагдсан сайд нарын хоёр
93	Нэвтрүүлэг	Баяр баяр баяр
94		Иод дутлын эмгэгийн тухай
95		Бэлгэвч юу өгүүлэх вэ?
96		НҮЭМ № 2
97		НҮЭМ № 7
98		ЭМДаатгалын тухай оюутан
99		ЭМДС /Булган, Хишиг-Өндөр/
100		НҮЭМ №4 ЭРүүл эхээс эрүүл хүүхэд
101		НҮЭМ №6 Миний хүү том болоорой
102		НҮЭМ №5 Ханьдаа баярлалаа
103		Эрүүл мэнд гэж юу вэ?
104		Амны хөндийн эрүүл ахуй
105		Эхчүүдийн амрах байр
106		Таны ирээдүй таны гарт
107		ЯБҮХ Газраас
108		Товчооноос зугатааж тахал уруу
109		Айдасгүй амьдарцгаая
110		Эрүүл мэндийн туслагч миний дотны зөвлөгч
111		Бүсгүй минь чи инээмсэглэж яваарай
112		Тамхи таныг
113	Нэвтрүүлэг	Зайн сургалт
114		НҮЭМ, ХАС хөтөлбөр.Орон нутагт хийх зүйл их байна
115		LKA төсөл
116	Зөвлөгөө	Шүдээ хамгаалъя
117		Эмчгүй газарт
118		Хүүхдийн хоол тэжээл №112

119		Ясны үрэвсэл №113
120		Цистит № 114
121		цуврал 5 хоол тэжээл
122		цуврал 6 жирэмсний хяналт
123		Гэр бүл-Хоол хүнс
124		АЦХХ-с сэргийлье /маск/
125		Бид таны төлөө
126		Эсэн мэнд амаржихуй цуврал 5-22
127		Гэмтэл бэртэлгүй спорт
128		Шүд
129		Хүүхдийн арьсны өвчнүүд, тууралт
130	Сэрэмжлүүлэг	Жоом
131		Цагаан сар ЭАХСХА
132		Ус
133	Реклам	НҮЭМ-ийн рекламууд
134		Үр хөндөлт
135		Төмрийн бэлдмэл
136		Төрөлт зохицуулагдах арга
137		Жирэмсний хяналтанд эрт орох
138		Гэрийн төрөлтийн хор уршиг
139		Хорт зуршил
140	Мэдээ. Архив	Сайд хүлээлцэх арга хэмжээ
2000 он		
141	Баримтат кино	Нууцлах ёсгүй нууц
142		Эмийн үйлдвэр 70 жил
143	Сургалтын кино	Амьсгалын цочмог халдвартай хүүхдийн үнэлгээ
144	Клипп	Вакцин маань ачтай шүү дээ /дуу/
145		Вакцины дуун
146		Долоон гайхамшиг
	Нэвтрүүлэг	Дэлхийн усны өдөрт
		Менежментийн хувьчлал Баянзүрх
		Аюулгүй цус өөрөөс минь эхтэй
		“Эрчүүдээ” эмнэлгийн тухай
		Ар жанчивлан
		Таны ирээдүй таны гарт
		Явахгүй гэсэн замаараа. Н.Удвал
		Дэлхийн усны өдөрт
		Идэвхитэй шилжилт амьдралыг өөрчилнө
		Сүрьеэ эдгэрдэг өвчин
		Элэг бүтэн инээж явъя ээжээ
		Амьдрахын тулд суралцъя
		Хаврын вакцинжуулалт
		Би чадах ёстой
		Болзошгүй аюулаас сэргийлье
		Иод дутлын эмгэг (JICA)
		Хээгүй хүмүүс өвчлөхгүй гэж үү?
		Амьдрах орчин
		Вакцины тухай

	Нэвтрүүлэг	Цөс
		Ус
		Эмийн үйлдвэр
		П.Улаанхүү нэр дэвшигч
		С.Сонин
		Улаануд уу? Улаанбурхан уу?
		Өрхийн шинэчлэл
		Нүдний шил ба гоо сайхан
		Таны төлөө
		Зөв хооллоё
		Тамхи таныг татна
		Нэг дэлхий явган аялал
		Архив-машин
		ЗУЗХ – гамшгаас сэргийлье
		МХЭН–Амьдрал хайраар эхэлж хайраар төгсдөг
		ГОС-хот өрхийн эмнэлэг
		Энэрэлт үйлстэн
		Байгууллагын танилцуулга
		Эмчгүй газарт 1-3б-р цуврал
		Томуугаас сэргийлэх сэрэмжлүүлэг Цуврал. № 1 Томуугаас урьд.сэргийлье №2 Томууг гэрээр эмчлэх
		Суулгалт. Цуврал
		Хүүхэд яагаад суулгалтаар өвддөг вэ?
		Ундны усны хэрэглээ
		Суулгалт өвчнийг гэрээр эмчлэх зарчим
		Хүүхдийг нэмэгдэл хоолонд оруулах
		7-9 сартай хүүхдийн хоол
		10 сараас 2 настай хүүхдийн хоол
		Бохир гарын тухай
		Шингэн сэлбэх д авс зөв найруулах, зөв хэрэглэх
		Хүүхдийг тураалаас хэрхэн сэргийлэх вэ?
		Суулгалт өвчний хүндрэлээс сэргийлэх
		Эмчгүй газарт
	Нэвтрүүлэг	Эмийг буруу хэрэглэвэл -28 Эмийг хэзээ хэрэглэх вэ? -29
		Жирэмсэн эхийн эмийн хэрэглээ /эмийн бус эмчилгээ/ -30
		Ханиад -34
		Өвдөлт нүд /нойр муудах/ -35
		Даралт ихсэх үед -36
		Эмийг яаж хэрэглэх вэ? -46
		Уламжлалт эм, тан -47 Уламжлалт эм, тан -48

	Нэвтрүүлэг	Эмийг тарьснаас үүсэх аюултай урвалууд -52
		Тариа хийх тухай -53
		Тариа буруу хийснээс үүдэх хор уршиг -54
		ЭСС ТВ студийн эхлэл
2001 он		
	Баримтат кино	Хот ариун бол хотол амгалан
	Нэвтрүүлэг	Түмэнд ээлтэй эмнэлэг
		Сүрьеэг би ялсан та ч чадна
		Хүүхдийг хөхөөр хооллох
		Өрхийн эмнэлгийн шинэчлэл Дорнын их талд
		Тахал
		Иодын тухай дахин ярилцвал
		Сайн байна уу? Сургууль минь
		Тэгш дүүрэн байхын учир
		Нүүдэлчин Монголчуудын эмэнд
		Наадам тойрсон яриа
		Амьдрах итгэл
		Тэжээллэг хүнс таны хүүхдэд
		Ахмадын нэвтрүүлэг
		Миний биед иод дутвал
		Түргэн тусламж
		Шүдний гоо сайхан
		ДЭМБ-40 жил
		Эсэн мэнд амаржихуй цуврал 2,3,4
		НҮЭМ
		Шилжилт хөдөлгөөн-эрүүл мэнд
		Цэвэр гар-хоросол хэрэглэх арга
		Цэвэр гар, эрүүл байхын нэг үндэс
		Цэвэр орчин
		Вакцин сэрэмжлүүлэг
		Эрүүл гэр бүл
		Эрүүл ажлын байр
		Хөх хотын эмнэлэг
		Алжаал тайлах дасгал
		Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл мэнд
		Сүрьеэ эдгэрдэг өвчин
		Сүрьеэгээс урьдчилан сэргийлье
		Зөөврийн усны хэрэглээ
		Зөөврийн усны эрүүл ахуй
		Эрчүүд ээ, эрүүл мэнд танаас 1, 2
		Охидын эрүүл мэнд
		Гоо сайхны эрүүл ахуй
		Олон улсын Ахмадын жилд зориулсан нэвтрүүлгүүд.
		Насны хойморт
		1999 оны 5 сарын 31. Дэлхийн тамхигүй өдөрт зориулсан реклам
		Залууст ээлтэй итгэлтэй эмнэлэг
		Сэрүүлэг сонины редакц

	Нэвтрүүлэг	Хяналтгүй хорио цээр /Монтаж оригиналь/
		Эсэн мэнд амаржихуй
		НҮЭМ цуврал
		НҮЭМ 19, 20
		Гэр бүл төлөвлөлт гэж юу вэ?
		Сильва ДЭМ-ийн өдөрт
		АЗЦХ-аас сэргийлье
		Сэрэмжлүүлэг
		Хэрвээ хүүхэд тань өвчилвөл
		“Бохир гар” сэрэмжлүүлэг
		Хайр ээжээс эхтэй
		Мэргэжил бүхэн сайхан ч
		Идээний дээж ихэдвэл...
		Бохир гар
		1.Эмчгүй газарт 10, 11, 12
		Эрүүл хүнс таниас
	Сэрэмжлүүлэг	Хүүхдэд ээлтэй орчин
		Мансуурлаас сэргийлье
		ДОХ
		ДОХ, БЗХӨ-өөс сэргийлье
		Тамхигүй орчин амжилтын үндэс
		Сүрьеэгээс сэргийлье
		Жимс, ногоог угааж хэрэглэ
	Зөвлөлгөө	Шүлхий
		Эмчгүй газарт № 103, 104, 105
		Хийн дасгал № 13
		Амьсгалын замын өвчний үед хийх дасгал № 14
		Үе мөчний дасгал № 15
		Иод гэж юу вэ? № 16 Иод хүүхэд № 17 Иод эмэгтэйчүүд № 18
		ИРЭ-ээс сэргийлье № 19
		Эмчийн зөвлөгөө
		АЗЦХ өвчин томуу
		Эмчгүй газарт 11 Эмчгүй газарт 12
	Реклам	Хүүхдээ хөхөөр хооллох нь эхчүүдийн эрх
		Вакцин товлол 1, 2
		Хүүхдэд ээлтэй орчин
		Дархлаажуулалт
2002 он		
	Баримтат кино	Хавдрын мэдээллийн төв
		Шорон дахь сүрьеэ
	Нэвтрүүлэг	Цонх
		Халдварт өвчнөөс хамгаалах гайхамшиг
		Эрүүл мэнд мэдээлэл
		Дархлааг дэмжье

	Нэвтрүүлэг	Эрүүл мэнд мэдээлэл/Өвөр Монгол/
		Эрүүл ажлын байр
		Аминчлан ярилцъя эрчүүдээ
		Алжаалаа тайлах дасгал
		ДЭМ-ийн өдөрт
		Хөвсгөл
		Далд эмзэглэл
		Төмөр зам. Их ойн өмнө
		Биднээс шалтгаална
		Эмнэлгийн магадлан итгэмжлэл
		Тамхи ба спорт
		Ярилцъя найз минь
		Шар өвчин
		Даралт ихэсдэг бол
		Хоёр дахь зүрх
		Учрыг тунгаавал
		103
		Эрүүл мэнддээ зориулах цаг
		ДЭМБ-д элссэний 40 жилд
		Охид ба хүсээгүй жирэмслэлт
		Орчны эрүүл ахуй
		Бүсийн эмчилгээ, оношилгоо
		ОУ-ын “Орбис” нүдний эмнэлэг
		Усан хангамж – Эрүүл мэнд
		Сүрьеэ
		Гал
		Хүүхдийг 4-6 сар хүртэл нь дан хөхөөр хооллох. Цуврал № 1, Цуврал № 2, Цуврал № 3, Цуврал № 4
		Мартагдсан сайд нарын 2-р эмнэлэг
	Сэрэмжлүүлэг	“Ухаарал” сэрэмжлүүлэг
		Бэлгийн харьцаа аюулгүйн баталгаа биш
		Хамгаалалтын бүсээ зүүж хэвшицгээе
		Энэ бол эрүүл байх
		Эмийг зөвхөн эмчийн зааврааp хэрэглэ
		ДОХ
2003 он		
	Баримтат кино	Хөхний хавдраас сэргийлье. Сүүн хэлхээ
		Умайн хавдрдаас сэргийлье
		Хавдар судлалын Үндэсний төв
	Нэвтрүүлэг	Хүйн ижий
		Нийслэл чиглэсэн их нүүдэл
		Хавдраас сэргийлье
		Чихрийн шижингээс сэргийлье
		Хууль таны эрүүл мэндэд
		Мэдээ
		Уул Алтайн унаган хүү

		Охид
		ЭМ-ийн даатгалын хууль
		Өрхийн эмнэлгийн шинэчлэл. Ховд аймагт. Цуврал Бэрхшээл биднийг тойрохгүй. Цуврал № 10.
		Дорнын их говь – шинэчлэл Дорноговь аймагт Цуврал №7
		Багаас төхөөрөмж яагаад саатав. Цуврал № 8.
		Шинэ ажлын эхлэл–ЭМСХ хөтөлбөр цуврал № 9. /Баримтын ажлын явц
	Сэрэмжлүүлэг	SARS. Халдвараас сэргийлье
		АЦХАХ
	Зөвлөлгөө	Тахир дутуу 12 цуврал
	Мэдээ	Ховд аймаг
2004 он		
	Баримтат кино	Сумын эмнэлэг
		Насан хутгийн 80 жил
	Нэрвтрүүлэг	Дундговь –Нутаг шигээ сайхан түмэндээ
		НҮЭМ-ийн цуврал № 21,22,23,24
		Бэлгэвч
		Хамтдаа сэргийлцгээе
		6. Болгоомжгүйгээс
		Айдасгүй амьдрахын тулд сонсъё, суралцъя, амьдаръя
		ДОХ семинар
		Хүүхдийн эрүүл мэнд цуврал №1-4
		Хүний төлөө /Монгол улсад эмгэг судлалын алба байгуулагдсаны 70 жилийн ойд зориулав/
		Хүүхдийн эрүүл мэнд цуврал №5-8.
		3-р эмнэлэг /зүрхний бичлэг/
		Таны эрүүл мэндийн боловсролд даралт ихсэх өвчин
		АЗЦХ с сэргийлье
		Элэг 1 цуврал
		Нярайн асаргаа
		Гэмтэл 10 цуврал 5 минут
		ДОХ 5 цуврал
		Тамхи 2 цуврал
		Өглөөний дасгал зохиомж
		Шүд 4 цуврал
		Эмийн тухай 1 цуврал
	Эмгэнэл	Нарантуяа эмч, эмгэнэл
	ТВ шторк	Ажлын байранд хийх дасгал хөдөлгөөн
	Сэрэмжлүүлэг	Хавдраас сэргийлье
		Томуу
2006 он		
	Нэвтрүүлэг	Дархлаажуулалт
		Улаан бурхан
		Хүйтэн хэлхээ
2007 он		
	Програм	Шувууны томуу ба томуугийн цартахал

	Шторк	10 000 алхам
		Эрүүл Монгол үндэсний хөтөлбөр
	Үзүүлэлт	Эрүүл Монгол үндэсний хөтөлбөрийн дата файл
2008 он		
	Нэвтрүүлэг	Үерээс сэргийлье
	Шторк	Үерээс сэргийлье
		Гахайн томуу
		H1N1 сэргийлье
2010 он		
	Нэвтрүүлэг	Уур амьсгалын өөрчлөлт
		Халдварт боом, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтын нэвтрүүлэг
		Бие засах газар
		Алтнаас илүү эрдэнэ
		Эрүүл мэндийг дэмжигч байгууллага
		ЭМЯ 80 жил
	Шторк	Тамхигүй өдөрт
		Дэлхийн эрүүл мэндийн өдөрт
		Бичил тэжээл
		Гепатит А
		H1N1 вакцин
		Гар угаах өдөрт
		Бэлгэвч
2011 он		
	Нэвтрүүлэг	Ус чандмана эрдэнэ
		ЭМД сургууль
		Хоол хүнс
	Шторк	Хөхөөр хооллох өдөрт
		Дархлаажуулалт
		Эмийн зохистой хэрэглээ
		Гэр бүл төлөвлөлт
		Дэлхийн эрүүл мэндийн өдөрт
	Баримтат кино	Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баримтат кино
	Концерт	Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын концерт
	Ном	Эрүүл мэндийн салбарын хөгжил 1-9 боть ном
2012 он		
	Нэвтрүүлэг	Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 1-5
		Шүд эрүүл бол бие эрүүл
		Хүүхдийн осол гэмтэл – түлэгдэлт
		Харшил
		Боом өвчнөөс сэргийлье
		Галзуу өвчнөөс сэргийлье
		Эрүүл мэндийн анхан шатны тусламж
		Эрүүл мэндийн даатгал

	Нэвтрүүлэг	Эмийн хэрэглээ
		Эмнэлгийн тусламжийн чанар
		Нийгмийн эрүүл мэнд
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 6-10
		Архины хор уршиг
		Тамхинаас гарцгаая
		Бухимдлаа тайлах аргууд
		Хоол хүнсээ хэрхэн сонгох вэ
		Хөдөлгөөн, эрүүл мэнд
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 11-15
		Амин дусал – цус сэлбэлт
		Та ч бас донор
		ДОХ ба шивээс
		Вирус гепатитын халдвараас сэргийлье
		Халдварт шараас сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 16-20
		Бага насны хүүхдийг чийрэгжүүлэх
		Хүүхдийг усаар чийрэгжүүлэх
		Нярайн асаргаа сувилгаа
		Охидын эрүүл ахуй
		Хачигт халдвараас сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 21-25
		Эмийн зохистой хэрэглээ
		Эмийн чанар аюулгүй байдал
		Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлье
		Ясны сийрэгжилтээс сэргийлье
		Хавдраас сэргийлэх 7 алхам
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 26-31
		Компьютер тоглоомонд донтохоос сэргийлье
		Бөөрний өвчнөөс сэргийлье
		Чихрийн шижингээс сэргийлье
		Толгой нүцгэн явснаас...
		Хэрх өвчин
		Хүн бүр аягатай байя
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд /16/ Бага насны хүүхдийг чийрэгжүүлэх
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд /17/ Хүүхдийг усаар чийрэгжүүлэх
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд /18/ Нярайн асаргаа сувилгаа
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд / 19/ Охидын эрүүл ахуй

	Нэвтрүүлэг	Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 20 Хачигт халдвараас сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 21 Эмийн зохистой хэрэглээ
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 22 Эмийн чанар аюулгүй байдал
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 23 Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 24 Ясны сийрэгжилтээс сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 25 Хавдараас сэргийлэх 7 алхам
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 26 Компьютер тоглоомонд донтохоос сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 27 Бөөрний өвчнөөс сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 28 Чихрийн шижингээс сэргийлье
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 29 Толгой нүцгэн явснаас...
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 30 Хэрх өвчин
		Иргэн таны эрүүл мэндийн боловсролд 31 Хүн бүр аягатай байя
		Эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөрийн дата файл
		Байгууллагы нэгдсэн мэдээний сан 1
		Бусад мэдээний сан дата файл
		5 дугаар сарын 31 Дэлхий нийтээрээ тамхи татахгүй өдөр
	Шторк	Анагаахын дээд боловсрол

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 13б, Утас: 7012-8801,
Факс (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn
http: www.hdc.gov.mn